

83.8
P.93



А.РЫБАКОВ

КРОШЕЙН ПЯН

ББК
84(2p)
P.93

83.8
P.93



А.РЫБАКОВ

Крошійн паян

ББК
84(2р)
P.93

А. РЫБАКОВ

КРОШИЙН ПАЯН

“БНМАУ Ардын боловсролын яамны хэвлэл” Улаанбаатар хотноо 1971
онд эрхлэн хэвлүүлсэн номоос

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар **Цагаан бамбарууш хэвлэлийн**
газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



Tsagaan **bambaruush**

ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**"БОЛОР ДУРАН"
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР
АЛДАА ШАЛГУУР

БОЛОР
АЛДАА ШАЛГУУР 2.0

БОЛОР
АЛДАА ШАЛГУУР 2.0

А. РЫБАКОВ

ПРИКЛЮЧЕНИЯ КРОША

Орос хэлнээс орчуулсан Г. Аким

КРОШИЙН ПАЯН

1

Автобаз манай сургуулиас холгүй, зэргэлдээх гудамжинд байдаг юм. Ангийн цонх онгорхой байхад моторын чимээ бидэнд сонсогдоно. Ачааны болон ачаагаа өөрөө буулгагч машинууд ажилдаа гарч байгаа нь тэр ээ. Энэ машинуудаар Москвагийн барилга, барилга руу материал зөөдөг билээ.

Шөнө нь машинууд эзгүй хашаандаа урт эгнээгээр ярайн зогсоно. Манаач эдгээрийг манах бөгөөд дах нөмөрчихсөн кабинд унтаж байдаг юм. Ямар нэг хэрэг гарвал түүнийг дор нь сэрээж жишээлэхэд шөнө хулгай гарлаа гэж мэдэгдэж болно л доо.

Өдөр нь автобазын дааманы харалдаа хувийн тэрэгтнүүд хөлхөнө. Машинаа өөрсдөө засаж чадахгүй болохоор тэд их л царайчлангуй байдаг байлаа.

Бааз манай сургуулийг шефлэн авсан юм. Иймээс үйлдвэр сургалтын хувьд манай сургууль райондоо хамгийн сайн нь билээ. Бусад сургуулийнхан авто техникийн танхимыг маань ирж үздэг юм.

Бид Газ-51-ээр машин жолоодож сурч байгаа бөгөөд түүнийг мөн л бааз бэлэглэсэн билээ. Сургуулийн аж ахуйн эрхлэгч Иван Семенович машины маань аж ахуйн ажилд л дандаа зарж байх гэнэ. Биднийг дадлага хийхээр явахад уцаарлаж, нүүрс юм уу, өөр ямар нэг юм авчрах хэрэгтэй байна хэмээн зандачна.

Тэглээ ч гэсэн бид хорь хорин цагийнхаа дадлагыг хийсэн юм. Зарим хүүхэд тэр ч байтугай машин барих эрхийн үнэмлэхтэй. Түүнийг «залуу жолоочийн үнэмлэх» гэдэг. «Хүүхдэд зориулсан зам дээр машин жолоодох эрхтэй...» гэж түүнд бичсэн байдаг. Яг тэгж бичсэн байгаа.

Гэвч энэ үнэмлэхтэй хотоор явахад дажгүй. Гэхдээ цагдаатай халз тулгарчихгүй бол шүү. Ер нь цагдаатай дайралдчихгүй бол огт үнэмлэхгүй ч явж болно л доо.

Бид автобаз дээр үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа юм. Нөгөө «Б» анги маань барилгын дадлага хийж байгаа. Тэд Липка дахь пионерын зуслангийн барилга дээр ажиллаж, тэндээ сууж байгаа юм. Дадлага хийх ч гэж дээ, зусланд байгаа л гэсэн үг. Гэтэл бид зургаадугаар сарын турш Москвад хөлсөө цувуулах ёстой байлаа.

Энэ дадлага надад ерөөсөө хэрэггүй. Техникийн авьяас над даанч байхгүй дээ. Бааз дээр миний сонирхож байгаа ганц юм гэвэл машин барих л юм. Гэвч дадлага хийгчдэд жолоо бариулна гэдэг хол. Тэгэхлээр надад хийх юм даанч алга даа.

Биднийг дадлага хийхээр ирэхэд баазын дарга:

— Сайн ажилласан хүн зэрэг ч авч болно. Тав гэхгүй. Харин дөрөвдүгээр зэрэг авч болох юм гэж хэлсэн юм.

Бид хашаа дотор зогсож байлаа. Дарга бол ажлын хөх цамц өмссөн, лагс биетэй, наранд түлэгдсэн нүүртэй хүн ажээ. Жолооч байсныг нь би харсан дороо мэдэв. Настай жолооч бүр тийм бор царайтай байдаг юм. Тэд бол насан туршаа хөдөө хөхөрч гадаа гандаж явдаг улс шүү дээ. Дарга найгасхийн тайван уужуу ярих нь биеэ ямагт барьж байх мэт ажээ. Үүнийг нь ч харсан түүний жолооч байсан нь илт. Мэдрэл муу бол машин барьж болохгүй, дороо л осолд орно гэсэн үг.

— Зэрэг авахад юу нь муу байх билээ? гэж дарга асуугаад биднийг бардам харлаа. Зэрэг өгнө гэж сонсоод биднийг учиргүй баярлана гэж санажээ.

Гэвч бид дуугарсангүй. Өнгөрсөн дадлагын үеэр ганцхан охин л маш сахилга багтай, дуулгавартай байсны учир зэрэг авсныг бид мэдэж байлаа.

Дарга дээш харснаа хажуугаараа өнгөрч яваа засварчныг ширтэн,

— Ажиллах дургүй хүн байвал шууд хэл, би дор нь чөлөөлөөд өгье гэв.

Зарим нь үнэндээ эндээс арилаад өгөхөөс буцахгүй байлаа. Техникт авьяасгүй болохлоор би ч тэгмээр байв. Гэвч даргын «чөлөөлнө» гэдэг нь «хөөнө» гэсэн үг байлаа. Үүнийг бид ухаарахтайгаа. Тэгээд ажилламааргүй байна гэж хэн ч ам нээсэнгүй.

Дараа нь ерөнхий инженер бидэнд автобазыг үзүүлэхээр явав. Биднийг аж ахуйн талаар ерөнхий төсөөлөлтэй байг гэж тэр ээ.

Энэ нь ч аргагүй. Чи ямар нэг бүхэл бүтэн юмны нэг хэсэг болж байвал түүний тухай төсөөлөлтэй байх хэрэгтэй. Ингэхгүй бол үнэнийг хэлэхэд чухам юуны хэсэг болж байгаагаа ч мэдэхгүй шүү дээ.

Семечкина, Макарова хоёр ерөнхий инженертэй зэрэгцэн явна. Тэд ойлгосон юм огт үгүй мөртөө ээлж ээлжээр бичиж авах ажээ. Ерөнхий инженерийн ярьж байгааг нэг нь бичиж авч байхад нөгөө нь чагнах ч үгүй гээч. «Үгүй мөн та хачин сонин ярьж байна! Би холдож ч

чадахгүй байна шүү гэж» хэлэх гэсэн мэт инженерийн аманд орчих шахна.

Би юу ч бичиж аваагүй. Гэртээ хариад биччихнэ ээ гайгүй.

Би ерөнхий инженерээс зайдуухан явав. Гэхдээ юу ярьж байгаа нь дуулдахаар ойрхон, бас хэтэрхий хэнээтэй юм шиг харагдахааргүй зайтай явлаа.

Ард хүүхдүүд цувран дагажээ. Тэд нүдэндээ өртсөн болгоныг шохоорхож, тэр машин сайн, энэ машин муу гэлцэнэ. Игорь энэ талаар өөрийгөө лут мэргэжилтэн гэж үзэх аж.

Харин би ерөнхий инженерийн ярихыг чагнаж байлаа. Тэртэй тэргүй дадлагын тухай тайлан бичих юм чинь.

Автобаз техникийн, ашиглалтын гэдэг хоёр албатай гэнэ. Техникийн албанд нь машин засах, ер нь арчлах явдал хамаарагддаг аж. Ашиглалтын албанд нь чиглэлд ачаа зөөх ажил ордог юм байна. Техникийн албыг ерөнхий инженер удирддаг. Ашиглалтынхыг ашиглалтын дарга удирддаг гэнэ.

Гэвч ерөнхий инженер бол даргын нэгдүгээр орлогч, ашиглалтын дарга бол зөвхөн хоёрдугаар орлогч нь юм.

Ерөнхий инженер нэгдүгээр орлогч, ашиглалтын дарга хоёрдугаар орлогч байдаг нь буруу юм гэдгийг би дор нь ухаарав. Ачаа тээвэрлэх нь хамгийн чухал шүү дээ. Наргиан болгож үүнийг хэлж болох л юм. Гэвч өөрийг нь нэг дүгээр орлогчоос бууруулж хоёрдугаар орлогч болгоно гэж ерөнхий инженерт хэлэх юм бол тэр шар нь хөдөлнө дөө. Нуруу нам боловч хамар унжуу, дуу нь цухалдуу юм. Тийм ч найзлууштай хун биш дэгээ.

Бид цех тасгийг үзэж дуусаад, хашаанд эргэж ирэв. «Техничка» гэдэг бүхээгтэй машин хашаанд зогсож байх агаад дээр нь «Техникийн тусламж» гэж бичжээ. Энэ машин дээр ажиллахаар болбол зүгээр сэн дээ гэж би бодлоо.

Техникт сонирхолтой хүүхдүүдэд ч ёстой завшаан болсон нь мэдээж. Механик, дархан, мотор, угсралт, цахилгаан техник, гагнуур, бүрээслэх, будаг, гөлмөн төмрийн зэрэг янз бүрийн цех автобазад бий. Гэвч техникийн бүх мэргэжил дотроос ганц жолоочийнхыг л би сонирхдог. Хэрэв «Техничкад» очвол жолооч нь над жолоогоо өгч юуны магад.

Ерөнхий инженер биднийг кабинетад оруулаад

— Одоо би тануусыг ажиллах газар чинь хуваарилна гэхэд нь

— Ажиллах газраа бид өөрсдөө сонгож авч болох уу гэж би асуулаа.

— Үгүй ээ. Сурганд таарахгүй гэж ерөнхий инженер хариулдаг байна.

Тэр бээр ширээний шилэн дор бангаа цаасыг шагайж, ангид бидний хичээл хариулахдаа дэвтрээсээ будаа иддэг шиг нөгөөдхийгөө харан харан:

«Мөн тэрчлэн сурагчдын хувийн шинж чанарыг харгалзвал зохино. Салан задгай хайнга сурагчид анхаарал шаардагдах ажил өгнө. Шантрамтгай хүүхдэд туйлбартай хийвэл зохих ажил, аймхай (зожиг) хүүхдэд зохион байгуулах, залхуучуудад үр дүн нь тэр дороо харагдахуйц ажил даалгана» гээд биднийг харж

— Ойлгов уу? гэлээ.

Бид ойлголгүй яах вэ. Биднийг салан задгай (хайнга), аймхай (зожиг), шантрамтгай, залхуу гэж хуваах хэрэгтэй аж.

— Бидний дотор тийм хүүхэд байхгүй гэж би хэлж орхив.

— Тийм гэж ямар?

— Салан, хайнга, шантрамтгай, аймхай, зожиг хүүхэд.

Залхуугийн тухайд гэвэл та яаж мэдэх юм бэ?

Ингэж асуугаад би ерөнхий инженерийн амыг таглах нь тэр. Ах нь «Москвичтай» нөгөө Игорь түүнд тус болов.

Игорь ер нь манай ангийн мундаг хүн байгаа юм. Түүний царай нь цайвар. Үүнийг манай сургуулийнхан хамгийн дэгжин гэж үздэг юм. Тэгээд даан ялангуяа хар үстэй байвал уу. Игорийн дуу хичээлийн эрхлэгчийнх шиг намуухан аргилдуу. Манай ангийн багш Наталья Павловна Игорийг бидэнд дандаа жишээ болгож ярина. Түүний маш хүмүүжилтэй, ухаалагт нь тэр. Үнэн хэрэгтээ бол Игорь овжин хүүхэд.

Бүү зов, энэ ах гуайг бид одоохон аргалаадахъя гэх аятай Игорь бидэн рүү нүд ирмэснээ ерөнхий инженерт их л хүндлэлгүй хандаж:

Вячеслав Петрович, хүүхдүүдийг авьяас сонирхлынх нь дагуу хуваарилах гэсэн юм уу? гэж асуулаа.

Тэр шүү. Игорь ерөнхий инженерийн нэрийг хэдийнээ олоод мэдчихэж гээч!

— Уухайс даа гэж ерөнхий инженер баярлан, дахиад нөгөө бичгээ шагайж «авьяас сонирхлын нь дагуу» гэлээ.

— Тэгвэл үүнийг биднээр хэлэлцүүлчихнэ үү. Бид хүүхэд болгонд авьяас, сонирхлын нь дагуу цех зааж өгье гэж Игорь буурь

зааж хэлэв.

— За тэг, чи зөв юм ярьж байна гэж ерөнхий инженер зөвшөөрөв.

Тэгээд намайг зэмлэнгүй харлаа. Игорийн ярьсан зөв, минийх дэмий гэдгийг надад ойлгуулж байгаа нь энэ ажээ.

Игорийн хэлсэн ухаалаг минийх маанаг байдагт, түүний үгийг дагадаг мөртөө минийхийг хүлээж авдаггүйд бүүр дасчихжээ. Инженерийн зэмлэнгүй харцыг би тоосонгүй өнгөрөөв. Гэсэн хэдий боловч тэр бээр хөмсгөө дахин зангидаж

— Гэвч тануус цэцэрхээд байвал... гэхэд нь

— Яалаа гэж, тэгэхгүй хэмээн хашхиралдав.

Бид ч цех тасгаа авлаа.

Авьяас сонирхолтой хүүхдүүд ч шийдэж ядах юмгүй байв.

Гринько, Арефьев хоёр цахилгаанч, радиоч болохоороо цахилгааны тасагт очуулахыг гуйв. Пелкутин моторынхонд, Гаркуш, Рождественский нар гарын уртай болохоороо будгийн тасагт очихоор боллоо. Игорийг зүгээр хүүхэд санасан бололтой, ерөнхий инженер түүнийг дэргэдээ авав.

Гэвч авьяас, сонирхол байхгүйчүүд ялангуяа охидыг хуваарилах үед тун замбараагүй юм боллоо. Охид цөм нэг дор ажиллах гэв.

Шуугиан дэгдлээ.

Ерөнхий инженер анивчин ийш тийш эргэнэ. Одоо тэр бээр залхаж гүйцээд, биднийг өөрийнхөө санаснаар хуваарилах гэж байгааг нь би мэдлээ.

Тэгтэл аз болоход миний ээлж таарав. Ашиглалтын албанд дадлага хиймээр байна гэж хэллээ.

Ерөнхий инженер миний ингэж сонгож авсанд хачирхжээ. Гэвч надаас хоёр яс салж амрах нь гэж баярлан зөвшөөрлөө.

Би ашиглалтын дарга руу явав. Тэр бол тас хар халимагтай, пэмбэгэр уруултай бүдүүн эр байлаа. Түүнийг хэн нэг хүнтэй утсаар хэрэлдэж дуустал нь яг даг хүлээв. Ярьж дууссан хойноо ч харилцуур руугаа ухасхийсээр байлаа.

Үйлдвэрлэлийн практик хийхээр ирснээ би хэллээ. Сайх хүн гайхав.

— Цаадуул чинь ухаан балайраагүй биз гээд харилцуураа шүүрээд авлаа.

Түүнийг дарга руу утасдах байх гэж айхдаа би:

— Техникийн тусламжийн машин дээр ажиллах гэсэн юм гэж шалавхан хэлэв.

Тэр бээр тас тас хөхөрснөө харилцуураа илдэг байна шүү.

— Хонгор минь, очих газраа олсонгүй. Нээрээ гэм, үнэн хэлж байна. Техникийн тусламжийн машин миний мэдэлд байдаггүй.

Түүнийг ерөнхий инженер мэддэг юм.

Би яасан эндүүрэв ээ?

Автобазад техникийн болон ашиглалтын гэдэг хоёр алба байдаг. Техникийн албанд нь гээд тэр бээр тайлбарлаж гарлаа.

Би үгийг нь тасалж:

— Уучлаарай, би андуурч гэв.

Тэгээд буцаж ерөнхий инженер дээр очлоо. тэр бээр албан тасалгаандаа бичгийн том ширээний ард хүрлийн сууж байв.

Ашиглалтын албанд надад таарахаар ажил байхгүй гэнэ гэж намайг хэлэхэд:

— Ээ дээ дүү минь, хараад байвал чи чинь ажил зэгсэн уядаг эр байх нь ээ гэж ерөнхий инженер өгүүлэв.

Тэгээд сэргийлэх тасаг буюу энд жирийн нэрлэдгээр гарааш руу намайг олон таван үггүй явууллаа.

Шмаков, Петр бид хоёрын ёстой аз таарлаа даа. Тэр бас гараашинд хуваарилагджээ.

Дотор тасагт ажиллагчид машины зөвхөн эд ангийг л янзална. Гэтэл бид гараашинд бүтэн машин дээр ажиллана. Энд машиныг угааж, тосолж, тохируулж, аар саар засвар урьдчилсан үзлэг хийнэ. Засварчид машиныг нааш цааш явуулж, тэр ч байтугай тоормос нь хэр барьж байгааг шалгахаар гудамжинд гарна. Шмаков, Петр бид хоёрт жолоо барих боломж бүрэн бий.

— Шмаков оо, биднээр машин жолоодуулах болов уу, чи юу гэж бодож байна?

Тэр бодолхийлснээ

— Жолоодуулна гэв.

Петр үргэлж бодож байж хариулна.

— Ингэхийн тулд нэг юм хийх хэрэгтэй гэж би хэлэв.

— Амжина аа, гайгүй.

— Тэгсээр байтал дадлага өнгөрнө дөө.

— Жаал ажиглах хэрэгтэй.

Гэвч бид хэчнээн ч ажиглалаа гээд нэмэр болсонгүй. Бидэнд жолоо бариулья гэж хэн ч санасангүй. Бидэнд хайхрамжгүй, бүүр тоомсоргүй хандаж байлаа.

Болгоомжлоод биднээр бие даалгаж ажил үл хийлгэнэ, Эндэх ажил маш хариуцлагатай. Ганц эрэг дутуу чангалснаас болж осол гарч мэднэ. Сүйрэл ч гарч магад. Сүйрэл гэдэг бол осолтой адилхан боловч хүний амь сүйдвэл тэгж хэлдэг юм.

Бид ч тааваараа ажиллаж байлаа. Харин засварчинд төлөвлөгөөтэй, график биелүүлдэг улс болохоор шаргуу ажилладаг юм.

Үнэнээ хэлэхэд би өөрөө ч энэ ажлыг төдийлөн сонирхохгүй байлаа. Гэвч эргэн тойронд чинь ажиллаж байхад дэмий сэлгүүцэх нь эвгүй.

Нэгэнт энд ирснээс хойш би хойш суугч, хоолны тулам гаж үзэгдэхийг үл хүснэ.

Бид «гар хөлийн үзүүрт» зарагдана. Ийш тийш явж, элдэв юм авчирна. Агуулах буюу тасаг руу гүйнэ. Багаж барьж өгнө, зөөдөг дэнлүүгээр гэрэлтүүлнэ, эд ангийг угаана...

Машиныг хашаанд, усан хөөргөөр бүхэлд нь угаах болбол ч ёстой догь доо. Тэгэхэд үнэхээр сайхан! Ус гожгодно гэж үзүүлээд өгнө! Шүршүүрийг энэ тэр газар руу чиглүүлэхэд шавар бөөн бөөнөөрөө ховхорч сувагт унана. Хашлаганаас уур савсаж, ус зургаадугаар сарын нарны гэрэлд дорхноо уурших билээ. Шинэхэн гялалзсан машин тавцан дээрээс бууж явахад хийсэн ажлынхаа дүнг харна даа.

Тэвч тийм сайхан ажил бидэнд тохиолдох нь нүдний гэм. Машиныг ажлаас бууж ирсэн хойно орой угаана. Гэтэл бид өглөө ажилладаг байлаа.

Шмаков бид хоёрыг нэг их аз дайраагүй нь илт. Тасагт ажиллагчид харин илүү азтай ажээ. Засварын газрынхан нэг ээлжээр ажилладаг, манай хүүхдүүд нэг л хүмүүстэй ажиллана. Тэд энэ хүмүүст дасаж, цаадуул нь ч хүүхдүүдэд дасжээ.

Гэтэл гарааш гурван ээлжээр бүтэн 24 цаг ажилладаг байв. Шмаков Петр бид хоёр янз бүрийн бригадтай ажилладаг.

Эхний өдөр бидэнтэй цуг ажилласан бригадынхан нөгөөдөр нь ирээд биднийг таньсангүйгээр барахгүй ор тас мартчихсан байв. Гайхсанаа нууж хаах ч юмгүй, «үгүй, тануус чинь байсаар л байгаа юм уу?!» гэсэн мэт биднийг харна.

Тэд бидний нэрийг ч үл мэднэ. Шмаков Петр надаас ахмад харагдах тул түүнийг «залуу» гэж дуудна. «Хүүе залуу, аль вэ залуу!» гэнэ. Намайг анхандаа «тоодгор» гэдэг байв. «Хүүе, тоодгор, аль вэ тоодгор» гэлцэнэ. Хүүхдүүд намайг «Крош» гэдгийг дуулаад тэд бас л «крош» гэх болж, зарим нь бүр «Кроша» (өөдөсхөн гэсэн үг) гэж дуудах боллоо. «Хүүе Кроша, аль вэ Кроша» гэнэ. Намхан нуруутай болохоор намайг тэгж нэрлэдэг гэж тэд боджээ. Угтаа бол Крашенинников гэдэг нэрийг минь товчлон Крош гэж хочилсон юм. Сургуульд хүүхдүүдийн нэрийг, тэр тусмаа минийх шиг урт нэрийг заавал товчилдог юм. Ингээд л «Крош» болчихсон юм даа. Гэтэл гараашны ажилчид энэ нэрийг минь бүүр намайг басамжлангуй болгожээ.

Ер нь бидний байдал нэг л санасанд хүрэхгүй байлаа. Ийм байхад бидэнд яасан ч жолоо бариулахгүй

Би Шмаков Петрт санаснаа ярив. Мань эр «Тайван сууж бай» гэж хариулдаг байна.

Шмаков Петрт ч тэгж хэлэх нь сайхан байгаа л даа. Тийм зантай хүн тайван байж чадна. «Аль вэ хө, залуу боолт аваадах» гэнэ. Шмаков Петр дув дуугүй түлхүүр авч, эргийг авч эхэлнэ. Хэнийг ч харахгүй, шуухитнана. Нэг сүрхий юм хийж байгаа мэт ажилдаа улайрна... Цугаараа түүнийг ойшооно. Түүний сүрхий ажилдаа шимтсэн дүртэйг яана.

Гэтэл Шмаков огт авах хэрэггүй шураг тайлчихсан байдаг байлаа. Шмаков ажрахгүй... Мань хүн юу ч болоогүй юм шиг бүгдийг эхнээс нь хийж гарна. Аанай л уужуу тайвуу шимтэнгүй янзаараа шүү. Шмаковыг надаас дээр ажилладаг гэж цөм үзнэ. Яагаад тэр вэ. Би Шмаковтой адилхан эргийг зүгээр л нэг эргүүлж чаддаггүй. Энэ чухам ямар учиртай эрэг юм, яах гэж түүнийг эргүүлж байгааг би мэдэх гэнэ. Би ажлаа өвчид нь, утга учир, ерөнхий зорилгыг нь ойлгох ёстой. Ерөнхийгөөс онцгой руу явах сэтгэхүйн дедукцийн арга тэр билээ. Шмаков Петр юу ч үл асууна, гэтэл би шалгааж гарна. Засварчид юм асуухад дургүй. Тэд завгүй гэнэ. Хариулж мэддэггүй ч байж магадгүй.

Засварчдын дарга Дмитрий Александрович гэдэг тоорцог өмссөн туранхай, испанирхуу царайтай эр хүртэл:

— Номын хэнээ минь бага л шалгаа гэж надад хэлэв.

Яагаад намайг тэгж нэрлэснийг нь би эхлээд ойлгосонгүй. Тэгсэн чинь Чеховын «Гэнэн хонгор сэтгэл» гэдэг өгүүллэг байдаг ажээ. Хөдөөгийн нэг ламынд нэрт өмгөөлөгч болсон хүү нь иржээ. Эцэг лам нь өмгөөлөгч хүүгээ «Номын хэнээ» гэж нэрлэсэн байна.

Засварчдын бригадын дарга Дмитрий Александрович тоорцог өмсдөг, испани хүнтэй адилхан, мөн Чеховыг тэгж сайн мэддэг нь маш сайхан хэрэг. Гэвч тэр тусмаа хүнд хоч өгөх нь тусгүй юм.

Ялангуяа залуу засварчин Коська амар заяа үл үзүүлнэ. тэр бээр Шмаковоос баахан эмээнэ. Шмаков түүнийг огт хайхардаггүй байлаа. Гэтэл тэр намайг ээрч, ийш тийш зарна. Түүнийг өөрийг нь алчуур авчир гэсэн байтал «хөөе Кроша алчуур аваад ир!» гэж хашхирдаг байв. Тэр бол ердөө л дөрөвдүгээр зэргийн засварчин юм.

Сайх Коська Шмаков бид хоёрт ямар ч утгагүй асуулт тавих дуртай.

— За аль вэ, дадлагынхан минь (биднийг тэр тэгж дууддаг байв) машин зогсож байхад юу нь ажиллаж байх вэ? хэлээд орхи гэнэ.

Би мөрөө хавчиж

— Юу гэнэ ээ? Мотор нь

— Мотор нь унтарсан байхад
— Гэрэл
— Гэрлийг нь унтраасан бол
— Тэгвэл юу ажиллах вэ дээ.
— Ээ чааваас аа, Кроша минь, тоормос нь ажиллаж байдаг юм байхгүй юу.

— Тэгвэл тоормосыг татаагүй байвал гэж би татгалзав.

Коська хөхрөв.

— Тоормосыг нь бариулахгүй орхиж яаж болох вэ дээ? Юу ч мэддэггүй чинь илт байна.

Энэ Коська миний хаана ч хүрэхгүйг нотлохын тулд би «Залуу жолоочийн үнэмлэхээ» гэрээсээ авчирч засварчдад үзүүлэв.

Энэ үнэмлэх тэдэнд тийм сэтгэгдэл төрүүлнэ гэж санаанд минь ч ороогүй билээ.

Тэд мэл гайхжээ. Тэгэхдээ би үнэмлэхээ гарт нь бариулсангүй. Хавтсан дээрх «Залуу жолоочийн үнэмлэх» гэсэн бичгийг нь л үзүүлэв. Дараа нь нээж овог нэр, зургаа харуулав.

Залуу засварчин бүхэн жолооч болохын хүслэн болно. Далим гарвал л жолооны ард сууна. Айсандаа царай нь хувирна.

Гэсэн мөртөө бууж ирэхдээ сансарт хөөрсний дайтай маадгар гарч ирдэг юм.

Би сурагч мөртөө жолоочийн үнэмлэхтэй байгаад тэд маш их хачирхжээ.

Энэ бол жинхэнэ үнэмлэх биш гэж тэдний толгойд ч орсонгүй. Хэвлэх үйлдвэр хуурамч юм хэвлэхгүй нь мэдээж.

Шмаков Петрт үнэмлэх байхгүй. Мань хүн тэгэхэд «Хүүхдүүдийн үнэмлэх хэнд хэрэгтэй юм» гэж хэлээд шалгалтаа очиж өгөөгүй юм.

Одоо тэгж хэлсэндээ харуусна. Энэ үнэмлэхээрээ намайг ямар их нэр нүүр олж авсныг үзээд шалгалт өгөөгүйдээ амаа барьжээ.

Гэвч Шмаков харагддаг шигээ тийм ч сөгөөгүй эр бишээ. Тэр өөрөө мөн л үнэмлэхтэй мэт додигор явна.

Засварчин Коля надаас их хүндлэнгүй «Үнэмлэхтэй байж чи яагаад машин барьдаггүй юм?» гэж асуухад Шмаков миний орноос «Жолоо барих гэж гүйгээд яах юм? Үнэмлэхгүй улс л жолоо барих гэж гүйлдэж байг» гэдэг байна.

Ингэж хариулснаар Шмаков ч бас үнэмлэхтэй юм шиг, чухам ийм учраас жолоо барих гэж нэг их хорхойтдоггүй гэсэн сэтгэгдэл төрүүлэв.

Би ч гэсэн бид хоёрт хоёуланд маань үнэмлэх байгаа юм шиг явдаг байлаа. Найзын сэтгэлийг бодож тэр шүү дээ. Тэгээд ч Шмаков тэгж хариулаад Коськад хэрийг нь мэдүүлээд өгсөн юм чинь.

Бидэнд хоёуланд минь үнэмлэх бий гэдэгт хэн ч тээнэгэлзсэнгүй. Бидний нэр хүнд цаглашгүй өслөө.

Гэвч хожим нь миний жинхэнэ Шмаковын хий үнэмлэх хэчнээн балаг тарьсан гээч.

Яваандаа бидэнд дасаж, бид ч ажилдаа халдаж оров. Дөрөвдүгээр зэргийн засварчдын гүйцэтгэдэг ажлыг бид нараар итгэн хийлгэх боллоо. Жишээлбэл урд бамбай, дугаарын тэмдэг хэр зэрэг бэхлэгдсэнийг, анхааруулах дохио, гэрэл, тосолгоог шалгадаг болов. Хаана нь, хэдийд, юугаар тослохыг мэдэх хэрэгтэй.

Радиаторыг шалгаж бэхлэх тавдугаар зэргийн ажил хүртэл надад нэг удаа дайралдав. Эхлээд радиатороо гоожиж байгаа эсэхийг сайтар ажиглаж, тэгээд хоолой нь гоожиж байгаа эсэхийг бас үзээд, бэхэлгээг нь болгоомжтой чангалах хэрэгтэй. Маш нарийн хариуцлагатай энэ ажлыг надад даалгалаа. Би ч цөмийг нь зөв хийв.

Испани хүнтэй төсөөтэй бригадын дарга нөгөө Дмитрий Александрович ажлыг минь шалгаж байхад би ажиггүй царай гарган алчуурынхаа сэжүүрээр гараа арчиж байлаа. Хамгийн гол нь сандрахгүй байх хэрэгтэй. Сандарвал чинь ямар нэг юмыг буруу хийчхэж гэж заавал бодно.

Одоо бид, биднийг хааш нь зарах бол гэж нүдээ бүлтийлгээд зогсож байдаг мануухай биш болжээ. Бид ч дасаж, тэд ч дасжээ. Харш жолоо өгөхгүй л байлаа. Гэвч бид горьдлого тасарсангүй. Шмаков бид хоёр ч овоо азтай юм гэж ахиад бодох болов. Тасагт ажилдаж байгаа хүүхдүүд нэг л газар уяатай юм шиг байна. Гэтэл бид хоёр автобазаар хаагуур нь ч явна. Нэг бол тийш нь, үгүй бол ийш нь явуулах бөгөөд гарааш бүх тасагтай холбоотой. Явж байдаг шуурхай ажилтайд минь бидэнд цөм атаархана.

Бид голдуу хашаанд ажиллана. Нар ээнэ. Амьсгалахад уужуухан. Хэн орж, хэн явсныг, хэн хаачиж, хааш нь юу аваачсаныг цөмийг нь харна. Ашиглалтын дарга утсаар хэрэлдэж байгаа нь дуулдана. Нэг үгээр хэлэхэд баазын амьдралыг нэвтэрхий мэдэж байна.

Ерөнхий инженер биднийг дагуулж явсан өдөр саяхан биш үү? Гэтэл бидэнд өөриймсөг болжээ. Жижүүр нэвтрэх бичиг шалгахаа ч байсан.

Өглөөдөө л нэг босмооргүй дээ. Гэвч бос! бос! гэж нэг юм түлхээд байх шиг болно. Тусгүй, эвгүй... Хориод минут хожимдлоо гэхэд л бултаараа ажиллаад учиргүй удчихсан мэт санагдана. Хүн бүхэн байраа эзэлж, ажлаа хийж байхад чи гадна нь байж байдаг. Өглөө юу болохыг мэдэхгүй. Юм болсон ч байж, үгүй ч байж мэднэ.

Учир нь сахилга баттай байхад байгаа юм бишээ. Бусад хүн ажиллаж байхад чи үгүй байна гэдэгт хэргийн учир байгаа юм. Цаашилбал тэд чиний өмнөөс ажиллаж байна гэсэн үг.

Арван тав, хорин минутын урьд ирвэл хамгийн сайн. Шөнийн ээлжийнхэн хараахан буугаагүй, өглөөнийх нь дөнгөж ирж байдаг. Шөнийн ээлжийн дарга манай даргад ажлаа хүлээлгэж өгнө. Ажилчид хувцсаа сольж, инээж хөхрөлдөн, тоглоом наадам болж, элдвийн сонин хачин хөөрнө. Хэн нь худал, хэн нь үнэн хэлж байгааг бид андахгүй.

Бид ээлж халалцахыг хүлээн гараашны дааманы харалдаа урт сандал дээр сууна. Өглөөний наран ээх нь тааламжтай. Сүүлчийн машин замдаа гарна. Зам явахаа барьсан жолооч нар бүртгэгчийн өрөөнөөс гүйлдэн гарах нь хожимдчихоод яарч байгаа нь тэр ажээ. Машин шингэн цэнхэр утаа суунаглуулсаар замд гардаг билээ.

Хашаанд дарга зогсож байна. «Сайн байна уу, Владимир Георгиевич» гэж бултаараа түүний амрыг эрнэ. «Сайн, сайн байна уу?» хэмээн дарга хариу мэндэлнэ. Дарга заримыг нь нэр овгоор нь дуудах бөгөөд бас заримыг нь, жишээлбэл биднийг нэрлэхгүй зүгээр л «сайн байна уу?» гэнэ.

Гэвч Игорийг нэрээр нь дуудна. Игорь конторт, техникийн тасагт ажиллаж, дарга нарын хавилдаа эргэлдэх учир дарга түүнийг Игорь гэдгийг мэднэ. Харин овгийг нь мэддэггүй байх л даа. Игорь цех тасгаар явж, албан хуудас бөглөнө. Гялалзсан том хавтас сугавчилж энгэртээ авто үзэг зүүх бөгөөд ажилчдыг «Цагаан далайн суваг» тамхиар дайлна. Ерөнхий инженерийн орлогч аятай ялдам, ивээнгүй явна. Энэ нь ажилчидтай ингэж байгаа хэрэг. Бидэн рүү бол өөрийнхөө үүргийг шоолох мэт нүд ирмэнэ. «Конторын албан хаагч» гэж биеэ доогтойхон нэрлэнэ. Өөрийгөө онгирч байна гэж биднийг бодуузай гэж тэр. Хамраа сөхөгчдийг бид болгож тавьдгийг мань хүн мэднэ. Тэгэхдээ хамгийн энгийн аргаар шүү. Энэ аргыг биеэр үзэхийг хүсэхгүй байгаа юм.

Игорь томчуултай эн зэрэгцэх дуртай, бүх зүйлийг мэдэж, үйл явдлын төвд байх дуртай. Бүх дарга, механикч, мастер бригадын даргыг нэр овгоор нь андахгүй. Манай ашиглалтын даргыг мөд трестэд татан авахыг олоод мэдчихсэн, тэр ч байтугай ашиглалтын дарга болох хүний нэрийг хэлж байв. Өчигдөр даргыг трестэд дуудаж Черемушка дахь орон сууцын хорооллын барилга руу материал муу зөөлөө гэж

зэмлэснийг бидэнд мэдэгдэв. Ер нь Игорь миний ч, Шмаков Петрийн ч, бусад хүүхдийн ч мэдээгүй юмыг мэдэж байдаг байлаа.

Манай гарашинд ирдэг хөнгөн тэрэгтнүүдийг хүртэл мань эр танина. Гудамжинд гараад:

Энэ бол Липа гэдэг эмчийн «Волга» байгаа юм. Тэр алаг машин бол төв зах дээр жимс худалддаг нэг нөхрийнх. Энэ яйжгай «москвич» бол тэр гэгч профессорынх гэж заадаг байв.

Игорь хэдийгээр дарга нарын ойролцоо эргэлдэж, бүгдийг таньж ажилчдыг «цагаан далайн суваг» тамхиар дайлдаг боловч тэдний дунд огт нэр хүндгүй. Ажилчид түүнийг бидний адил дадлага хийж байгааг хүртэл мэдэхгүй, шинэ ажилтан гэж бодно.

Шмаков бид хоёр хамгийн хар бор ажил хийдэг, машин дороос гарна гэж байхгүй. Гэхдээ үүгээрээ бид нэн бардамнадаг байлаа. Бохир болсон цамц, тос болсон брезент өмдөөрөө бахархана. Надад техникийн авьяас байхгүй боловч нэгэнт ажилласан л бол ажиллах юм бол дайтай ажиллах хэрэгтэй. Игорийг гялалзсан хавтсаа сугавчилсаар гарашинд хүрч ирэхэд бид:

— Азнаж бай, зав алга. Харахгүй байна уу? гэнэ.

Ийм хариу дуулаад Игорь уур нь шатах боловч үүнийгээ мэдэгдэхгүйг хичээнэ.

Өнөөдөр ч бас ингэлээ.

Шмаков бид хоёр машинаас шатсан дуу намхруулагчийг авч байв. Үүнээс яршигтай ажил гэж байхгүй. Нүхэн дотор зогсож, шатсан дуу намхруулагчтай ноцолдоно. Ажиллахад эвгүй, гар хүрэхгүй. Эрэг шураг нь зэвэрчихсэн учир эргэж өгөхгүй, дийлдэхгүй мах иднэ. Шмаков хар чадлаараа ноцолдон шуухитнах боловч ажил урагш ер ахихгүй байлаа.

Тэгтэл нүхний амсар дээр Игорь хүрч ирээд явган сууж эелдгээр

— За ажилч найз нар сайн! гэлээ.

— Сайн гэж би тун дурамжхан хариулав. Шмаков огт ам нээсэнгүй.

— Төнхөж байна уу? гээд бидний хариу хэлэхийн завдалгүй

— Өнөөдөр ажил тараад бүх дадлага хийгчдийн хуралтай. Заавал ирэх хэрэгтэй гэсэнд

— Өнөөх нь эхэллээ гэж би бувтнав.

— Юу гэж бувтнаад байна аа гэж Игорь ялдамхан асуув.

— Чиний наад хурлаас чинь залхаж гүйцлээ.

— Би хийлгэх гэж байгаа юм биш ээ. Ерөнхий инженер, Наталья Павловна хоёр цуглуулж байгаа юм гэж Игорь мөн л эелдэг гэгч нь хэлэв.

Наталья Павловна бол манай анги даасан багш билээ.

— Би та нарт хэллээ шүү гээд Игорь гялалзсан хавтсаа сугавчилсаар цааш явав.

Шмаков бид хоёр ажлаа хийсээр хоцров. Золигийн дуу намхруулагч ер дийлдэхгүй цухал хүргэнэ. Бид засварчин Лагутинтай хамт ажиллаж байлаа. Энэ бол тун нүдэнд хүйтэн этгээд байгаа юм.

Хүдэр, цэвэрхэн залуу. Гэхдээ маш дээрэлхүү, ялихгүй юманд ч адгийн муухай хараал тавина. Ингэхдээ царай нь догширч минчийн улайгаад, галзуу юм шиг болчихно. Лагутин намайг басамжлах гэдэг юм бол мөчөөгөө өгөхгүй юм шүү гэж би хатуу шийдэв.

Биднийг дуу намхруулагчтай ноцолдоод удаад байхлаар Лагутин нүхэнд орж ирэв. Гэхдээ намайг чанга гэгч нь түлхээд авлаа. Нүх давчуу болохоор нэгийгээ шүргэхгүй байхад хэцүү. Гэвч Лагутин намайг тэгэхээс тэгэх гэж түлхсэн гэдэгт би эргэлзсэнгүй

— Түлхэхгүй байж болохгүй байна уу? гэлээ.

Лагутин хариу хэлэх үгээ олсонгүй зөвхөн над өөд бүлтийн харав. Тэгж тэгж нэг юм дуу намхруулагчаа салгаж аваад нүхнээс түүнийг татаж гаргатал Лагутин Шмаковыг зүв зүгээр байтал нь хараав

Шмаков өөдөөс нь тоосон ч шинжгүй бас хараалаа.

— Хэрэлдвэл өөрийнхөө өчүүхнийг л харуулж байгаа хэрэг гэж намайг хэлэхэд Шмаков Петр

— Яадаг юм, би ямар мундаг эрдэмтэн биш гэв.

Зинатай Лагутины харьцаж байгаа нь зэвүүг минь тун хүргэнэ. Зина автобазын бүртгэгч бүсгүй билээ. тэр бээр Лагутинд дурлачихсан бололтой. Өдөр зуу дахин гараашинд ирнэ. Хэн нэг хүнийг эрж байгаа дүр үзүүлнэ. Гэтэл гараашинд эрээд байх хүн үгүй. Ер нь хүн дуудах хэрэг гарвал «жолооч тэрийг бүртгэгч дээр дуудаж байна» гээд радиогоор дуудаж болох шүү дээ.

Зина гарааш дотуур явж Лагутиныг харна. Цаадах нь хайхрамжгүй царайлна. Зинаг дэргэдээ очиход Лагутин хөмсөг зангидан, завгүй байгаа дүр гаргана. Зина холдон явна. Бүсгүйг харахаас өрөвдмөөр. Тэгж царай алдаж яаж болох билээ.

Шмаков энэ тухай:

— Зина юунд түүнийг дагаж гүйнэ вэ? Лагутин түүнтэй явах албатай биш шүү дээ. Маанаг юм гэнэ.

Би бол Зинаг өрөвдөнө. тэр бээр Лагутиныг учир утгагүй ялаа гэж хоргоох вэ. Лагутин түүнтэй явж байгаад хаячихсан ч юм билүү?

Хархүү нь ер хайхрахгүй байхад түүнд бүсгүй дурлалчиг удаа байдаг. Гэвч ийм тохиолдол өдрийн од шиг. Би ийм тохиол ганцыг л мэддэг юм. Манай ангид Флерова Надя гэдэг охин сурдаг. Гялалзсан нүдтэй, горзгор охин. Катанскийн Майкатай тэр үерхдэг. Гэтэл Майка сургуульдаа хамгийн царайлаг охин билээ. Нэг нь Майкад сэтгэлтэй болбол Флерова Надя тэр хүнд дурлана.

Ийм явдал гарах нь ховор. Флерова Надя найздаа жөтөөрхөхдөө дурлаж байгаа юм. Магадгүй, найзын сэтгэлийг бодож тэгдэг ч байж мэдэх юм.

Майка Катанская, Надя Флерова хоёр бүрээслэх тасагт дадлага хийж байв. Тэнд суудал засаж, брезент бүрээс, багажийн цүнх гэх мэтийг оёно. Майкаг бааз дундуур явахад цөмөөрөө түүн рүү нүд бэлчээнэ. Майка бол тийм хөөрхөн, гоолиг, урт салаа гээгтэй охин билээ. Цугаараа түүнийг ширтэх нь надад эвгүй санагдана. Хүний араас харна гэдэг ямар гээч зуршил вэ?

Лагутин бас Майка руу нүд тавина. Майка түүнд аятайхан санагдаж байгаа нь илт. тэр бээр гэнэт бүрээслэх тасагт машины суудал аваачиж өгөв. Уг нь сайнаараа суудал байсан юм. Гэтэл Лагутин засаж янзлах хэрэгтэй гэлээ. Орой харихаар гартал Лагутин хаалган дээр зогсчхоод Майкаг ширтэж байв. Тэгээд Надя Флерова тэр хоёрт нэг юм хэллээ.

Чухам юу гэж хэлснийг би олж сонсоогүй. Хэрэв Майка Лагутинд хариу хэлбэл түүнийг үүнээс хойш ойшоохоо ч байя гэж би тэр хооронд шийдэв. Нэр төрөө хамгаалж чаддаггүй эмэгтэй хүнийг ингэхээс өөр яах билээ дээ.

Майка эргэж ч харсангүй.

Би үүнд туйлгүй баярлав.

— Харин Надя Флерова эргэж харлаа. Надя Флерова над падгүй ээ!..

Бид дуу намхруулагчийг аваад гагнуулахаар өгөв. Дараа нь тэндээс авчирч угсрах гэж нэлээд удлаа. Дуу намхруулагчийг тавих нь авахаасаа бүр ч адармаатай, түүнийг тэгш барих хэрэгтэй, гэтэл удаан барихад гар чилнэ.

Энэ машиныг гараас гаргахад одоо урд дугуйных нь холхивчийг солих хэрэгтэй байв. Холхивчийг агуулахаас би түрүүнд авчирсан. Гялтгар, тостой цаасан боолттойгоо вандан дээр хэвтэж байлаа. Түүнийг Лагутин өөрөө тавих ёстой. Гэтэл мань эр байсангүй, тэр бүрээслэх тасагт эргүүлдэж яваа. Би тийшээ явлаа.

Лагутин вандангийн ирмэг сандайлчихсан додигорхон сууж тамхи татаж байна.

Майка машин торчигнуулж, Флерова Надя гараар оёж, мастер Иван Кузьмич шалан дээр хиймэл илэг эсгэж суулаа.

— Холхивч тавих боллоо гэж би Лагутинд хэлэв.

Тэр бээр дуугарсангүй.

Би ч дахиж хэлсэнгүй. Миний хэлснийг тэр сайн дуулсан.

Би охид дээр очив. Лагутин шиг ийм дээрэнгүй этгээд тэдэнтэй яаж ярихыг сонсох нь над сонин байв. Гэвч тэр бээр дуугүй сууна. Би түүний яриаг тасалсан ч байж магад. Эсвэл миний дэргэд тэр ярихыг хүсэхгүй ч байгаа байж мэдэх юм. Намайг ирэхээс урьд ярьдгаа ярьчихсан байж болзошгүй.

Гэнэт бүртгэгч Зина тасагт орж ирээд үүдэнд зогслоо

Одоо ялихгүй цуугиан гарна гэж бодоод би үүнд нь олзуурхав.

Лагутин гэдэг ямаршуухан эр болохыг Майка үзэг.

— Нөхөр Лагутин, түр уулзах уу? гэж Зина өрөвдөм дуугаар өгүүлэв.

Лагутин хэнэггүй царайллаа.

— Бас юу гээ вэ?

— Түр уулзъя гэж Зина дахин хэлэв.

— Лагутин хөмсөг зангидан:

— Ямар гээч нууц юм гарав? гэлээ.

— Ажил байна гэж хөөрхий Зина өгүүллээ.

— За яах вэ, танай өрөөгөөр очимз гэж Лагутин дуу гарч ядан хэллээ.

Зина жаал зогссоноо эргэж цехээс гарч одов.

Би инээмсэглэчхэв.

Лагутин намайг хялайж

— Юунд ярзайгаад байна гэхэд

— Яадаг юм, чиний шүдээр ярзайгаагүй. Холхивчоо тавьсан нь дээр байхаа. бид хуралд орлоо гэж өчив.

«Дээр байх» гэж намайг хэлэхэд мань хүний царай барс гээд явчихлаа. Миний егөөдсөнийг ойлгожээ. Тэгээд

— Та наргүй дөнгөнө өө гэж гүвтнэв.

— Өөрөө л мэд гээд би тасгаас гарав.

Ажил тараад бид хашааны цулгайд, хуучин Газ-51 машины дэргэд сууцгаалаа. Энэ машиныг акталжээ. Хэрэггүй учир үүнийг задлах ёстой байсан юм..

Игорь хурал нээв. Бид долоо хоног ажиллав. Одоо дүнгээ гаргах цаг болж гэж тэр хэллээ. Гэхдээ юуны өмнө дарга, нарийн бичгийн дарга сонгох хэрэгтэй гэв.

Даргаар өөрийг нь сонголоо. Манайхан Игорийг дандаа даргаар сонгодог юм. Нарийн бичгийн даргаар намайг сонгох гэв. Тэгэхэд нь би алхаар цохичихсон чинь гар хөндүүрлээд байна гэж шалтаг заалаа. Энэ ч аль дивангарын юм, тэр тухайгаа таг мартчихсан байсан юм. Харин одоо аз болоход санаанд оров. Надад үнэмшлээ. Миний оронд Макароваг нарийн бичгийн даргаар сонгов.

Хуралд манай ангийн багш Наталья Павловна, автобазын ерөнхий инженер хоёр ирэв. Яагаа вэ, биднийг анх ирэхэд тасгуудаар дагуулж явсан нөгөө хүн. Тэгсэн чинь манай дадлагыг удирдаж байгаа юм санж. Гэтэл би үүнийг мэдээгүй байдаг. Та нөхдөд автобазын захиргаа тохиромжтой нөхцөл бүрдүүлж өгсөөн. Бүх хүүхдийг дур сонирхол, авьяас билэг, хувийн зан чанарын нь дагуу хуваарилсан. Нийт тасаг, бригад та нарыг их анхаарч байгаа. Ер нь бүх юм бүтэмжтэй байна. Та нарыг хөдөлмөрийн дүйтэй болно гэж найдаж байна. Гомдолтой хүн байвал түүнийгээ ярь, дуртайяа хүлээж авна гэж ерөнхий инженер ярилаа.

Гэвч царайг нь харахад тавьсан гомдлыг сонсохдоо тийм ч их баярлахгүй нь илт байлаа.

Цөм дуугүй сууцгаан, гомдол тавих хүн гарсангүй.

Тэгтэл Игорь ерөнхий инженертэй санал нэгтэй байгаагаа хэллээ. Дадлага сайн болж байна. Баазын захиргаа бидэнд маш сайн хандаж байна. Бүх хүүхэд мундаг амжилт олсон. Хоцорч яваа хүн байвал өөрийнх нь буруу, өөрөө ахих хэрэгтэй гэнэ. Гэвч чухам хэн хоцорч явааг Игорь хэлсэнгүй. Хэнийг ч гомдоохгүйг тэр хичээдэг юм.

Угтаа бол дадлага тэдний ярьж байгаа шиг тийм ч урагштай биш байлаа. Жишээлбэл Шмаков бид хоёрыг аваад үз л дээ. Бид хоёр сүүлийн хоёр өдөр л хүн шиг ажилласан. Үүнээс урьд гар хөлийн үзүүрт л зарагдаж байв. Механикийн цехэд ажиллагчид одоо болтол хийсэн юмгүй байгаа. Ажилчдын ард зогсчоод, тэдний онд ондоо

суурь машин дээр хэрхэн ажиллахыг нүд хужирлана. Бид тэднийг «арынхан» гэдэг. Тийм нэг «арын» этгээд Солоухин миний хажууд сууж байлаа. Би түүнийг ярь гэж түлхээд авав. Солоухин гараа сэгсрээд үүнд орооцолдохыг хүссэнгүй.

Тэгэхэд нь би:

— Зарим хүүхэд юу ч хийхгүй, зүгээр л харж суух юм гэж хэлээд тавьчихав.

— Үгүй ээ, тэд харж байгаа юм биш, ажиглаж байгаа юм. Эд чинь ажиглах дадлага хийж байгаа улс гэж ерөнхий инженер хэллээ.

Бүх юм бүтэмжтэй сайн байгаад Наталья Павловна багш маань учиргүй баярлав. тэр бээр ажил бүтэлтэй байвал баярлах нь ч амархан урагш муутай байвал гомдох нь ч амархан хүн дээ. Тэгэхлээр түүний урмыг нь хугалахыг хүссэнгүй. Нас нь дээр гарсан, зүрх муутай юм. Тэгээд ч би ерөнхий инженерийн үгийг сөргөсөнгүй.

Наталья Павловна ажил бүтэмжтэй байгаад баярлаж байгаагаа хэлэв. Гэхдээ дадлагыг сургалтын үйл явц, хичээлийн хөтөлбөртэй холбох хэрэгтэй гэлээ. Бид ажиллаж байхдаа хичээл дээр үзсэн бодисын зүй, хувилахуй ухааны хуулийг үргэлж бодож байх хэрэгтэй гэнэ. Эдгээр хуулийг үйлдвэрлэл дээр харж хийж байгаа зүйлтэйгээ холбох ёстой гэнэ.

Бид Наталья Павловнагийн хэлснийг зөвшөөрөв. Ер нь бид хэлснээс нь зөрдөггүй билээ. Яах вэ ярьж л байг.

— Нөхөд өө! Би та нарын ажлын бүртгэлийг хараагүй минь тоогүй юм боллоо. Гэвч хүн бүр өдөрт рубль гучин копейкоос доошгүй ажил хийж байгаа байх гэж бодож байна гэж ерөнхий инженер хэлдэг байна.

Үүнд нь цугаараа хөл хөөрцөг болов.

— Анхаарч бай! Нэг чухал санал байна гэж Игорь ихэмсэг хэлэв.

Гэвч хүүхдүүд хөөрсөн сэтгэлээ дарж чадахгүй байв. Өдөрт рубль гучин копейк гэнэ ээ! Ийм их мөнгө авна гэж хэний ч зүүдэнд орсонгүй. Даан ялангуяа охидын... Тэднүүс хөхрөлдөж, жиг жуг гэлцэн байгааг нь харахад мөнгөө яаж зарах тухай л ярилцаж байгаа бололтой.

— Хүүхдүүд ээ, чимээгүй. Хэчнээн чимээгүй сууна вэ, төдий чинээ хурдан хурлаа дуусгана гэж Наталья Павловна хэлэв,

Багш биднийг дандаа тэгж чимээгүй болгодог юм.

Хүүхдүүд чухал саналыг нь сонсохыг хүсэхгүй байгаад харин Игорь маш их гомджээ. Төлөв томоотой хэр нь адайр зантайг яана. тэр

бээр нялх хүүхэд шиг болж хошуугаа цорвойлгон гоморхов.

Сонирхохгүй байвал ярихгүй байсан ч болно.

— Энэ бол чамин үг. Игорь ямар ч байсан ярихаасаа буцахаар хүн биш. Цөм нам гүм болмогц түүний элсэн нь

— Наталья Павловна маш зүйтэй юм хэллээ. Бид ажлаа хичээлтэйгээ холбох хэрэгтэй юм. Иймд бид нэг чухал санал оруулах байна гээд Игорь бидний шохоорхол татаж, үгээ жинтэй болгох гэж зогсосхийв. Энэ бол уран илтгэгчийн болхи арга, гэвч Игорь ингээд зорьсондоо хүрч нам гүм болгодог байв. Би энэ аргыг ашиглаж ер чадахгүй юм. Намайг зогсосхиймэгц л хэн нэг нь ярьж гардаг байв.

Игорь үгийг нь бүгдээрээ чагнаж байгаад итгэснийхээ эцэст их л хөхиүн

— Ангийнхаа нийтийн хүчээр энэ актлагдсан машиныг сэлбэн засаж, сургуульдаа бэлэглэх санал байна гэв.

Тэр бээр бидний хажуу дахь эвдэрхий машиныг сүржин гэгч нь заав.

Цугаараа эргэж, хөөрхий болчихсон машиныг харлаа. Машин огт мэдэхгүй хүн ч арчаагаа алдсаны нь андахгүй мэдэхээр байв. Доогуур нь мод ивж, хэрэгтэй гэсэн болгоныг нь авч, юу ч үгүй «тоножээ».

— Энэ машин ёстой ямбий болжээ. Ажил их орно. Гэвч бидний зүтгэл төдий чинээ дорвитой болно!.. гэж Игорь ярьсаар байв. тэр бээр бас хэдэн сайхан үг хэлэв. Энэ ямбийг бид босговол ангиа мөнхжүүлж өөрсдийгөө алдаршуулна, бидний тухай үр сад маань шагшин ярилцах болно гэж хэлэв. Үүнээс жаахан өөрөөр хэлсэн гэхдээ утга нь ийм л байсан юм.

Наталья Павловна самгардсан янзтай. Бидний хэн нэг нь санамсаргүй санал гаргахад багш дандаа сандардаг юм. Үүнийг сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч хоёр юу гэхийг мэдэхгүй дээ тэр.

— Тануус барах юм уу? гэж Наталья Павловна сэтгэл зовонгуй асуулаа. Бултаараа их далин авах болсондоо хөөрцгөөгөөд цаанатай наанатай ч сэтгэж чадахаа больжээ. «Барна аа» гэж зэрэг зэрэг хашхиралдав.

Тэгэхэд нь би

— Юуны өмнө энэ ямбийг үзье. Тэгж байж шийдэцгээе гээд үгээ үнэмшүүлэхийн тулд эвдэрсэн хэмхэрснийг нь бүртгэж, ажлын цар хэмжээг тодорхойлох хэрэгтэй гэж нэмж хэллээ.

Би ямар ончийг нь олсон үг хэлсэн гээч! Миний хэлсэн энэ зүйл хүүхдүүдэд нэлээд юм бодогдуулжээ.

Игорь хүртэл хариу хэлж чадсангүй. Гагцхүү доогтойхон:

— Чи хулчийгаа юу? гэж асуухад нь

— Үгүй чиш! Гэвч хариуцлагатай хандах хэрэгтэй гэж би хариулав.

Тэгтэл Вадим Беляев босож, хэмхэрхий машины хашлагыг чичсэнээ

— Энэ ямбийг би андахгүй. Бас ч сайнаараа байгаа юм. Юм дутагдвал би яах ихийн зуургүй л олоод ирнэ гэдэг байна

Хойно болох үйл явдалд Вадим голлон гарах тул түү ний талаар хоёр гурван үг хэлье.

Нэгд, Вадим Игорийн дотнын анд, итгэлт туслагч дагуул нь юм. Хэддүгээр ангид байхад билээ дээ санахгүй байна, бид Игорийн тухай

Тушаал зааврыг нь хүлээгээд

Түүний өмнө Вадим бөмбөгнөнө

гэсэн дуу гаргасан билээ.

«Түүний өмнө» гэсэн нь Игорийн өмнө гэсэн үг л дээ.

Хоёрт, Вадим «хэцүү сурагч». Сургууль даяар зартай наймаач байгаа юм. Мань эр марк, чихрийн цаас, чүдэнзний хайрцгийн нүүр сольж, элдвийн түүвэр зохиолыг арын хаалгаар захиалдаг бөгөөд залуучуудын их наадмын үеэр аль ч орны тэмдэг, түүгээр ч барахгүй Канадынхыг хүртэл олж ирдэг байсан юм. Вадим хөл бөмбөг, концерт, үзэсгэлэн үзэх, ер юу ч үзэх билет олж дөнгөнө. Яаж ингэж чаддагийг бүү мэд. Гэхдээ панзчин хүн бишээ. Уг нь гэм халгүй залуу. Гэвч ямар нэг юм олж, ямар нэг юм сольж байх донтой болчихсон юм. Ердөө л өвчтэй ч байж болзошгүй. Наталья Павловна Вадимыг нэг л хий тусчихсан хүн гэж бидэнд сануулж, түүнтэй ямар ч наймаа бүү хий гэж гуйдаг байв.

Дадлага эхэлсэн өдөр Вадим «Хар морьт» тамхины хайрцгийн дайтай боловч арай зузаан халаасны хүлээн авагч бааз дээр авчрав. Үүнийг хаанаас олсныг бүү мэд. Авчирч бүхэнд хачирхуулаад дахин авч ирээгүй Маргааш нь Вадим цагаан утсаар шоо дөрвөлжилж оёсон маш нарийн бариу финн өмдтэй ирсэн. Энэ нь олон халаастай аятайхан сайхан өмд байлаа. Гэвч махлаг тарган Вадимд нарийджээ.

Мань эр сууж ч босож ч чадахгүй байв. Тэр ч атугай товчилж ч үл хүрнэ. Дараа өдөр нь Вадим өмдөө үгүй хийчихсэн байлаа.

Тийнхүү Вадим өдөр бүр нэг шинэ юмаар бүхнийг хачирхуулна. Нэг бол америк машины загвартай том гоё зарлал авчирна, үгүй бол хумсан чинээхэн үнсний савтай тамхины асаагуур авчирна. Эсвэл өөр юу ч юм олж ирнэ. Ер нь авчрахгүй юм гэж үгүй. Нэг өдөр авчраад маргааш нь хааш нь ч юм алга хийчихнэ. Хэний юм гэдэг нь мэдэгдэхгүй. Вадимынх ч юм уу, өөр хүнийх ч юм уу бүү мэд. Мань хүн зүгээр түр барих гэж хүнээс авдаг ч байж магадгүй.

Гэвч эдгээр зүйлээрээ Вадим автобазад тэр дороо товойж нэртэй хүн болов. Түүнийг танихгүй хүнгүй. Гэсэн хэдий боловч Вадим «гарын үзүүрт» зарагдахыг урьтал болгож бааз дотуур дэмий хэсэх дуртай. Ямар тасагт түүний ажилладгийг ч би сайн мэдэхгүй. Нэг бол агуулахад байж байна, үгүй бол агенттай хаашаа ч юм явчихна, эсхүл Игорийн даалгаврыг биелүүлж явдаг юм.

Гэтэл тарган, цатгалан, ягаарч гэрэлтсэн хацар, ширүүн цайвардуу үстэй, том эвэр хүрээтэй шил зүүчихсэн Вадим одоо өмнө маань зогсоод яах ийхийн зуургүй олоод ирнэ гэж ам алдаж байдаг.

— За харахгүй юу. Вадим ухааныг нь ойлгож байхад чи үгүй байдаг гэж Игорь надад аальхан боловч зэмлэнгүй хэлэхэд нь би:

Ойлгож байна, харин Вадим амандаа орсныг чалчиж байна гэж хариулав.

— Үгүй ээ! Машиныг босгож болно. Би ч бас энэ талаар жаал зугаа юм мэднэ гэж Игорь зөрөв.

Ахынхаа машинтайг, өөрөө биднээс машин сайн барьдгаа битүүхэн цухуйлгав. Гэвч машин барина гэдэг нэг хэрэг, засна гэдэг шал өөр хэрэг.

— Тэгэхлээр Крош, чамд ямар ч урам зориг алга. Чи нийтийн ажилд оролцохоос хойш уллаж байх шив гэж Игорийг үргэлжлүүлж хэлэхэд би:

— Миний санааг бүү мушгиад бай. Нийтийн ажилд оролцолгүй яах вэ. Гэхдээ хий хоосон ам өгөхийг хүсэхгүй байна. Би гарашинд ажилладаг, автомашин гэдэг бүтнээрээ юу байдгийг мэднэ ээ. Давын өмнө ажлын хэмжээг тогтоох хэрэгтэй. Гарашинд ажилладгаараа Шмаков Петр хэлэг гэв.

Гэтэл Шмаков Петр дуугарсангүй. Тэртэй тэргүй дуугүй хүн, хурал дээр бүр ч юм хэлдэггүй юм. Петр шуухитнасан боловч ганц үг

дуугарсангүй.

Гэвч Вадим

— Игорийн саналыг зүйтэй гэж үзэж байна. Хүүхдүүд саналаа хэлэг л дээ гэхэд Игорь зөвшөөрч

— Нээрээ тэгэг! Крош тувт эсэргүүцэж байдаг хүн. Энэ ч түүний гэм биш зан л даа хэмээв.

Тэр намайг басамжлах гэжээ.

Механикийн цехэд ажилладаг хүүхдүүд машиныхаа эд ангийг өөрсдөө зорох уу эсвэл зүгээр л ажиглах уу гэж асуув.

— Өөрсдөө байлгүй яах вэ гэж Игорь батлаад тийм биз дээ, Вячеслав Петрович? гэж лавласанд ерөнхий инженер Вячеслав Петрович,

— Хэрэв та нар машиныг сэлбэн босгох гэж байвал өөрсдийн гараар л босго.

Гэвч түүний маш учиртай хэлсэн “хэрэв” гэдэг үгийг хэн ч анзаарсангүй. Гагцхүү өөрсдийн гараар гэдгийг л цөм анхаарав.

Моторын цехэд ажиллаж байгаа Полекутин болон бусад хүүхэд машиндаа мотор эвлүүлж лав барах байх гэж хэллээ.

Майка, Надя Флерова хоёр суудал, суудлын түшлэгийг оёхоор болов.

Элдэв цахилгаан тоног төхөөрөмж тасагт бишгүй бий, тэдгээрийг засаж янзлаад машинд тавьж болно гэж цахилгаан тасагт ажиллагчид өгүүллээ.

Рождественский, Гаркуш нар машиныг дуртай өнгөөр будахаар амлав. Резвяков гагнуурын газар ажилладаг болохоороо хэрэгтэй бүх зүйлийг гагнахаар ам гарав. Радиаторыг засаж зэс тавих, төМөрлөх бүх ажлыг хийнэ гэж Свидерский, Смирров нар хэллээ. Ер нь энэ санаа бүхнийг эзэмдэв.

— Манай ангийнхан, Крошоос бусад нь санал нийлж байх шив. Аз болоход Крош ганцаархнаа зожгирон үлджээ гэж Игорь хэлэв.

Миний хэлснийг ойлгосонгүй гэж би татгалзлаа.

— Би эсэргүүцэж байгаа юм биш, харин бодохдоо...

Игорь үгийг минь таслан, эгдүүтэй жуумалзан, эсэргүүцээгүй гэдгээ ажлаараа нотолж болно гэж хэлэв.

Яахлаараа ингэнэ вэ? Игорь ямар ч тэнэг юм ярилаа гэсэн цөм амыг дагах юм. Намайг ярихлаар наадах чинь олигтой юм огт хэлэхгүй гэсэн шиг л хүмүүсийн царай үл итгэх байдалтай бодчихно. Тэр бүрд

нь би дахиад ярьж байхгүй гэж дотроо ам тангараг тавьдаг юм. Тэгсэн хэр нь амаа барьж чадахгүйг яана.

— Одоо штаб сонгох саналтай байна. Штаб машин засах ажлыг удирдана гэж Игорь хэлэв.

— Штабаар яах юм? Хурал хийлгэж байх гэж үү? гэж би хашхирлаа.

Нээрээ ямар ч штаб хэрэггүй. Хэн ч хуралдахыг хүсэхгүй байна хэмээн цугаараа бархиралдав.

— Энэ зүйтэй гэж Игорь гэнэт зөвшөөрч, штаб хэрэггүй юм байна. Гэвч ажлаа зохицуулж байхын тулд ахлагч сонголгүй горьгүй гэв.

Мань хүн дарга болох гэжээ.

Тэгэхэд нь би техник хамгийн сайн мэддэг Полекутиныг сонгох санал гаргав.

— Полекутин техникт хэнээс ч илүү. Полекутин ахлагч болог гэж би хэллээ.

Гэтэл бялдууч Вадим татгалзаж

— Ахлагч хүн зохион байгуулах авьяастай байх хэрэгтэй.

Тэгэхлээр би Игорийг сонгох саналтай байна. Игорь Конторт ажилладаг болохлоор ажлын эвийг олоод байна. Харин Полекутиныг техникийн талыг хариуцсан орлогчоор сонгоё гэв.

Бүгдээрээ үүнийг зөвшөөрлөө. Игорийг даргаар, техникийн талыг хариуцсан орлогчоор Полекутиныг сонгов.

— Өөрсдөө мэд, гэвч хангамж хариуцсан туслагч хэрэгтэй.

Вадимыг сонгоё, овсгоотой эр шүү гэж Игорь хэллээ.

Вадим овсгоотой нь ч овсгоотой. Гэвч даварч мэднэ. Тэгээд:

— Би зөвшөөрөхгүй гэж намайг хэлэхэд Игорь:

— Яагаад гэж асуув.

Учрыг нь би хэлье гэсэнгүй.

— Үгүй л гэж байна, гүйцээ!

— Дургүйцэж байгаагийнхаа учрыг тодруулах хэрэгтэй гэж

Игорийн шалгаахад би:

— Цаадах чинь чиний найз гэж хэлээд тавьчихав.

Бултаараа инээд алдав. Игорь дахиад эгдүүтэй жуумганалаа.

— Энэ ч татгалзах шалтгаан биш дээ.

Ханган нийлүүлэгчээр Вадимыг сонголоо.

Тэгэхэд Игорь

— За харахгүй юу, Полекутин, Вадим бид гурав миний түрүүний хэлээд байсан нөгөө штаб чинь байхгүй юу гэлээ.

Үүнийгээ штаб гэж нэрлэж л байг гэж тогтоцгоов. За яах вэ тэгж л хүсэж байгаа юм бол түүгээрээ л болог!

— Одоо цех бүр ахлагчаа сонго гэж Игорь хэллээ. Цөмөөрөө сонгож гарлаа.

Гараашинд Шмаков Петр бид хоёр хоёулхнаа ажилладаг. Шмаков маань намайг ахлагчаар сонгов.

Энэ хурал сэтгэлд минь нэг л сэв суулгав. Хүүхдүүд урагшгүйхэн ярьсныг минь л бодон бодон намайг шоолж байгаа мэт надад бодогдож байлаа.

Би машин засахаас дургүйцсэн гэж үү? Өөр хүн жишээлбэл техник хамгийн сайн мэддэг Полекутин биш, Игорь үүнийг санаачилсан нь надад тусгүй санагдана. Полекутин бол ажил болгохын тул үүнийг сэдэх байсан, харин Игорь мундаг хүн болж харагдахын тулд ингэж байгаа юм.

Игорь ямар нэг юм эхлэн үүсгэж санаа сэдэн, чимээ шуугиан дэгдээчихдэг, гэтэл тэр ажил нь нурахлаар бид л буруутай болж таардгийг би юу эс андах билээ. Энэ явдал бүү давтагдаасай гэж би бодсон юм.

Хурал дээр чухам ингэж л хэлдэг байж дээ. Игорийн санаачилж байсан зүйлийн тухай сануулж, урьдынхаас жишээ дурдсан бол уу. Тэгсэн бол хүүхдүүд зөв зөв гэж хашхиралдаж гарсан даа. Игорь Вадимтайгаа хоёулхнаа шившгээ хутгаж хоцрох байсан юм.

Гэвч хурал өнгөрчээ. Энэ үгээ хэлэх хөг ч өнгөрч. Би үүнийг ерөнхийд нь Шмаков Петрт хэллээ. Гэтэл Шмаков

— Орхи! гэж хэлдэг байна.

Тэгэхлээр нь Полекутинд хэлсэн чинь тэр бас л

— Орхи! гэв ээ.

Полекутиныг өндөр, булиа болохоор нь бид «аав» гэдэг юм.

Шмаков тэр хоёр ангидаа хамгийн чадалтай нь билээ.

Миний урагшгүйхэн ярьсныг санаж яваа хүн үгүйг би түдэлгүй мэдлээ. Вадим хүртэл өөрийг нь сонгохоос татгалзсаныг таг мартсан ажээ. Ер нь Вадим ч хөнгөн хүн дээ.

Вадим одоо Игорьт тусалж байна. Игорь ирмүүн ажиллаж, бас нэг гялалзсан хавтас олж авчээ. Үүндээ машин сэлбэж босгох ажилтай холбоотой материалыг цуглуулж хийнэ. Бидний санаачилгыг эдгээр цаасан дээр сайшаасан бий. Игорь тэр ч байтугай районы намын хороогоор оржээ. Тэнд бидний санаачилгыг бас сайшаасан байна. Харин бичиг цаас өгсөнгүй «явж ажилла!» гэжээ.

Цоохор цаас ямар хэрэгтэйг би ухаарахгүй юм. Бичиг цаас хэрэггүй, сэлбэг хэрэгсэл хэрэгтэй.

Игорь цаас цуглуулаад гүйж явдаг, гэтэл машин нь эзгүй хэвтсээр л байлаа. Ажилчид биднийг даажигнах болов.

Засварчин Коська

— Марзан амьтад гэв.

Бригадын дарга Дмитрий Александрович,

— Жүжигчид гэж хэллээ.

— Ажилчид бидний амыг асууж байна гэж Шмаков Петрт би хэлсэн чинь өөдөөс аанай л

— Орхи! гэдгээ хэлэв.

Би моторын цехэд Полекутин руу очлоо.

— Нэг юм сүвэгчлэлгүй болохгүй нь.

— Би юу хийдэг юм? гэж Полекутины асуухад нь

— Юу юу гэж? хэмээн би гайхаж чи чинь техникийн талыг хариуцсан орлогч шүү дээ. Бодох хэрэгтэй.

— Үүнийг Игорь л санаачилснаараа бодож байг.

— Тэгвэл чи яагаад хурал дээр хэлээгүй юм бэ?

Энэ асуултад мухардсан Полекутинд хэлэх үг олдсонгүй.

Тэгэхэд нь би,

— Ажил тараад цуглаж энэ ямбийг үзье гэв.

Ажлын дараа бид чөлөөнд цугларав. Шмаков Петр, Полекутин, цахилгааны тасгийн Гринько, угсрах тасгийн Таранов бид хэд уулзлаа. Асуудлыг нарийвчлан шийдвэрлэхийн тулд би тэднийг дуудсан юм.

Хэдүүлээ хамрыг нь сөхөж хөдөлгүүрийг үзэв. Хөдөлгүүр нь бохиртож, бялт ч үгүй, ремень ч үгүй, ер нь авах юмгүй ажээ.

— Хөдөлгүүр ямар янзтай байгааг би хэлж мэдэхгүй байна.

Үүнийг авч задлан үзэх хэрэгтэй гэж Полекутин хэлбэл Мишка Таранов

— Хурд тохируулах хайрцаг мөн хойд урд мостыг авах хэрэгтэй. Авч үзье. Тэгж байж л чухам яасныг нь харья.

Гринько харин тодорхой гэгч нь

— Машинд цахилгаан тоноглол юу ч алга гэв.

Шмаков Петр:

— Хянах самбарыг нь авчхаж гэлээ.

Хянах самбар байдаг газар нь шалбарсан утас цухуйж байв.

— Суудлыг нь аваад явчхаж гэж Шмаков нэмэрлэв.

Кабинд суудал байсангүй.

Бид яах тухай ухаан зарж гарлаа.

— Аль вэ, гэмтсэн зүйлийнх нь бүртгэлийг гаргаадахъя гэж би санал тавилаа. Энэ нь машины бүх эвдэрхий зүйлийг заасан бүртгэл юм.

— Түүнийг хаанаас олох вэ? гэж хүүхдүүдийг асуухад би

— Одоохон олоод ирье гээд гарааш руу гүйв.

— Лагутины вандан дотор тийм бүртгэл багцаараа хэвтэж байгааг би харсан юм. Хэвлэмэл бүртгэл байсан юм. Машины бүх эд ангийг тэнд тоочсон байна. Эд анги бүрийн ард бүтэн, эвдэрхий гэсэн тэмдэг тавих хэрэгтэй. Их догь бодож олсон эд.

Хүмүүс үдийн цайндаа явчхаад гарааш эзгүй байв. Би ванданг онгойлгож үзэхэд шургуулга дотор боодолтой бүртгэл байлаа. Энэ боодлыг автал дороос нь хоёр холхивч гарав. Уржигдар Лагутин бидний тавих ёстой байсан Лагутины өөрөө тавьчихъя гэсэн нөгөө холхивч яах аргагүй мөн дөө. Тэр холхивч тостой цаасаар боодолтой хэвтэж байв. Хажууд нь миний үзүүлж байж агуулахаас энэ холхивчийг авсан, миний гарын үсэгтэй нэхэмжлэг байж байна.

Юу гээч нь энэ вэ? Машин засвараас аль язгуурын гарсан байдаг, гэтэл холхивч энд хэвтэж байдаг. Лагутин сольж тавихаа мартчихсан байж таарах нь. Машин хуучин холхивчтойгоо засвараас гарч. Лагутин ч салан эр юм даа.

Би хүүхдүүд дээр эргэж очив. Манайхны дэргэд жолооч Зуев зогсож байв.

— Энэ машинаар оролдоод нэмэргүй ээ. Шинийг цуглуулж босгох ч үүнээс амархан гэж Зуев гуай хэлэв.

Зуев сахлаа ер хусдаггүй хачин зантай хүн. Хүн сахлаа хусахгүй бол ёстой бавгар сахалтай болчихно шүү дээ. Хааяа нэг ч атугай авдаг бол нэг өдөр сахалгүй явах шүүдээ. Гэтэл Зуевын шөвгөр шар сахал нь нэг л янзаараа ургах ч үгүй, ахарсах ч үгүй.

Туранхай, үг цөөнтэй жолооч хүн. Гэвч ямар нэг алдаа таргасан учир тэргийг нь аваад гараашинд шилжүүлжээ. Тэр ч атугай машин барих эрхий нь түр хассан шиг санагдаж байна. Санаанд орохгүй байна. Түүнийг би сонирхсонгүй. Нэг л ноомой хүн. Ганц яриа таардаг хүн нь гэвэл манай Шмаков Петр. Хоёулаа ярьж хөөрөх дуртайг яана. Сэрүүн газар ганц нэг үг солиод хагас цагаар суучихдаг юм.

— Пионерын зусланг мэдэх үү гэж Зуев асуув

— Мэдэлгүй яах вэ гэж бид хариуллаа.

— Тэнд бас нэг актлагдсан машин бий. Үүнээс эрх биш танагтай. Үүнтэй ноцолдоод сарын гарз гээд Зуев явав.

— Ямар ч тус байхгүй гэж Полекутин өгүүллээ. Машин босгоно гэдэг бараг л хоёр мянган рубль ордог юм гэж нотолж гарлаа. Полекутин техник зэгсэн мэддэг билээ.

— Чи тэгээд хурал дээр хэлэхээ яасан юм бэ? гэж би асуув,

— Ямар янзтайг нь мэдэхгүй байсан юм чинь.

— Уухай! Би эхлээд үзье ээ гээгүй юу

— Чиний тэгж хэлснийг санахгүй байна. Чиний юу гээд байгааг хүн ер нь ойлгоно гэж үү. Харин энэ сэгийг хог дээр хаяхад болно гэж Полекутин хариулав.

— За яах вэ, нэгэнт үзэж харсан болохлоор гэмтлийг нь бүртгэе гэж би буурь зааж хэллээ.

Гэмтлийн бүртгэлд «засварт», «байхгүй» гэдэг хоёрхон үг л бичих хэрэг гарав. Хөдөлгүүр нь засварт, зай хураагуур нь байхгүй, араа залгуур засварт, динамо байхгүй гэхчлэн бүгдийг нь тийнхүү бичлээ.

Тэгж тэгж гэмтлийг нь бүртгэж аваад байтал Игорь, Вадим хоёр хүрч ирэв. Игорь өнөө зартай хавтсаа барьжээ Вадимын гарт юм байсангүй.

— За сайн! Юу хийж байна? гэж Игорь асуув.

Юу хийж байгаагаа би тайлбарлалаа.

— Овоо л доо.

Игорь гишгүүр сандайлан сууж хавтаснаасаа бэхт үзэг гарган нэг юм бичиж эхлэв.

— Чи юу бичээ вэ гэж бид асуулаа.

Тэр бээр хариу дуугарсангүй, бичсээр л байв. Тэгээд бичсэнээ амандаа нэг уншсанаа дараа нь:

— «Нөхөр Полекутин, Крашенинников, Шмаков, Гринько, Таранов нарт гэмтлийн бүртгэлийг гаргаж, штабт өгөхийг даалгасугай» хэмээн чангаар дуудав.

Бид юу гэхээ мэдэхгүй дуугүй зогслоо.

Ганц Вадим л

— Энэ бүртгэлээр бүгдийг би хоромхон зуур олно гэж хэлэв.

Игорь Вадим руу бодлогошронгуй харснаа:

«Хангах ажил хариуцсан туслах Вадим Беляевт сэлбэг хэрэгсэл олохыг даалгасугай» гэж нэмж бичлээ.

— Одоо ч ул шагайгаад нэмэргүй ээ, баримт сэлт зохих ёсоороо боллоо гээд Игорь энэ цоохор цаасаа ямар нэг хүнд сурталтны амыг таглах гэж л хөтөлдөг хүний дүртэй нүдээ онийлгов.

Игорь өөрөө яах аргагүй хүнд сурталтан гэдгийг бид ойлголгүй яах билээ.

Шмаков, Игорь, Вадим бид дөрвүүлээ гэрийн зүг явлаа. Бид хэд нэг гудамжинд суудаг юм. Шмаковынх, манайх хоёр нэг байшинд, Игорь Вадим хоёрынх хажуугийн байшинд байдаг билээ.

Хэдэн жаал хашаанд бөмбөг өшиглөж байгаа харагдлаа. Бид тэднийг баярлуулахаар шийдэв. Биднийг өөрсөдтэйгөө тогловол тэд ганц бах нь ханадаг юм.

Тарган Вадим онгод нь орсон юм шиг харайлгаж, “туучуулах” боловч хаалга үл ононо.

Шмаков харин нэг газар зогсчихоод бөмбөг ирэхийг анана. Бөмбөг очиход хажуугийн хашаа руу өшиглөчихнө.

Игорь сүрхий хүн болж харагдах гэж тоглоно. Бөмбөг ямар лут оруулдгаа бүгдэд харуулах гэжээ. Өөртөө бөмбөг дамжуулахыг шаардана. Бөмбөгөө хаалганд оруулж чадахгүй бол биднийг муу дамжууллаа гэнэ. Өөрөө хүнд дамжуулна аа гэж нэг байхгүй.

Бид арван таван минут хэртэй бөмбөг хөөв. Тэгснээ дургүй хүрлээ. Бас жаалууд ч гоншгонолдов. Ганц ганцхан ч болсон өшиглүүлсэнгүй гэж урвайцгаалаа. Өдий аяганы чинээнээсээ цор цор гэж сурах нь уу хэмээн шазрууныг нь бид эцгийн ёсоор ялихгүй сургав. Гэхдээ бөмбөгийг нь өгсөн л дөө. Яах вэ наадаж л байг.

Бид газарт зоосон ширээ тойрон суулаа Оройдоо энд даалуу тавьдаг юм. Харимааргүй байв. Зургаадугаар сарын нарлаг өдөр байлаа. Хотын төв дэх шиг тийм бүгчим нозоорсон биш, сэрүү татаад сайхан.

Манай энд сайхан агаартай! Москвагийн бусад районыхоос¹ хавьгүй дээр онцлог агаартай.

Бид хотын захад суудаг юм. Захад ч гэж дээ зах байсан газар суудаг юм. Одоо энд орон сууцын барилгууд босжээ. Цэлгэр, цэлгэр гудамжны хоёр талаар зургаагаас найман давхар байшин ярайна.

Урьд нь энд тосгон байсан юм. Тэр тосгоноос үлдэж хоцорсон хэц, жалга, чулуу дэвссэн энхэл тонхол зам, хоршоо, гудамжиндаа ганцхан байсан автомат утас, арын хашаануудад одоо хүртэл хаа нэг байгаа байшинг би санаж байна.

Аль дивангарын «Дедюкийн ой», «хэц», «цөлөх жалга»... зэрэг нэрийг өнөө болтол бид хэрэглэдэг юм. Жалга, хэц одоо ор ч байхгүй. Ойгоос хэдхэн мод үлдсэн бөгөөд тэнд цэцэрлэг байгуулахаар завдаж байгаа юм.

Бид хэд хашаанд модон ширээ тойрон сууж, сайхан агаараараа ханатал амьсгалж байлаа.

Игорь өөрийнхөө ажиллаж байгаа конторын тухай инээдтэй нь аргагүй ярина. Игорь томчуулын дунд эргэлдэх дуртай, тамхи татаж, тэдэнтэй ихэмсэг ярилцдаг авч далдуур тэднийг элдвээр шоолно.

Игорь конторын ажлын дутагдлыг маш уран инээдтэй уудална.

Гараашны ажлын дутагдлын талаар би яримаар байлаа. Гэвч бидэнд хэлчихмээр онцгой дутагдал ер байсангүй. Азаар нөгөө холхивч санаанд орж:

— Манай тэнд ч хүний санаанд оромгүй юм гарах юм. Машинд шинэ хэрэгсэл захиалж аваад тавихаа мартчихсан байдаг гэлээ.

Тэгээд Лагутины вандан дотор байсан холхивчийн тухай ярив.

Игорь өөдөөс минь:

— Крош минь, чи мөн ч гэнэхэн байна даа гэж ялдамхан айлдав.

Вадим унаж тусан хөхөрч:

— Ёо, ёо Крош элэг хөшөөчихлөө гэв.

Шмаков хүртэл муухан мушилзлаа. Би юунд инээд нь хүрсний учрыг ойлголгүй тэднийг хачирхан харлаа.

— Сонин хүн юм чи! Түүнийг чинь зориуд тавиагүй байхгүй юу. Машинд хуучныг нь тавиад, шинийг нь борлуулчихна гэж Вадимын хэлэхэд би яарч:

— Тэгвэл энэ чинь мэхэлж байгаа хэрэг. Хуучин холхивчтой машин ажиллагаанаас гарна шүү дээ.

— Гарахгүй ээ гэж Игорь миний сэтгэлийг засаж, хуучин холхивч нь сайнаараа байсан биз, тиймгүй бол хаанаас солихгүй байх вэ гэж хэлэхэд нь би:

— Ямар ч байсан луйвар гэж хэллээ

Игорь нүдээ аньсхийж:

— Хэн ч болов өөртөө жаахан ч гэсэн хожоо харах шүү дээ гэж хэлэхэд:

— Хүн бүр тиймгүй ээ, Лагутин л ганцаараа тийм гэж татгалзахад минь Игорь:

— Гэлээ ч гэсэн дажгүй. Энэ бол нэг л удаагийн явдал. Хэрэв хуучин холхивчийг сольсон бол хаячих шүү дээ. Гэтэл одоо болж л байгаа юм байна. Хэн ч тэгж их хохирсон юм алга гэв.

— Лагутин энэ холхивчийг хулгайлсан байна. Ингэх нь зөв үү гэж миний асуухад Игорь ярвайн:

— Тийм ахадсан үг хэлэх хэрэг юу вэ? «Хулгайлсан гэнэ ээ?»
Арга сүйхээлсэн хэрэг! Зуун граммын мөнгө аргалж... Холхивч ямар
үнэтэй байдаг билээ. Рубль тавь л биз... Шалихгүй юм!

— Улсынхаа юманд хуруу дүрэхлээр ямар гээч ажилчин анги
байх вэ гэж намайг хэлэхэд Игорь гараа ширвэж:

— Дэндүүлж байна гэв.

Тэгтэл нэг «Победа» хашаанд орж ирлээ. Игорьтой үерхдэг нэг
бүсгүй, хоёр хархүү түүнээс гарч ирэв. Игорь босож тэдэн рүү очлоо.

Сургуулийнхнаас гадуур, суудаг байрынхнаас өөр танил
хүүхдүүд цөмд маань бий. Энэ ч зүйн хэрэг. Заримдаа садны хүүхдүүд
байдаг. Москвагийн нөгөө захад суудаг үеэл ах юм уу, эгч байдаг юм.
Хаанаас гарч ирсэн нь мэдэгдэхгүй танил ч мэр сэр бий.

Тийм нэг танил надад ч гэсэн бий. Тэр бол Полина
Григорьевнагийн хүү Юра билээ. Полина Григорьевнатай ээж аль
язгуурт олон жилийн өмнө сувиллын газарт танилцсан юм санж. Тэд
түүнээс хойш утсаар хааяа нэг ярьдаг болсон юм. Дэвэн дэлхийн юм
хамж шимнэ. Тэдэнд яриад байх юм огт үгүй. Гэсэн мөртөө ярих
бүрдээ л заавал нүүр учрах юм сан гэнэ. Тэр хоёр жилд нэг уулзана.
Нэг жилд ээж Полина Григорьевнагийнд очно. Дараа жил нь Полина
Григорьевна манайд ирнэ «Сувиллын газрын танилууд» гэлцэнэ.

Полина Григорьевна манайд ирэхдээ Юраг дагуулж ирнэ.
Тэднийг ирэхийн өмнө ээж намайг «сэнхрүүлж гарна».

«Өнөөдөр Полина Григорьевна ирнэ шүү. Гадагш гаралгүй Юраг
зугаацуулаарай» гэнэ.

Түүнийг яаж зугаацуулахаа би мэддэггүй юм. Тэр жигтэйхэн
дүнсгэр амьтан байгаа юм. Түүнд байгалиас заяасан юм гэвэл ердөө
өндөр нуруу билээ. Аав түүний мөрөөр татна, гэтэл би аавын мөрөөр
байдаг юм. Ясан хэдрэг янхигар эр. Эгээ л асуултын тэмдэг гэсэн үг.

Түүнтэй ярих юм огт үл олдоно. Франц хэлээр хичээл ордог
тусгай сургуульд тэр явдаг. Ам ангайвал л францаар дуугарна.
Францаар сэтгэж сурч байгаа нь тэр гэнээ

Үүнээс нь би яваандаа залхаж, өмнөөс нь англиар авч гарах
болов. Дэмий донгосоод байхуйц үг би мэднэ. Бид хоёр үдэш тэгж цаг
нөхцөөнө. Түүнийг урт урт франц өгүүлбэр хэлэхэд нь би санаандаа
орсон бүхнийг англиар бурна.

Тэр явахдаа «Же ву ремерси де ту кер, пур сет суар агреабль»
буюу «энэ оройг сайхан өнгөрүүлсэнд чин сэтгэлээсээ талархлаа» гэж

хэлэхэд нь би «жон ком ин зе рум, энд оупен зе виндоу» буюу «жон тасалгаандаа орохдоо цонхоо нээдэг» гэж хариулдаг билээ. Энэ өгүүлбэрийг би аль зургаадугаар ангид байхдаа тогтоосон юм.

Ээж нар бидний гадаад хэл ямар лут мэддэгт баярлан баярлан зогсоно.

Би ийм л танилтай хүн дээ. Түүнийг хүүхдүүдээс нуудаггүй. Англиар францаар ярьж, ярьж залхуугаа хүрэхлээр Юраг хашаанд дагуулж гардаг юм. Түүнийг хүүхдүүдтэй танилцуулж, түүнийг тэдэнтэй тоглуулж, тэдэнд тийм гайхалтай хүнийг сонирхуулна. Тэр тоглоно гэж зангүй, зайдуухан зогсож биднийг харангаа хааяа францаар боддог байлаа.

Манай бусад хүүхдүүд ч хөндлөнгийн танилтай. Далим гарвал л биднийг танилцуулна. Энэ бол ердийн зүйл.

Харин Игорь бол тэгэхгүй.

Игорь найз нартайгаа биднийг танилцуулна гэж ер байхгүй. Мань хүн биднээс ичнэ. Биеэ насанд хүрсэн болгоно. Арай ахмад найз нартаа багачуултай үерхдэгээ харуулахыг хүсдэггүй юм. Биднийг жижигт тоолдог билээ.

Энэ нь бидэнд ямар пад байх билээ дээ. Бид хэнтэй ч албаар танилцах гэж зүтгэхгүй. Гэвч Игорь нэг л өөдгүй араншинтай хүн.

Найз нараа хүрч ирэхлээр биднээс холдохын түүс болно. Муухай бааш гаргана. Нөхрийн хуншгүй аашилна.

Сая ч бас ингэлээ. «Победа» явган хүний замд тулж очмогц Игорь хэрэггүй царайлж, шалавхан босоод машин руу явав.

Миний дээр хэлсэнчлэн машинаас нэг бүсгүй хоёр хархүү гарсан нь нүдэнд тусахаар хааш яаш хувцаслаж үнгэлэгдсэн өмд биеийн тамирын шагайвч, хүрэм өмсжээ. Ганцхан бүсгүй нь хүрмийн оронд судалтай ногоон цамцтай байлаа.

Тэд Игорьтой мэнд усаа солив. Нэг юм ярилцлаа. Игорь алгаа тэнийлгэн гараа өргөв. Ингэж дохивол бүх зүйлийг амжуулна гэж байгаа хэрэг. Тэгээд машинд сууж автобазын зүг одов.

Шмаков бид хоёр тэдний араас тоосон шинжгүй харж байлаа. Вадим л сэтгэл үймэрчээ. Игорь түүний хамгийн сайн анд нь гэж байгаа, гэтэл тийм мөсгүй аашилж байдаг.

Хэн буруутай вэ? Вадим л өөрөө байхгүй юу. Игорийн гарын үзүүрт зарагдаж тэгж басамжлуулж байж гэж түүнийг албадсан хүнгүй. Хүссэн юм хүзүүгээр гэдэг энэ. Гомдох гонсойх хэрэг алга.

— Игорь чамайг авч явсангүй яа гэж Шмаковыг хайхрамжгүйхэн боловч егөөдсөн шинжгүй хэлэхэд

— Тэр намайг аваад хаачих юм. Би ямар хүүхэд юм уу? гэж Вадим мангар мөрөө хавчисхийлгэв.

— Би зүгээр л тэгсэн юм гээд Шмаков эвшээлгэв.

— Кино үйлдвэрийн л залуучууд байна. Би танина гэж Вадим хэлэв.

Вадим үүгээрээ эвгүй байдалд орсноо жаал засах гэжээ. Игорьт өөрөөс нь нуудаг юм байхгүй, түүний хамаг явдлыг анддаггүй гэж Вадим харуулах гэж л дээ.

Игорь сургуулиа төгсөөд УКУДС-д (улсын кино урлагийн дээд сургууль) орохоор завдаж байгааг бид мэднэ. Олны дунд хүмүүстэй цуг зургаа авхуулж байсан. Түүний гарсан киног үзэхээр бид зориуд очиж билээ. Игорь бидний хажууд суучхаад «Тэр тэр би тэр хүний хажууд сууж байна» гэж байлаа. Игорийн зэрэгцэж суусан гэсэн хүнийг харсан боловч Игорийг өөрийг нь бид олж харсангүй. Гэвч нэг нөхөр маань кинонд гараад сая живаа хүн түүнийг үзэж байгаа нь бидэнд сайхан санагдаж, бид ч юмны учир ухаан олохгүй донгио болж харагдахыг хүссэнгүй «тийм байна, тийм байна харлаа» гэж хариулж байлаа.

Хүүхдүүд юу ч гэж хэллээ гэсэн Лагутин яах аргагүй луйварчин гэж би бодож байв. Ердийн энгийн хүн шиг тэр надтай нэг дор ажиллаж, алхаж гишгэж, ярьж хөөрч байна гэдэг сэтгэлд үл дасна. Би түүнээс нүд салгаж чадахгүй цаг үргэлж ширтсээр байлаа.

Лагутин унтууцаж:

— Яах гэж гөлийгөөд байгаа юм гэж асуув.

Гэсэн ч би түүнийг харахгүй байж үл чадна. Тэгэх тэгэхдээ цуг ажиллаж, нэг «победыг» яаралтай засаж байгааг хэлэх үү.

Энэ «Победыг» урьд ерөнхий хорооны дарга унадаг байсан юм. Гэвч яваад байх газаргүй учир машин нь өдөржингөө хаалган дээр сул зогсоно. Гагцхүү жолоочид нь цалин хий төлж байв. Одоо уул машиныг такси баазад шилжүүлэх гэж байгаа юм. Тэнд түүгээр зорчигчдыг зөөнө. Машины хэрэг гарвал дарга такси дуудаад явах болно. Улсад ч, даргад өөрт нь ч ашигтай юм. Хаалган тушаа машин сул зогсоож байхад бас эвгүй байгаа л даа.

Аж ахуйн зарим эрхлэгчид такси баазад аль муугаа шургуулахыг оролддог. Иймд таксиныхан машиныг маш чамбай хүлээж авдаг юм. Машиныг тушаах үеэр ямар нэг маапаан гарахааргүй болтол нь янзалж байв.

Энэ өдөр чухал чухал юм болсон учир бүгдийг нь дэс дараатай ярья.

Өглөөнөөс хойш Вадим баазаар гүйж, юм хум агуулахдаа цуглуулж байсан юм. Бидний босгох машинд тавих хэрэгслийг цуглуулахад зориулж түүнд агуулах гаргаж өгсөн билээ. Энэ бол хаалгыг нь аваад хаячихсан жижигхэн төмөр саравч байв.

Вадим бидэн дээр давхин ирж:

— Машиндаа хэрэгсэл цуглуул, дарга зөвшөөрсөн гэж дуржигнууллаа. Шмаков бид хоёр гайхан,

— Юун хэрэгсэл гэвэл

— Манай машинд тавих, ойлгохгүй байна гэж үү дээ? дарга тэг гэсэн юм.

— Гараашинд хэрэгсэл юу ч байхгүй цехэд л эд анги, сэлбэг байдаг. Манай энд юу ч алга гэж бид хариуллаа.

— Ямар ч болсон юм олдвол агуулахад аваачиж өгөөрэй! гэж Вадим мундагдаад, харайлган одов.

Бид тийм дэмий юм хийгээгүй нь мэдээж. Тэр тусмаа яаралтай ажил хийж байсныг хэлэх үү. Энэ «победыг» маргааш засаж дуусгахаар тооцоолж байтал дарга өнөөдөр дуусга гэж тушаасан. Бидэнд туслуулахаар нөгөө сахлаа авдаггүй, Шмаковтой ярих дуртай Зуевыг өгөв.

Зуевыг элбэлцүүлэхээр өгөнгүүт Лагутин барс гээд явчихлаа. Энэ нь тэр дороо нүдэнд тусав.

Шмаков бид хоёр багаж авч, өгч чийдэн барьж өгч, сэлбэг хэрэгслийг дөхүүлж байлаа. Анхны үеийг бодвол бид ухамсартай ажиллаж байв. Бид хэлүүлэлгүй ажлын явцыг харан хэрэгтэйг нь авч өгч байв.

Тэгээд ажлын явцаар би одоо зөөллүүр тавихыг ухаарав. Зөөллүүр замын донсолгоог зөөлрүүлж, машины хөдөлгөөнийг намуухан болгодог. Энэ машинд шинэ зөөллүүр цохож өгсөн юм. Би өчигдөр түүнийг агуулахаас аваад Лагутины ванданд хийчихсэн юм л даа.

Би ванданг онгойлгож харвал нөгөөх маань байдаггүй. Явган сууж байгаад гайгүй сайн үзлээ. Зөөллүүр алга. Хачин юм даа! Өчигдөр би өөрөө тавьсан билээ.

Би ванданг эргэж тойрч үзлээ. Лагутин гаргаад тавьчихсан байж болзошгүй яа?.. Өө тийм байна. Вандангийн араар бөөн даавууны дороос зөөллүүрийн хөшүүрэг цухуйж байв.

Би гаргаж аваад вандан дээр тавин зүлгэж гарлаа. Энэ үеэр испани хүнтэй төстэй бригадын дарга Дмитрий Александрович хажуугаар явж байж. тэр бээр зөөллүүрийг үзээд намайг харснаа зогсож, миний юу хийж байгааг асуудаг байна.

— Хаанаас авав?

— Юу хаанаас, агуулахаас л байхгүй юу.

— Өөрөө авсан уу?

— Тэгсэн.

Дмитрий Александрович хөмсөг зангидаж,

— Авч байгаа юмаа сайн харж авч байвал зүгээр дээ гэв.

Дмитрий гуай зөөллүүрийг хөшүүргээс нь барьж Лагутин, Зуев хоёрын ажиллаж байсан машины доорх нүх рүү очив. Би ч араас нь дагалаа.

— Лагутин! гэж Дмитрий Ивановичийг дуудахад Лагутин

— Юу вэ? хэмээн машин дороос асуув.

— Гараад ирээч.

Лагутин гарч ирээд Дмитрий Ивановичийн барьж байгаа зөөллүүрийг харж хөмсөг атируулав.

— Үүнийг хаанаас авав? гээд Дмитрий Александрович зөөллүүрийг заав. Лагутин түүнийг дахин харж, авч эргүүлж тойруулж үзсэнээ мөрөө хавчисхийлгэв.

— Бүү мэд...

— Яагаад мэддэггүй юм? гээд Дмитрий Александрович над руу дохиж агуулахаас авсан гэж байна гэв.

— Агуулахаас шинийг авсан л даа, шинийг нь яасан юм? гэж Лагутин миний зүг эргэж асуув.

Би дөнгөж сая учрыг олов. Энэ хуучин зөөлөвч байх нь. Зассан боловч хуучин байх нь. Вандангийн ард байсны учир энэ байж.

Эвгүй оргив. Би зовонгуй инээмсэглэж.

— Би эндүүрч... Энэ зөөллүүр вандангийн араар хэвтэж байсан юм.

— Ялгах цаг болсон баймаар... гэж Дмитрий Александрович ширүүн хэлээд шинийг нь аваад ир. Шинэ хуучин хоёрыг яаж ялгахыг зааж өгье гэв.

— Тэнд байхгүй байна лээ.

Лагутин улам барайж,

— Юу байхгүй гэж! Чи өчигдөр хаана тавьсан юм? гэхэд нь,

— Ванданд хийсэн, та тэнд тавь гэсэн шүү дээ гэж би хариулав.

— Яагаад байхгүй байдаг билээ? гэсээр Лагутин вандан тийш очиж, цомцойн сууснаа босон ванданг тойрч хараад намайг ширтэж

— Чи хаана тавьсан юм бэ? гэлээ.

Би өөдөөс нь дуугүйхэн харав. Бүх юм надад тодорхой байлаа. Үүнийг ойлгоход нэг их ухаан зараад байх юмгүй ээ. Лагутин шинэ зөөллүүрийг завшчихаад машинд засагдсан боловч хуучныг тавих гэж. Ингэх гэж түүнийг вандангийн араар нуусан юм санж. Зуевыг бидэнд туслуулахаар өгсөнд Лагутины тэгж уурласан учир энэ байжээ. Хуучин зөөллүүр тавихад нь Зуев саад болно гэж айж л дээ. Гэтэл Зуев биш би, миний илүүц чармайлт саад болов.

Лагутиныг чанх өөдөөс нь ширтэж,

— Би таныг байхад тавьсан шүү дээ. Ванданг та надаас хойш таглаагүй юу?

Лагутин нүднээс минь юу олж үзсэнийг бүү мэд, ямар ч гэсэн далдирч,

— Яачихдаг юм бол? гэж хэлэв.

Бултаараа алга болсон зөөллүүрийг бэдэрч гарлаа. Зөөллүүр олодохгүй гэдгийг би сайн мэдэж байлаа. Өөр хүмүүс мэдэхгүй болохоороо эрсээр байв. Зөөллүүрийг хаалгаар гаргаж чадахгүй манаач харах ёстой гэлцэнэ. Өөр машинд тавьчихсан болов уу? гэхэд бас үгүй, энэ үед засварт «победа» машин байгаагүй. Хэн нэг нь тоглоом хийнгээ тийнхүү нуусан байж болох юм. Бааз дээр тийм юм гардаг аж.

Хагас цаг болоод бааз даяараа шинэ зөөллүүр алга болсныг мэдэв.

Нэг юм л алга болбол алга болсон бусад юм дараа дараалан үгүйлэгдэнэ... Цахилгааны цехээс бараг шинэ зай хураагуур, шинэ шахуу динам, бүрээслэх цехээс бараг шинээрээ суудал, суудлын түшлэг, механикийн цехээс өөр юу ч юм алга болсон нь мэдэгджээ.

Энэ цуу үгийг би хайхарсангүй, ганцхан өдөр баазын хамаг юмыг авчихна гэдэг байж болшгүй. Зөөллүүр алга болохоор бүгдээр хар авч эрж хайж, ухаж төнхөн, цехээсээ бас л юм хум алдчихсан юм шиг санасан хэрэг. Харин «победын» зөөллүүр алга болсон нь барин тавин зүйл. Түүнийг Лагутин сольж авсан гэдгийг би мэдэж байлаа. Гэвч нотлох юмгүй болохоор үүнийгээ хэлж чадсангүй.

Хонх жингэнэв. Ажилчдын үдийн завсарлага эхлэв. Бид ажлаа бүр мөсөн дуусаад хашаанд гарав.

Хашаанд хүн дүүрэн. Албан хаагчид нарлаж байлаа. Сүү зардаг эмэгтэй тэргээ түрэн хүрч ирэв. Ажилчид сүү худалдан авч, сүүдэрт суун түүнийг уунгаа загасан талхаа идэцгээх ажээ. Лонх сүү, тал загасан талх бол тэдний өглөөний нь хоол. Бааз дээр мухлаг бий авч бүгдээрээ сүүг дээр гэж үзнэ.

Гэнэт дарга хүрч ирлээ. Ерөнхий инженер, бүрээслэх цехийн мастер, цахилгаанчдын бригадын дарга, Игорь нар түүнийг дагажээ. Цөмөөр хүрлийн, Игорь тэр аяараа бэмбэгэнэж байв. Дарга эргэж харалгүй,

— Аль нь вэ? гэж лавлав.

Мастер Иван Кузьмич Вадимыг заалаа. Цахилгаанчдын бригадын дарга ч бас Вадимыг заав. Тэд цөм Вадимыг заадаг байна. Вадим юу ч ойлгосон янзгүй инээмсэглэж зогсоно.

— Явцгаая гэж дарга царайгаа барайлган өгүүлэв. Вадимын сэлбэг хэрэгслээ хадгалдаг жижиг саравч руу явцгаалаа. Бултаараа араас нь хуйлрав. Бид юмнаас яалаа гэж хожигдох вэ. Сэтгэл минь

сэрхийгээд явчихлаа. Даргын дүнсгэр царай Игорийн бажгадсан царайг харахад нэг л бишээ. Игорь барьц алдаж байгаа болохлоор болдоггүй хэрэг гарсан байж таарна.

Вадим агуулахаа нээв. Дарга тийш орлоо. Минут хэртэй болоод дарга агуулахаас эхлээд шинэ суудал, дараа нь суудлын түшлэг, тэгээд шинэвтэр динам, бас бус сэлбэг гаргаж шидээд, адаг сүүлд нь бараг шинэхнээрээ байгаа зай хураагуурыг цахилгаанчдын бригадын дарга руу сарвайв.

Бид балмагдаж, бантаж, нам цохиулсан мэт зогсож байлаа. Нүүр хийх газар үл олдоно. Ганц Вадим л саравчныхаа дэргэд жишим ч үгүй, тайван зогсоно. Даргыг саравчнаас юм гаргаж шидэх болгонд маадгар нь аргагүй инээмсэглэх аж. Ямар сайхан сайхан сэлбэг хэрэгсэл энд цуглуулж амжсан байна даа хэмээх мэт бүгдийг сайрхуу харцаар тойруулан харна.

Дарга сэжиглэсэн байртай гараа навтсаар арчсанаа

— Зөөллүүр хаана байна гэхэд

— Юун зөөллүүр гэж Вадим хачирхав.

— «Победын»

— Мэдэхгүй ээ гэж Вадим хариуллаа.

Дарга Игорь руу эргэж:

— Зөөллүүрийг ол гэвэл,

— За, за гэж Игорь бушуухан амыг нь дагалаа.

— Эдгээрийг ав! гэж дарга тушаагаад агуулахаас гаргаж хаясан хэрэгслийг хөлөөрөө түлхсэнээ яваад өгөв.

Ажилчид аль олигтойг нь аваад аль өөдгүйг нь орхилоо.

Бид саравчны дэргэд дуу шуугүй зогсож хоцров. Манайхан ангиараа тэнд байсан юм. Юугаа ч хэлэх билээ. Хаашаа ч зайлах аргагүй. Алга болсон зүйл биднээс олдлоо. Мөн шившиг ээ!...

Тэгтэл Майка:

— Яасан муухай юм бэ... гэж хэлэв. Бүгдээрээ хашхиралдаж, ам булаалдан шуугилдлаа. Бултаараа Вадимыг зэмлэнэ. Дарга эд анги цуглуулахыг зөвшөөрсөн гэж хэлсэн эзэн нь мань хүн. Хүүхдүүд ч дэвэргээд өгсөн, ингээд юу болов доо.

Вадимыг ханган нийлүүлэгчээр сонгож байхад өөдтэй юм болохгүй. Вадим заавал нэг хэрэг тарьчихад бид хоморгод нь орно гэдгийг би юу эс андах вэ. Үүнийг хэлэх сэн гэхээс хэл загатнана. «Вадимыг сонгохоос миний татгалзаад байхад үгийг минь дуулаагүй. Игорийн үгэнд орсон бил үү. Хар толгойдоо гомдоцгоо» гэж хэлмээр байв.

Ингэж хэлэн хэлэн алдлаа. Гэвч би биеэ барив. Вадимыг өрөвдсөндөө ч биш, харин түүний буруу биш гэж бодсондоо тэр. Вадим энэ зүйлсийг сэм аваачсангүй, ил ирээд биднийг цуглуул гэж ил хэлсэн. Дарга үүнийг зөвшөөрсөн эсэхэд л хамаг учир байгаа юм. Хэрэв зөвшөөрсөн бол Вадимын буруу юу байх вэ? Вадим үүнийг санаанаасаа зохиочихсон бол буруутай байлгүй яах вэ. Үүний учрыг эвтэйхэн олох хэрэгтэй. Ингэж үймэлдээд юу хийнэ.

— Дарга хэрэгсэл цуглуулахыг зөвшөөрсөн юм уу, эсвэл чи өөрөө ингэе гэж санасан юм уу? гэж миний асуухад Вадим

— Зөвшөөрсөн байлгүй яах вэ гэж хариуллаа.

— Чи яаж мэдсэн юм?

Вадим Игорийг заалаа.

— Игорь надад тэгж хэлсэн. Тийм биз дээ Игорь?

Игорь хариу хэлэхийн оронд бодлогошронгүй

— Зөөллүүр яачихдаг юм бол? гэж хэмээн үглэв.

— Би ямар ч зөөллүүр аваагүй гэж хөөрхий Вадим хашхирав.

Игорь хариу хэлэхээс булзаж байгаа нь эвгүй санагдан

— Зөөллүүр ямар хамаа байна аа. Дарга хэрэгсэл цуглуулахыг зөвшөөрсөн үү, үгүй юу? гэдгийг хэлчих.

Игорь цэнхэр нүдээ бүлтийлгэн намайг ширтэж:

— Тэгж бодъё. Тэгээд юу гэж?

— Бүү булзааруул!

— Зөвшөөрсөн юм.

— Тэгвэл Вадимын буруу юу байгаа юм.

— Юу гэнээ? гэж няхуур дуугаар Игорь хариулаад
— Дураараа дургилгүй, цехийн даргаас зөвшөөрөл гуйх ёстой байсан юм.

— Вадим ямар өөрөө авсан юм уу, хүүхдүүд авсан болохоос гэж би татгалзав.

Игорь зэмлэнгүй толгой сэгсэрч

— Бүгдэд нялзаах хэрэггүй ээ. Энд хамт олон ямар ч хамаагүй.

— Чи сүржигнэхээ боль! Хамт олноор бамбай бүү барь.

Амташсан хэрээ арван гурав дахина гэгчээр! Вадимын бурууг л шууд хэлээдэх гэж би хашхирав.

Игорь ууртаа царай нь хөхөсхийгээд явчихлаа. Гэвч биеэ барих гэж оролдоно.

— Зоргоороо юу ч бүү аваарай гэдгийг Вадим хүүхдүүдэд сануулах хэрэгтэй байсан.

Тэгэхэд хүүхдүүдийн санал хоёр хуваагдав. Зарим нь Вадим буруутай, зарим нь үгүй гэнэ. Үгүй гэгсэд олон байлаа.

Майка:

— Хүүхэд бүр нөхрөө хэрэгт түлхэх биш, хийснээ хариуцах ёстой. Зөөлөн суудал, түшлэг хоёрыг Надя бид хоёр зөвшөөрөлгүй авсан юм. Тэгэхлээр бидний буруу. Нэгэндээ хамаг хэргээ тохно гэдэг шударга биш явдал гэв.

Надя Флерова:

— Цөмөөрөө л буруутай гэж нэмэрлэв.

Хүүхдүүдийг булаацалдаж байх зуур сайхан санаа төрөв.

— Байзнаарай, одоо бүх юм тодорхой болно гэж би хашхираад, цехийн дарга нараас зөвшөөрөл авах хэрэгтэй гэж дарга чамд сануулсан уу? гэж Игороос асуув.

Үгийг нь ороох гэж байгааг минь мэдчихээд Игорь намайг учиргүй том харав. Тэгснээ хаяагаа манаж

— Сануулсаан. Ер нь... «Цехийн дарга нар нөөцөө ухааж үзэг» гэж хэлсэн л дээ гэв.

— Тэгэхлээр дарга чамд сануулсан байж! Чи тэгвэл Вадимд сануулсан уу? гэж би дуу алдав.

Энэ бол гол асуудал гэдгийг бүгдээрээ ойлгов. Тэгээд Игорийг харцгаалаа. Түүний хариунаас бүх юм тодорхой болов...

— Тэгэхлээр би хэлсэн л байж таарна даа... гэж итгэлгүйхэн дуугарав.

— Худлаа! Чи надад юу ч хэлээгүй. Зөвхөн хэрэгсэл цуглуул гэсэн шүү дээ гэж Вадим хашхирлаа.

— Байз гэм. Би яг юу гэж хэлснээ санахгүй байна... Ямар ч гэсэн би Вадимыг дайралдсан бүхнээ чирээд ир гэж хэлээгүй юм даг. Вадим нялх хүүхэд биш. Эргэцүүлж бодох хэрэгтэй. Юуны төлөө мөрөн дээрээ бөндгөр зүүж яваа билээ гэж хэнэггүй мэлзэв.

Тэгэхэд нь би:

— Дарга чамд хэлсэн байтал чи Вадимд сануулсангүй. Тэгэхлээр чи Вадимыг бөндгөр зүүж яваа гэж бодож, дарга чамайг бөндгөртэй гэж бодсонгүйеэ.

Игорь мэдлуулснаа ухаарав.

Гэвч мань эр маш овжин болохлоороо миний тохуурхсаны хариуд бусдын хамт инээд алдаж:

— За яах вэ. Хэн буруутай нь хамаа алга. Ямар нэг хэмжээгээр би ч буруутай байж магад. Өнгөрсөн хурал дээр Вадимыг сонгохоос татгалзсан нь Крошийн зөв байсныг би одоо үзлээ.

Үүгээрээ Игорь намайг тал тохой татахыг хүсжээ. Энэ ч харин хойшлогогүй үерхэл байх сан.

— Үүнд Вадим хамаагүй, харин чи л хамаатай. Чиний буруу. Тэгээд бас Вадим руу хамаг хэргээ чихэх гээд байгаа шүү. Барсангүй дээ.

Ангиараа буруутай, бид захиргааны өмнө буруугаа хүлээж, дахиж ингэхгүй гэж амлавал зохино гэсэн Майкын саналыг хүүхдүүд зөвшөөрөв.

Би саналаа өгөхөө түдгэлзэв. Игорь л гэмтэй болохоос биш анги буруугүй гэж би үзэж байлаа.

Игорь дорхноо сэргэв.

— За яах вэ тийм болог. Гэвч тэр золигийн зөөллүүрийг яадаг билээ? Биднийг авсан гэж байна.

— Авсан л гэж байг! Бид ямар ч зөөллүүр аваагүй гэж хүүхдүүд шуугилдлаа.

Майка Вадимд:

— Вадим, чи аваагүй гэдэг амаа өг! гэлээ.

Вадим зүрхээ дарж зөөллүүрийг авах нь битгий хэл, үзээ ч үгүй хэмээн ам шүд алдав.

Үүнд цөмөөрөө үнэмшив. Би тэр тусмаа итгэж байв. Зөөллүүрийг хэн сольж авсныг би мэдэж байсан юм чинь.

Игорь ч Вадимд үнэмшив. Гэвч даргаас зүрх алдаж байлаа. Ингээд ийм санал гаргав.

— Төлөөлөгчид сонгоё. Тэд дарга дээр ороод бидний юу гэж шийдсэнийг дамжуулаг. Төлөөлөгчийн бүрэлдэхүүнд Майя, Полекутин, Крош нарыг сонгох санал байна.

— Өөрөө хулчийгаа юу? гэж би хэлэв.

— Үгүй ээ. Элдэв ажлаар би дарга дээр дандаа ордог. Намайг очиход огт тоохгүй. Харин тусгай комисс очвол шал өөр сэтгэгдэл төрнө гэж Игорь цааргалав.

Тэр дороо Майя, Полекутин бид хэд дарга руу явлаа. Игорь аанай л биднийг дагав. Түүний биеэ товойлгох дуртайг яана. Гэвч тасалгаанд санаандгүй орж ирсэн хүний байртай хөндийхөн зогсоно.

— Яах гэж ирэв хэмээн дарга асуулаа.

Майка эхэлж ярихаар бид тохиролцсон юм. Эмэгтэй хүн болохоор дарга түүнтэй зөөлөн ярих ёстой. Ер нь төлөв хүн, гэвч юмыг яаж мэдэх вэ?.. Хэрэг гарвал Полекутин бид хоёр ярианд оролцох байв.

— Ангийнхан маань буруугаа хүлээж байна. Бид нээрээ жаал зугаа юм зөвшөөрөлгүй авчхаж. Дахиад ингэхгүй.

— Зөөллүүр хаа байна! гэж дарга лавлав. Бид аваагүй. Бидэнд хэрэггүй.

— Хэн авсан юм?

— Үүнийг бид мэдэхгүй.

— Олох хэрэгтэй гэж дарга тайвуухан өгүүлэв.

Оролцох цаг болсныг би ярианы явцаас үзээд

— Хачин юм, түүнийг чинь бид яаж олох юм? гэв.

Дарга гараа дэлгэж

— Энэ бол та нарын хэрэг гэлээ.

Тэгтэл Игорь хошуу нэмэрлэж

— Владимир Георгиевич бүү зов. Бид арга хэмжээ авъя.

Мань эр даргад ая тал засах гэжээ.

— Үгүй ээ. Игорь хоосон ам өгч байна. Ангийнхан түүнийг төлөөлөгчөөр явуулаагүй. Бид зөөллүүрийг аваагүй, хаана байгааг нь ч мэдэхгүй, эрье ч гэж бодохгүй байна. Хий амлаад юу хийнэ гэж би татгалзаж орхив.

Дарга намайг гайгүй сайн харлаа. Бидний ямар улс болохыг огт ойлгохгүй байх мэт тэр биднийг яагаад ч юм цоо ширтдэг билээ.

Ерөнхий инженер даргын дэргэд хар цагаан дуугүй сууна. Тэр бол дадлагыг удирдаж, биднийг хариуцдаг болохоор ийм хэрэг гарсан нь түүнд эвгүй байсан учир дуугүй суухаас өөр аргагүй.

— Цехээс хэрэгсэл асуулгүй ав гэж хэн хэлсэн юм? гэж даргыг лавлахад

— Бид буруугаа хүлээсэн шүү дээ, гэж Майя хариулав.

— Буруугаа хүлээгээд л болчихно гэж бодож байна уу?

Майка гэзгээ нэг мөр рүүгээ шидэв. Энэ бол Майка тэвдэж эхэлсэн гэсэн үг.

— Бид тэгээд яах вэ?

— Эхлэх зүгээ олохгүй л байна даа. Машинаа эд ангиар нь задлаад, цех цехэд тарааж өгөх хэрэгтэй, Ямар нь хэрэгтэй, ямар нь хэрэггүй гэдгийг тэнд үзэх ёстой юм.

— Энэ зүйтэй гэж Полекутин зөвшөөрөв.

Зөв гэдгийг би ч бас баталлаа.

— Бид яг ингэх гэж шийдсэн юм. Владимир Георгиевич гэж Игорийн хэлэхэд дарга:

— Ганц ч эрэг гээхгүйгээр нямбай хийх хэрэгтэй гэж сануулав.

— Санаа бүү зов гэж Игорь батлав.

Игорь даргатай ярихад тийм чиг аймаар бишийг үзээд тэр дороо зүрх орж дахин удирдагч, штабын даргын буурь орлоо.

Биднийг тасалгаанаас гарахад тэр тэнд хоцроод араас минь

— Хашаанд гараад хүлээж бай. Би одоохон очно гэлээ.

Юу болсон, яасныг мэдэх гэж хүүхдүүд биднийг хашаанд хүлээж байжээ. Бид бүх юм бүтсэнийг мэдэгдлээ.

Игорь гарч ирээд халимгаа хойш болгосноо баясангуй:

— Будилаан нэг юм шувтарлаа. Маргаашаас эвдэрхий тэргийг зохион байгуулалттай задалж эхэлнэ. Гэхдээ эндэхийг бишээ. Бидний гэнэн бага насаа өнгөрүүлсэн Липкийн зусланд бас нэг машин байгаа аж. Бас актлагдсан боловч үүнээс арай дөнгүүр гэнэ. Түүнийг бидэнд өгч байна.. Маргааш бид чирч авчиръя.

Игорь их сайн байна хэмээн бүгдээрээ хашхиралдав.

Игорь бас ч овоо хэмээн би ч бодов. Липкад байгаа машины тухай Зуевын хэлэхэд бид нэг чихээрээ оруулаад нөгөөгөөрөө гаргасан. Гэтэл Игорь дор нь санаа авч даргатай тохиролцож амжсан байна. Удирдах авьяас түүнд байна. Үүнийг үгүйсгэх аргагүй.

Гэсэн ч

— Бид үүнийг чамаас түрүүнд мэдэж байсан юм гэж би хэлээд үзэв.

— Тэгээд хэлэхээ яасан юм? гэж ёжтойхон асуув.

Би амаа таглуулах нь энэ.

Хэн хэн Липка орж машин авчрахыг бид ярьж тохирлоо. Ер нь энэ бол тодорхой байв. Гарааш л машин чирэх ажлыг эрхэлдэг. Гараашинд Шмаков Петр хоёр ажилладаг...

— Серёжа, Шмаков хоёр яваг, эд машиныг бүхэлд нь мэддэг шүү дээ гээд Майка инээмсэглэв.

Майка намайг «Крош» гэж ер дууддаггүй, дандаа нэрээр минь дууддаг юм. Надтай ярихдаа ямагт инээмсэглэдэг бөгөөд ямар учиртай инээмсэглэдгийг нь ойлгодоггүй болохоороо би баярлах уу, гомдох уу гэдгээ мэддэггүй билээ.

— Энэ зүйтэй гэж Игорь ам нийлээд би ч бас эд нартай явъя.

Ванька Полекутин энд ахлагчаар үлд гэв.

Зусланд Игорь юугаа хийх билээ. Энд зууралдахаас дургүй нь хүрч, зүгээр л зугаацаж яваад ирмээр санагджээ. Яах вэ, явбал яваг! Полекутин энд юуг ч түүнээс хавьгүй дээр хийж дөнгөнө. Полекутин олон таван үггүй, хагархай хэнгэрэг шиг биш, сүрхий залуу, техник мэдэхийг нь яана.

Гэвч Игорь үүнд сэтгэл ханасангүй

— Вадим бидэнтэй яв гэж түүний хэлэхэд

— Яах юм? гэж бид хачирхав.

— Юмыг яаж мэдэх вэ, тэнд хэрэг болж. Юу ч гэсэн овсгоотой залуу.

— Игорь даргархаж явах гэж Вадимыг зориуд авч явах гэж байгааг би гадарлалаа. Шмаков Петр бид хоёрт даргархаж барахгүйгээ мэджээ.

Маргааш намайг эртхэн сэрээгээрэй. Липки орж машин чирч ирэх ажилтай гэж би орой нь гэрийнхэндээ хэлэв.

Би тэр болгоныг тоочсонгүй. Гэртээ сургуулийн тухай, тэр тусмаа автобазын тухай ярих дургүй. Юугаа хийх юм бэ? Ээж хүүхдүүдийн овог, багш нарын нэрийг тогтоодог ч үгүй юм. Нэг хүүхдийн тухай ярьж байхад ээж өөр хүүхдийг гэж бодно. Нэг хэлснээ далан долоо дахих, энэ бол ийм тэр бол тийм гэж хүүхэд бүрийн талаар тайлбарлах хэрэг гарна. Түүнээс гадна олон хүүхдийнх манайтай айл. Ээж тэдний аав ээжийг танина. Болохгүй юмны талаар тэдэнд үг алдчихаж магад. Манай ээж тэр талаар даанч ам султай.

Хэддүгээр ангид сан билээ дээ санахгүй байна, би харьж ирээд Шмаков Петрийг орос хэлний хичээлд гурван муу дараагаар авчихсан гэж ярих аа. Яах гэж ярьснаа ч би санахгүй байна. Гал зуухны өрөөнд хэл амаа билүүдэж суусан нь тэр. Ердөө ч даажигнаж тавласан юмгүй л ярьсан юм. Тэр тусмаа Шмаков гурав дахь муугаа шал дэмий юмнаас болж авсныг яана. Харин түрүүчийн хоёр мууг л тавиулах юман дээр тавиулсан.

Гэтэл манай ээж гадаа Петрийн эмээтэй дайралдаад өнөө муугийн тухай ярьчихаж. Тэгэхдээ хамгийн сайхан санаагаар л хэлж дээ. Эмээд жаал зугаа зөвлөж, туршлага хуваалцах гэсэн юм байх...

Үүнд гойд юм байхгүй. Би ээжид хэлчихсэн, ээж туршлагаа хуваалцах гэсэн нь тэр. Тэгээд ч Петр муу авснаа гэрийнхнээсээ нуугаагүй, хүснэгтэд нь байсан юм.

Гэтэл Петрийн эмээ гэртээ ороод шившгийн юм! Чиний муу байраар л нэг тарж. Айлынхнаар л нэг яриа болж байна гээд л түүнийг аашилж гарчээ.

Шмаков бид хоёр түнжин тасрах дөхсөн юм. Ээж ч, би ч ер хар санаа агуулсан юм байхгүй хэмээн түүнд ойлгуулж ядав. Петр ямар ч тайлбар сонсохыг хүссэнгүй, дахиад ингэх юм бол овоо юм хүртэнэ гэж мэдээрэй гэв. Би хагархай хэнгэрэг шиг хүн, задгай амтай хүн гэж хүлээх хэрэг гарав. Тэгж байж сая Шмаковтой эвлэрч билээ.

Ээжийн цэх шулуун зан уу. Ээж хов жив хөөцөлддөг хүн биш. Зүгээр л цагаахан, шударга зантай юм. Онд ондоо хүмүүс өөр өөрөөр ойлгоно гэдгийг ээж ухаардаггүй. Зарим нэгд нь юман чинээ санагдахгүй зүйлийг нөгөө нь нэг их сүртэй юм болгоно...

Ээжийн шулуун цагаан занг би үнэлдэг юм. Гэвч үүнээс нь болж гэнэ алдахыг юунд хүсэх билээ. Би сургуулийнхаа ажил төрлийн талаар ам нээхээ больсон юм. Харин өдөрт рубль гучин копеек олохоо л хэлэв.

— Энэ чинь сард хэдэн рубль болох вэ? гэж ээж асуугаад, цээжээрээ бодож гарав.

Би хурал дээр хэдийнээ бодчихсон юм.

Зургаадугаар сар гуч хоногтой. Тэгэхлээр гучин есөн рубль бараг дөчин рубль авна гэсэн үг

Гэтэл аав ажлын өдөр ажилласны л мөнгө авдаг, өөрөөр хэлбэл ням гарагийг оруулдаггүйг хэлж өгөв. Энэ нь гучин хоёр рубль тавин копеек болно. Дөч шахам биш гучаад рубль авах юм.

— Чи яаж зарцуулах гэж байна? гэж аав асуулаа

— Унадаг дугуйндаа мотор авна.

— Яасан ч үгүй. Чамайг дугуй унахлаар сэтгэл зовохыг яана.

Мотортой ч... ёстой больё оо! гэж ээж хэлэв.

Үүлгэр хүн л энэ ээ, тэр ээ болох байх. Зөндөө хүүхдүүд моторт дугуйтай мөртөө сүйд болсон юм алга л байна гэж би түүнд тайван тайлбарлав.

Гэтэл өөдөөс минь аанай л

— Чи хамгийн жаахан гэдгээ мартав уу гэлээ.

Ангидаа хамгийн бага нь үнэн л дээ. Долоон ойдоо хүрэхэд гурван сар дутуу байхад минь намайг сургуульд оруулсан юм. Бусад хүүхэд долоо нас бардан хүрсэн, зарим нь наймтай байжээ. Игорь бол бүр естэй байсан юм. Би хамгийн жаахан нь байсан учир жагсахад хамгийн дор зогсдог байв.

Эр өсөж эсгий сунадаг гэгчээр би ч өсөн, сүүлдээ намайг ангид хамгийн багад тоолохоо болив. Ганц ээж л намайг жаахан гэж бодно. Юм л бол хамгийн бага нь гэдгээ бүү март гэнэ.

Сая ч бас тэгж хэлэв. Тэгснээ:

— Арван найм хүрэхээрээ дуртай юмаа унаарай гэж нэмж хэллээ.

Урьд нь «арван зургаан нас» гэж ярьдаг байсан юм... «Арван зургаатай болохлоороо хийх гэснээ хийгээрэй» гэдэг байв.

Харин одоо арван зургаан нас хүрэхэд уртаашаа долоохон сар үлдэхээр арван найм гэдэг шинэ тоо гарч ирэв... Арван найм хүрээд оюутан болохлоороо чи... гэх зэргээр л ахиад байна...

Сая үүгээр дахиад л шалтаг заав. Дугуйнд мотор авхуулахгүй гэж тэр дээ.

Яагаа ч үгүй юмны төлөө би маргалдахыг хүссэнгүй. Мотор авахаар болбол цаг нь болмогц өөрийнхөөрөө зүтгэчихнэ. Одоо сүүлд, хоёр дахин зүтгэхийн хэрэг юу байх вэ.

— Одоо шийдсэн юм алга. Мотор ч авч мэднэ, бүүр байчхаад Чехов, Бальзакийн зохиолыг ч захиалж магадгүй гэж хэлэв.

Би орондоо ороод, сэрүүлэгтэй цагаа түлхэж, унтаж хоцрохгүйн тулд орныхоо дэргэд тавив. Автобаз дээр өнөөдрийн болсон хэргийг бодоод нойр минь хулжлаа.

Игорь тусгүй нөхөр юм даа. Түүнийг ажиглах тусам тарыг нь таних юм. Нөхөртөө туслахгүй байна гэдэг бол муухай. Өөрийн гэмийг нөхөртөө тохно гэдэг бол адгийн явдал.

Игорийг таг суулгаж, Вадимын тухайд би зөв юм хийлээ.

Харин зөөллүүрийн хэргийн талаар миний байж байгаа нэг л буруудаа. Гэхдээ чухам яахаа би бодоод олонгүй...

Лагутин зөөллүүрийг сольсныг би нотолж чадахгүй. Гэвч тэгсэн гэдгийг сайн мэдэж байна. Мэдсэн хэр нь дуугүй байна гэдэг бол Лагутиныг хаацайлж байгаа хэрэг. Хаацайлахаар барахгүй түүнтэй ярьж хөөрч хамт ажиллаж, өөр зүгээр улстай харилцдаг шиг, өөрөөр хэлбэл үнэнч шударга хүнтэй харьцдаг шиг л харьцаж байна.

Ингэхлээр ичих нүүрээ илгээр хааж байгаа хэрэг.

Яадаг хэрэг вэ? Лагутиныг улаан цайм хэлчих үү?... Хүнийг хулгайч гэж хэлэх гэдэг тун муухай юм... нотлох юм хаана байна? гэж надаас асууна. Гэтэл надад нотлох юм алга.

Хэрэв би тэгэхэд холхивчийн тухай дуугүй өнгөрөлгүй ил хэлчихсэн бол Лагутин зөөллүүрийг сольж зүрхлэхгүй байсан юм. Надад тэгэхэд итгээгүй байсан ч Лагутин айгаад зөөллүүрийг сольж авахгүй байсан даа. Холхивчийн тухай хэлснээрээ үүнээс урьдчилан сэрэмжлэх байж. Тэгтэл надад итгээгүй бол? Чалчаа, алтан хошуу хүргэгч гэж бодвол... Тэгэхлээр зөөллүүр нэр хүнд хоёрын аль нь үнэ цэнтэй вэ гэдэг асуудал гарч ирнэ...

Гэтэл энэ бол номчирхол. Би номчирхох дургүй ээ. Хурдан унтахын тулд Лагутины тухай биш, өөр сайхан юмны тухай бодохоор шийдэв. Жишээлбэл гучин хоёр рубль тавин мөнгөө яаж зарах тухай бодов.

Давын өмнө аав ээж хоёрт бэлэг авч өгөх хэрэгтэй. Мотор авахаа больё. Жолоочийн үнэмлэхтэй хүн дугуй унана гэдэг тэнэг хэрэг. Бальзак, Чеховын зохиолыг ч захиалахаа байя. Хожим амжина...

Тойрон аяллаар явдаг хэрэг! Крым, Кавказын аль нэг рүү явъя. Майка ч явж юу магад. Хамт хад өөд авирч, би гараас нь татаж гаргана. Хар далайд хамт орж, Майка живж эхэлнэ. Би ус руу үсрэн орж, түүнийг аварна. Усанд живж байгаа хойно тэр надтай ноцолдоно... Толгой руу нь түншээд авах хэрэгтэй болно. Тэгэхдээ энэ бол түүний амь насны төлөө юм чинь...

Эрэг дээр гаргаад Майкаг зохиомлоор амьсгалуулна. Тэр бээр ухаан орж, нүдээ нээн зохиомлоор амьсгалуулж байгсдыг харна. Гэтэл би тэдний дунд байхгүй байх юм. Тэднээс зайдуухан сууна. Өөрийг нь миний аварсныг Майка мэдэхгүй. Хэн намайг аврав? гэж дорой дуугаар асууна.

Тэнд нэг хүн... гэж би бүрхэгдүү хэлнэ.

Тэгээд Майкагай цааш жуулчлан явна. Дахиад л хоёул хад асга өөд авирч би Майкаг татаж гарган, урьдын адил хамгаална. Гэвч энэ нь битүүлэг үл таних хүний баатарлаг үйлсийг бодоход ялихгүй өчүүхэн зүйл мэт Майкад санагдах болно. Тэгээд тэр хүнийг гуниглан бодно. Надтай эн зэрэгцүүлж үзнэ. Би биш тэр хүн өөрийг нь аварсан гэж санаж байгаа болохлоор түүнийг илүү гэж үзнэ. Майка дотроо намайг тоохоо болино...

Гэвч би хэлэхгүй л байгаад байна. Хаданд авирахдаа Майкаг урьдынх шигээ боловч гунигтайхан татаж гаргасаар л байна. Өөрийн минь зоримог үйлийг өөр хүнийх болгож бодож байгаад нь сэтгэл нэг л хачин. ид тойрон аяллаа гунигтайхан дуусгана. Майка амийг нь аварсан үл таних хүнийг санахдаа уйтгарлаж, би тэр хүний тухай Майка бодож байгаа гэж санахдаа гуньхарна.

Бид Москвад буцаж ирнэ. Майка яаж усанд унаснаа, үл таних залуу хэрхэн амийг нь аварсныг охидод хуучилна. Аварч гаргачхаад яваад өгсөн. Даруу зантай сайхан сэтгэлтэй учир, мэдэгдэхгүй чигээрээ байхыг хүссэн учир явсан юм гэж ярина. Охид сэтгэл хөдлөн мэл гайхаж дуу алдан шагшиж Майкад атаархацгаана. Тийм санаанд багтамгүй адал явдал өөрт нь тохиолдолгүй Майкад учирсныг бодохдоо Надя Флерова байж ядна. Тэр сайхан залуу мөд гараад ирнэ. Хаялгаас ч яах вэ явчхаж. Гэвч Майкаг харж яваа хэн болохыг нь мэдээд огт санаандгүй байтал хүрээд ирнэ. Дахиад чамайг аврах

тохиолдол гарахыг ч хүлээж байж магадгүй гэж бүгдээрээ Майка ятгана.

Бид сүүлийн жилд тийнхүү сурна. Майка аврагч залуугаа мөрөөднө. Бидний харилцаа нэг л хөндий, Майка намайг Крош гэхгүй Серёжа гэж дууддаг нь хэвээрээ, инээмсэглэдэг нь ч хэвээрээ боловч би түүний сэтгэлтэй, үүрд сэтгэлээ өгөх залууг нь санагдуулах учир нэг л гунигтай инээмсэглэнэ.

Бид сургуулиа төгсгөнө. Төгсөлтийн үдэшлэг болно. Тэр үед тэнгисийн эрэг дээр Майкад амьсгаа оруулсан хүн зочдын дунд байна. Энэ хүн хэн ч байсан яах вэ. Эцэг эхчүүдийн нэг, жишээлбэл Инна Макаровагийн аав байсан ч болох юм.

Тэр хүн Майка руу очиж

— Тантай уулзсан минь яасан сайхан юм бэ гэвэл

Майка

— Та намайг яаж таньдаг юм бэ? гэж асууна.

— Юу яаж таньдаг юм гэж? Чамайг уснаас гаргаж ирэхэд би амьсгал оруулаагүй юу.

— Өө тийм үү гээд Майка гунигтайяа инээмсэглэнэ.

Тэгэхэд нь Инна Макаровагийн аав

— Таныг уснаас гаргасан тэр сайхан залуу одоо хаана байгаа вэ? гэж асуухад Майка улам уйтгартай болж

— Мэдэхгүй юм аа... гэнэ.

— Байз яагаад мэддэггүй билээ хэмээн Инна Макаровагийн аав хачирхаж, та түүнтэй цуг ирээд, цуг явсан шүү дээ гэж хэлнэ.

Майка мэл гайхаж хоцорно. Гараас минь барьж чичирхийлсэн хоолойгоор

— Серёжа чи яагаад хэлээгүй юм бэ? гэж асуухад нь би анзааргагүй,

— Ямар хэрэг байгаа юм? гээд хажуу тийш хөндийрнө.

Оройжин Майка намайг ширтэж, надад эвгүй зан гаргаж байснаа санан тарчилна.

Охид цөмөөрөө намайг бишрэн харна. Би танхимаар хэсэг сүлжин явснаа гэртээ харина.

Дараа нь Майка бид хоёр өөр өөр дээд сургуульд орж, уулзахаа болино.

Жил юм уу, хоёр жил өнгөрсөн хойно бид санамсаргүй дайралдана... Би спортын гавьяат мастер, юуны ч юм улсын аварга

болсон байна...

Тэгээд би спортын ямар төрлөөр аварга болохоо бодож гарав. Их л удаан бодов. Гэвч Майка бид хоёр уулзаад цааш юу болсныг гүйцэд бодож амжсангүй.

Би нам унтчихжээ...

Маргааш өглөө нь яг долоон цагт Шмаков бид хоёр гараашинд ирэв. Шмаков Петрээс миний үнэлдэг ганц зүйл бол цаг баримталдаг нь юм. Долоон цагт ирнэ гэж тохиролцсон, тэр яг л долоод ирэв. Хэчнээн наазгай хүн боловч Шмаков хариуцлага алдах гэж байхгүй.

Гэтэл Игорь найман цагт таван минут дутуу байхад хүрч ирэв. Вадим бидний хөдөлж байхад ам мөлтөс чавхдаж ирлээ. Иймээс тэд машин өглөө замд гарч байгааг хараагүй.

Ёстой үзүүштэй дээ! Шмаков Петр гайхсандаа ам ангайжээ. Лут лут ачааны тэрэг, ачаагаа өөрөө буулгагч хаалганаас хар хурдаараа дараа дараалан гарч, төгсгөлгүй цуваа болон цардмал замаар жирийлгэсээр хотын гудамжаар тархан одно. Жолоо барьж энэ хүчирхэг цувааны дотор ингэж хар хурдаараа давхиж явахын тулд би юу байдгаа өгөх сөн...

Шмаков бид хоёр гараашны дэргэд зогсоод, кабинд жирэлзэн өнгөрөх жолооч нарын царайг харлаа. Жолооны ард суучихсан цуваан дунд явахдаа тэд ердийнхтэй огт адилгүй хавьгүй буурьтай эршүүд харагдах ажээ. Машин барина гэдэг энэ дээ.

Автобаз өглөө эрт хөл ихтэй, би бол гоё гэж хэлэхээр байдаг. Тийм жолооч зам явах бичгээ аваарай!.. Тийм жолооч чиргүүлээ зэхээрэй! Тийм жолооч ашиглалтын дарга дээр яаралтай ир... гэх бүртгэгчийн чанга шаардангуй дуу чанга яригчаар сонстож байв. Жолооч нар бүртгэгчийн өрөөнөөс гүйлдэн гарч, зам явахаа халаасандаа явуут хийгээд, машиндаа суун хаалгаар гарч, цувааны ард орох ажээ. Агуулахын эрхлэгч сандчин торх, брезент, багаж түгээж өгч байв. Шөнийн бригадын засварчид дуусаагүй юмаа гүйцээх гэж яаравчилна. Угаалтуур дээр усан манан татаж сүүлчийн машинуудыг угааж байлаа. Бүгдээрээ яарч тэвдэж шуугих ажээ... Гэвч гагцхүү өглөө л ийнхүү шуугилдаж яарч сэргэлэн баясгалантай байдаг билээ. Машин ч цэвэрхэн, сайхан, гял цал болчихсон гардаг байв. Орой нь тоос шороонд дарагдаж, цемент шохой тоосгоны хог болчихсон ажлын хүнд өдөр үнэнч ажиллаад буцаж ирнэ...

Владимир Георгиевич дарга энэ бүхнийг чимээгүйхэн ажиглан, хашааны голд зогсож байв. Юунд ч л оролцож, ямар ч тушаал заавар эс өгөн, үг ч үл дуугарна. Хажуугаар нь хүмүүс гүйлдэж, машин өнгөрөх авч тэр бээр гагцхүү дуугүй ажигласаар байх ажээ. Гэвч энэ хашаанд

дуугүй тайван зогсох нь албан тасалгаандаа байдгаас илүү буурьтай харагдаж байв...

Энэ үед юу бодож байгаа бол? гэдэг нь сонин. Машин нь хэдий хэр ачаа зөөдөг бол? Гэвч үүнийг цээжээрээ тоолно гэдэг амаргүй. Бааз гурван зуун машинтай, машин нэг бүр тав долоо эсвэл арван тонны даацтай, хэд хэдэн удаа явчихна. Өнөөдөр яаж өнгөрөх бол, ямар нэг хэрэг гарчих болов уу гэж бодож байсан байж магадгүй. Энэ гурван зуун машин одоохон нүдний үзүүрээс далд орж, Москвагийн өнцөг булан бүрд тарах учир юу тохиолдохыг яаж мэдэх вэ. Ямар нэг заводын дарга бол ажрахгүй, бүх ажилчид нь нүдний өмнө байж байна. Баазын дарга бол түүнээс дор. Юу гэвэл жолооч нар нь өдөржин тарж явчих учир хүн бүхний төлөө хариуцлага хүлээж, үдэш болтол сэтгэл зовно...

Сүүлчийн машин гарч одоход бааз дороо эл хуль болов. Гэвч ингээд удсангүй. Засварчид хойно хойноосоо цувран ирж даргатай мэнд усаа солилцон цех цех рүүгээ тарав. Эхний ээлжийн ажил эхэллээ.

Бид Липка руу жолооч Ивашкинтай явлаа. Тэр зуслан руу барилгын материал зөөдөг юм. Эргэх замдаа манай машиныг чирч ирэхийг түүнд даалгажээ. Бид агуулахаар дайрч, гөлмөн төмөр аваад зуслан явах юм. Липкад салхи татуулаад буучихна гэж найдаж байлаа.

Тэгтэл урмыг минь хугалсан явдал болж бид агуулах, гөлмөн төмрийн тухай мартав...

Бидэнтэй Зуев явах болжээ. Тэр хоёр дахь машиныг барих гэнэ. Бидний урам хугарсныг яана. Хоёр дахь машиныг өөрсдөө барьж ирнэ гэж бодож байсан юм байхгүй юу. Гэтэл Зуевыг бидэнд дагуулдаг, итгэхгүй байгаа юм бол биднийг явуулахын хэрэг юу байна? гэж асуумаар.

Зуев дотор бид дээр суув. Кабин налж суугаад ийш тийш алмайран харж, Зуевыг хамт явуулсанд унтууцаж явлаа.

Ханхай хашлаганд сууж явна гэдэг дотор сууснаас хавьгүй илүү. Кабинд урагшаа л харж явна. Зам дээр ямар нэг сонирхолтой зүйл тааралдахад зурс гээд алга болно. Дээрээс бол бараа тасартал харагдана.

Тэгэхлээр дээр сууж явах хавьгүй илүү! Өдөр халуу шатаж байсныг хэлэх үү, дээр салхи сэвэлзэж машин чирч ирэх завшаанаа

алдсан гэж сэтгэл гонсойгоогүй сэн бол ингэж явахад бузгай таатай байлаа.

Давхар хашлагат гүүрээр Москва голыг хөндлөн гарч, Лужникийн хажуугаар Крымын гүүрэн харалдаах шинэ тавцангийн дэргэдүүр өнгөрч, цэцэрлэгийн гудамж руу эргэснээ Красная Пресня тийш өндөр барилгын тушаа эргэн төмөр замыг хоёр дахин огтлоод, сая Москвагийн захад хүрч ирэв. Машин агуулахын хаалгаар орж, бид гудамжинд хоцрон хүлээлээ.

Гудамж ч гэж дээ дан модон хашаа байв. Би модон хашаанд хачин дургүй. Харахаас уйтгар төрөөд байдаг юм. Жаалхан байхад ард нь ямар нэг хүн нуугдаж байгаа юм шиг санагдан айдас хүрээд байдаг байсан. Үүний хэрэг юу байна вэ?! Социализмын үед модон хашаа байх ёстой юм гэж үү?

Би энэ бодлоо хүүхдүүдэд хэлэв. Гэтэл тэд надтай санал нийлсэнгүй, хашаагүй байж болохгүй! гэлээ. Игорь сургамжилсан дуугаар

— Крош, бүү цэцэрх гэв.

Игорь шар нь хөдөлж гомджээ.

Түүн шиг нэгдүгээр зэргийн жолоочид машин чирч ирэхийг итгэж болохоор доо. Гэтэл Зуевыг явуулж байдаг. Юм юманд Игорь уцаарлаж байв. Ивашкин биднийг ингэж удаан хүлээлгэж байгаад ч эгдүүцэж байлаа.

Энэ талаар Шмаков хэлсэн нь

— Машин төмөр ачна гэдэг тийм гарын дор биш ээ. Жинлэхээс гадна бас ширхгээр тоолдог юм.

— Нээрээ гэж үү? хэмээн гайхахад минь

— Чи юу гэж бодов оо! Цайрдсан төмөр их үнэтэй эд шүү гэв.

Шмаков Петрийн хар ухаан ихтэйд нь би атаархав.

Тэгж тэгж Ивашкины машин гарч ирлээ. Бид хэд хашлага өөд авиран гарч, төмөр дээр хэвтэв. Хэвтчихсэн болохлоор бид орчин тойрныг харж чадсангүй. Гэвч Липка орох замыг бид андахгүй. Пионер байхдаа бид үүгээр элтэл нь явсан юм. Машин, тариалангийн талбай, цахилгаан дамжуулагчийн шон, хэсэгхэн ой, зуун мод энэ бүхнийг бид юу эс андах вэ.

Ивашкин хурд мэдэн давхиж байлаа. Гүйцэж түрүүлэхийг хориглосон тэмдэгтэй газар ч бусад машиныг гүйцэн түрүүлж байв.. Өмнөө явсан машиныг гүйцэж түрүүлж байгаа нэг машинаас хүртэл

түрүүлэв. Ингэж давхар гүйцэн түрүүлэх бол ноцтой зөрчил! Гэвч ингэж давхих нь ямар сайхан гээч. Ивашкин эрдүү хүн гэдэг нь яриангүй. Машиныг чадмаг барина, арга алга. Донгио Зуев жолоодож яваа бол өөх ч биш булчирхай ч биш гэгчээр яст мэлхий шиг гэлдэрч байгаа.

Нар цоо төөнөнө. Төмөр улайсан, бид халууцаж эхлэв. Ивашкины ингэж зантай сайхан явж байгаад ч урам сэргэсэнгүй. Зуевыг явуулсантай эвлэрч яагаад ч чадахгүй байлаа. Түүнийг явуулахын хэрэг юу байна! Ялангуяа Игорь бухимдан ярвайн ярвайн уурсаж:

— «Хөдөлмөрлөж сурцгаа». «Толгой даа»... гэнэ. Сайхан л үг юм! гэв.

— Хоосон үг гэж Шмаков Петр урвагархан үг хавчуулав

— Санаачилгыг дарж байна хэмээн Вадим ярвагархан нэмэрлэв.

Энэ удаа би Игорьтой санал нийлж байлаа. Нээрээ ч машиныг цагт хамгийн ихдээ л арван таван километр хурдтай чирнэ. Бид жолоодож чадахгүй байсан гэж үү дээ?

— Бидний орноос ах гуай бодоод өгчихнө, өөрсдөө бодох боломж алга. Бид тэдний хувьд балчир байна гэнэ. Арван зургаан нас тэр шүү. Александр Македонский Хероны дэргэд фиванчуудыг бут ниргэж байхдаа арван найм ч хүрээгүй байсан юм. Наполеон хорин гуравхан настайдаа бүр генерал болчихсон байсан... Эр өсөх гэж энэ дээ! гэж Игорь ярьсаар явав.

Хэсэг зуур дуугүй болсноо:

— Яая гэхэв. Хорьдугаар зуун өвгөчүүдийн зуун юм гэж гонсгорхон нэмж хэлэв.

Машин цардмал замаар хурдалсаар байлаа. Нэг удаа Ивашкин улаан гэрэл ассаар байтал давхиад гарчхав. Энэ нь өөрөө ажилладаг гэрлэн дохио байсан нь ойр хавьд сэргийлэгч байгаагүй нь түүний зол.

— Хасаг ч билүү, солонгос ч билүү нэг жаалын тухай юунаас ч билээ би уншсан юм. Тавхан настай мөртөө нэгдүгээр зэрэгтэй шатарчийн дайтай шатар тавьдаг гэнэ гэж Шмаков Петр гэнэт ам нээвэл Игорь тоомсоргүй инээмсэглэн:

— Гоц авьяастай хүүхэд байхгүй юу гэж хэллээ.

— Арван зургаан настай спортын мастер хэд байна? гэж Шмаков шалгаав.

Игорь эгдүүтэйгээр онийж:

— Бие бялдрын хөгжлийг оюуныхаас ялгадаггүй юм уу гэв.

Гэвч Петр өөрийнхөөрөө зүтгэж

— Хөгжимчид?

— Хөгжим гэдэг бол ховор авьяас. Онцгой тохиолдол гэж Игорь айлдав.

— Чиний сэтгэлд юм таарах биш! «Онцгой тохиолдол, ховор авьяас, дан биеийн хөгжил» гэнэ. Юу гэж байгаагаа мэдэхгүй байж! гэж Вадим хэлэв.

Сэлбэг хэрэгслийн хэргээс хойш Вадим Игорийн нөлөөнөөс гарч байгаа нь илт байв. Үүнд нь би урамтай байлаа.

— Техник хөгжиж байна гэж Шмаков хэлэв.

Шмаков заримдаа огт ойлгогдохгүй үг хэлчихдэг юм. Түүний хэлснийг хүн бүгд ойлгодоггүй. Би харин ойлгодог юм. Түүнийг тийм тодорхойгүй юм ярихад нь би санааг нь лавшруулдаг юм.

Петрийн хэлэх гэснийг тодруулж:

— Македоны Александрын үед техник огт хөгжөөгүй, заан, илд, жад, бамбайтай байв. Пуужин, нисэх онгоц, танктай болсон орчин үеийн армитай жишиж үзэж болно гэж үү. Орчин үеийн техникийг эзэмшихийн тулд ихээхэн боловсролтой байх хэрэгтэй.

— Ээ чааваас аа! Македон биш Кир заантай байсан юм гээд Игорь инээв.

Македон Киртэй байлдаагүй, Дарийтай байлдсан юм гэж би хариулав.

— Хааны тухай ярьсан болохоос биш зааны тухай яриагүй гэж би хэлэв.

Игорь кабин руу даажинтай дохин:

— Харваас Зуев чиний сэтгэлд ганц таарч байх шив гэв.

— Зуев нэг хэрэг. Македоны Александр өөр хэрэг. Лев Толстой насан өндөр болсон хүн байсан, гэвч энэ нь түүний зуун бол өвгөчүүлийн зуун гэсэн үг бишээ. Жишээлбэл Лермонтов, Добролюбов...

Ингээд залхуутайяа сунжирсан явган хэрүүл болсон бөгөөд юу гэлцэж байснаа ч мартчихжээ. Халуу шатаж бие нозоорон, бид ч Липка руу эргэдэг тохой дээр хүрч ирсэн байлаа.

Липка бол зуслангийн суурин билээ. Энд туж модон хашаа байдаг. Заримынх нь дээгүүр өргөст тор татчихсан бий. Энд хувийн байшинтай, зусланд гарагчид суудаг. Зусланд гарагчид хувийн байшинтнуудаас сууц хөлсөлнө. Хувийн байшинтнууд зусланчдыг хөөрхөн шулдаг улс.

Машин зогслоо. Зуев кабинаас цухуйв.

— Хүүхдүүд ээ, зуслан руу очиж бай. Бид ачаагаа буулгачхаад очъё.

Бид бууж, зуслангийн барилга өөд явав. Тойруулан барьсан урт урт гонхтой том модон байр хэд хэд байлаа. Банз, дүнз, нимгэн банз, туйпуу болон барилгын бусад материал энд тэндгүй хэвтэж байв.

Бид нэг байраар орвол эзгүй байв. Бас нэгээр орвол хоосон ажээ. Амьтай голтой амьтан, тавилга мавилга юу ч алга.

— Гурав дахь байраас ярилцах дуу сонстов. Энэ дуу хоёрдугаар давхраас гарч байлаа. Бид өгсөж гарвал «Б» ангийнхан ажээ. Тэд залхуутай гэгч нь яриа дэлгэж, шалан дээр тэрийн хэвтэж байлаа.

Биднийг ороход тэд дуугаа хурааж, биднийг ширтэв. Бид ч өөдөөс нь харлаа. Ямар гэгч дадлага хийж байгаа нь бидэнд тодорхой болов.

— Ажил хийж байгаа нь энэ үү? гэж Игорь доогтой асуулаа.

— Тэд ёстой нэг залхуу хүмүүсийн байртай: Тэгээд юу гэж?! гэж хариулав.

Барилгын материал тасарснаас тэд сул зогсож байгаа нь цааших ярианаас нь мэдэгдэв. Энд хүүхдүүдийн хагас нь байсан бөгөөд бусад нь голд орохоор явжээ. Гэвч ингэж сул зогсох нь тэдний ганц жаргал гэдэг нь илт. Тануусыг гар таталгүй хооллодог юм шив? гэж Шмаков Петр хэлэв. Тэд дахиад л үг сөргөн Тэгээд юу гэж?! гэлээ.

— Нүүрээ ширлэчихсэн улс юм гэж Шмаков хэлэв. Петрийг ямар нэг бахдууштай юм хэлчихлээ гэсэн шиг тэднүүс хөөрөлдөн, тачигнатал инээлдэв. Гомдохоосоо ч хүртэл залхуурах болжээ.

Бид ирсэн учраа хэлж, актлагдсан машин хаана байгааг асуув.

— Агуулахын няравт л байгаа гэж тэд хариулав.

— Та бүхэн бөгс өндийж агуулахын нярвыг зааж өгч хайрлана уу? гэж би хэлэв.

Тэдний хэн нь ч байраасаа хөдөлсөнгүй. Тэд дахиад л тас тас хөхрөлдөн, машин засах гэсэн бидний саналыг элдвээр тохуурхаж гарав. Тэд ер нь зүгээр хүүхдүүд. Гэвч одоо ийм ааш нь хөдөлжээ. Анги нийтээрээ юу ч болоогүй байхад инээж, бархирч, элдэв наадам хийж, хий нь хөдлөх үе гардаг. Ийм үе нь болжээ.

— Янцгаахаа боль! гэж би хэлэв.

Гэвч тэд солио туссан юм шиг инээлдсээр байв. Машин босгох гэлээ гэж тэр. Машин сэлбэх гэсэн бидний санаа тэдэнд жигтэйхэн инээдтэй санагджээ. Тэд машины ажлын дөр юугаа мэдэх билээ.

Гэвч тэнэг юм бүр цэцэн цэлмэгийн охь мэт бодогдоно. Хэт идэж мийн суусны гор гарч байгаа нь энэ.

— Наргицгаа гэж бид хэлээд агуулахын нярвыг олохоор явав.

... Бид машинаа шалавхан бэлдчихээд залгаж авангуутаа яваад өгнө гэж бодож байлаа. Гэтэл тийм хялбархан юм биш аж. Зуев байгаагүй бол бид яаж ч чадахгүй байсныг би ойлгов. Ивашкин ажилд хуруу ч нэмэрлэсэнгүй, хэсэг сууж байснаа яваад өгөв.

Зуев дугуй хийлэхийг тушаагаад, гэрэл, дохиог янзалж гарлаа. Гэрэл, дохиогүй машин чирэхийг хориглодог юм.

Буланд нь гадуур хаймрыг углаж, олгойг нь дотор нь хийнэ гэдэг их хэцүү. Бид дугуйг эргүүлж, тойруулсаар ер нь өглөө болтол ноцолдох байсан байх. Игорь Вадимыг зандчин, би ч бас Вадимд цухалдаж эхэлсэнд Вадим юм юм барьж тавьж байв. Тэгснээ би түүнийг өрөвдөв. Тэр ямар ч гэмгүй, бид л түүнд уураа гаргажээ. Би түүнийг зандчихаа болиод, бас Игорийг битгий хашхичаад бай гэлээ. Игорь «чамаар заалгахгүй» гэж хариулаад Вадимыг аашилсаар байв.

Зуев ирж гадар хаймрыг гишгэн гөнжүүрээр дарж, олгойг хийв. Бидэнд хийлэх ажил л үлджээ. Бид ээлжээр хөөрөгдсөн боловч Игорь хөөргөө нэг л түргэн өгөөд байв. Тэгэхэд нь би:

— Ингээд ч бүтэхгүй шүү. Хүн бүр зуу дарах ёстой. Зуу дарж байж л дараагийнхаа хүнд дамжуулах хэрэгтэй гэв.

Бид тэгж ээлжлэх болов. Дугуй хий орсон юм шиг бидэнд хэд хэд бодогдсон боловч Зуев гөнжүүрээрээ цохиж үзээд «болоогүй» гэв. Бид ч хийлээд л байлаа.

Дөрвөн дугуйг цаг, магадгүй гурван цаг хэртэй ч хийлсэн байж мэднэ. Унатлаа ядарч, тоос шороонд хутгалдаж гүйцлээ.

Зуев ч ажлаа дуусаж байлаа.

Бид машинаа хөшүүрэгдэн, ивээс модыг авч дугуйг нь тавив. Энэ ч харин ядахааргүй ажил байлаа.

Зуев жолоо барьж биднийг түлх гэлээ. Бид налан түлхсэн боловч машин байраасаа огт хөдөлсөнгүй. Бүүр зэврээд барьцалдчихаж. Зуев кабинаас гарч, мөрлөж, агуулахын нярав ч ирж бидэнд хамжилцав. Тэгж, тэгж машиныг саравчнаас хашаанд өнхрүүлж гаргалаа.

Бид өлсөөд зусланд очиж юм олж идье гэж Зуевт хэлэв. Зуев дуугүйхэн толгой дохисноо, цаасанд боосон хиам, талх, өргөст хэмх гарган идэхээр суув.

Бид зуслан руу очлоо. Гуанз нь хоосон. Гал зууханд нь бидэнд юу ч өгсөнгүй, оройн хоол хүлээхийг зөвлөдөг байна.

— Сууринд цайны газар бий гэж Вадимыг хэлэхэд

— Мөнгө байхгүй гэж бид хариулав.

Вадим хэсэг тээнэгэлзсэнээ:

— Би зээлүүлье, гэхдээ цалингаа авахлаараа өгнө шүү гэв.

Бид өгнө гэж ам алдаад, цайны газар руу урамтай нь аргагүй явцгаалаа. Бид ёстой ажилчид шиг цайны газар хооллохоос биш, усан шөл, жимсний идээ өгдөг зуслангийн гуанзанд хооллохгүй дээ.

Цонхны дэргэдэх ширээнд сууцгаав. Вадимын минчийсэн малигар царай нь нэг л түгшсэн байртай. Биднийг өрөө төлөхгүй гэж айжээ. Гэвч яах ч арга байсангүй. Халааснаасаа үнгэгдсэн гуравтын дэвсгэр гаргаж

— Гурван рубль гаргалаа. Хүн бүрээс дал далан мөнгө авах болж байна. Илүү гарсан хорин мөнгө нь миний тооцоонд орно. Зарцгаа гэв.

Хорин мөнгө илүү гарахыг хэлээд бүр ч сэтгэлээр унав.

— Хүн бүр дуртайгаа захиалъя. Мөнгө тооцоод яах юм гэж Игорь санал гаргав.

Мөнгө тооцоод юугаа хийх вэ гэдгийг бид зөвшөөрч байв. Гэвч бүгдээрээ адилхан захиалбал дээр юм. Игорь тоомжиргүй царай гаргасан боловч олонхын саналыг аргагүй дагав.

Бид май загасны зууш дөрөв, ногоотой шөл дөрөв, ястай махан хуурга дөрөв, жимсний шүүс дөрвийг захив.

— Эндэхийн жимсний шүүс лав өөдтэй байж чадахгүй дөрвөн шүүсний оронд хоёр шил пиво захъя. Хүн хүнд нэг шилэн аяга ноогдоно гэж Шмаков хэлэв.

Шмаковын саналыг бид зүйтэй гэж үзэв.

Хормын дотор май загасан зуушийг цааш нь харуулж, пивоор дарууллаа. Дараа нь шаз халуун шөл авчирч өгөв. Үүнээс бид урсчих дөхөв. Бас тэгээд цонхны дэргэд суучихсаныг хэлэх үү. Нар гудайсан боловч цоноосоор байлаа. Хуурга идээд бүр мангуу юм шиг болчхов. Гэвч хоол идэж аваад ер нь сайхан болоод явчхав. Нар цоргиж, сууринд таг чимээгүй учир ам цангаж, нойр хүрнэ.

Бид нэг ч их яарсангүй. Юундаа ч яарах билээ. Хийдгээ хийж, машинаа жин тан болгочихсон. Зуев нь барьж, Ивашкин нь чирэх юм чинь. Биднийг орхиод явахгүй. Явбал ч явж л байг! Тэгвэл усанд орж аваад галт тэргээр явчихна. Машинаар явах ямар албатай биш. Машиныг Зуевт итгэмжилсэн болохоос ямар бидэнд итгэмжилсэн биш. Баяртай, алтан шар зам ерөөе.

«Б» ангийнхны байгаа зуслангаар оров. Тэднээр даажигнаж хариугаа авах хэрэгтэй. Гэвч зусланд амралтын цаг болчхож. Хэрэв шуугиан дэгдвэл жаалууд сэрчихнэ. Тэдэн дээр «Б» ангийн усан тэнэгүүдийг ирүүлсэнд тэдний буруу юу байх билээ.

Хоёр машин байрандаа зогсож, Ивашкины машин ч бидний чирч явах ёстой машин ч хоёулаа байна. Дор нь Зуев суудлын зөөлөвчийг дэвсчихсэн унтаж хэвтэнэ.

Бидний дуунаар Зуев сэрж машин дороос мөлхөн гарч ирээд нойрмог дуугаар

— Ивашкин хаана байна гэж асуув.

Бид мэдэхгүй гэж хэллээ.

Зуев торхон дох усаар нүүрээ шавшаад, Ивашкиныг эрэхээр явав. Ашигч Шмаков Зуевын унтаж байсан зөөлөвчийг бушуухан дэлгээд хэвтэж өгөв. Вадим суудлын түшлэгийг шүүрэн авч бас хэвтчихэв.

Тэгэхэд нь Игорь бид хоёр Ивашкины машин руу ухасхийв. Кабиныг бие биеэсээ түрүүлэн эзэлж авахыг мэрийлээ. Бидний нойр хүрсэнгүй. Вадим, Шмаков хоёр унтах байр олсон бол бид бас түүнээс нь тухтай байр олох гэлгүй яах вэ.

Бид хоёр кабиныг зэрэг онгойлгож чихэлдэн зүтгэв. Тэгж тэгж хоёулаа кабинд орохчоо боллоо. Хэвтэх газар байсангүй, би жолооны ард Игорь хажууд суув.

Игорь хянах самбараас нүд салгаж чадахгүй байгааг би үзлээ. Би харцыг нь дагуулан харлаа. Бидний нүд нэгэн цэг дээр туссан тэр агшнаас эхэлж хамаг хэрэг мандав... Ивашкин түлхүүрээ кабиндаа орхичхож. Машин бидний гарт байлаа...

— «Москвичийнх» байрлал нь шал ондоо... гэж Игорь бувтнав.

«Москвичийг» би мэдэхгүй. Гэвч ГАЗ-51-ийг сайн мэднэ. ГАЗ-51-ээр би дадлага хийсэн юм. Тэгээд Игорьт тайлбарлаж гарлаа. Бүр сайн тайлбарлахын тулд моторыг асаамаар санагдаад байв. Тайлбарлаж байгаагаа практик дээр нотлохын тулд шүү.

Энэ машин хүнийх нь хүний л дээ. Гэвч хоромхон зуур асаагаадахъя. Юу л болоо гэж. Хэн юу мэддэг юм... Би түлхүүрээ эргүүлж, агаар соруулан, асаагуурын дөрөөг гишгэв...

Мотор хүрчигнэлээ. Агаар сорогчийг цааш түлхэж хаазаа хасав... Мотор нэгэн хэвээр намуухан хүрчигнэнэ.

— Сайхан ажиллаж байна гэж Игорь хэлэв.

— Дажгүй гэж би хариулаад унтраав.

Мотор чимээгүй болов.

— Аль вэ хө, би нэг үзье гэж Игорь хэллээ.

Бид суудлаа солив. Игорь түлхүүрээ түлхэж, хэсэг бодон санаа алдсанаа асаагуурыг гишгэв.

Мотор дахин асав.

Игорь хаазаа нэг хасаж, нэг чангаруулав. Хөдөлгүүр нэг хүч аван хүнгэнэж, нэг намжина.

— Одоо боль, унтраа!

Бид байраа дахин солилоо.

— «Москвичийн» мотор арай намуухан, жигд асдаг юм гэж

Игорь хэлэв.

Би хариуд нь

— За мэдэхгүй... ялгаа юу байгаа юм гэж хайнгадуу хэллээ. Энэ үед би зүүн хөлөөрөө залгуурын дөрөөг гишгэж, дараа нь хөлөө авав. Тэгээд дахин гишгэснээ ахиж болилоо. Ингэхдээ байцаагчийн зааснаар зөөлхөн хийх гэж мэрийж байв. Дараа нь нэгдүгээр араанд залгасан чинь сайхан залгагдав. Хоёрдугаар араанд нь бас сайхан залгалаа. Гуравдугаарх нь ч сайхан залгагдав. Ухрах араанд нь хийвэл бас сайхан боллоо. Хөнгөхөн, ямар ч гацаагүй сайхан залгагдаж байв. Мотороо асаагаад энэ бүхнээ дэс дараатай хийвэл, явах гэсэн газраа тайван гэгч нь явна даа.

Игорь ГАЗ-51-ээс «Москвич» илүү гэж ихэрхүү ярина... Гэвч түүний үгийг сонсохтой манатай байв. Өөрөөр хэлбэл хамаг анхаарал минь машин руу явчихсан байв. Би мотор дахин асааснаа унтраалаа. Дахин асаав...

Моторыг гурав дахиа асаахдаа нэгдүгээр араанд нь залган, залгагч дөрөөг аяархан тавиад хаазаа нэмж эхэллээ.

Машин алгуурхан, намуухан урагш хөдлөв.

Тэгэнгүүт нь хоёрдугаар арааг залгах гэсэн боловч болж өгсөнгүй. Би сандран түлхсэн боловч араагаа оруулж яагаад ч чадсангүй. Машин хүч алдав. Тэгэхлээр нь нэгдүгээр араанд дахин залгалаа. Энэ үед би дэндүү их хаазалчхаж. Машин ухасхийснээ зогсчхов. Мотор унтарлаа.

— Гайхуулах юмгүй л байна даа гэж Игорь хэлэв.

Би жаал тайвширч биеэ барин машиныг дахин асааж, арын цонхоороо харсаар ухарч эхлэв. Байсан газар нь хүрмэгц тоормослов. Мотор ахиад л унтарчихлаа.

Дунд гэж Игорь хэлэв.

Яагаад ингэснийг би тайлбарлаж гарлаа. Гэтэл Игорь угийг минь тасалж:

— Шүүхэд л очиж биеэ өмөөр. Хоёр дахиад л унтраачихлаа даг гэв.

Шмаков, Вадим хоёр хүрч ирээд Вадим нь:

— Зугаалж байна уу? гэж асуув.

Шмаков Петр юу ч асуусангүй. Шмаков Петр асууж хоргоох дургүй. Тэр тусмаа Вадимынх шиг юм бол бүр ч асуухгүй.

— Аль вэ би! гээд Игорь намайг суудлаас минь түлхэв.

Мань хүн бас хөдөлгөж үзэх гэж. Би болгоомжиллоо. Би ч яах вэ амиа хоохойлчихно, харин надаас илүү барьдаг ч гэсэн Игорийн төлөө айж байв.

— Ивашкин ирвэл сүйд болно доо гэж би санууллаа.

Игорь хариуд минь

— Надад зоволтгүй, өөрийгөө л хичээ гэж бувтнав.

Тэр бээр машиныг асааж дааман хүрээд, ухарч ирэх, ахиж хаалга хүрснээ буцаж ирэв... Тэгээд Москва руу бидний чирч явах ёстой машины зүг явлаа. Дэргэд нь очоод зогсож, кабинаас цухуйн:

— Чиргүүлийг холбоодох! гэж хашхирав.

— Чи яах нь вэ? солиоров уу? гэхэд минь

— Зоволтгүй, дөнгөж татлагаар нь холбож, ажлаа ян тан болгочихъё, жолооч бидэнд баярлалаа л гэнэ. Аль вэ Шмаков холбоодох! Вадим хамжилц!

Шмаков, Вадим хоёр чиргүүлийг шүүрэн авч зүүж гарав.

Ингээд яахыг би ойлголоо...

Игорийн онгод нь орчхож. Вадим, Шмаков Петр хоёр ч онгод нь хөдөлчхөж. Машиныг ялимгүй ч гэсэн чирч үзэх юм. Ингэвэл ч би маанайж хоцрохгүй ээ. Би хоёр дахь машины кабин руу бушуухан орж жолооны ард сууж авав. Намайг алмайрч хоцорвол Вадим, Шмаков хоёрын нэг нь надаас энэ жолоог булаачихна.

— Болсон уу? гэж Игорь кабинаас цухуйн гарлаа.

— Болсон гэж Вадим хариулав. Тэр түрүүчийн машины татлагыг уяж байсан юм.

Шмаков хариу дуугарсангүй. Тэр арын машины татлагыг бэхэлж байсан юм. Урьдынх шигээ л тэнхээ мэдэн янцаглана.

— Крош, түүнд элбэлцээд өг! гэж Игорь тушаав. Би байраасаа хөдөлсөнгүй. Мөн хүнээ олов оо! Намайг кабинаас бөгс өндиймөгц

Вадим, энэ Шмаков Петр хоёрын нэг нь байрыг минь эзэлчихнэ.

Игорь тэсгэлгүй кабинаас ухасхийн гарч Шмаковт тусалж эхлэв. Хоёулаа машин дор хэвтчихээд шуухинан янцаглан, хараал тавина... Тэгснээ тоосоо гөвж амьсгаадсаар босов... Хамаг юм бэлэн болжээ.

— За Вадим чи Крошийн гишгүүр дээр зогс. Шмаков чи минийх дээр зогс. Дохио өгөөрэй. Крош чи бэлэн үү?

— Би бэлэн гэж хэлээд жолооноос чанга зуурав. Гишгүүр дээр Вадим зогслоо.

Урдах машин хөдлөв. Татлага чангарав. Машин ч овсхийж араас нь өнхөрлөө.

Би машин дажгүй барьдаг юм. Манай байцаагчийн хэлдгээр итгэлтэй барьдаг. Гэвч одоо надад нэг л итгэл алга байлаа. Би өөрөө явж байгаа биш чирүүлж яваагаас тэр. Бугуйлаар оосорлуулчихсан юм шиг. Би хүний эрхэнд, Игорийн мэдэлд байв. Игорь машин жолоодож чадах нь чадна. Гэхдээ машин чирнэ гэдэг шал өөр хэрэг. Хэнийг чирч яваа билээ гэдгээ бодолцох хэрэгтэй. Гэтэл Игорь хувиа борлуулж явлаа. Угз угз татна. Татлага нэг чангарч, нэг суларна. Игорийн машины араас очоод мөргөчих вий гэж би эмээж явав.

Бид хашаанаас гарч зогслоо. Игорь кабинаас гарч над руу хүрч ирээд:

— Ямар байна? гэв.

— Дажгүй! Харин битгий угзчаад байгаач! гэж гуйхад минь

— Өөрөө угзачсан байж гэж Игорь хариулав.

Бид хэд ахиад урагш хөдөллөө. Замын баруун гар талд ой үргэлжилж, зүүн гар талд бузгай гүнзгий жалга байв. Зам донсолгоо ихтэй ажээ. Гэвч ой мод, жалга донсолгооны алинаас нь ч би зүрх алдсангүй. Одоо би бүр зэгсэн дасжээ.

Игорийн ч булуу халчхаж. Хурдаа арай нэмлээ. Тэгснээ гулд татав. Хоёрдугаар араагаа залгахдаа бас ухасхийлгэв. Машин минь гэнэт баруун тийшээ дөлөв. Би жолоог зүүн тийш нь эргүүлэв. Игорь дахиад л угзрав. Машин маань зүүн тийшээ чангаав. Би жолоогоо баруун тийш хариулж мушгив. Намайг зүүн баруун тийш авч шидлэв...

Вадимд «Зогсоо» гэж хашхирлаа. Вадим гараараа далласан авч Игорь зогссонгүй. Намайг дахиад л зүүн тийш нь ганга руу чангаав. Би хамаг чадлаараа жолоогоо мушгисан боловч дийлдэхгүй байв. Би тоормос гишгэлээ... Машин маань хэлтийж ганга руу гулсаж эхлэв.

Өмнө маань Вадимын айчихсан царай зурсхийв... тэр бээр
гишгүүр дээрээс харайн буугаад доош бөмбөрөв. Машин гулссаар
улам улам хэлтийнэ. Би суудлаасаа өнхөрч хаалга руу унав...

Кабин газар хэвтэж байсан учир би гарах аргагүй байлаа. Гар минь нэг юманд түлэгдсэн байна, гэвч үүнийг анзаарахтай манатай. Эндээс шалавхан гарах юм сан гэдэг ганц бодол төрнө. Баруун талын хаалга дээр минь байсанд би онгойлгох гэж үзэв. Хаалга яйжийгаад гацчихжээ. Аз болоход шилгүй байж. Би тэнийж нэг хөлөөрөө жолоо, өрөөснөөрөө суудал руу жийн кабинаас мацаж гараад, газарт үсрэн бууж ийш тийш харлаа.

Машин маань ганганд бөөрөөрөө хэвтэж байна. Ивашкины машинд холбосон татлагад торж тогтжээ. Татлага чавхдас аятай чангарч, түүнд миний машин дүүжлээстэй байв.

Машины тэндээс бэлийн дагуу зурвас газрыг онги онги татаж, ногоог няц дайрсан нь зурайн харагдах бөгөөд Игорь намайг хориод метр хэртэй газар хөндлөн чирчээ.

Игорийн машин зам дээр зогсож байна. Игорь кабинаас цухуйн намайг харж байх аж. Тоормосноос хөлөө авахаас айгаад гарч ирэхгүй байлаа. Царай нь цонхийжээ. Гишгүүр дээр Шмаков Петр зогсох бөгөөд царай нь хувираагүй байна. Дээхэнтэй Вадим зогсож байв. Түүний царай цайсан эсэхийг харсангүй.

Гурвуулаа намайг балмагдан харах боловч байраасаа үл хөдөлнө. Намайг үхчхэж гэж бодоод ойртохоосоо зүрх алдаж байжээ.

Гэвч би амьд мэнд гарав. Тэр бүү хэл шалбарсан ч үгүй. Зөвхөн гараа л түлж. Зай хураагуурын хүчилд гараа түлчхэж гэдгээ сая л нэг юм ухаарав. Зуев түүнийг Москва хүртлээ кабинд түр зуур тавьсан юм. Айгаад байх юмгүй. Зай хураагуурт зуун хувийн хүхрийн хүчил байхгүй, электролит уусмал байгаа. Жаахан хорсгоод л зүгээр болно.

— Крош чи амьд уу? гэж Вадим хашхираад над руу гүйж ирэв.

— Өөд болсоон гэж би хариулав.

Шмаков ч бас хүрч ирлээ. Тэд намайг нөгөө ертөнцөөс ирсэн мэт ширтэнэ.

— Танихгүй байна уу? гэж намайг хэлэхэд Шмаков

— Чи яагаад ингэчхэв? гэж асуулаа.

Би мөрөө хавчисхийлгэв. Ганга руу яаж орсноо, яагаад ингэчихсэнийг би өөрөө ч ойлгохгүй байв. Жолоогоо тавиагүй, ухаан алдаагүй. Жолоо надад дийлдэхээ больсныг л, машин залагдахаа

байсныг л сайн мэдэж байв. Үнэхээр л машин залагдахаа больж, ганга руу шарваад байсан юм.

— Хүүе, нааш ир! гэж Игорь дуудав.

Хөөрхий минь тоормосоо тавьж чадахгүй байж. Бид хүрч очив.

— Яав аа? гэж Игорь асуув.

— Харахгүй байна уу?

— Яахлаараа ингэчихдэг байна?

— Чөтгөр бүү мэд! Чи угзчаад гарсан, машин залагдахаа больсон.

Игорийн уруул нь чичгэнэв.

— Хэдийд би угзарсан юм?

— Тэгэхэд! Вадим чамайг зогс гэж хашхирсан, чи урагшаа зүтгээд байсан.

Худлаа, би дороо зогссон гэж Игорь дүрсхийв.

— Үгүй ер... хэн намайг гангаар... хориод метр чирсэн болж байна... Пушкин уу?

— Чи залуураа сайн барихгүй яасан юм?

— Би барихад ч барьсан... Машин л залагдахаа больсон. Жолоо нь эвдэрсэн байж магад... Бид энэ машиныг мэдэхгүй шүү дээ. Чирэх хэрэггүй л байж!

— Хэн анх машин асаасан бэ? Хэн анх явуулсан бэ? гэж Игорь хариуцав.

— За маргалдаад яах вэ. Дандаа л чинийх зөв байдаг газар. Яахаа л бодъё гэж би дүнсгэрхэн хэллээ.

Яахыг хэн ч мэдэхгүй байлаа.

— Доош нь татаад оруулчихгүйн тулд энэ машины доогуур чулуу ивье гэж Шмаков санал гаргав.

Бид дөрвөн дугуй доогуур нь том том чулуу ивлээ. Игорь тоормосноос хөлөө болгоомжтой авав. Машин дөлсөнгүй.

— Гарч болно. Гар тоормосыг нь татаад араатай нь орхичих гэхэд минь

— Ганц ухаантай нь чи бишээ гэж Игорь хариулаад кабинаас гарав.

Хэдүүлээ миний машин руу очлоо.

— Бензинтэй байсан бол гал гарах байж шүү гэж Вадим, хэлэв.

Юу болох байсныг бодох нь сонин биш. Энэ гарсан хэрэг бидэнд багадахгүй.

— Мундаг цуугиан дэгдэнэ ээ гэж Вадим ам дуугүй байсангүй.

— Хэнийгээ ч ховлохгүй гэж тохиръё гэж би хэллээ.

Хүүхдүүд ч тэгье, бурууг бүгдээрээ хүлээе гэв.

Машинаа яаж чирч гаргахаа бид эргэцүүлж гарлаа. Татлага бөх боловч жалга эгцийг хэлэх үү, бас тэгээд машин хажуулдчихсаныг яана.

Гэсэн ч Игорь үзээд алдъя гэлээ.

— Осолтой хэрэг! Хоёр дахь машинаа ч ийш хийнэ гэсэн үг. Тоормос л тавивал доош нь татчихна гэж Шмаков хэлэв.

— Яах вэ?

Яах тухай бодож завдсангүй. Ивашкин, Зуев хоёр замаар гарч ирэв.

Юу ярилцсанаа би тоочихгүй. Ивашкины хэлсэн үгийн оронд цувраа цэг тавьчихъя.

Гэвч цувраа цэгтэй хамт архи хан тавьж байлаа. Ивашкины нүүр улаан лооль шиг минчийжээ.

Энэ зуур Зуев явган сууж татлага бэхэлсэн газрыг харав. Тэгээд босож:

— Тийм л байх ёстой гэж тайвуухан хэллээ.

— Татуургаас уу? гэж Ивашкин асуухдаа царай нь час улайв.

— Ай даа.

— Дахиад л цувраа цэг тавья. Энэ зуур би машины доогуур тонгойж харав. Осол гарсны учрыг дор нь ойлголоо. Татлагыг зохих ёсоор арлаас бэхлээгүй, жолооны хөндлөн татуургаас бэхэлсэн ажээ. Угз татсанаас татуурга нь мултарч, машин жолоодогдохгүй болсон байна. Ингээд би сувраг руу ойчжээ. Жолооны удирдлагын аль нэг хэсгээс татлага уяна гэдэг бол ёстой бүдүүлэг алдаа. Үүнээс болж заавал сүйрэл гардаг. Бид ч харин гайгүй өнгөрч. Машины хурдыг нэмсэн бол тэгээд бас машин зөрдөг зам дээр бол Вадим бид хоёроос яс ч үлдэхгүй байжээ.

Үүнийг бодохоос гол руу хүйт оргиод явчхав. Ээж минь сүйд болох байсан даа! Бодоход ч зүрх ширхийнэ.

Би Игорь, Шмаков Петр хоёрыг харав.

Тэр хоёр л татлага уясан шүү дээ. Игорь буруудахаас сүнсгүй айж, цас шиг цонхийн зогсоно. Харин Шмаков зүгээр байна. Шмаковын царай хувирсан янзгүй.

Үдэш болтол ноцолдож байж машинаа арайхийж нэг юм татаж гаргав. «Б» бүлгийн хүүхдүүд, амралтын хувцастай зусланчид бидэнд

бэлдэлцэж өгөв. Зусланчид ийм тийм гэлцэж, ингэ тэг гэж зөвлөнө.

Яагаад ингэчихсэнийг «б» ангийнхан шалгаана. Бид тэдэнд юу ч ярьсангүй. Осол гарсан л байгаа биз? Долоон булчирхайгаа тоочих юм уу...

Харай бүрий боллоо. Хоёр машинаа зам дээр гаргалаа.

Бүгдээрээ тарцгаав. Ивашкин, Зуев бид зургаа хоцорлоо.

Шөнө, бас тэгээд жолоодлого нь хэмхэрсэн машин чирч болохгүй гэж Ивашкин хэлээд багажаа хурааж, татлагаа хашлага руу шидээд Зуевт:

— Явцгаая гэж хашхирав.

Зуев

— Хүүхдүүд ээ, суугаарай! гэхэд нь би

— Машинаа орхих юм уу? гэж асуув.

— Бас юм ярина аа! гэж Ивашкин бархирав.

— Хүүхээ, зоволтгүй, машин яах ч үгүй гэж Зуев хэлэв.

Гэвч би үлдэнэ гэж хатуу шийдсэн байлаа.

— Үгүй ээ, бид машинаа орхиж чадахгүй, үүнийг хариуцаж байгаа юм. Та нар очоод маргааш өглөө засварын тэрэг явуул гэж хэлээрэй.

— Үлдэж л байхгүй юу гээд Ивашкин кабин руугаа орчхов.

Гэтэл Зуев биднийг үлдээх дургүй, авч явах гэж ятгав.

Энэ зуур Игорь ганц ч үг дуугарсангүй. Тэгснээ биднийг хажуу тийш аваачаад

— Бидний нэг нь хот явалгүй горьгүй. Нэгд энд үлдэгсдийн тухай ар гэрийнхэндээ хэлэх ёстой, хоёрт туслах ажил зохион байгуулах хэрэгтэй гэв.

— Явах гээд байгааг чинь мэдэж байна, явж л байхгүй юу.

Вадимыг аваад яв. Цаадах чинь бас л харихын хүслэн болж байгаа байлгүй.

Игорь ёжилж байгааг минь анзаараагүй дүр үзүүлэн

— Ингэсэн нь зөв болов уу гэж бодно. Вадим гэрийнхэнд хэл хүргэг, би даргыг эрж олъё, тэр дор нь «засварын» тэрэг явуулах байх, би түүгээр эргээд ирье.

Игорь даргыг олно гэдэг дэмий, шөнөөр «засварын тэрэг» хэн явуулах вэ. Энд хоцрох дургүйдээ л тэгж байгаа юм.

Би доогтойхон:

— Яв, яв, чамайг барьсан хүн алга гэлээ.

Игорь дооглосныг минь бас л үл анзааран:

— Харж байгаарай, тэгсэн нь дээр дээ. Ер нь Шмаков та хоёр яв, Вадим бид хоёр үлдье гэв.

Түүний яагаад ч хоцрохгүйг нь би мэдэж, яаралгүйхэн:

— Яв, донгосохоо боль! гэв.

— Та нар явах юм уу, үгүй юу гэж Ивашкин кабинаас бархирав.

— Одоохон, одоохон гэж Игорь хашхираад надаас за тэгж шийдэх шив гэж асуулаа.

— Тэглээ гэж би ууртайхан хариулав.

— Вадим, явъя гэж Игорь хэллээ.

Вадим гэнэт:

— Би явахгүй ээ гэж хариулав.

— Яагаад?

— Би эдэнтэй үлдэнэ.

— Битгий тэнэглээд бай. Чамайг яв гээгүй юу, тэгэхлээр явъя гэж

Игорь цухалдав.

— Орилоод байвал чамайг... гэж Вадим өчив.

Вадим Игорьт уруу татагдахаа бүр байж гэдэгт би итгэлээ.

— Байж л байхгүй юу! гээд Игорь хашлага өөд авирав. Машин хөдөллөө. Минут болоод арын улаан гэрэл далдрав.

Шөнө болов. Намуухан, жихүүвтэр байлаа. Баруун талд ой бараална. Урд маань, жаахан зүүнээр пионерын зуслангийн гэрэл гялалзаж, баруухнаар зуслангийн суурины дэнлүү хаа нэгтэй харагдана. Бид замын хажууд сууцгааж Москва руу яваагүйн учрыг хэлэлцэж гарав.

Энэ тухай хэлэлцэх оройтжээ. Үлдэхийнхээ өмнө бид ярилцах хэрэгтэй байсан юм. Тэр үед нь тэгээгүйгээс хойш одоо ярихаас өөр яах вэ.

Бид явсан бол яах вэ? Бид машиныг онхолдуулж, осол гаргачихсан учраас машингүй гараашинд очих байсан. Хоёр дахиа биднийг явуулалгүй жолооч нарыг явуулах байсан. Тэгвэл бид машиныг авчирч чадаагүй, тэд авчирсан болж таарна. Үүгээрээ бид бүтэлгүй улс гэдгээ харуулах байсан.

Одоо бол шал ондоо хэрэг. Маргааш энэ машинаараа гараашинд орж очно. Тэд юу ч гэж хэлж байлаа гэсэн үнэн юм үнэнээрээ бид ямар ч атугай машинаа авч очиж байгаа юм. Осол гаргасан ч байсан тэр. Үүгээр бид чадалтай гэдгээ нотолно. Энэ болсон явдал юухан ч биш! Замд хэрэг явдал болохыг алийг тэр гэх вэ? Тэр тусмаа өвөлжингөө саравчинд хэвтсэн эвдэрхий, үл мэдэх машин шүү.

Ийм учир бид энд үлдсэн юм. Машин яачих бол гэж айсандаа ердөө ч биш. Шөнө түүнийг хэн хайхрах вэ?

Яах гэж үлдсэн тухай асуудлыг шийдвэрлээд бид гарсан ослыг шүүмжлэн хэлэлцэв.

— Ээ чааваас гэж! Дэгээнээс татуургыг ялгаж чадсангүй юу гэж би Шмаковт хэллээ.

— Би ч ялгаж л байсан даа. Игорь давхиж хүрч ирээд л, татлагыг татуургаас өлгөчихсөн.

— Чи дуугүй л байжээ

— Хэлэх гэсэн чинь та нар хөдөлчихсөн.

— Түргэн сэтгэх хэрэгтэй.

Вадим:

— Би л татлагыг зөв бэхэлсэн дэг гэж онгиров.

— Тэгнэ ээ бас! хашлаганы доор юм чинь. Дэгээ тэнд хамар дор чинь байгаа гэж Шмаков зөрөв.

— Юу ч л гэсэн би зөв бэхэлсэн юм даг гэж Вадим осол өөрийнх нь уршгаар гараагүйд их додигор давтан хэлэв. Тэр дандаа л буруутаж явдаг агал өнөөдөр түүнээс бусад нь буруутжээ.

— Чи хаашаа зугтлаа. Километр гаруй гэж би сануулав.

— Чи намайг хаана зогсож байлгах гэв. Машин чанх дээрээс минь унаж ирсэн шүү дээ.

— Өнхөрч явахад дотор нь сууж байсан надад аятайхан байсан гэж бодож байна уу? гэж асуугаад би ч гэсэн ухасхийж гараад километрийн газар зугтчихаж болох л байсан шүү дээ. Гэтэл би эцсийн хором хүртэл жолоогоо барьсаар л байсан биш үү.

— «Далайчин минь залуураа бүү тавь» гэж Вадим аялав.

— Машинаас гарч байхад чинь гар хөл чинь чичирч байгаагүй юу гэж Шмаков хэлэв.

— Миний юу ч чичрээгүй ээ! гэж би хариулав. Баруун талын шуумагт алга дарам газар цоорхой тэмтрэгдэв. Хүрмэгц хурууны аяар даавуу өмөрч ойчиж байлаа... Аа мэдлээ! Би өмдөө зай хураагуурын хүчилд түлчхэж. Электролит арьс түлдэггүй, даавууг дор нь түлдэг юм. Мөн золиг оо! Өглөө гэхэд өмдгүй хоцорч мэдэх нь ээ!

Би өмдөө тайлав. Хүчилд их түлэгдэж үү, маргааш өмсөж хот орж болох нь үү үгүй юу гэж өмдөө сарны гэрэлд үзэв. Хоёр цоорчээ. Хоёулаа баруун гуяндаа нэг нь өвдөгний тушаа, нөгөө нь бүүр шуумагтаа.

— Өмд ч хөг өнгөрчээ гэж Шмаков Петрийг хэлбэл Вадим:

— Алзахгүй, салхи орж байх нь дээр гэж Вадим сэтгэл засав.

Сэрүүн салхи сэвэлзэв. Шуудагтай зогсоход хүйтэн байлаа. Би өмдөө өмсөв.

Бид унтахаар хэвтэв. Унтвал гэдэс өлсөхгүй. Шмаков дээр гарч Вадим бид хоёр кабинд оров.

Бид хоёр талын буланд сууж кабины хана дэрлэв. Хөлөө жиймээр, юм идмээр, кабин шилгүй учир ямар нэг дулаахан юмаар биеэ хучмаар байлаа...

Нэг мэдсэн чинь энгэрээр машинтайгаа гулсаж байна гэж зүүдэлж байлаа. Бензингүй байж мотор нь ажиллаж байгаа нь жигтэйхэн. Би дохиог дуугаргаж, хамаг чадлаараа товчлуурыг балбана. Гэвч Игорь зогсохгүй байлаа. Тэгэхэд нь би цээжээрээ дохиог дарвал үргэлжилсэн дуу хадна... Би улам хүчтэй дарав.

Би унах шиг болж толгойгоо сэгсэрснээ сэрчхэв... Бүрээн дуу сонстлоо. Зуслангийнхны босох цаг болжээ. Үүр цайж байлаа. Шөнө өнгөрлөө гэж үү? Бид дөнгөж сая унтсан шүү дээ...

Би Вадим, Шмаков хоёрыг сэрээв.

Тэр хоёрын жалх гэж ёстой тавиад туучихсан байлаа. Үүнийг нь тэдэнд хэлсэн чинь тэд нар чиний ийм ёозгүй царайтай байхыг огт хараагүй гэж өөдөөс минь хэлэв.

Бид кабинд оров. Хэсэгхэн зөвлөлдөөд, хоёр нь гуанз руу явж, нэг нь үлдэж машиныхаа дэргэд жижүүрлэхээр шийдэв.

Бид шоодов. Аз харихад над жижүүр хийх надад ноогдлоо.

Жигтэйхэн өлсөж, хүүхдүүдийн авчирч өгөх юмыг бушуухан идэхээр, тэднийг тосон замаар лагерийг зүглэв.

Би хором бүр эргэн эргэн харсаар явлаа Биднийг авах гэж Москвагаас ийм эрт ирэхгүй нь лав. Дарга ирээд, Игорь болсон зүйлийг яриад «засварын тэрэг» төхөөрөөд, тэр нь энд иртэл өдий, лав хоёр, гурван ч цаг болж мэднэ. Гэвч би эргэж харсаар л явлаа. Гэнэт эрт хүрээд ирвэл яана?

Ийнхүү явсаар л байлаа. Нэг тохой тойрлоо, дараагийнхыг тойрлоо. Машин маань харагдахаа больсон авч засварын машин ирвэл дууг нь дор нь сонсоно гэж би сэтгэлээ засаж явав.

Ингэж сэтгэлдээ тооцоолсоор явтал зусланд хүрч ирлээ. Шинэ талх, бэрээсээ, шарсан махны үнэр хамар цоргив. Гуанзанд шуугилдаж байгааг үзэхэд өглөөний цай ид ууж байгаа хэрэг. «Б» ангийнхны хооллож байсан саравч руу хөлийнхөө чадлаар хурдлав.

Биднийг авахаар засварын машинаар олон хүн ирсэн нь хачирхалтай. Хоёр жолооч, засварчин ч ирэх нь аргагүй. Бригадын дарга Дмитрий Александровичийг ч яах вэ гэе. Игорь ч яалаа гэж хожигдох вэ. Гэтэл ерөнхий инженер, ангийн багш Наталья Павловна хоёр юугаа хийж ирсэн юм бол? бүхээгтэй тэрэгнээс бууцгааж байгааг нь хараад бид мэл гайхаж хоцров.

Наталья Павловна бидэн рүү ухасхийж ирээд, биднийг мөн үү? гэсэн шиг цөмийг минь илж үзэв. Бид мөн бол амьд мэнд үү? Амьд мэнд бол зүгээр үү? гэж үзнэ.

— Та зовоод л байсан! гэж ерөнхий инженер түүнд хэлэв.

Түүний царайг харахад биднийг амьд байгаа гэж бодоогүй бололтой.

— Хэрэг мандууллаа даа гээд бригадын дарга Дмитрий Александрович тоорцгоо авлаа. Малгайгаа авахад нь толгойных нь халзан ил гарч испани хүнтэй огт төсгүй болчхов.

Биднийг сүйд болсон байх гэж Москвад үзэж байгаа нь бидэнд илт боллоо.

— Гөжүүдлэлгүй надтай цуг хот руу явсан бол яалаа гэж ийм шуугиан дэгдэх билээ гэж Игорийн зэмлэнгүй хэлэхэд нь

— Бидний юунд үлдсэнийг чи мэднэ шүү дээ гэж бид хариулав.

— Ийм ямбийг манахаар та нарыг үлдсэн гэдэгт итгэх хүн олдсонгүй гэж Игорь хэлэв.

Бас л бид буруутан болж таарав.

— Хүүхдүүд минь бодоод үз, та нар ар гэрийнхнийхээ сэтгэлийг хэчнээн зовоов! Машин хөмөрсөн гэж байдаг, та нар алга байдаг. Ямар юм тэдний толгойд орох билээ дээ!

Тэр ч тэгнэ ээ! Ар гэрийнхэн өөдтэй юм, ядахдаа наанатай цаанатай юм бодно гэж үү?

Ийнхүү ярилцаж байх зуур манай машиныг янзалж, «засварын тэрэгний» араас холбов. Татлагаар биш урт металл аргамжаар холбов. Үүнийг «хатуу татлага» гэдэг. Одоо манай машин яах ч үгүй ээ.

Ерөнхий инженер түрүүчийн машины кабинд, бригадын дарга Дмитрий Александрович арын машины кабинд, бусад нь засварын тэрэгний бүхээгт суув. Наталья Павловна кабинд суу гэсэн боловч тэр бээр бидэнтэй цуг сууна гэлээ. Ялихгүй донслоход л бидний

ханцуйнаас зуурч авна. Бүхээгээс ойж уначих вий гэж айх ажээ. Биднийг амьд мэнд эрүүл саруул гэрт минь хүргэхийг л ганц хүсжээ.

Юу болсныг биднээс замын турш шалгаав. Бид юу ч нуугаагүй нь нуугаагүй л дээ. Хамаг юм илэрхий байхад нууна гэдэг ямар ч утгагүй хэрэг. Чухам хэн нь буруутайг л хэлсэнгүй. Юм бүхнийг олуулаа хийсэн болж «бид» гэж ярив.

«Бид машиныг хаалгаар гаргах гэсэн юм», «бид татлагаа буруу уяад», «бидний буруу»... гэж ярилаа.

Наталья Павловна:

— Та нар ямар ч буруугүй гэж гэнэт хэлдэг байна.

Ингээд царай нь ширүүн дүртэй болов. Царай нь тийм болохоор Наталья Павловна уур нь хөдөлдгийг бид мэдэлгүй яах вэ.

— Та нарын буруу биш, та нарыг явуулагсад, та нартай хамт явж, осол гаргуулчхаад, шөнө зам дээр хаячхаад явагсдын л буруу. Эдний л буруу! гэж хэлэв.

Бид дотроо түүний гэнэн зантайд нь гайхаж байсан боловч Наталья Павловнатай цэц булаацалдсангүй. Биднийг хүүхэд гэж боддог юм. Автобаз дээр бид юуны хүүхэд байх вэ, цалин авч хийснээ хариуцаж байгаа ажилчид шүү дээ.

Гэтэл хожим нь үзвэл Наталья Павловнагийн энэ үзэл бодлыг хүн бүр тийм гэнэн гэж бодсонгүй.

Бид хамгийн муугаар бодож болгоомжлон байснаасаа ч долоон дор юм Автобаз дээр үзлээ.

Хүүхдүүдийн хэн нь ч харьсангүй, биднийг хүлээж байв. Засварын тэрэг хашаагаар ормогц цех цехээс ажилчид, албан тасалгаанаас албан хаагчид цутган гарч ирэв. Бүхээгээс биднийг гарвал манай ээж, Шмаков Петрийн өвөө эмээ хоёр, Вадимын ээж, хоёр охин дүү зогсож харагдана.

Сүйдийн манан хаджээ.

Бодоод үз л дээ! Өнөө өглөөхөн бид машины кабинд тайван сууж, дараа нь зусланд тостой талх идэж байхдаа ийм болно гэж санаа ч үгүй юм.

Өмдний минь цоорхой мундаг сэтгэгдэл төрүүлжээ. Машинтай би л ганцаараа онхолдсоныг цөм мэдэж байв.

Ээж маань надад ойртож ч ирж чадахгүй, толгой сэгсрэн зогсоно.

Шмаковыг эмээ өвөө хоёр нь гараас нь шүүрч аваад, гэр рүүгээ чирч одов. Үүнийг харахаас инээдтэй. Тэдэнд чирэгдэж яваа

Шмаковыг харахад Гулливер хоёр аварга хүний дунд чирүүлж яваа юм шиг байлаа.

Вадимын дүү нар гэж нэлээдгүй зэвүү хүрэм, гэдэлзэж годолзсон жаахан охид түүнийг тойрон эргэлдэнэ.

Дараа нь дарга гарч ирээд, намайг эргүүлж тойруулж харан
— Амьд мэнд шив... мөн чиг тэвдүүлээ дээ... гэснээ инээв.

Гэхдээ энэ бол доголлон нулимстай инээд байлаа.

Вадимын ээж хэрүүл өдсөн дуугаар

— Ямар ч л гэсэн та үүнийг хариуцах болно доо! гэв.

Дарга царай нь барайж, толгой ганзагалан тасалгаа руугаа явлаа.

Би бүр түүнийг өрөвдөв. Нээрээ шүү! Вадимын эжий шиг тийм эжий нар хэрүүл гаргавал чих ч муудахгүй халууцна. Гэтэл тэр ямар ч хамаагүй...

Би Вадимын ээжид:

— Битгий хэрүүл өдөөд бай гэж хэллээ.

— Сергей гэж ээж намайг зандарч над руу том харсан бөгөөд намайг эвгүй харьцлаа гэх буюу эвгүй явдал гаргалаа гэж бодохлоороо дандаа ингэдэг юм.

Вадим ч бас ээждээ:

— Мэдэхгүй байж бүү ярь гэв.

— Харьж байгаад чамтай яримз аа, гайгүй! гэж хэлээд Вадимыг мөрнөөс нь барьж аваад чирч гулдрал одов.

Хоёр дүү нь годгоносоор араас нь гүйв.

Хүүхдүүд аанай л надаас холдсонгүй. Майка намайг ахархан харахад нь би бүүр зовчхов.

Игорь ч энд байлаа. Царайг нь харахад над жөтөөрхөж байгаа нь илэрхий. Энэ хэрэг явдлын гол хүн болж байгаад минь атаархжээ. Одоо миний оронд байсан гэж мань хүн хүснэ. Намайг машинтай өнхөрч явахад тэгэхийг нэг их хүсээгүй биз ээ!

— Серёжа, харья гэж ээж хэлэв.

— Одоохон гээд би хүүхдүүдэд хандаж энд элдэв яриа гарч, янз янзын хэрүүл уруул гарч магад байна. Тэгэхлээр биднээс өөр хэн ч буруугүй гэдгийг мэдэгтүн гэв.

Наталья Павловна

— Хэн буруутайг чамтай чамгүй ялгаж дөнгөнө гэж дургүйхэн бувтнав.

Тэгэхэд нь би

— Үнэн юм үнэнээрээ гэж хэлэв.

— За, за бүхний учрыг олно, зоволтгүй! Гэртээ харьж өмдөө соль гэж яаран хариулахад нь

— Өмднөөс чухал зүйл бий гэж би татгалзав.

Ээж бид хоёрыг гэр рүүгээ явахад хүүхдүүд бүчин дагав. Хамаг буруу биднийх өөр хэнийх ч биш гэдгийг би замдаа хүүхдүүдэд дахин дахин батлав. Гэвч хүүхдүүд үүнийг төдий л сонирхохгүй байв. Өөрөөр хэлбэл хэний буруу вэ гэдгийг нэг их сонирхохгүй байлаа. Машин онхолдож байх тэр агшинд надад юу бодогдсон нь тэдэнд сонин байв. Тэгэхэд нь би надад бодож санасан юм огтгүй гэж хариулав.

Ийм хариуд сэтгэл дундуур хоцорсон тэд гэлээ ч гэсэн ямархуу байв? гэж надаас асуулаа.

Ямар ч байгаагүй гэж би хариулав.

Гэрт юу болсныг би тоочиж бичихгүй ээ. Залхаж гүйцэв! Юу болсныг би ээжид лав далан долоо ярьсан байх. Аавыг ажлаас ирэхэд нь бас далан долоо ярьж өгсөн.

Аав машины сурах бичиг надаас авч жолооны татуурга хэрхэн мултарч, машин жолоодлогогүй болсныг нэгд нэгэнгүй нарийвчлан үзэв. Дараа нь хуудас зургийн цаас өмнөө тавьж, осол гарсан байдлыг тоймлон зурлаа. Ингэж байж юу болсон нь тодорхой боллоо гэв. Ингэж хэлсний нь дараа бид сая унтахаар хэвтлээ.

Маргааш нь зарлалын самбар дээр даргын тушаалыг хаджээ. Зуевыг хатуу сануулж донгодсон байв. Машиныг орхиж явсан гэж тэгсэн ажээ. Дадлага хийгчдийн хэн нэг нь дахиад жолоо барьдаг юм бол автобазаас даруй хөөнө гэсэн байлаа.

— Чи юу хэлэх гэж байна? хэмээн би Игориос асуув.

— Догь бичиж.

— Юу нь догь байгаа юм?

Тэр бээр өрөөсөн нүдээ доогтой бөгөөд учиртай гэгч нь онийлгов. Даргын далд санааг ганцаараа л мэдэж байгаагаа ойлгуулах гэж...

— Шалтгааныг нь илрүүлж, гэмтэй этгээдийг шийтгэн, арга хэмжээ авч...

— Зуев буруутай болж байна уу? Игорь хөмсгөө сөхөн:

— Ингэх л хэрэгтэй.

— Юу ингэх хэрэгтэй гэж! Зуевын буруу юу даа, үгүй юу?

— Ингэхлээр байна шүү дээ. Бидний бодоход бол Зуевын буруу биш ээ. Даргын бодлоор бол буруутай. Зуев ингүүлэхгүй байх ёстой байсан. Гэтэл чадсангүй. Би л дарга байсан бол бас л түүнийг донгодох байсан гэж Игорь хоолойгоо шахан дуугарав.

— Чи дарга биш нь их аз! гэж би хэлчхэв.

Гэвч Игорь амарлингуй:

— Зуев тэгэхэд явчхаагүй сэн бол бид машиныг яалаа гэж чирэх билээ гэв.

— Уухайс! Чи өрөөгөө цоожлохоо мартчихаж, тэгтэл хулгай орсон байг, тэгвэл чиний буруу биш хулгайчийнх нь болох нь уу? гэж би дуу алдав.

— Онож зүйрлэхгүй л байна даа. Чи юунд тэвдээд байгаа юм.

Зуев энэ шийтгэлийг тоохгүй ээ.

— Бид хүний араар нуугдах ёстой болж байна уу? гэж би хэлэв.

— Ямар шударга эр вэ, энэ чинь гэж Игорь егөв.

— Хар амиа хичээгч байснаас шударга явсан нь дээр дээ гэж би хэллээ.

Игорь хачин хүн байгаа юм. Дутагдлыг нь битүүхэн сануулж байхад ойлгоогүй царйлдаг юм.

Одоо ч ийм дүр үзүүллээ. Дуугаа намсгаж

— Зуевын талаар бодож үзээрэй, нөгөө зөөллүүр санаж байгаа биз?.. Ийм тиймээ гэлцээд л байна... гэж хэлэв.

Би Игорь руу гайхан харлаа. Их л учиртай хуруугаа хөдөлгөсний нь үзэхэд Зуевыг зөөллүүр солилоо гэж сэрдэж байгаа нь илт. Үгүй мөн сонин юм даа! Зөөллүүрийг сольсон хүнийг би мэдэж байгаа. Гэвч үүнийг Игорьт хэлсэнгүй. Игорь нотлодох гэж шаардана, гэтэл надад нотолгоо байхгүй.

— Бид өргөдөл бичих ёстой. Осол гарсанд Зуевын буруу юу байх билээ, харин бидний буруу гэхэд минь,

— Крош, чи инээдтэй гэдэг нь ээ! Чиний өргөдөл хэнд хэрэгтэй юм бэ? бодоод үз. Зуев буруугүй юм бол тэгэхлээр хэн буруутай юм? Дарга уу, Тэр биднийг машин авчруулахаар явуулсан. Даргыг өөрөө өөрийгөө донгодог гэх гээ юу? тэгээд өргөдөл мөргөдөл бичнэ гээд байгаа... Дургүй хүрмээр юм гэж үрчийн хэлэв.

Би арга барагдан

— Хэн нэгэн хүнд өргөдөл гаргах гээгүй, хүний төлөө гаргах гэж байгаа шүү гэж хашхирав.

— Чи маанаг юм! гэж Игорь зэвүүцэн хэллээ.

Урам минь бүүр хугарлаа. Ийм шударга бус юм байх гэж! Зуевыг шийтгэсэнд хэн ч дургүйцсэнгүй, тэр ч атугай үүнийг хэн ч анзаарсангүй.

Бүх юм хуучин янзаараа явагдана. Машин орж гарч, засварчид цехдээ, албан хаагчид контортоо ажилласаар л байв. Ашиглалтын дарга аанай л утсаар ярьж хашаагаар нэг бархирсаар.

Зуев донгодуулснаа огт хайхрахгүй байгаа нь хамгийн хачирхууштай. Бидэнтэй ажлаа хийнэ. Өнөө л янзаараа Шмаковаас элдэв юм асууж, Шмаков нь цаг шахам болж байж хариуг нь хэлнэ.

— Таталцлын хууль... хэрэв үйлчлэхээ байчихвал яах вэ? Огторгуй яах бол? Эмх замбараагаа бүрмөсөн алдана даа гэж хүртэл асууж билээ.

Хариуд нь Шмаков яагаад ч юм харьцангуйн онолыг тайлбарлаж гарав. Шмаков түүнийг ойлгодоггүй учир шал худлаа зална. Гэтэл Зуев нь сайшаан толгой дохино.

Зуевыг хөндийрөнгүүт би Шмаковт шударга бус шийтгэлийн талаар хэлэв.

Шмаков хэсэг бодсоноо

— Орхи! гэлээ

Вадим ч бас үүнийг юман чинээ тоосонгүй.

— Үгүй их юм болов оо! гэв.

Вадим автобаз дотуур харайлгасан хэвээр. Хаа ажиллаж байгааг нь ойлгох аргагүй.

... Ажил тараад бид чөлөөнд цугларч, Липкаас гаргаж ирдэг өнөөх машинаа янзалж эхлэв.

Зуевыг бидэнд туслуулахаар өглөө. Тэр бол бааз дээр бараг нөхөөсөнд явдаг хүн. Даалгах хүн олдохгүй бол Зуевт даалгана. Ерөнхий инженер, бригадын дарга Дмитрий Александрович нар бидэн дээр байн байн ирнэ.

Гэвч хэрэг дээрээ Зуев удирдаж байлаа.

Зарим хүүхэд хашлагыг нэг хэсэг нь кабиныг, гурав дахь хэсэг нь моторыг авлаа. Хөвүүд бэхэлгээг салгаж, эд ангийг авч, охид эрэг, боолт, шургийг керосинд угаав. Машин арван мянган шахам янз бүрийн хэсгээс бүрдэнэ.

Орой болтол мунгиналдав. Гэвч бүх зүйлийг задалж авлаа. Машин нүцгэрэв.

Дараа өдөр нь бид дамжлага гол, урд хойд мост, нум, жолоог нь авч, цех цехээр тарааж өгөв. Гадаа зөвхөн арал нь л үлдлээ. Дараа нь бид арлыг нь ч гагнуулахаар аваачив. Зөвхөн модон суурь нь л үлдлээ. Тэгтэл түүнийг ч хэн нэг нь авч оджээ.

Бүгдээрээ эрвийх дэрвийхээрээ ажиллалаа. Наталья Павловнагийн хэлдгээр «шимтэн» ажиллалаа. Хуучин муу ямбий шинэ машин болно гэж бодохоос бүгдийн сэтгэл өег байв. Машин босгоно гэдэг том ажил болохыг хэн юу эс андах вэ? Урамтай ч байлаа.

Хог дээр хэвтсэн сэгийг ёстой машин болгоно гэж бодохоос би ч хөхиүн нь аргагүй байлаа. Шмаков бид хоёр аар саар юм хийж сурсан, тэгэхдээ бусад хүүхдүүдээс ч илүү сурсан минь сайхан санагдана. Тэд машины саланги эд ангийг мэдэж байхад би өвчид нь мэднэ. Зуев бид хоёртой ажиллаж дасаад, бидэнд итгэнэ. Хүүхдүүд өөдөөс нь ямар нэг юм асуухад заагаад өг гэж Шмаков бид хоёр руу дохино. Шмаков бид хоёр зааж өгнө. Бид хоёр маш нэр хүндтэй болов.

Урьд би Зуевыг хайхардаггүй байсан юм. Түүгээр барахгүй таашаадаггүй байв. Нэг л «өвчтэй» юм шиг санагддаг байлаа.

Гэвч яваандаа би түүнд өөрөөр хандах боллоо. Яагаад гэвэл юун түрүүнд түүнтэй ажиллахад сайхан байдаг юм. Бусад засварчидтай ажиллахад бид цухал хүрч, буруу зөрүү болчих вий гэж халширна.

Харин Зуевээс би айдаггүй байв. Тэр биднийг загнах гэж огт байхгүй. Тэр байтугай буруу хийчихвэл:

— За гайгүй засаж ядах юмгүй ээ гэнэ.

Тэгээд бидний хийснийг дахиад хийчихдэг юм.

Липкад осол гарч хэрэг мандахад хэчнээн төвшин байсан нь надад сайхан санагдав. Бидэнд ганц ч ширүүн үг хэлээгүй шүү. Бидний балгаар донгодуулчхаад, дуугүй л явж байдаг. Өөр хүн бол «та нараас болж би юм хүртлээ» гэх буюу иймэрхүү юм наанадаж хэлсэн дээ. Зуев юу ч дуугараагүй.

Зуевыг хэчнээн хүндлэх тусам биднээс болж зүй бусаар донгодуулсанд нь би сэтгэл өвдөнө. Ноомой сайн хүн ээ. Биеэ өмгөөлж чаддаггүй.

Зөөллүүр сольсон гэж Зуевыг хардан байгааг Игорь надад битүүхэн цухуйлгахад нь анхандаа би гайхаж байсан боловч юман чинээ бодоогүй. Гэтэл энэ нь маш ноцтой болохыг би сая л ухаарав. Зуевт осол болсны зэмийг тохчихсон юм чинь зөөллүүрийг түүн рүү чихчхэж болохгүй яах вэ. Нэг нь болсон юм, нөгөө нь болно. Ямар хариу тавих хүн биш, юу ч байсан түүнд үүрүүлээд бай хамаагүй гэнэ.

Гэтэл Зуев энэ аюулын тухай санаандгүй яваа. Ажлаа тайван хийж, ямар аюул заналхийлж байгааг мэдээгүй байдаг...

Ингэхлээр яах вэ? Түүнд хэлэх үү? Зуев итгэхгүй, яах ч үгүй, гараа сэгсрээд л өнгөрнө. Ер нь тэгээд чамайг хулгайд сэрдэж байна гэж хүнд яаж хэлэх вэ дээ?

Лагутин зөөллүүрийг авсан гэж даргад хэлдэг юм билүү? Гэтэл нотлох зүйл надад байдаггүй.

Лагутинтай өөртэй нь яриад үзвэл яадаг юм гэсэн бодол төрөв...

Энэ ч бузгай санаа, үүнийг эргэцүүлэх тусам овоо санаа гэдэгт нь улам итгэв.

Лагутин тийм үнэнч хүн биш нь биш. Гэвч тэр хүн шүү дээ. Бүр ажилчин хүн. Нөхрийнхөө хувь заяаг хайхралгүй орхино гэж үү? Тийм ч муу хүн биш байж юу магад. Зам нь хазайж яваа ч байж мэднэ. Зам нь хазайж байгаа хүмүүст туслан, тэднийг дахин хүмүүжүүлэх хэрэгтэй гэж сонинд бичсэн байдаг шүү дээ. Үүнээс Лагутин дахин хүмүүжиж эхлэх ч юм билүү. Өөрөөс нь болж, ямар ч гэм зэмгүй сайн хүн хэлмэгдэж байна гэж бодоод тэр шүү дээ.

Лагутинтай яаж уулзаж, Зуевын тухай хэрхэн хэлэхээ сэтгэлдээ өрж үзэв. Лагутиныг зөөллүүр авсан гэж хэлэхгүй нь ч хэлэхгүй л дээ.

Харин ингэж хэлье.

«Үүнийг авсан гэж Зуевыг буруутгах гэж байна. Гэтэл энэ бол тийм биш. Зуев ингээгүй».

«Тэгээд яагаа вэ?» гэж Лагутин асууна.

Тэгэхэд нь би

«Тэр бол хамт ажилладаг нөхөр маань шүү дээ. Бид түүнийг аврах ёстой» гэе.

«За яах вэ, би бодъё» гэж Лагутин хариулна.

Маргааш нь Лагутин дарга дээр ирээд ширээн дээр нь зөөллүүрийг тавьж,

«Владимир Георгиевич, зөөллүүрийг би солиод авчихсан юм.

Намайг явал яа, Зуев энд ямар ч хамаагүй» гэж хэлнэ.

Тэгэхэд дарга

— Хэн таныг над дээр ирүүлэх болгов? гэж асууна.

«Тийм хүмүүс олдсон. Тийм хүн... гээд энэ хүн нь жирийн нэг сурагч байгаа нь түүнд ичгэвтэр санагдах учир уруу царайтайхан энэ хүн хэн болох нь онц биш... » гэж Лагутин нэмж хэлнэ.

«Та үнэнч шударга байна гэж амлаж байна уу?» гэж дарга асуухад, Лагутин

«Харж байгаарай» гэж хариулна.

Дадлага дуусаад бидний баазаас явахад Лагутин над руу ирж гар сарвайн

«Баярлалаа!» гэж хэлнэ.

Би гарыг нь атгаж

«Танд ч баярлалаа» гэж хариулна.

Юу болоод л бид хоёрыг бие биедээ тал өгөөд байгааг хүүхдүүд лавлана.

«Зүгээр нэг зүйл бий юм» гэж би хариулна

Өөр юу ч ярихгүй.

Ингэж Лагутинтай ярилцах зүйлээ төсөөлж байлаа. Ийнхүү ярихын өмнө зүрхшиж байснаа яг ийм болно гэж бат итгэсэн учир эцсийн эцэст зоригоо чангалав. Хойшлуулалгүй ярихаар шийдлээ.

Ээлжийн ажил тарахыг би хүлээж байгаад Лагутиныг гудамжинд гүйцэж очин:

— Нөхөр Лагутин, түр азнаач гэв.

Лагутин зогсож, намайг ширтэв. Бид явган хүний замын голд зогсож байлаа.

— Жаахан ийшилье гэж би хэлэв.

Бид хажуу тийш гарав.

— Тэгэхлээр ийм байна гэж би эхлэн тэр зөөллүүрийг авлаа гэж Зуевыг хардаж байгаа юм байна. Түүнийг аваад сольчихсон юм шиг ярьж байна гэв.

— Тэгээд юу гэж? хэмээн Лагутин яг миний санаж байсанчлан асуулаа.

Миний тааварлаж байснаар түүний ингэж хариулсанд эрэмшсэн би итгэлтэй гэгч нь:

— Нэг юм хийх хэрэгтэй. Тэр бол бидний хамт ажилладаг нөхөр шүү дээ гэж хэллээ.

Лагутин намайг дуугүйхэн харав. Би ч бас түүнийг харав. Бидний харц мөргөлдлөө. Чухамхүү Лагутин л зөөллүүрийг авч гэдэгт би гүйцэд итгэв. Үүнийг миний мэдэж байгааг ч Лагутин ойлгожээ. Гэнэт эвгүй оргиж, түүгээр барахгүй бие зарсхийв.

Лагутин нэг л биш инээмсэглэнгээ

— Тэр авсан ч юм билүү?! гэж асуув.

Бидний хажуугаар хүмүүс өнгөрсөөр байв. Лагутин яаж ч чадахгүй нь гэдгийг би мэдлээ. Энэ нь надад аймаар байв. Тэгтэл Лагутин зовуурьтай, цаанаа л нэг муу ёрын инээмсэглэн:

— Үнэхээр тэр авсан байх гэдэг байна шүү.

Би хариу дуугарсангүй. Зөөллүүрийг Зуев аваагүй, Лагутин өөрөө авсныг нь яг одоо түүнд хэлэх ёстой болсноос нэг л аймаар байв. Үүнийг хэлэхэд надад эвгүй байлаа.

— Ээ чааваас аа! Осол гаргаж Зуев рүү бухчихсан. Зөөллүүрийг авчхаад бас түүнд тохож байдаг. Үгүй мөн олхиогүй амьтад аа гээд Лагутин ярвайв.

Би пал хийгээд явчихлаа.

— Та юу ярьж байна аа? Хэн Зуевт тохсон юм?

Лагутин энгүүтэй мушийж:

— Зуев зөөллүүрийг сольсон гэж сая өөрөө хэллээ шүү дээ гэхэд нь

— Тэгж ярилцаж байна гэж хэлсэн болохоос гэж би арга барагдан хашхирлаа.

— Бүү зал! Хэлэх чинь билээ! Бусдад чихэж байна. Үгүй мөн хүн ээ гэж Лагутин доогтой хэлэв.

Ямар маанаг булай юм болов оо. Итгэж хэлсэн хүн нь хэн бэ гээч? Очиж очиж Лагутинд шүү. Илэн далангүй ярих хүнээ мөн олов оо!

Маргааш нь бригадын дарга Дмитрий Александрович ажлыг минь шалгаж байгаад

— Чалчих чинь дэндэж байна гэлээ.

Юу хэлж байгааг нь би ойлголоо. Лагутин надтай ярьснаа дамжуулжээ.

Зуев ч дуугарсангүй. Гэвч над руу харсан байдлаас нь үзэхэд тэр ярианы тухай бас мэджээ. Түүний үл таашаах харцнаас миний гол харлаад явчхав.

Засварчин Коська хүртэл шүднийхээ завсраар сийгүүлж

— Хагархай хэнгэрэг! гэв.

Хэний ч өөдөөс би үг дуугарсангүй. Лагутин миний хэлснийг мушгин явааг нотолж чадна гэж үү? Тэгэхлээр юм хэлээд юугаа хийх билээ.

Игорь л намайг ганц дөнгөлөө! Зуевыг хардаж байна гэж түүний надад хэлээгүй бол би Лагутинд үүнийг яалаа гэж донгосох билээ.

Игорь өнөө гялалзсан хавтсаа сугавчилсаар л бидэн дээр хүрч ирэв. Өөрөөс нь болж ямар эвгүй байдалд орсноо би түүнд ярилаа.

— За тэр дээ, Крош зөрүүд загнаад юу болов доо! Хөндлөнгийн юманд хошуу дүрж явж тэр! Өөрийгөө ч бусдыг ч хөөдөөд гэж сургамжлангуй хэлэхэд нь

— Зуевын тухай чи л надад хэлсэн биш бил үү? гэж би хашхирлаа.

— Бүү хашхичаад бай. Би чамд хэлснээ санахгүй байна. Зуевын нэрийг хэлж байсан ч байж болно л доо. Гэхдээ би тэгж тааварлаж байсан хэрэг шүү дээ гэж Игорь эгдүүтэй хэллээ.

— Юу тааварлах гэж, чи чинь «тэгж ярилцаж байна» гээ биз дээ.

— Үүнд ялгаа юу байгаа юм. Би тэгж бодсоноо нөхөртөө гэж чамд л аминчилж, зүгээр л хальт мөлт, сэм дурссан, гэтэл чи Зуевыг албан ёсоор буруутгаж байдаг.

— Хэзээ би албан ёсоор буруутгав.

— Чи Лагутинд хэлсэн байна, гэтэл Лагутин чинь энэ баазын нэг хүн байхгүй юу. Чи бид хоёр хоорондоо энэ тухай цуурч байх нэг

хэрэг. Гэтэл энэ талаар хамт олноороо хэлэлцэнэ гэдэг өөр хэрэг. Ялгааг нь ойлгох хэрэгтэй. Өөрийгөө бусдаас ухаантай гэж сагсуурдгийн харгай энэ дээ.

Би ч хуншийж хоцорлоо. Би Зуевт тус болох гэтэл юу болж орхив?

Бүтэл минь яагаад ингэж бүүр хазайсан юм бол? Тус хийх гэтэл ус болчих юм.

Гэтэл Игорийг хар л даа. Маанаг юм хийчихсэн мөртөө ер дажгүй гээч. Хэнэг ч үгүй алхаж явахыг яана. Гэтэл би дөнгөж ганц хүнд хэлсэн. Гэхдээ үүнийг баталж нотолж биш, үгүйсгэж хэлсэн гээч. Тэгээд юу? болов? Намайг ховч, гүтгэгч гэж байна.

Игорийн ор үндэсгүй юм ярьж байгааг нь би яагаад тэр дор нь мэдсэнгүй вэ? Намайг самгардуулж, их юм мэддэгээрээ далайлгах гэж. Надаар өргөдөл бичүүлэхгүй гэж энэ оргүй юмыг зохиож. Гэтэл би үнэн гэж ойлгодог. Лагутин миний тэнэглэснийг ашиглалаа. Миний тусламжтайгаар мөрөө арилгав. Зөөллүүр авсан хүн тэр шүү дээ. Энэ нь одоо тов тодорхой.

Намайг цөмөөр нүд үзүүрлэн байгаа гэдэгт би итгэж байлаа. Гол минь гонсойно. Хүний нүүр рүү эгц харж чадахгүй байв. Намайг аашилж загнасан бол дээрсэн. Гэтэл тэгсэнгүй. Энэ яриаг дахин сэргээхийг хүссэнгүй. Энэ нь ч аргагүй ээ. Цөмөөрөө гол нуруу алдахгүй байхад ганц би л тэнэгээ харуулав.

Адгийн юм болжээ!

Мордохын хазгай гэж Игорь энэ паянг хүүхдүүдэд хошуу хүргэж. Майка намайг гараашнаас дуудаж уулзаад:

— Сережа, Зуев та хоёр яагаа вэ? гэж асуув.

Би дуугарсангүй. Юугаа ч хэлэх билээ дээ? Юу ч хэллээ гэсэн тэртэй тэргүй чалчаа болж хоцрох юм чинь.

Чи надад итгэхгүй байна гэж үү? гэж Майка шалгаав.

— Онц юм болоогүй. Тэнэг юм шиг хэл амаа билүүдээд гэж би бүрсгэрхэн хэллээ.

— Чухам юу гэж?

Зуевыг өмгөөлж, өргөдөл бичих гэснээсээ аваад Игорь зөөллүүрийн тухай юу гэж хэлсэн, маанагтаад энэ тухай Лагутинд хэрхэн бурчихсан тухайгаа хүртэл ярив.

— Сэтгэлээ дэмий зовоох юм. Чи тус болох гэсэн байна шүү дээ гэж Майка хэллээ.

— «Тэгсэн» Тэгээд юу болов? Одоо цөмөөрөө чамайг хялайж байгаа.

— Хялайж байгаад болино л биз. Чи сэтгэлээ дэндүү шаналгах юм. Царай гэж яваад өгч. Чи ухаантай, бодлоготой шүү дээ.

Майка намайг тэгж сайн ойлгож байгаа нь надад сайхан санагдаж байлаа. Гэвч Майкагаар сэтгэлээ засуулж байгаа минь эвгүй. Би маш өрөвдөм харагдаж байгаа хэрэг.

— Игорь л намайг ганц чадлаа! Би түүнд бурууг өгөхгүй, гэхдээ мань хүн л намайг хөөдлөө. Яахлаараа түүний хамаг юм нь үйлстэй бүтнэ вэ? Бүүр гайхмаар гэхэд минь

— Яагаад гэвэл Игорь үнэнч биш, гэтэл чи шулуун шударга учраас тэр гэж Майка хэллээ.

Үүнийг ч сонсоход сайхан байлаа. Гэвч магтуулахаар би эвгүй оргиод байдаг юм. Үүнд нь яахаа би мэддэггүй юм. Амыг нь дагах даруу биш болно, харин үгүй гэвэл... үгүй гээд ч яах билээ?!

— Хүмүүс бүгдээрээ үнэнч сэн бол хамаг юм нэн хялбар, энгийн байх сан гэж би хэллээ.

Майка үүнийг зөвшөөрөв.

Майкатай ярилаа гээд сэтгэл минь тайвширсангүй. Нөхрөөрөө дэмжүүлнэ гэдэг сайхан. Майка намайг бас л ховч, чалчаа гэж бодох байх гэхээс яс хавтайж байсан юм. Майка намайг тэгж бодсонгүйд би баярлав. Гэтэл Майкагийн мэдэж ойлгож байгаа зүйлийг бусад хүмүүс мэдэхгүй ойлгохгүй байна. Намайг бултаараа жигшиж, би нэг л гажууд амьтан шиг санагдана.

Би автобаз дундуур тэнэж, орох газраа олж ядаж байлаа. Энд хүн бүрд би өөрөө нэг л гаднын хүн шиг санагдаад болохгүй байв. Алхны тас няс буух, лантууны лүгхийх дуу сонстоно. Гагнаас тавьдаг үлээгүүр исгэчин шуугьж, ширээх гагнуур шарчигнан, ацетон ханхалж, шахуурга шуугин, мотор шалгаж байгаа пүл пүл гэх дуу хамын цаана гарна... Хүмүүс тэнд сайхан, хөгжилтэй, сэтгэл амгалан бодох санах юмгүй ажиллаж байна. Ганц би л энд бүгдийн дургүйг хүргэсэн илүү хүн гэдгийг ижил дасал болсон тэр чимээ шуугиан, үйлдвэрлэлийн үнэр илтгэж байлаа.

Би Вадимтай тааралдав. Мань хүн одоо өөрийнхөө ажиллаж байгаа төв агуулахын үүдэнд зогсож байна. Намайг гараараа даллаад агуулах руу орчхов.

Би хойноос нь орлоо.

Агуулах бол Автобаз дээрх миний дургүй ганц газар байгаа юм. Таазанд тулсан өндөр өндөр тавиурын хооронд нарийхан харанхуй давч хонгилууд байна. Тавиур дээр, хайрцгаан дотор сэлбэг хэрэгсэл эд анги байдаг бөгөөд дээрээ урт урт дугаартай, Вадим эдгээрийн нэрийг нь ч үл мэднэ. Дугуйн бэхэлгээний эрэг аваад өгөөч гэхэд өөдөөс дугаарыг асуудаг юм. Дугаар цээжлэх нь нэр тогтоохоос амархан юм шиг байдаг. Хүнд сурталт новширсон ажил. Вадим яагаад үүнд дурладаг юм бол?.. Би ойлгодоггүй юм.

Агуулахын нярав байсангүй. Вадим түүний ширээнд заларч байна. Би өөдөөс нь харан суув. Вадим намайг харж

— Чи яав гэв.

— Чи мэдээгүй байна уу? гэж би хариуллаа.

Агуулахад биднээс өөр хүн байгаагүй боловч Вадим над руу тонгойж:

— Крош, би нөгөө зөөллүүрийг олсон гэж аяархан хэлэв.

Би мангуурч хоцров.

— Хаанаас?

— Явъя! гээд Вадим бослоо.

— Агуулахаа яаж орхих юм бэ?

— Цоожилчихъё.

— Сэлбэг авахаар ирвэл яана?

Вадим үүнд ёстой агуулахын ажилтан шиг хариулж

— Хүлээж байна биз? гэв.

Вадим хаалгаа цоожлоод намайг цулгай руу дагуулж явав. Бүх машин замд гарсан байв. Цулгуйн захад замын хажууд засварт орох ёстой тавхан машин зогсож байлаа. Хашлага дээр нь «Засварт» гэж шохойгоор бичжээ. Бид хоёр нэг машин руу нь очиж хашлагыг нь өнгийв.

Хашлагийн буланд хар цаасны тасархайд боолттой нэг юм хэвтэж байна. Вадим хар цаасыг ярахад цоо шинэ зөөллүүр гарав. Энэ бол агуулахаас миний авсан зөөллүүр мөн байлаа.

— Яагаад энд байдаг билээ гэж асуухад минь

— Бүү мэд гэж Вадим хариулав.

— Хэн үүнийг энд тавьсан бол.

Бүү мэд гэж Вадим дахин хэллээ.

— Чи яаж олоо вэ?

Вадим түгдэрснээ

— Огт санамсаргүй... би нэг юм эрж явсан юм...

— Чи юу эрсэн юм?

— Машинд маань таарах юм байхгүй байгаа гэж харж явсан юм гэж Вадим үнэнээ хүлээв.

— Бас л өлбөлзөж гүйсээр үү?

Вадим толгой ганзагалан:

— Харсаар байж гэв.

— Чиний ингэж гүйх юунд хүргэж байна даа гэхэд минь

— Онцгой юу байгаа юм? Би ингэж гүйгээгүй бол олохгүй байсан биш үү? гэж Вадим зөрөв.

— Ээ, мангуу минь ээ! Чиний оллоо гээд ямар тус байна?

Вадим намайг сандран харлаа. Малигар ягаан царайд нь мэл гайхсан байдал илэрчээ.

— Мангуу минь ойлгож ав. Чамайг олсон гэж хэн итгэх юм? Чамайг өөрөө энд тавьсан гэж хэлнэ дээ. Яг л ингэж хэлнэ. Мангуу минь чи үүгээр шиншилж яваагүй, өөр хүн үүнийг олсон бол бидэнд хамаагүй байх биш үү.

— Яадаг билээ? би сайн юм хийх гэсэн шүү дээ гэж хөөрхий Вадим хэлэв.

— Чи бид хоёр шиг тэнэгүүд ингэчих юм. Бид сайн юм хийх гэтэл муугаар эргэх юм! гэж би гунигтай хэллээ.

Вадимыг дэндүү айлгалаа л даа. Зөөллүүрийг даргад аваачиж өгч болохгүй яах вэ. Бидний олсон гэдэгт итгэнэ л дээ. Өөрт нь итгэхгүй гэж хүн дандаа айж бэмбэгэнэж явбал үүрд түгжигдмэл байх болно. Гэвч бид хоёр үүнийг даргад одоо аваачаад өгчих юм бол хэн энд тавьсныг мэдэж чадахгүй болчихно. Лагутин л үүнийг энд тавьснаас гарцаагүй! Хий тааруулж байгаад авч гарах гэж л дээ. Чухамхүү Лагутины энд тавьсныг цөмөөрөө мэдвэл тэр яах гэж намайг гүтгэснээ ойлгох болно.

Түүнд итгэсэндээ цугаараа ичих болно.

Тэгэхлээр болгоомжтой ажиллах хэрэгтэй. Зөөллүүрт гар хүрч болохгүй. Эндээ хэвтэж л байг. Даргад л зөвхөн ярих хэрэгтэй. Дарга арга хэмжээ авна...

Вадим бид хоёр контор руу явав. Дарга, ерөнхий инженер хоёр эзгүй, трест рүү явчихжээ. Ингэхлээр оройтож ч ирнэ, ууртай ч ирнэ. Трестэд банга авхуулах тул тэндээс дандаа ууртай буцаж ирдэг юм. Яалаа гэж тэднийг аашилдгийг бүү мэд. Манай бааз сайн ажилладаг,

төлөвлөгөөгөө давуулан биелүүлдэг, шилжин явах улаан туг хоёр дах жилдээ авч яваа боловч трестийнхэн биднийг үүнээс сайн ажиллуулах гэдэг байх, манай даргыг тувт бангаддаг юм.

Бид хоёр урт сандал дээр суун хүлээв. Манайхны хүүхдүүд явчихсан бодовч ажлын өдөр дуусаагүй байлаа. Агуулахын нярав ирж, Вадимаас түлхүүрээ авлаа. Агуулахыг дураараа түгжлээ гэж Вадимд хүний урамд ганц үг хэлсэнгүй. Агуулахын нярвыг яагаад тэгж удаан хүлээдгийг би сая ойлгов. Ажилчид цехэд сул зогсож байгаад сэтгэл өчүүхэн ч зовдоггүй аж. Үүнийг Вадимд хэллээ. Аргагүй л агуулахын ажилчин хүн шиг Вадим дахиад л

— Та нар олуулаа, бид хоёулхнаа гэж хариулав.

Түүнийг тэнэг гэж би хэллээ.

Даргыг хүлээх нь зэгсэн залхуутай байсан авч сэтгэл сэргэв. Одоо л энэ явдлын учрыг би тайлаад өгнө дөө. Хүн гүтгэх ямар байдгийг Лагутин мэднэ ээ гайгүй

Гурван цагт хэсэг залуу ажилчин хажуугаар минь өнгөрөв. Эд нар оройн сургуулийн аравдугаар ангид, зарим нь бүр наймдугаар ангид сурдаг юм. Өнөөдөр эднийг ажил дуусахаас хоёр цагийн өмнө тараажээ.

— Эд нар суралцаж байгаа нь маш сайн хэрэг. Ерөнхий боловсрол нь дээшилнэ гэж би хэллээ.

Гэтэл Вадим зөрж, эд нар дээд сургуульд орох гэж байгаагаас биш, ерөнхий боловсролоо дээшлүүлэх гэж сураагүй гэлээ.

Бид хоёр ерөнхий боловсрол гэж юу болох талаар цэц булаалдав. Тэгтэл хонх жингэнээд явчихлаа. Нарийн бичгийн дарга хүүхэн гарч ирээд даргыг өнөөдөр ирэхгүй, трест дээр саатах гэнэ гэж хэллээ. Вадим бид хоёр энэ хэргийг маргааш болтол хойшлуулахаар шийдэв. Зөөллүүрийн тухайд гэвэл хоёр өдөр тэнд хэвтсэн юм чинь ганц шөнө юу болоо аж.

Энэ орой би клубт бүжигт очив. Энэ нь машин үйлдвэрлэх заводын клуб л дээ. Манай ойр хавьд өөр клуб байхгүй учир бүгдээрээ тэнд очдог юм.

Манай гудамжинд «Искра» гэдэг кино театр бий.

Энэ театр хоёр танхимтай, найрал хөгжимтэй, дуучидтай, мухлагтай. Гэвч тэнд кино үзчихээд л яваад өгнө. Клубт бол үдэшлэг болно, жүжиг гарна концерт тоглоно, жүжигчид ирнэ, лхагва, ням гарагт дагшаа хөгжимтэй буюу радиолтой бүжиг явуулдаг юм. Бид клубт билетгүй орохыг хичээнэ. Гэвч Игорь, Вадим, Шмаков Петр гурав л билетгүй орж чадна. Би бол бардаггүй юм. Игорь бол «Урлагийн хүн урлагаа үнэгүй үздэг» гэж үзнэ. Игорь биеэ урлагийн хүн гэж тоолдог юм. Хоёр ч удаа олны дунд кинонд зургаа авхуулсан юм л даа. Клубийн гол гол бүх ажилтан түүний найз нь.

Вадим бас л клубт эргэлдэж, янз янзын даалгавар биелүүлэн сүрхий хүнд тооцогдоно. Тийм хүн үнэгүй ордог гэнэ.

Харин Шмаков Петр сэм орчихно. Шалгагчийн дэргэд чимээгүй зогсож байгаад сэм орчихно. Түүний сүрхий төв царайг харахад билетгүй орж явна даа гэж бодохын аргагүй.

Даргыг хүлээлгүй Вадим бид хоёрын баазаас явсан тэр үдэш клубт дагшаа хөгжимтэй бүжигтэй байв.

Би бүжигт хорхойтой. Гэхдээ үүнийг амьдралынхаа утга учир гэж үздэг зарим улстай би адилгүй ээ. «Хийморь золбоогоо бадрааж, гэрэл гэгээнд умбаж, хөгжиж явахдаа би дуртай» гэж Пушкины хэлдэг байсны хэртэй л дурладаг юм. Дагшаа надад сайхан санагддаг. Миний дуртай юм гэвэл ном, кино, дагшаа хөгжим энэ гурав шив дээ. Техникт авьяас сонирхолтой сон бол өөр арай дөнгүүр юманд дуртай байх байсан байх л даа.

Надад хийхгүй бүжиг байхгүй. Хуучныхыг ч орчин цагийнхыг ч тэр адилхан. Гэхдээ орчин үеийнхэд илүү дуртай. Орчин үеийн бүжгийг хүссэнээрээ хийж болно. Бүжиг хийхэд хүний зан төрх өвчдөө ултай илэрдэг. Зарим маягтай амьтад гэдэлзэж годолзож байдаг л даа. Эрвэлзүүр польк хийхэд ч гэдгэнэж годгонож болно шүү дээ.

Клубт хүн пиг дүүрэн байв. Манай хүүхдүүд бүгдээрээ шахам иржээ. Автобазаас олон хүн байв. Ханцуйдаа улаан даавуу уясан туслах бригадынхан үүдэн дээр зогсож байна.

Лагутин бүртгэгч Зинатай бүжиглэж байв. Энэ хоёр хүний харилцааг би огт ойлгодоггүй юм.

Игорь миний үл таних нэг бүсгүйтэй бүжиж байна. Энэ бүсгүйд ч, хөгжимчид ч, ер нь танхимд байгсдад цөмд нь нэг их тус хүргэж байгаа мэт бүжиглэх ажээ. Бүүр цөхөрч гүйцээд урмыг бодож, хөлөө зөөж тавьж байгаа хүний сульдсан байртай байлаа.

Танхимын голд Вадим бүжиглэж алдаж байна. Вадим биеэ твистийн ганц эзэн гэж боддог хүн. Хөл гараа есөн жороор маяглуулна.

Шмаков Петр харин бүжигт тааруухан. Ер нь муу гэж хэлж болно. Гэвч бүжиг алгасна гэж байхгүй. Баганын дэргэд чимээгүй зогсож байгаад ганцаараа суугаа бүсгүй хаана байгааг ажиглана. Тэгээд очиж урина даа. Нэг их нарийн төвөгтэй, хариуцлагатай ажил хийж байгаа мэт буурьтай төв царайтай бүжиглэнэ. Бүсгүйгээ хаашаа авч явж байгаагаа харна гэж байхгүй, хүмүүсийн дундуур зүсээд л орж явчихна. Бүсгүйнхээ хөлийг нь гишгэнэ. Бүсгүй нь зугтчихгүй бол дараагийн бүжигт урина.

Авч яваа хүнтэйгээ Шмаков ганц үг солихгүй. Ер нь оройжин дүнсийчихнэ гэж мэд. Хөгжим дуугарангуут л «ямар танц вэ?» гэж надаас асууна. Юу тоглож байгааг өөрөө ялгахгүй, сонсгол ер байхгүй. Ямар бүжиг болохыг асуудгийнх нь учрыг би олдоггүй юм. Юу ч тоглолоо гэсэн фокстрот, танго хоёрын хооронд нэг юм бүжиглэдэг билээ. Зарим охид тэр ч байтугай үүнийг нь шинэ маяг гэж бодоод Шмаковтой бүжиглэхдээ ихэд мэрийхийг нь яана.

Би Майкатай бүжиглэх л тун дуртай даа. Гэвч Майкаг хүн болгон урих бөгөөд Майка ч хэнд ч үгүй гэдэггүй юм. Энэ нь надад нэг аятайхан, нэг тусгүй санагдана. Яагаад аятайхан санагддаг вэ гэвэл энэ нь Майкагийн эгэл жирийн зантай болохыг харуулж байгаагаас тэр. Майка маяглах гэж байхгүй, нэгэнт бүжиглэх гэж ирснээс хойш бүжиглэж, хэнийг ч гомдоохыг үл хүснэ. Урихад Майка инээмсэглэсээр босож, бүжиглэхээр ердийн нэг явна.

Гэвч аль дайралдсан хүнтэй бүжиглэж яахан болох вэ? Танхай амьтантай ч тааралдахыг байг гэхгүй. Тийм нэг амьтан Майкаг нэг удаа оройжин хоргоов. Би хүүхдүүдийн хамт сайх эрийг тас дайрч Майкатай ээлжлэн бүжиглэлээ. Гэвч бүжиг тарахад тэр бээр Майкаг гудамжинд хүлээгээд зогсож байгаа харагдав. Тэгэхлээр нь бид бүгдээрээ Майкаг хүргэж өглөө. Тэр амьтан зүрх алдаж биднийг

дагасангүй. Тэр хүн заводын зохион бүтээх товчоонд ажилладгийг би сүүлд нь мэдсэн юм. Нүдний шилтэй, унжийсан нөхөр.

Майка хэнд ч цааргалдаггүй учир түүнийг урихад хэцүү. Хажууд нь суугаад байх эвгүй, хоргоогоод байгаа юм шиг харагдана. Тэгээд хос хосоор суух ёсгүй. Бид энд бүжиглэх гэж ирсэн болохоос биш эргүүлдэх гэж ирээгүй. Охид нэг тусдаа, хөвүүд нэг тусдаа зогсоно. Гэвч танхим дундуур явсаар байтал хэн нэг нь чамаас урьтаад Майкаг урьчихна гэж мэд.

Намайг ирэхэд Майка зохион бүтээх товчооны нүдний шилттэй яг бүжиглэж байлаа. Бүжиг дуусахад тэр дахиад урих санаатай Майкагийн дэргэдээс холдсонгүй.

Би хөгжим дуугараагүй байхад охид руу очиж, тэдэнтэй яриа үүсгэн хөгжим дуугармагц Майкаг урив. Нүдний шилт хана налан зогсож хоцорлоо. Тэр ч атугай хэнийг ч урьсангүй. Майкад үнэнчээ харуулж байгаа аж.

Вальс тоглов. Би зүүн баруун хоёр тийшээ эргэн бүжиглэдэг юм. Нүдний шилт этгээдийг сэтгэлээр унагахын тулд би зүүн мөр тийшээ нэг эргэж, дараа нь зөв мөр рүүгээ нэг эргэв. Ямар догь бүжиглэдгээ түүнд харуулж над шиг гаргууд хүнтэй бүжиглэх нь дүйнгэ юмтай бүжиглэснээс Майкад хавьгүй сонин гэдгийг нөгөө нөхөрт ойлгуулах гэж түүний зогсож байгаа газрын эсрэг талд бүжиглэхийг хичээв.

Дараагийн бүжгийг бас Майкатай хийж, байранд нь хүртэж өгөөд сая үзвэл хөгжимчид хөгжмөө хажуу тийш нь тавиад завсарлахаар явж байв.

Шмаков Петр бид хоёр тасалбар аваад, сэрүүцэж хийжүүлсэн ус уухаар гадаа гарав.

Ер нь Шмаков тасалбар авахын тулд завсарлагаар дагтан гадагш гардаг юм. Клубт буцаж орохдоо түүнийгээ эргүүлж өгөхгүйг хичээнэ. Шмаков тасалбар цуглуулдаг юм л даа. Мань хүн сэм орж барахгүй болбол завсарлагаар энэ тасалбараараа орно. Тасалбар орой болгон өөрчлөгдөж байдаг. Гэвч Шмаковт хэрэгтэй нь заавал байж байна.

Гадаа бороо шивэрч байлаа. Энэ ч сайхан, бороонд бүр ч аятай сэрүүцнэ. Бид хийжүүлсэн ус тайван ууж, шиврээ бороонд сэрүүцэн оройн агаар амьсгалж, ийш тийш нүд бэлчээнэ. Би л алмайран харж зогссон юм л даа. Шмаков Петр ус ууж байхдаа аяганыхаа ёроолоос өөр юм үл харна.

Ийш тийш нүд бэлчээж байтал минь нэг «победа» зогсож байгаа харагдав. Ерийн л нэг «победа» машин л даа. Энэ машин клубийн хаалга руу ойртож ирэлгүй, булангийн цаана, харанхуй гудамжинд зогссон болохоор анхаарлыг минь татсан юм. Машинаас хоёр хүн гарч, бидний хажуугаар клуб руу оров. Пиджактай, зангиа зүүдэггүй цамцтай, бөгөөд саравчтай малгай духдуулсан хоёр залуу байлаа. Нэг нь цагаан зотонгоор хийсэн шаахайтай ажээ.

Ямар ч хувцастай байлаа гэсэн эдний хэн болохыг даруй ойлгов. Би ийм залуусыг юу эс андах вэ. Ийм залуутай гудамжинд дайралдахад царайг нь хаалганы завсраар, дэлгүүрт, троллейбусанд, киноны завсарлагааны танхимд хальт харахад л түмэн хүний дундаас дор нь танина. Тэдэнд нэг л онцгой юм байдаг, чухам юу гэдгийг би хэлж ч мэдэхгүй юм... Харц нь юм уу даа... Гаднаас нь харахад амарлингуй, хэнэггүй мөртөө цаанаа нэг л болгоомжлонгуй, хянуур даа. Айвуу тайван юм шиг эргэж ч харалгүй явах атлаа бүх бие нь хөвчирч, араас нь хүн нүд тавьж байгаа эсэхийг ардаа нүдтэй юм шиг мэдэж байдаг...

Манай сургуульд наймд билүү, есөд билүү тийм нэг хүүхэд сурч байсан юм. Түүнийг дээрэмчин гэж бүгдээрээ боддог байлаа. Бид бүр жаахан байсан болохоор түүнийг сонирхон хардаг сан. Бүгдэд зартай дээрэмчин наймдугаар ангид ил сурч байгаа болохоор томчуул ч түүнээс айдаг хэрэг. Дараа нь тэр дээрэмчин ердөө ч биш байж билээ. Зүгээр л гал унтраагч болох гэж дээврийн хонгилоор яван урьдаар дасгал хийж байсан юм санж.

Гэвч машинаас гарсан хүүхдүүд бол яг тийм хүүхдүүд гэдэгт би эргэлзэхгүй байлаа.

Шмаков бид хоёр клубт буцаж оров. Завсарлагаа дуусаагүй байсан боловч улс танхим руу яарав. Зарим нь ханын дэргэд байр эзэлж авах гэж, зарим нь ганц бүжиг алгасчих вий гэж яарчээ. Тийм улс алийг тэр гэх вэ.

Нүдний шилтийг Майкатай бүжиглүүлэхгүйн тулд би ч гэсэн танхим руу шалавхан оров. Хонгилын нөгөө үзүүрт Лагутин өнөөх залуучуудтай зогсож байгаа нь нүдэнд туслаа. Би зог тусаж хажуу тийш боллоо. Тэгээд хүмүүс орж гүйцэхийг хүлээх гэж байгаа дүр үзүүлэв.

Лагутин тэр залуустай уулзаад ер удсангүй. Юу гэж ярилцсаныг нь би олж дуулсангүй. Лагутины баргар царайг л олж харав. Тэгтэл

хоёр залуу тушаал авсан юм шиг эргэж хажуугаар минь үүд рүү зүглэв.

Хөгжим дуугарахыг сонсоод би ч танхимд оров. Манай охидын гол төлөв суудаг ханын тэнд Майка алга байлаа. Тэгсэн нь нүдний шилттэй бүжиглэж байгаа харагдлаа. Ямар гээч нойтон хамуу шиг эд вэ?

Би танхимыг тойрч, баганын дэргэд зогсов. Надаас холгүйхэн Зина бүртгэгч зогсож байв. Зина ногоон ноосон цамц, хадаас шиг нарийхан өсгийтэй шагайвч өмсжээ. Эмэгтэйчүүд яаж тийм өсгийтэй гутал өмсөж чаддагийг бүү мэд.

Лагутин араас минь орж ирэв. Над шиг танхимыг тойрч гараад Зина руу очив. Тэр хоёр баганын цаана, нэлээд ойрхон байсан боловч хөгжмийн дуу тэдний дууг дарав. Лагутин юу ч юм цухалдангуй ярьж, шахаж шаардаж байлаа. Зина ч тээнэгэлзэж дургүйцэж, татгалзаж, царай, нь ув улайжээ.

Хөгжим зогсов. Нүдний шилт Майкаг байранд нь хүргэж байгаа харагдав. Би хөгжмийг анхааралтай ажиглаж эхэллээ. Хөгжимчид хөгжмөө авмагц Майка руу очиж түрүүлж урья.

Гэвч урих гэж байтал минь хүн надаас урьтчихлаа... Хэн бэ гээч? Лагутин шүү! Том том алхалсаар тэр бээр танхим дундуур гарч, Майка руу очин яриа өдтөл хөгжим эгшиглэж, тэд ч бүжиглэж гарах нь тэр.

Үүнд нь Майкаг би яасан ч өнгөрөөхгүй ээ! Лагутин бол миний ганц өштөн, намайг ямар муухай дөнгөснийг Майка сайн мэдэж байгаа шүү дээ.

Эгэл даруу байх гэдэг сайхан чанар боловч хэрээс хэтэрч болохгүй ээ. Хэр хэмжээ гэж байх хэрэгтэй. Энэ бол найз нөхрөөсөө урвасан хэрэг! Найзыгаа гүтгэсэн хүнтэй бүжиглэнэ гэнээ! Майкаг гүжирдсэн охинтой би бүжиглэх байсан гэж үү? Холоо хэвтэнэ.

Нүдний шилттэй бүжиглэснийг нь уучилсан минь хангалттай! Учир зүйг нь олох юм бол түүнтэй ч бүжиглэх ёсгүй байсан. Хүн бүжиг хийнэ гэдэг нэг хэрэг, эргүүлнэ гэдэг өөр хэрэг. Нүдний шилт түүнийг эргүүлэх гэж оролдож байна. Үүнийг харахгүй хэн байх вэ. Майка түүнтэй бүжиглэснээрээ тийнхүү оролдоход шижим өгч байна.

Гэвч шилттэй бүжиглэснийг нь өнгөрөөсөн, харин Лагутинтай бүжиглэснийг хэрхэвч үгүй дээ! Надаас урвасан нь бага хэрэг, Лагутин хөөрхий Зинагийн л үйлийг үзэх гэж л Майкатай бүжиглэж байгаа юм. Майка үүнийг мэдэхгүй байна гэж үү?

Нэр төрөө бодох сэтгэл хумсын чинээ ч алга.

Майка Лагутинтай бүжиглэж байхдаа намайг хараад
инээмсэглэсэн гээч.

Би нүүр буруулж, инээмсэглэхийг нь байтугай өөрийг нь
хараагүй байгаа царай гаргав.

Энэ шөнө нойр муутай хонов. Майкаг бодоод тэр биш шүү. Майкагийн тухай бодсон бол түүнийг дахиж ер бодохгүй л гэдэг ганц зүйл бодсон байх.

Лагутин болон нөгөө хоёр залуугийн тухай, Вадимтай хоёулаа шөнө хуучин машин дээр гоомойдож орхисон зөөллүүрийн тухай би бодсон юм. Автобазаас амархан авч гарахын тулд тэнд тавьсан байсан. Яг өнөө шөнө л түүнийг аваад явчхаж магадгүйеэ. Зөөллүүр нөгөө залуучууд, Лагутин гурвыг би яагаад ч юм холбож бодоод байв. Лагутин зөөллүүрийг тэр машинд тавьж, тэр хоёр залуу авч гарах ёстой байж гэсэн бодол аажуухан төрөв. Цаанаа л нэг учиртай, авцалдаатай бодол доо.

Энэ тухай бодсоор тэгж тэгж нам унтчихжээ. Өглөө нь аав намайг арайхийж сэрээв. Ажлаасаа эгээ л хожигдчихсонгүй. Хонх дуугарч байхад гүйж хүрэв. Хонхон дуутай ямагт уралдаж ирдэг Вадимтай би хаалган дээр тулгарлаа.

Би гараашинд орж, ажлаа авав. Тэгээд гадаа гарч, намайг хүлээж байгаа Вадим руу очив. Зөөллүүрийн тухай ярих гэж хоёул дарга руу явав.

Даргын өрөөний хаалгыг татвал утаа суунаглаж хүн дүүрэн цуглажээ. Хуралдаж байна. Хар өглөөгүүр гар доорх хүмүүсээ бангадаж байгаа болохоор өчигдөр орой трестэд өөрөө бузгай донго авсан хэрэг.

Тэгэхлээр нь бид хоёр зөөллүүрийг байрандаа байгаа эсэхийг үзэхээр шийдэв. Шалгаж үзэх хэрэгтэй.

Бид цулгуйгаар гарч «засварт» гэсэн бичигтэй захын машин тийш очиж хашлага өөд авирав.

Тийш өнгийвөл зөөллүүр байхгүй байлаа. Хөглөрч хэвтэх хар цааснаас өөр юу ч алга байлаа.

Зөөллүүрийг аваад явчихжээ. Бид бие биеэ дуугүй ширтэв. Тэгээд Вадим итгэлгүйхэн:

— Манаач олсон байж магадгүй дээ? гэв.

Тэгсэн байж болох л юм. Тийм бол ч маш сайн. Бүүр догь! Зөөллүүр олдсон, бидэнд ямар ч хамаагүй, ёстой гоё.

Ингээгүй ч байж мэдэх юм. Авах гэсэн хүмүүс аваад явчихсан байж болзошгүй. Машинаар хүрч ирээд, зөөллүүрээ тавьж аваад

арилаад өгнө. Манаач шөнөжин тайван гэгч нь унтана. Ирж байгаа машины чимээ сонсоод анзаарах ч үгүй дээ. Хожимдсон ямар нэг машин л шугамаас ирж байна гэж бодоо биз.

Энэ цулгуй нь засварын цехийн ард байдаг шоо дөрвөлжин газар юм. Баруунаараа модны агуулахын модон хашаатай. Ард нь орхигдсон элсний ил уурхай бараална. Зүүнээр нь сувгийн цаагуур хуучин зам өнгөрнө. Дээр үед ил уурхай руу элсэнд үүгээр явдаг байжээ. Одоо энэ замаар явахаа больсон. Хэрэв зөөллүүрийг авч гарсан бол үүгээр л авч явсан.

Бид машинаас бууж зам руу очлоо. Сувагт хэвтэж байгаа хар цаасны тасархай хамгийн түрүүнд нүдэнд тусав. Бүх юм тодорхой болов. Зөөллүүрийг яг үүгээр авч өнгөрчээ. Чимээ гаргахгүй гэж цаастай нь авч очоод «Победдоо» хийж цаасыг нь сувагт хаясан хэрэг.

Бид сувгийг гаталж зам дээр гарав. Энэ зам элс авдаг газар өөд явж элс зарим газар нь нимгэхэн, зарим газар нь зузаан хунгарлажээ. Өчигдөр бороо орсон учир машины мөр элсэн дээр дурайн байгааг үзлээ...

Бид бөхийн ажиглаж гарав.

Зам дээр дугуйны мөр, тодруулж хэлбэл гадуур хаймрын мөр, бүр тодруулбал улны мөр үлддэг. Ул гэж гадуур хаймрын иржгэр хээтэй гадна талыг хэлдэг. Энэ иржгэр нь замд дугуйн үрэх үрэлтийг сайжруулж өгдөг юм.

Тэгээд ч бид маш гүн шигдсэн, гацуурын мөчир шиг жишүү шүдтэй нэг тод, өргөн мөрийг харлаа.

Энэ бол «победын» мөр биш, бидний мэдэхгүй өөр ямар нэг машины мөр ажээ. «Победын» мөр ийм гүн байдаггүй.

— Трактор шиг байна гэж Вадим эргэлзэнгүй хэлэв.

— Үгүй мөн хэлэв ээ! Трактор газрыг онги татсан байдаг юм.

Бид элс авдаг газар тийш мөр мөшгөн явав. Миний таамаглал буруудсанд би гонсойж хоцров. Тэр залуучууд «победтой» байсан, гэтэл энд өөр машин байж. Зөөллүүрийг Лагутин тавиагүй, өөр хүн тавилаа гэж үү?

Элс авдаг газрын дэргэд учиргүй олон мөр байлаа. Энд машин эргэдэг юм. Энд элс нь их учир мөр тод гарчээ. Би эдгээрийг сайн ажиглавал үл мэдэх машины гүн мөрийн харалдаа «победын» жижигхэн жиргэр мөр байлаа.

Сэтгэл хөдөлснөөс зүрх минь түг түг цохив. Ямар ч гэсэн «победа» энд ирж!..

Би явган суулаа. Энэ хоёр бол зуузай холбож, бүүр давхцаж явсан мөр байна. Хоёр машин хоёул энд эргэжээ. Хоёул ийш ирээд хоёул буцаж...

Гэтэл «победын» мөр зөвхөн энд л гарсны учир юу билээ? Зам дээр яагаад байхгүй байна вэ?

Муу харсан юм болов уу?

Мөрөө нэгд нэгэнгүй ажиглан гэдрэг явав. Гэвч яаж ч харлаа гэсэн «победын» мөр зам дээр алга ажээ. Зам дээр ганц л мөр, гүн шигдсэн жишүү хээтэй, үл мэдэгдэх мөр л байлаа.

— Өө мэдлээ! Победын мөр бүдэгхэн учир салхи үлээгээд арилгачхаж гэж Вадим мэдэмгийрхэв.

— Тэгвэл элст хонхрынх яагаад арилсангүй вэ? гэж би татгалзлаа.

Жигтэйхэн, ухаанд ер багтамгүй юм боллоо. Эхлээд «победа» явж, араас нь яг мөрөөр нь хоёр дахь үл мэдэх машин явж өнгөрсөн болж байна. Түүний гүн бадируун мөр «победныхыг» арилгачхаж...

— Бүх юм тодорхой байна! Хоёр дахь машин эхнийхээ мөрийг баллахын тулд араас нь явсан байна. Зөөллүүрийг «победоор» аваачжээ. Тэгэхлээр мөрөө буруулах хэрэгтэй гэж Вадим хэллээ.

Энэ тайлбар учир утгатай юм шиг санагдав. Хэсэг эргэцүүлбэл үүнд ямар ч авцалдаа алга байв. Мөр буруулах ямар маанаг арга гээч вэ! Шөнө мөрийг онолдуулна гэж үү! Энэ нь тэгээд тэнэг ч юм! Вадимын санал эхлээд ухаалаг юм шиг санагддаг нь юу ч билээ.

Бид цардмал зам өөд явав. Элс нь багасаж, мөр бүдгэрэв. Гэвч хоёр дахь машины мөр гэдэг нь тод ялгагдахаар байв. Зам засмалд нийлсэн уулзвар дээр л «победын» мөрийг ахин олж үзлээ. Элсэн дээр үл мэдэх машины дугуйрсан мөр тодхон дурайж, хажууханд нь победын дугуйны бүдэгхэн мөр байна... Цааш нь засмал дээр юу ч ялгаж харахын аргагүй байлаа...

Тийнхүү олигтой олж мэдсэн юмгүй бид бааз руу буцав. Миний таамаглал хялгасанд торж байгаа боловч түүнийг бүрэн үгүйсгэх үндэсгүй, тэнд ямар ч гэсэн нэг «победа» байжээ. Тэгэхлээр зөөллүүрийг тэр залуучууд авч явсан, Лагутин түүнийг аваачиж өгсөн гэж тааварлаж болно.

Гарашинд эргэж ирэхэд минь

— Хаашаа алга болчхов гэж Шмаков надаас асуув.

Би гараа хааш яаш дохисноо

— Тэнд... гэлээ.

— Бригадын дарга уурлаж байна лээ гэж Шмаков хэлэв.

Урьд нь бригадын дарга намайг алга боллоо гэдэггүй байсан.

Одоо бол аашилж байна гэнэ. Ойлгомжтой. Надад өөрөөр хандах болж. Лагутинаас л болж байгаа юм даа. Лагутин намайг гүтгэснээс ингэж байгаа юм.

Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнээ гайгүй!

Шмаков бид хоёр ажлаа хийж эхлээд түүнээс

— Чи даргад юу гэж хэлэв? гэж асуухад минь

— Чамайг хичээлийн эрхлэгч дуудсан гэсэн гэж Шмаков

хариулав.

Шмаков Петрийн ухаантайг гайхаад гайхаад бардаггүй юм. Ганц тэр л тийм овжин хариу бодож олж чадна. «Хичээлийн эрхлэгч дуудсан» гэнэ. Мөн догио! Дарга юм уу ерөнхий инженер дуудсан гэж хэлсэн бол бригадын дарга үүнийг шалгаж орхино. Хичээлийн эрхлэгч дуудсан гэхлээр бригадын дарга яаж шалгах вэ дээ. Хичээлийн эрхлэгч гэж юу байдгийг мэдэхгүй ч байж мэднэ. Мэддэг ч байлаа гэсэн шалгах гэж сургууль руу явахгүй нь лав. «Хичээлийн эрхлэгч» гэдэг нэг л холын, ойлгомжгүй, иймээс үнэмшмээр үг. Зарим хүмүүсийн хувьд хамгийн ойлгомжгүй юм нь ёстой үнэмшим юм байдгийг би хэдийнээ мэдэх билээ.

Шмаков сайн байна! Итгэлтэй найз! Түүнд зөөллүүрийн тухай юу ч хэлээгүйдээ би ичив. Шмаков Вадимыг бодвол хавьгүй итгэлтэй хүн. Шмаков мохоодуу боловч хар ухаан гэж мундаг, юмыг практик дээр ултай мэддэгийг нь үнэмшсэн минь олон.

Би бүхнийг Шмаковт дэс дараалан ярихаар завдав. Түүнд дэс дараатай ярьж өгөхгүй бол юу ч ойлгохгүй. Гэтэл гэнэт нэг зүйл сэтгэлд орж, намайг сандаргав...

Үл мэдэх машины мөрийг юунд зурж авсангүй вэ?! Мөр мөд арилчихна шүү дээ. Ийм чухал баримтыг алдаж болно гэж үү. Хоёр дах мөрийг зурж авах хэрэгтэй байж. Би түүнийг «победынх» гэж бодож байсан, гэтэл биш болчихвол?...

Жийрэг зүсэж хийдэг хатуу цаасны өөдөс, хэсэг шохой, харандаа авч бригадын даргыг ирвэл хичээлийн эрхлэгч дуудсан гэж түрүүнийх шигээ хэлээрэй гэж Шмаковт хэлчхээд цулгүй руу гүйв.

Хагас цаг болоод би эргэж ирлээ. Үл мэдэх машины дугуйн мөрний нямбайлан зурсан, «Победын» мөрний тааруухан зурсан зураг халаасанд минь байж байлаа. «Победын» мөр маш ярвигтай, балархай, зурахад хэцүү байв.

Шмаков бид хоёр ажлаа дахин хийж эхлэв. Бригадын дарга хүрч ирээд намайг харсан боловч юм хэлсэнгүй. Сурагчдын хувьд далд утгатай «хичээлийн эрхлэгч» гэдэг үг түүнд нөлөөлсөн бололтой.

Шмаков бид хоёр ажиллаад төдий л удаагүй байтал хонх дуугарав. Ажилчид завсарлаж, бид харьж болох байв.

Би Шмаковт

— Азна, хэрэг байна гэлээ.

— За гэж Шмаков Петр хариуллаа.

Яав ийв гэж тэр асууна гэж ер байхгүй. Сайхан зан шүү.

Бид хоёр үйлдвэрчний хороонд очиж, номын сангийн авгайгаас «Машины дугуй» гэсэн ном аваад ширээнд сууж үзэж гарлаа. Би зам дээр зурсан дугуйнхаа мөрний зургийг гаргаж номтой зэрэгцүүлж тавиад Петрт

— Энэ ямар дугуйных вэ? гэдэг асуулт байна гэв.

— «Победын» улныхыг бид дорхноо олов. Энэ бол үнэхээр «победынх» байлаа. Хэмжээ нь 6x16. Сэтгэл минь жаал онгойв. Ашгүй дээ!

«Победа» тэнд байх нь л байж. Сайхан! Догь! Ёстой гоё! Би эндүүрсэнгүй...

Гэвч хоёр дах машины мөртэй төстэй зураг бид номоос олсонгүй.

Тэгтэл Шмаков миний зурж авсан зургийг сайтар хараад

— Энэ чинь бартаач машиных байна гэв.

— Чухам ямар машиных гэж?

— Газ—69

— Чи тэгж бодож байна уу?

— Тийм

Тэр даруй би номын сангийн эмэгтэйгээс ГАЗ—69 машины тухай ном авав. Хоёулаа хуудсыг нь эргүүлж «Дугуй ба хаймар» гэсэн бүлгийг гарган, дугуйны зургийг олов. Энэ зураг зам дээр миний зурж авсантай яв дав нийлж байлаа. Гацуурын мөчир шиг жишүү өргөн хээ... байна. Бартааг сайн туулдаг болгох гэж иржгэрийг нь лав хийж...

Бид номын санчид номыг нь эргүүлж өгөөд, нөгөө газар руу очив. Замдаа Шмаковт дэс дараагаар нь ярьж өглөө. Зам урт, цаг

мундахгүй байв.

Би дахиад, тэгэхдээ энэ удаа Шмаков Петргэй хамт нөгөөх мөрийг үзлээ. Элс хатаж, мөр нь баларч эхэлсэн авч бас ч гэж харагдахаар байлаа...

Шмаков бодосхийснээ

— Хэрвээ «победоор» хулгайчид явсан бол ГАЗ—69 өөр сэргийлэгчид ирсэн байхгүй юу.

Гонсойсондоо би толгойгоо шаагаад авав. Яагаад би тухайлсангүй вэ? Шмаковын зөв байлгүй яах вэ? Хар ухаан гэдэг энэ дээ! Уухайдаа...

Гэвч «уухайдаа» гэж хэлэх ч болоогүй байна. «Победын» мөр зам дээр яагаад гардаггүй билээ?

Шмаковын тайлбар Вадимынхаас арай бодлоготой юм. Гэвч толгой шаахаар ч үндсэндээ биш ажээ.

Шмаков хар ухаантай хүн. Гэвч нууцыг тайлахад өөр бас нэг юм хэрэгтэй...

Чухам юу вэ? Хар ухаанаас тэс ондоо ч юм байж болно! Жишээлбэл уран сэтгэдэг байх хэрэгтэй.

Энэ явдлыг хэнд ч хэлэхгүй гэж шийдэцгээлээ. Тэртэй тэргүй үнэмшихгүй юм чинь. Итгэдэг юм гэхэд биднийг алмай амьтад гэнэ. Зөөллүүрийг маанагтаж байж алдчихсан нь ор үндэсгүй ч бишээ.

Шмаков Петр энэ хэргийг мэдэж байгаа гэж би Вадимд хэлсэнгүй. Вадим үүнийг дуулчихвал дорхноо л цааш нь нэг хүнд хэлчихнэ. Тэгээд намайг эхэлж нууц задалсан гэж биеэ зөвтгөнө. Вадим тийм л хүн байгаа юм даа. Түүнд өөрийн биеэр л үлгэрлэж болно. Үнэнийг хэлэхэд Шмаков Петрт байдгаа ярьчхаад Вадимд ямар үлгэр үзүүлэх билээ дээ. Ингэхэд маргааш нь анхны цалин буух ёстой байсан учир түүнтэй мантай юм болов.

Бааз дээр цалинг сард хоёр олгодог. Тэр болгонд нижгэр юм болно. Цалин авч сурчихсан хүмүүс хүртэл энэ өдөр сэтгэл нэг л хөөрсөн байдаг. Бидний тухайд бол хэлэхийн ч хэрэггүй. Энэ бол насандаа авч байгаа анхны цалин шүү дээ.

Үүнийг Игориос дууллаа. Эдний цалин авч байгаа нь миний л ач гэх аятай, намайг байгаагүй бол улаан мөнгө олохгүй байсан гэх аятай нигүүлсэнгүй ивээсэн дүртэй хаахалзана.

Биднийг «цэсэд оруулсан» гэж эхлээд хэллээ. Цалин өгдөг жагсаалтад бидний нэрийг бичсэн гэнэ. Үүнд багагүй хүчин чармайлт тавьсан гэдгээ ойлгуулж байгаа нь энэ. Дараа нь хүрч ирээд цалингийн хагас, урьдчилгааг өгөх юм байна гэж хэллээ. Үлдсэн мөнгийг нь сарын эцэст тооцож бодуулж байж авах гэнэ. Тооцоо нь бид хэр зэрэг ажилласнаас шалтгаална. Илүү ч гарч мэднэ, дутаж ч мэднэ. Игорь биднийг бага авхуулахгүй, их авхуулахыг хичээх нь дамжиггүй.

Дараа нь ирээд мөнгөний нярвыг банк руу явчихсан гэлээ.

Тэгснээ банк дээр ажил бүтэхгүй байна, өнөөдөр өгөхгүй ч байж магад гэж хэллээ. Дараа нь ирээд ажил бүтэж байгаа гэнэ, гэвч цалин таван цагаас хойш өгөх гэнэ гэж хэлэв.

Ер нь өдөржин Игорь бидний сэтгэл үймрүүлж, ажилд саад хийв.

Шмаков бид хоёр төдий л зовсонгүй. Авах цалин байгаагаас л цааш авахдаа л авна. Өнөө маргааш хоёр дүндээ л дүн. Битгий туулайн чинээ юмыг уулын чинээ болгож ярь гэж Игорьт хэлэв.

Мань хүн тунирхан яваад өгөв. Гэвч тэсэж чадаагүй, бүх юм бүтэмжтэй цалин үдээс хойш тавих гэнэ гэж бидэнд тал засахаар эргэж ирлээ.

Үүнд нь Шмаков бид хоёр
— За яах вэ! гэж хариулав.

Ажил тараад бид ангиараа кассын дэргэд цуглав. Цонх онгойлоо.
Бидэнд цалин өгч эхэллээ.

Бид цэс дээр нэрийнхээ ард гарын үсэг зурна. Мөнгөний нярав гэж ямар ч сэтгэлийн хөдөлгөөнгүй хүн хэний ч царайг үл харна. Цэсээ л шагайж тэмдэг тавин мөнгөө тоолно. Арван зургаан рубль хорин мөнгөө авлаа.

Хөвүүд д нэрээ бодож мөнгөө халаасандаа хайхрамжгүйхэн хийж байлаа. Зарим нь оочиргүй авах гэж оролдсон л доо. Гэхдээ шунахайрсандаа биш, дүрсгүйтсэндээ тэр. Ганц Шмаков Петр л мөнгөө нямбай эвхэж түрийвчлэв. Ийм зантай юм.

Гэвч охид хөхиүн байлаа. Кассаас холдоод мөнгөө тоолж, хоорондоо баясан ярилцана. Майка л ганцаараа сүйд майд болсонгүй. Мөнгөө тайван гэгч дашинзныхаа халаасанд хийв. Би үүнийг нь огт санаандгүй харсан юм л даа. Бидний хооронд бүх юм шувтарсан. Гэтэл тэр бээр яагаа ч үгүй байхад аанай л ээлдэгхэн инээв. Хачин юм!

Игорь нөхдөө дайлж байгаа гар султай эзэн аятай төвшин инээмсэглэсээр кассын дэргэд зогсож байлаа. тэр бээр биеэ ихэд бодохын өвчин туссан хүн. Конторт ажилладаг өөрийн хүний хувьд цалингаа биднээс түрүүлээд авчихсан. Вадим хажууд нь зогсож авлагаа авч байв. Липкад хоол идсэний нэг рубль би түүнд өглөө. Шмаков бодолхийлснээ бас өгөв.

Би арван таван рубль хорин мөнгөтэй үлдлээ. Би их дэлгүүрт очиж, аав ээж хоёрт бэлэг авахаар шийдлээ.

— Их дэлгүүрээр орё гэж би Шмаковт хэлэв.

— Яах юм?

— Аахар шаахар юм авъя.

Би бэлгийнхээ тухай түүнд ярихыг хүссэнгүй. Шмаковын аав ээж нь Энэтхэгт заводын барилга дээр ажилладаг юм. Шмаков эмээ өвөө хоёртойгоо суудаг. Петр тэдэнд бэлэг өгнө гэдэгт би итгэхгүй байв. Бэлэг гэж дуулчхаад явахаа байчхаж мэднэ. Гэтэл ганцаараа явах уйтгартай.

Их дэлгүүрийн нэгдүгээр давхарт цаасан нэхмэл, спорт, тоглоомын тасгийн дэргэд миний зорьж ирсэн үнэртний тасаг байна.

Дэлгүүрүүдэд хэрэгцээгүй юмтай тасаг нь дороо байдаг, хэрэгцээтэй нь дээрээ байдгийг аль язгуурт би ажигласан юм. Дээшлэх

тусмаа л хэрэгтэй болдог. Жишээлбэл гутлын тасаг дөрөвдүгээр давхарт байдаг юм.

Би ийн ажигласнаа Шмаковт хэлэв.

Тэр бодсоноо

— Үнэртэй ус авах гэж хэн ч дөрөвдүгээр давхар өөд мацахгүй, харин гутал авахаар бол явна, дөрөвдүгээр давхар руу яваа хүн замдаа нэгдүгээр давхраас ямар нэг юм авна. Дэлгүүр төлөвлөгөөгөө биелүүлнэ. Тасгийн ажилтнууд шагнал хүртэнэ гэж хэлэв.

Шмаков Петрийн хар ухааныг хэд дэхээ ч байна вэ бүү мэд, гэж гайхан бишрэв.

Биеийн тамирын тасаг бараагаа цоо шинэ, гялалзаж гялтганаж, харагдахаар өрсөн учир бүгдийг худалдаж авмаар санагдана. Боксын бээлий авбал зүгээр сэн. Туйван ч бас хэрэгтэй. Биеийн тамирын өмд Шмаков бид хоёрт юу юунаас аятайхан санагдлаа. Цэнхэр өнгөтэй дороо резинтэй, сүлжмэл даавуун өмд. Үүнийг өмссөн хүн аргагүй тамирчны буурь ордог юм. Захандаа цагаан судалтай хөх ноосон цамц хослуулчихвал ч догь доо. Ёстой бэлтгэлийн хувцас болно.

Ноосон цамц, өмд авчихвал би бүх мөнгөө зарчихна гэсэн үг.

Ингэдэг хэрэг. Биеийн тамирын өмд авъя, гурван рубль байдаг юм. Хоёр хориор нь бэлэг авъя. Яг арван рубль үлдэнэ. Игорийн хэлснээр сарын эцэст хорин рубль авбал би гучин рубльтэй болно. Үүгээр нэг дориухан юм авдаг хэрэг.

— Авах уу? гэж би Шмаков Петрээс асуулаа.

Тэр бээр өмдийг няхуур гэгч нь эргүүлж тойруулж үзэн, барилж, энд тэндээс нь харан дуугүй зогсоно.

— Очиж мөнгөө төллөө! гэж эрс хэлэв.

Шмаковыг Вадим шиг өөрийн биеэр үлгэрлэх хэрэгтэй.

Би кассад гурван рубль төлөөд юмаа боох цаас авч байхад Шмаков өмдийг эргүүлж тойруулж үзсээр л лангууны дэргэд зогсож байлаа.

— Гар чинь загатнаж байгаа биз дээ, мөнгөө тушаагаач гэж намайг хэлэхэд Шмаков санаа алдаж

— Даавуу нь муу юм. Хоёр хоноод л суначихна. Өвдөг гарна... Тэгээд өнгөрөх нь тэр. Хоёрдугаар зэргийнх юм.

Гол минь харлав.

— Чи надад юунд хэлсэнгүй вэ гэхэд минь Шмаков бахь байдгаараа

— Амжсангүй гэлээ.

Энэ удаа түүний хар ухааныг шагшин гайхсангүй. Үүнийг чөтгөр аваасай! Юун удаан юм дээ.

Аяа гэх вэ. Нэгэнт хийчихсэн юмыг яах вэ дээ! Гурван рублээ үрчихлээ, хойшид л ухаантай байж үзье.

Би үнэртний тасаг руу даруйхан очиж, ээжид үнэртэй ус авахаар шийдэв. Гэтэл замд бичгийн хэрэгслийн тасаг тааралдав. Шмаков бид хоёр тэнд саатлаа.

Авто үзэг, гөлөнгөр хавтастай зузаан дэвтэр хоёр нүд булаав. Аавд үзэг авбал зүгээр сэн ээ. Бэлэг гэж үүнийг л хэлнэ дээ! Аавын үзэг бүүр болохоо больсон байсан.

Гэтэл дөрөв тавь юм. Аравтдаа хүрэх хэрэгтэй болох нь ээ... Энэ өмдийг ав гэж ямар эз хатгав аа. Хэрвээ би аваагүй сэн бол аавд үзэг, ээжид жижиг шилтэй үнэртэй ус авч ,хүрэхгүй юу. Тэгээд надад яг арван рубль үлдэх байсан...

— Дэвтэр авах хэрэгтэй юм. Чи ямар өнгөтэйг авах вэ? гэж Шмаков хэлэв.

Өөртөө одоо юу ч авах ёсгүй байсан юм. Гэвч өмд авсан гурван төгрөгийг бодвол гучин тавхан мөнгө юухан байх вэ? Тэгээд би:

—Хүрнийг авна, харин чи? гэв.

Шмаков «бодох хэрэгтэй» гэсэн байртай толгой хөдөлгөв.

Би кассад гучин таван мөнгө тушаагаад, хүрэн гилгэр гадартай сайхан гэгчийн зузаан дэвтэр авчихлаа.

— Хурдхан шилээд аваач гэж би Шмаковыг яаруулав.

Мань хүн санаа алдсанаа

— Тусгүй юм аа гэв.

— Чи ч ёстой харамч амьтан юм аа гэж би Шмаковт хэллээ.

Үнэртний тасгаас би «бэлэг» гэдэг үнэртэй ус хайрцгаараа ямар үнэтэйг асуув.

— Таван рубль гэнэ ээ? Аяа!

Хайрцагт хоёр байдаг. Салгахгүй хоёулыг хамт л худалдах гэнэ. Жигтэйхэн журам юм даа...

Юу авахаа мэдэхгүй лангууны дэргэд таг самгардан зогсов. Тэр ч байтугай нүүрээс гал бутраад явчихлаа.

— Петро, мөхөөлдөс авч идье!

— Яах юм!

Би мөхөөлдөс авчихлаа. Жаал сэрүүцэхгүй бол яаж болох вэ? Миний үрчихсэн тэр мөнгөтэй жишвэл арван есөн мөнгө юу ч биш ээ?

Тэгж тэгж «Москвагийн гэрэл» гэдэг усыг хоёр рубль жараар авна. Надад мухар есөн төгрөг үлдэнэ. Нэг рубль ээжээс зээлчхээд яг арван төгрөгтэй болж, дориухан юм авна аа. Дараагийн цалин аваад ээжид өрөө төлөөд аавд бэлэг авч өгье. Энэ зөв юм. Энэ цалингаас ээжид, дараагийнхаас аавд бэлэг авна...

Шмаков Петрт жаал зугаа атаархаж байлаа. Тэр ганц ч төгрөг гарздаагүй шүү дээ. Гэвч тэр бол харамч, би бол үгүй гэдэг бодлоор сэтгэлээ засаж байв.

— Дэлгүүрээр жаахан тэнэх үү гэж Шмаков гуйв.

Би эрс татгалзлаа. Гар татуу Шмаков ч дажгүй. Би ямар нэг юм тэсэхгүй авчихна. Нэг харвал Вадим биднийг даллаж байна. Хаанаас гараад ирснийг бүү мэд. Биднийг даллачхаад, биеийн тамирын тасаг руу харайлгахыг нь ажиглав. Бид ч араас нь тавьж хүрлээ.

— Бушуухан оочирт зогс гэж Вадим сандрангуй шивнэв.

Лангууны дэргэд хүмүүс хэдийнээ дараалан зогссон байлаа. Түрүүхэнд байгаагүй юм. Бид хоёр Вадимын ард зогслоо. Бидний ард хэд хэдэн хүн нэмэгдэв.

— Усан дор өмсдөг баг, хөлд угладаг сэлбүүр хосоор нь авчирсан. Одоохон зарна гэж Вадим шивнэв.

— Бид түүгээр чинь яах юм? гэж би асуулаа.

— Жигтэйхэн амьтан аа! гэж Вадим гайхаад «Намуун ертөнцөд!»... гэв.

«Намуун ертөнцөд» гэдэг номыг би уншсаан. Гэвч Москвад далай байхгүй. Нөгөөтээгүүр хавар Крым юм уу, Кавказ руу тойрон аяллаар явбал тэнд хэрэг болох юм даа. Гэтэл, баг, сэлбүүр авчихвал ямар мөнгөөрөө тойрон аялалд явах билээ дээ? Энэ золигийн өмдийг ав гэж ямар эз нь хатгав аа!

Би гайхаш тасран оочирт зогсож байлаа. Хүн улам олширно. Заримд нь баг хэрэгтэй болоод, зарим нь эхэнд зогсож байсан учир зогсоно. Игорь, Мишка Таранов хоёр ирж, Шмаков бид хоёрын дунд орж зогсон, урьд энд байсан царай гаргав. Бид ч тийм дүр үзүүллээ.

— Сайхан эд. Москвад нүдний гэм гэж Игорь хэлэв.

Худалдагчид баг, сэлбүүрийг боодол боодлоор нь авчирлаа. Дугаарлагсад шуугилдав. Арын улс өөрсдөдөө хүрэхгүй болчих вий

гэж айжээ. Хэдэн хүн сайн дураараа зохицуулах гэж лангууны дэргэд зогсов. Игорь тэднээс яалаа гэж хожигдох вэ.

Би яахаа, яаж шийдэхээ мэдэхгүй л байлаа. Баг сэлбүүр хоёр над огт хэрэггүй. Гэвч далайн эрэг дээр очвол яана, хүмүүс цөм шумбаж байхад би эргүү юм шиг элсэн дээр сууж байх гэж үү? Тэгээд бүтэн цаг яах гэж дугаарт зогсоно вэ? Авахгүй өнгөрвөл хожим амаа барих болно...

Лангуу руу алгуурхан дөхөх зуураа би ийнхүү бодож байлаа. Улам л удаан хөдлөөсэй гэж бодогдоно.

Бидний түрүүнд Вадим, түүний ард Игорь, Игорийн дараа би, миний хойно Мишка Таранов, хамгийн сүүлд

Шмаков Петр зогсож байсан юм.

— Иргэд ээ, хорьхон хос байгаа тул бүү зогсоорой гэж худалдагч хэлэв.

Дугаарлагсад сандрав. Гэвч хэн ч явсангүй. Цөмөөрөө л горь тасраагүй ажээ. Шмаков Петр өмнөх улсаа тоолж үзээд

— Надад хүрэхгүй нь шиг байна! гэв.

Би бас тоолж үзээд

— Хамгийн сүүлчийнх чамд ноогдох нь гэж хэлэв.

Ийм сэтгэл дэнслүүлсэн үед би яаж тэсэх вэ дээ? Надад хүрэхгүй нь гэж зарим нь уйлан алдаж байна. Гэтэл бүтэн цаг дугаарлаж азтайг нь тоонд орсон би болих гэж үү дээ? Энэ ч харин маанаг, инээдтэй юм болох биз ээ!

Би мөнгөө төлж баг, сэлбүүр хоёр авав.

Гэтэл Шмаковын айж байсан ёсоор боллоо. Сүүлчийн хос Мишка Тарановт ноогдов.

Шмаков уруу царайтай байлаа. Миний өрөвдсөнийг хэлэх үү. Ямар нэг юм өөрт чинь хүрээд, нөхөрт чинь хүрэлцээгүй байхад ямар эвгүй байдаг билээ дээ.

Чин үнэнээр нь хэлбэл, Игорь, Мишка Таранов хоёрын нэг л Шмаковт байраа тавьж өгөх байсан юм. Түүнийг бид урдуураа оруулснаас болж, Шмаковт хүртсэнгүй шүү дээ.

Игорь, Вадим, Мишка Таранов гурав ул мөргүй арилжээ.

Шмаков бид хоёр гадагш гарав. Шмаков үл дуугарна. Ер нь дуугарах биш дээ. Гэвч өөрт нь хүрээгүйгээс л одоо дуу шуугүй байгаа юм. Үгүй мөн тоогүй еэ. Хэрэггүй байхад надад олддог. Авах гэсэн Шмаковт хүрдэггүй. Юм гэдэг ийм оноогүй.

Би зог тусаж, Шмаков руу нөгөө хоёроо сарвайлаа.

— За үүнийг ав даа. Надад хэрэггүй.

Шмаков толгой сэгсрэв. Надаас ийм үнэтэй цайтай эдийг минь салгахаас зовж л дээ.

— Ав, ав! би зүгээр л юмыг яаж мэдэх вэ гэж авсан юм. Надад ер хэрэггүй гэж би шаардав.

— Наадах чинь надад ч бас хэрэггүй гэж Шмаков хэлдэг байна.

Би гэвдэж:

— Юу хэрэггүй гэж! гэлээ.

— Яах вэ дээ!

— Юунд тэгээд оочирлосон юм?

— Бүгдээрээ л зогсох чинь билээ.

Шмаков биеийн тамирын өмдийг голоход дотор палхийсэн бол одоо бие хөшчихөв. Тэгэхлээр би мөнгөө бас л дэмий үрсэн болж таарах нь ээ?

Гэсэн ч Шмаков сайхан сэтгэлийн үүднээс л авахаас татгалзаж байгаа байх гэдэг найдвар тасраагүй байлаа. Намайг энэ золигийн сэлбүүргүй болгочих вий гэж бодож байгаа байх.

Би:

— Авахгүй бол буцааж өглөө! гэж айлгав.

— Энэ зүйтэй ээ гэж Шмаков сайшаан, өгүүлээд. Энэ баг хэнд хэрэгтэй юм? Шил хийчихсэн энгийн нэг резин л байна. Сэлбүүр углачихлаар ердөө ч самарч болдоггүй юм гэж хэлдэг байна.

Би хоолой чичрүүлэн

— Авах уу, үгүй юу, сүүлчийн удаа асууж байна гэвэл Шмаков мөрөө хавчисхийлгэж:

— Хоргоогоод байдаг нь! Надад ийм өөдгүй юм хэрэггүй гэв.

Би дэлгүүр рүү эргэж явав.

Биеийн тамирын тасагт оочир байсангүй. Гэвч хэдэн хүн шахцалдаж, байлаа. Би баг, сэлбүүр хоёроо лангуун дээр тавиад буцааж өгмөөр байна гэлээ.

— Барааг буцааж авдаггүй дээ гэж худалдагч хариулав.

Худалдсан барааг буцааж авдаггүйг би ч бас мэдэж байсан юм аа. Үүнээс авч чадаагүй хүмүүс авч магадгүй гэж горьдож өнөө хоёроо лангуун дээр тавив.

Гэвч авах хүн алга байлаа. Яагаад тэр билээ? Уйлах шахсан өчнөөн төчнөөн хүн дөнгөж саяхан энд шавааралдаж байгаагүй юу.

Нэг хүн ирж, багийг үзэв. Би горьдон өөдөөс нь харлаа. Тэр хүн барьж үзсэнээ яваад өгөв.

— Жаалаа, лангууны дэргэд бүү зогс, саад болж байна гэж худалдагч хэлэв.

Би боодолтой юмаа хумин авав. Сэтгэл гонсойн хар бууна. Би бараг хамаг мөнгөө үрэн таран хийлээ, гэхдээ юу авсан бэ гээч? Авсан юман дотроос минь надад хэрэгтэй юм гэвэл хүрэн гадартай зузаан дэвтэр л байлаа.

Одоо яасан ч яах вэ? Би бичгийн хэрэгслийн тасаг руу очиж үлдсэн мөнгөөрөө хятад авто үзэг аавдаа авав.

Амьдрал бол голын ус шиг юм гэж хэн ч билээ дээ нэг нь их онож хэлжээ. Урссаар л байдаг. Нэг долгионыг өнгөрөөхөд араас нь дараа дараалан гарч ирнэ. Усан дээр зомгол гарч ирээд эргэлдсэнээ чамаас түрүүлэн урсаж алга болно.

Вадимын агуулахаас олдсон хэрэгсэл, Липкад гарсан ослыг аяндаа цөм мартаж тэр ч атугай зөөллүүрийн тухай дурсахаа ч больжээ. Би ч анхныхаа цалинг тэгж дэмий үрсэндээ ч харамсахаа болилоо. Авсан юмнаас над хэрэг болсон ганц зүйл бол одоо энэ дурсамжаа бичиж байгаа гөлгөр хавтастай дэвтэр л билээ.

Майка Лагутинтай бүжиг хийсэн явдал хүртэл тийм их сүрхий юм шиг санагдахаа байжээ. Лагутинтай ганц бүжиглээ л биз, үүнд гажууд юм байна уу? Миний хувьд бол найзгүй л юм л даа. Гэвч тэр бол бүсгүй хүүхэд, ухаантай, шулуун зантай байлаа ч гэлээ гэсэн хэрүүл гарахаас болгоомжилж бололгүй яах вэ.

Би Майкагийн дэргэд байсан бол Лагутиныг хавьтуулахгүй байсан. Гэтэл би дэргэд нь байсангүй, түүнийг өмгөөлөх хүн огт байгаагүй ээ.

Майка одоо над дээр хүрч ирээд «Тусгүй юм болжээ, Лагутинтай бүжиглэдэггүй л байлаа даа, гэвч би хэрүүл шуугиан гарахаас болгоомжилж л бүжиглэсэн юм шүү дээ» гэж хэлсэн бол дороо эвлэрэх байсаан. Бид ухаанаа ололцож урьдын янзаараа болох байлаа.

Майкагаас нүүр буруулахаа болиод, харин түүнийг өөр дээрээ ирүүлж, үүнийг хэлүүлэхийн тулд нүдэнд нь харагдахыг хичээх болов. Гэвч Майка над руу ирэхгүй, юм ч ярихгүй байлаа. Бидний хооронд юу ч болоогүй юм шиг холоос л над руу инээмсэглэнэ.

Би түүн рүү урьтаж очихыг хүсэхгүй байв. Учир нь Лагутинтай тэр бүжиглэсэн болохоос биш би бүжиглээгүй!

Үүрд эв тасрах гэж байж болохгүй. Хэзээ нэг цагт эвлэрэх хэрэгтэй. Хүмүүс эв зүйгээ олохгүй бол яваандаа бүүр хэрэлдэнэ гэсэн үг. Хэрүүл гарахад нэгийнх нь буруу нөгөөгийнх нь зөв байна. Тэгэхлээр буруутай нь эвлэрье гэж эхэлж гуйх хэрэгтэй.

Бүх юмс өөрчлөгдөн хувирах боловч мартагдахгүй зүйл бас бий. Сэтгэлээс хэзээ ч гарахгүй юм гэж бий. Удах тусам улам бодогдоно. Амар заяа үл үзүүлнэ.

Зуевын тухай бодох тусам ичгүүртэй санагдана. Бидний ер нь миний харгайгаар түүнд ноогдуулсан шударга бус шийтгэлийг залруулах гэж би юу ч хийгээгүй. Үүгээр ч зогсохгүй Лагутины балгаар би Зуевыг гүтгэсэн болж таарч байгаа. Би нөхрөө хохироогч гэж өөрийгөө үзэж байв. Хүн надаас болж хохирсон байхад би санаа амар явж байдаг. Муухай яа! Шмаков Зуевтай тэгж тайван ярьж, далан хэл дэлгэж яаж чадна вэ? Шмаков ч бас буруутай. Надыг бодвол бага, гэлээ ч гэсэн... Хэн татлагыг буруу холболоо доо?

Даргад өргөдөл бичих хэрэгтэй гэж Шмаков, Вадим хоёрт дахин хэлэв.

Шмаков

— Хэнд хэрэгтэй юм? гэж хайхрамжгүй хэлэв.

Вадим нь

— Амархан сайн байна уу, мөн дурсав аа! гэлээ.

Тэгэхлээр нь би өөрөө өргөдөл бичлээ. Товч боловч үнэмшихүйц бичив. Хамаг буруу Игорь, Вадим, Шмаков Петр бид дөрвийнх. Бид дур мэдэн машиныг чирэхдээ татлагыг буруу холбосон. Зуев биднээс холдоогүй, Ивашкиныг эрэхээр явсан юм. Түүнийг шийтгэдэг буруу байна. Энэ өргөдлөө даргын өмнө ширээн дээр тавилаа.

— Энэ юу вэ? гэж даргыг асуухад:

— Өргөдөл гэж би хариулав.

— Юун тухай?

— Наана чинь бичсэн байгаа.

Дарга хөмсөг атируулав. Өөрт нь өргөдөл гаргахад дургүй хүн. Өргөдөлд болохгүй юмыг л гуйсан байдаг. Болохтой юмыг ямар ч өргөдөл гаргалгүй авч болно.

Дарга миний өргөдлийг нэг уншсанаа хоёр дахиа уншиж гарав. Нэг уншаад ойлгосонгүй гэж үү? Хэчнээн тодорхой энгийн бичсэн билээ! Хоёр дахиа уншаад дарга намайг харав.

— Чи яалгах гэсэн юм? Тодруулаадах!

«Тодруулах» гэдэг үгийг хэлээгүй сэн бол бид түүнд юу хүсэж байгаагаа тайлбарлах байсан. Бидний буруу болохоос, Зуевынх биш гэдгийг би нотлох гэсэн юм. Гэтэл энэ нь бас л тодорхойгүй юм. Тодорхой нь чухам юу байх вэ? Тодорхой хэлбэл Зуевыг донгодсон тушаал байна. Дарга тушаалаа хүчингүй болговол энэ нь тодорхой болох юм. Түүнд ийм шаардлага тавивал наанадаж инээдтэй юм болно. Би сүйхээ гаргаж:

— Таны тушаал буруу байна. Зуев гэмгүй. Бидний буруу гэлээ.

— Тийм бий!.. гэж үүнийг анх сонсож байгаа мэт дарга уянгалуулан хэлээд, үнсний савны оронд ширээн дээр нь тавьсан хөнгөн цагаан бүлүүрийг яагаад ч юм хөдөлгөв. Тэгэхлээр та нарыг донгодох хэрэгтэй болж байна уу? гэв.

Би мөрөө хавчив.

— Ингэх нь зүйтэй гэж үзэж байгаа бол... болохгүй яагаад байх вэ? Биднийг донгодох хэрэгтэй.

— Тэгж болно оо! гэж дарга тайвуухан хэлэв.

Хэн нэг нь хаалга татав. Дарга «хүнтэй байна» гэж хэллээ. Хаалга хаагдав.

— Нэр хэн билээ?

— Крашенинников.

— Аав бий юу?

— Бий.

— Хаана ажилладаг вэ?

Аавын ажилладаг заводын нэрийг хэлэв.

Дарга ахин дуугүй болсноо,

— Тэгэхлээр чи ухаантай, би тэнэг болж таарч байна уу гэв.

Үүгээр тэр бээр намайг тэнэг, өөрийгөө ухаантай гэж хэлж байгаа юм. Би хариу хэлсэнгүй.

Хариу хүлээлгүй дарга цонх өөд харав. Би ч цонх руу харлаа.

Тэнд хараад байхаар юм алга байлаа. Дарга цонх руу харсан хэвээрээ төв хоолойгоор:

— Барилга дээр материал хүргэж өгсөнгүй. Хэн хүргэж өгөөгүй вэ? Жолооч хүргэж өгөөгүй. Хэн муу зохион байгуулав. Ашиглалтын дарга муу зохион байгуулсан. Гэтэл хэн шийтгүүлэв. Дарга шийтгэл авсан. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл дарга жолоочийг ч, ашиглалтын даргыг ч хариуцдаг. Машин чирэхэд хэн хариуцаж байлаа? Зуев хариуцаж байсан. Хэнээс асуух ёстой байв? Зуевээс. Ойлгов уу? Чи үйлдвэрчний хороон дарга биш тул чамд энэ бүгдийг тайлбарлах ёсгүй. Гэвч би тайлбарлаж байна. Яагаад гэвэл чи балчраараа байна. Одоо яв, хүмүүс намайг хүлээж байна гэв.

... Даргад ярихад амархан. Трестэд түүнд сануулга өгөхөд тэр бааз дээрээ хэн нэгэнд донго авч бас чадна. Гэтэл Зуев хэнийгээ шийтгэх билээ? Хэнийг ч чадахгүй! Зуев бол энгийн гүйцэтгэх ажилтан, өөрийнхөө хийснийг л хариуцна. Даргад ингэж л хариулдаг

байж дээ. Гэвч зөв хариу даргатай ярьснаас хойш цаг шахмын дараа сэтгэлд орж ирж байгаа юм.

Миний өргөдөл ямар ч нэмэр болсонгүй. Гэвч нүүр бардам аа. Би чадах бүхнээ л хийлээ. Өргөдөл өгсөн гэж Зуевт хэлмээр байв. Тэр мэдэг. Гэвч ингэж болохгүй ээ. Би онгирсон болно.

За яах вэ. Тэр юу л гэж бодно вэ бодог. Цөмөөрөө юу л гэж бодно вэ бодог. Би ажлаа л хийж байя. Хэнийг ч анхаарахаа больё. Дадлага удахгүй, арван хоёрхон хоноод тэртэй тэргүй дуусна. Надаас асуултгүй, би техникт авьяасгүй хүн. Үүнийг бултаараа мэдэж байгаа.

Би гарашинд эргэж ирэн, ажилдаа оров. Лагутин намайг нүднийхээ булангаар харж байна. Намайг дарга дээр орохыг харсан юм байх даа. Хялайж л байг яадаг юм!

Би өөрсдийнхөө машины урд мостыг барьж авав. Энэ бол Шмаков бид хоёрын хийх ёстой байсан сүүлийн зүйл бөгөөд үүнийг өнөөдөр гараас гаргачихмаар байлаа. Бидний хийсэн зүйл угсрахад бэлэн гэж хоёулаа хэлнэ. Ингэвэл бусад хүүхэд шалавлах болно. Ингэхгүй бол бид практик дуусахаас наана машинаа босгож амжихгүй нь.

Гэтэл Шмаков хажууд байгаа машиныг зааж:

— Үүнийг тослох хэрэгтэй гэлээ.

— Үгүй ээ, өөрсдийнхөө машины урд мостыг өнөөдөр дуусгасан нь дээр.

— Бригадын дарга манай машин дээр ажиллахыг болиулсан.

— Яагаад болиулсан гэж?

— Болиулсан, тэгээд л тэр.

Би бригадын дарга Дмитрий Александрович руу очиж, манай машиныг засахыг болиулсан нь үнэн эсэхийг асуулаа.

Машин сэлбэхийг хэн ч хориглоогүй. Гэвч үүнийг ажлын цагаар хийж болохгүй гэж Дмитрий Александрович хариулав.

Манай машин дээр ажилласны хөлсийг өгөхгүй юм байжээ.

— Шмаков та хоёр Липка руу хоёр хоног явсан, ингэж явсныг ажлын бүртгэлд оруулаагүй, гэтэл та нар мөнгийг нь авсан. Бригадын хөрөнгөнөөс. Энэ зөв үү?

— Буруу байлгүй яах вэ? Зохисгүй явдал гарч байна. Гэвч энэ талаар Игорь тэргүүтэй штабынхан бодно биз, ингэ гэж тэднийг сонгосон юм чинь. Миний хувьд гэвэл юм бүхэнд хуруу дүрж явахаа больё.

Гэлээ ч гэсэн ийм нөхцөлд штаб хэрхэн ажиллах гэж байгаа нь надад сонин байлаа. Үүнийг Игориос асууя гэж шийдлээ. Гэхдээ ажилд нь хөндлөнгөөс оролцох гэсэндээ биш зүгээр л үгэнд дурлаж асуух юм.

Игорь техникийн хэлтэст сандал дээр лаглайн сууж байх агаад ширээн дороос хөл нь ёрдойн харагдах ажээ.

— Мэдэж байна аа, цехээр л нэг тийм балай юм болоод байна гэж хайхрамжгүй хариулав.

— Ажлын дараа үлдье гэж би санал гаргав.

— Гялайлаа! Ажилгүй хэн байгаа юм. Жишээлбэл би студи дээр кино зураг авхуулж байгаа. Ер нь бүтэхгүй дээ. Ажилчин анги санаачилга гаргахгүй байна.

— Ажилчин анги энд ямар хамаатай юм?! Өөрөө зохион байгуулж чадаагүй байж гэж би зөрөв.

— Магадгүй гэж Игорь хэнэггүй хариуллаа.

— Ингээд амаа буцах хэрэг үү?

— Тэгж л байна.

— Зэвүү минь хүрэв.

— Машин сэлбэнэ гэж анх ам гараад одоо болохоор буцаж байх шив.

— Санаа байвч сачий хүрдэггүй гэж Игорь айлдаж байна.

Энэ машиныг босгоход хэчнээн хүч хөдөлмөр зарлаа! Гэтэл ажил ид оволзож байхад түүнийг хориглодог. Шмаков бид хоёрынх бэлэн шахам, зөвхөн урд мостыг эвлүүлэх л үлдсэн, төмрийн болон гагнуурын цехийн хүүхдүүд арлыг тэгшилж, гагнан, гөлмөн төмөрчид, бүрээслэгчид хийдгээ хийчихсэн... Үүнийг гарын гарз болгож яаж болох вэ?

Тэгээд «ажилчин анги санаачилга гаргахгүй байна» гэдэг юу гэсэн үг вэ? Энэ бол дэмий хэрэг. Ажилчид бүхнийг сайтар ухамсарлаж, ойлгож байна. Гэвч гол ажилд саад болохоос цаашгүй, гарын үзүүрээр тэгс ингэсхийж байгаа «ор нэр хэмээсэн» ажилд дургүй. Ингэхлээр үүнийг тодруулах хэрэгтэй юм.

Хөндлөнгийн хэрэгт оролцохгүй гэж би хатуу шийдэх нь шийдсэн л дээ. Гэхдээ ажил бүтэмжтэй байхад тэгнэ л дээ. Харин

ажил урагшгүй байвал? Тэгвэл оролцох хэрэгтэй! Ажил дахин зүгширмэгц цааш оролцохгүй байж болох юм.

Би эхлээд моторын тасгаар оров. Энэ бол засварын гол цех бөгөөд манай гараашийг бодвол гэрэл гэгээ ихтэй. Энэ ч аргагүй юм, мотор засна гэдэг нарийн ажил, тэгэхлээр цэвэр байх шаардлагатай. Миллиметрийн зууны нэг хувийг л алдвал мотор цохино. Полекутин моторын цехэд ажилладаг нь учиртай, энд техникийн учрыг сайн олох хэрэгтэй. Өндөр мэргэжлийн слесарь болох моторчид хэрээ мэддэг улс. Тэднийг дарга нэр овгоор нь дууддаг юм.

Моторын цехэд орохоосоо би төвөгшөөдөг юм. Тэнд дарга нь гэж хавчдаг шил зүүсэн, ууртай, биедээ эрэмшсэн залуу байдаг. Гаднын хүнд дургүй. Залхуу нь хүрээгүй бүхэн сэлгүүцэж байдаг манай гарааштай адилгүй. Би хаалгыг татаж, Полекутиныг хуруугаараа нааш ир гэж дохив.

Полекутин сайн залуу, техник бузгай мэднэ. Гэвч өөртэйгөө ярьж байгаа хүний мөрөн дээр гараа тавьдаг этгээд зантай хүн. Гэтэл түүний өндрийг яана. Ярилцаж байгаа хүн нь түүнтэй нуруу чацуу буюу арай нам бол бас ч гайгүй харагдана. Өөрөөс нь нуруугаар их нам хүний мөрөн дээр гараа тавивал цаад хүн нь намхан гэдэг нь өөрийн эрхгүй ялгараад байдаг юм. Иймээс би Полекутинаас ямагт хөндийхөн зогсдог билээ.

Полекутин миний үгийг бүрэн зөвшөөрч, штаб ажил хийхгүй байгааг хүлээсэн боловч,

— Сэлбэг хэрэгсэл гэдэг бас нэг адармаатай юм байна. Манай машинд цохож өгдөггүй. Аар саар юм цуглуулж болно. Гэвч ор байхгүй юмыг яах вэ? Жишээлбэл, жижиг хэсгүүд... гэж нэмж хэлэв.

Тэр бээр хэрэгслийн дугаарыг урсгаж гарав. Яг л Вадим гэсэн үг. Гэвч Вадим сайн мэдэхгүй учраас хэрэгслийн дугаарыг хэлдэг.

Полекутин харин сайн мэддэг учир ингэдэг билээ.

Би үгийг нь тасалж:

— Болих хэрэг үү?! гэхэд

— Тодорхой болгох л шаардлагатай байна гэж Полекутин хэлэв.

— Игорь та хоёр л тодорхой болгох ёстой доо.

— Игорь бид хоёрын гар нийлдэггүй ээ гэж Полекутин хэлэв.

— Үгүй мөн лут сайд нар аа! гэхээд би мужааны цех рүү очлоо.

Зарим хүүхэд ялангуяа техникт авьяастай хүүхдүүд бол мужааны цехийг тоодоггүй юм. Техник гэдэг бол дан металл, наанадаж хуванцар

байх ёстой, гэтэл мод бол үеэ өнгөрөөсөн эд гэж тоолно. «Мод шуу юм» гэж тоомсоргүй нэрлэнэ.

Тэгвэл мужааны цех надад аятайхан байдаг юм. Бусад цехтэй адилгүй. Энд хөрөө хяхтнаж, харуул шурд шурд хийн зомгол, давирхайтай модны үнэр ханхлах нь нэг л онцгой. Энэ цехэд очиход өвөө аавын суудаг тосгон сэтгэлд буудаг юм. Ажилчид нь хүртэл тайван, налгар, аажуу улс бөгөөд мохоор тамхи нэрж сууцгаана. Мохоорын үнэр хүртэл тосгоныг маань санаанд оруулдаг юм.

Мужааны цехэд манай дөрвөн хүүхэд ажилладаг. Тэдний дотор үргэлж ээлжээр юм бичиж авдаг нөгөө Семечкина, Макарова хоёр бий. Энэ дөрвөн нөхөр хашлага, кабиныг одоо болтол засаж янзалсан юмгүй, зөвхөн хугарсан өмхөрсөн банзыг авчээ. Шинийг эргүүлж тавиагүй.

— Дөрвөн ангалзсан амьтад байдаг, гэтэл ажил урагш ахисан юмгүй байдаг гэвэл:

— Тайвширч хайрла. Биднээс болж ижил саатах нь юу л бол гэж Инна Макаровыг доогтой хариулсанд Семечкипа нь:

— Бусдыг шавдуулаад ямар маягтай юм бэ? гэж хошуу нэмэрлэв.

— Тануусыг шавдуулсан хүн алга аа. Гэвч ямар ч уялдаа холбоо байхгүй байгааг харж байгаа биз дээ.

— Манайд л ингээгүй дэг. Машинаа хийхийг минь биднийг хориглоогүй ээ гэж Инна Макарова татгалзлаа.

— Тэгээд яагаад хийхгүй байгаа юм?

Тэр хоёр буланд гозойлгосон саяхан харуулдсан банзнуудыг зааж:

— Цөм бэлээн. Амжина аа. Хашлагыг хамгийн сүүлд тавих юм чинь. Мод хатаж байг гэв.

Макарова, Семечкина хоёрт би гайхав. Тэр хоёр техник сонирхохдоо надаас ч дор, гэтэл би огт сонирхдоггүй билээ. Семечкина, Макарова хоёр манай ангийн утга зохиол, урлагийн төлөөлөгчид. Макарова нь утга зохиолынх, Семечкина урлагийнх. Макарова өгүүллэг бичдэг, Семечкина дуу дуулдаг юм. Сургуулийн үдэшлэг дээр тэр дуулдаггүй, нэг багш нь хоолой засах, нөгөөдөх нь засах тэгээд хоолой «эвдчихнэ». Энэ дэмий юм хөгжмийн дээд сургуульд ортол үргэлжлэх болно гэж ярьдаг юм. Макаровагийн

тухайд гэвэл түүний өгүүллэг бүхэн нь «үүр цайж байлаа» гэсэн ганц өгүүлбэрээр дуусна.

...Өнчин хүүхэд ээж, ааваа оллоо. Тэд уйлж, үнсэлдэж, гадаа гарав... Үүр цайж байлаа.

Нэлээд залхуу нэг хүүхэд засарчээ. Амьдралдаа анх удаагаа хичээлээ хийгээд гадагш гарав. Үүр цайж байлаа...

Тэргүүн сурагч бас нэг хүүхэд хамт олноосоо тасарчээ. Хурал дээр түүнийг зад шүүмжилж, тэр бээр алдаагаа ухамсарлажээ. Бүгдээрээ сэтгэл дүүрэн гадагш гарлаа. Үүр цайж байв...

Энэ үүр цайхыг дайралдсан газраа чихнэ.

Ямар ч гэсэн мужааны газрын байдал сэтгэл жаал засав. Бусад цехэд ийм байдаг бол ч! Гэтэл бусад цехэд иймгүй байлаа...

Цахилгаан цехэд Гринько

— Өөрийнхөө ажлыг ч дийлэхгүй байна, танайхыг хийх зав алга! гэж бригадын дарга хэлсэн хэмээн надад хэлэв.

Энэ үг урам хугалж, цахилгаан цехээс хүхэр хүчил ханхлан , Липкад өмдөө түлсэн минь санаанд оров.

Гагнуурчид ер нь дуу цөөнтэй улс. Гагнуурын чимээнд юу хэлж байгааг сонсдоггүй байж болох юм. Энд ирэх тоолон би тэндээс «Гэдрэгээ бай» гэдгээс өөр үг дуулж үзээгүй ээ. Суурь дээр ганцаараа хэрзийн байгаа машиныхаа арлыг харж, дэнлүүний хөх дөлийг сонирхож байснаа цааш явав.

Тийнхүү би бүх цехээр оров. Майкагийн ажилладаг бүрээслэх тасгаар л орсонгүй. Майка эвлэлийн үүрийн дарга учир түүнтэй хамгийн түрүүнд уулзах ёстой байсан юм. Гэвч бид хоёрт ярих юм алга. Гэтэл бүрээслэх цехийн хажуугаар гарч явтал (би хэд хэд өнгөрсөн юм) Майка намайг хараад над руу өөрөө гарч ирэв. Юу ч болоогүй юм шиг шүү. Бид хоёр байдлыг хэлэлцээд, ангийн хурал хийхээр шийдэв. Майка над руу өөрөө хүрч ирсэнд би баярлаж байлаа.

Бид хоёрын хооронд бүх юм дууссан. Гэвч Майка үүнийг мэдээгүй боллохтой. Өөрөөр хэлбэл бид хоёрын хооронд бүх юм дууссан гэдгийг мэдээгүй юм. Ер нь яаж ч мэдэх билээ! Би өөрт нь хэлээгүй, өөрөө тааварлаж яаж чадах вэ.

Бид дассанаараа нөгөө цулгай дээрээ цуглав.

Автобазын дарга, ерөнхий инженер, моторын цехийн дарга, испани хүнтэй төсөөтэй манай бригадын дарга Дмитрий Александрович, бүрээслэх болон мужааны цехийн бригадын дарга нар ирцгээв. Бараг л баярын хуралдаан шиг юм боллоо.

Ерөнхий инженер хэлсэн нь:

— Та нарын санаачилгыг магтууштай. Машиныг сэлбэн зассанаараа тануус хөдөлмөрийнхөө нийгэмд ашигтай үр дүнг үзнэ. Гэвч үйлдвэрлэлийн бодит нөхцөлийг бодолцох хэрэгтэй юм. Энэ машиныг сэлбэх тухай төлөвлөгөөнд заагдаагүй. Үүнд зориулах цалингийн фонд ч, материал ч байхгүй. Энэ тухай бодож, ярилцаж, хэлэлцэх хэрэгтэй байна гэв.

Манай бригадын дарга Дмитрий Александрович

— Сайн хүүхдүүд. Ажиллаж л байна. Гэвч ажлын цагаар машиныг засаж байгаа юм, гэтэл энэ ажил тооцоонд орохгүй. Цалинд нь нөлөөлж байна гэж хэлэв.

Бүрээслэх бригадын дарга:

— Хаанаас материал авах вэ? гэж асуув.

— Арга ухаан сийлбэл болохгүй яах вэ гэж дарга анхааруулав.

— Норм маань яг таарсан шүү дээ, Владимир Георгиевич гэж бригадын дарга хэллээ.

Моторын цехийн дарга, хавчдаг шилтэй биедээ эрдсэн залуу:

— Аар саар юмыг ч яах вэ, аргалж болох юм биз. Бүлүүрийн хэсгийг яах вэ? Үнэнийг хэлэхэд шинэ мотор л цуглуулж байна шүү дээ. Тодруулах хэрэгтэй байна.

Дарга газар шагайж:

— Мөн ч хэлбэрдэгч улс юм! Гологдол гаргаж чадна, ажилгүй сэлгүүцэж чадна, гэтэл дөрвөн банз хаанаас авахыг мэдэхгүй байна гэнэ.

Үүнээс даргаар манай машиныг албан ёсны ажлаар хийлгэхийг зөвшөөрүүлж, үүнд материал гаргуулж, ажилласны хөлс өгүүлэх гэж бригадын дарга нар хүсэж байгааг бид ойлгов. Гэтэл дарга бүх ажлыг албан ёсны биш журмаар хийлгэж, цехүүдийг бидэнд өөрсдийн хүчээр, дотоод нөөц бололцоогоор нь туслуулахыг хүсэж байв. Бид ацад орчихлоо.

— Ганц ухамсар багадна. Дадлага хийгчид маань юу гэх нь вэ сонсьё гэж дарга хэлэв.

Бид юугаа хэлэх вэ? Тэд л яах аргыг олохгүй байгаа бол бид яаж олох вэ...

Тэгтэл Игорь ам нээж:

— Владимир Георгиевич бид юу гэх вэ? Цехийн нөхөд бидэнд туслахгүй гэж байгаа бол юу ч бүтэхгүй л дээ гэв.

Энэ нь машин босгох Игорийн дур байхгүй болсон гэсэн үг ээ. Тэр дандаа тэгдэг юм. Санаа сэдэж шуугиан дэгдээж, «товойж гарч ирснээ» дорхноо сонь нь буурч, тэр ч атугай сэтгэлээр унадаг юм.

— Ангийнхан маань урам зориг дүүрэн байсан, гэтэл юм юмаар мөхөстөж байна! Ингэхлээр бид аргагүйдэж ажлаа зогсоох болж байна гэж тэр бээр үргэлжлүүлэн ярив.

Майка тохуутай гэгч нь:

— Зэвсэг барьдаггүй л байж дээ гэж хэлээд тавьчихав.

Игорь гомдонгуй уруулаа цорвойж

— Боловсролтойгоороо бүү гайхуул. Плехановын хэн болохыг би ч бас мэднэ. Гэвч Плеханов энд ямар ч хамаагүй.

— Харин ч их хамаатай гээч! Чи яг оппортунист, эвлэрэгч мөн! гэж Майка хариулав.

Игорь яг оппортунист, эвлэрэгч яах аргагүй мөн гэж цөмөөрөө хашхиралдав. Би ч бас тэгж хашхирав. Машиныг босгохоос татгалзана гэдэг бол ёстой шившгээ дэлгэнэ гэсэн үг

— Чи бол ч аль хэдийн больчихсон доо! Нэгэнт эхэлснээс цааш дуусгах л хэрэгтэй. Ичгүүртэй, шившигтэй юм! Комсомолчид ингэдэггүй юм! Комсомолчид их бэрхшээл даван туулдаг юм! Жишээ нь: Атрыг тэдний эзэмшсэнийг үз л дээ гэж Майка хэлэв.

Игорь ахиад хамраараа дуугаран:

— Сайхан үг хэлж бид бүгд чадна. Харин бэрхшээлийг яаж давах юм бэ?

Тэгэхэд нь би,

— Чи л бидэнд ганц саад болж байна. Чиний туйлбаргүй зан, хүнд суртал хоёр чинь.

Бид хоёрыг хэрэлдэхээ боль гэж цөм хашхиралдав. Хэрэлдэлгүй, арга сүвэгчлэх хэрэгтэй.

Тэгэхэд нь би:

— Надад санал байна гэв.

— Чиний саналыг мэднэ ээ гэж Игорь бувтнав.

— Чи мэдэж байхад бусад нь мэдэхгүй байгаа гэж би хэлээд,

— Миний санал гэвэл машинаа ажлын дараа засаж дуусгая. Бид арван өдөр хоёр цаг илүү ажиллаж чадахгүй гэж үү дээ? гэлээ.

— Чадалгүй яах вэ! гэж Полекутин батлав.

— Яриагүй чадна! гэж Гринько, Мишка Таранов зэрэг техникт авьяастай хүүхдүүд ам нийлэв.

— Болох байх аа! гэж техникт төдийлөн авьяасгүй хүүхдүүд итгэлгүйхэн дуугарав.

— Бид ч үлдэцгээнэ, гэхдээ удахгүй гэж охид хэлэв.

Дарга бригадын дарга «ар тийш эргэж

— Та нар зовохгүй байна уу? Сурагчид сайн дураараа ажиллая гэж байна, гэтэл шефлэж авсан бид туслахаасаа татгалзаж байдаг. Та нарын хүүхдүүд чинь энэ машинаар сургууль хийнэ. Муухан ч аав ээж нар юм даа гэв.

Тэгтэл манай бригадын дарга Дмитрий Александрович:

— Хүүхдүүд ажлын бус цагаар хийвэл бид тусална. Гэхдээ материалыг нь яадаг билээ?

Моторын цехийн дарга хэлсэн нь:

— Асуудал нэг тийш болж, өөрөөр хэлбэл хүүхдүүд илүү цаг ажиллаж, ажилчид сайн дураараа эдэнд тусалбал цехийн дарга нар бид зарим зүйлийг дотоод нөөцөөс гаргаж болох юм. Гэвч ор тас байхгүй хэрэгслийг яадаг билээ гэв.

Энэ бол олддоггүй сэлбэг. Үүнийг Автобазын дарга л мэддэг юм.

— За яая гэхэв гээд дарга санаа алдан өөдөө харснаа

— Хүүхдүүд ажлын бус цагаар ажиллаж, ажилчид тэдэнд сайн дураараа тусалж, цехийн дарга нар дотоод нөөцөө уудлах юм бол ховор зүйлийг бид өгөхөөс яах вэ. Сургуульд шеф байгууллагын тусламж болгоё. Гол нь арга хэмжээ сайн дурын шинжтэй байх нь чухал юм гэв.

Миний бодоход өдөрт хоёр цаг л хүрэлцээтэй, насны байдлаар бол хүүхдүүд зургаан цаг ажиллаж чадна гэтэл дөрөвхөн цаг ажиллаж байгаа. Тэгэхлээр энэ сурганы ч, хууль зүйн ч үндэстэй болно гэж ерөнхий инженер хэлэв.

— Цаг ч гайгүй, сайн дурын үндсэн дээр ажиллах хэрэгтэй гэж дарга хэлэв.

Энэ санааг мөн чанартаа гаргасан хүн нь надаас өөр хэн байх билээ. Гэвч энэ тухай би бодсонгүй... Дэвэргэн зан маань хөдөлж байгааг би ойлгож байв.

Өнөөдөр бүтэн сайн!

Сүүлийн хоёр ням гараг хий дэмий өнгөрсөн. Яаж өнгөрөөснөө ч санахгүй байна. Гэвч энэ сайн өдрийг олигтой өнгөрүүлэхээр бид шийдэв. Бид гэдэг маань Шмаков Петр бид хоёр шүү дээ. Химки рүү элсэн эрэг дээр очъё. Би сэлбүүр, баг хоёроо авъя. Эдгээрийг ашиглах хэрэгтэй шүү дээ!

Вадим утасдав. Биднийг Химки рүү явах гэж байгааг дуулангуутаа л хамт явъя гэж хашхирлаа.

— Бид юмаа зэхчихсэн гэж би санууллаа.

— Би ч бас бэлэн. Юугаар явах вэ? Метрогоор уу? Явсхийж бай, би тосоод очъё гэж Вадим хэлэв.

Шмаков бид хоёр Вадимын суудаг байшинд дөхөж очтол Игорь харагдав. Мань хүн ахынхад «москвичтай» ноцолдож байлаа. Машин нь явган хүний замын дэргэд зогсож байна. Игорь асаах гэж ядчихжээ.

— Стартер бүү гишгэ, зайгаа барчихна гэж түүнд хэлбэл Игорь манийлаа бидэн рүү сарвайж:

— Эргүүл гэлээ.

Шмаков бид хоёр ээлжээр эргүүлж гарлаа. Мотор нь эргэх боловч асахгүй байлаа.

— Асаагуур тэжээлийг нь шалгах хэрэгтэй гэж хэлэв.

Игорь машинаас гарч, сөхсөн ,хамрын дэргэд самгардан зогсов. Асаагуур, тэжээлийг яаж шалгадгийг мэдэхгүй байгаа нь гарцаагүй. Хар толгойгоороо баталж байна!

— Шалгаач гэж би хэллээ.

Игорь тээнэгэлзэлгүй оч үүсгүүрүүдийг дараа дараалан барьж үзсэнээ биднийг самгардан харав.

Би «Москвич» дээр ажиллаж үзээгүй. Надад техникийн авьяас байхгүй. Гэвч энэ нь «москвич» мөн, биш алин ч байлаа гэсэн бүгдээрээ нэг л зарчимтай. Эхлээд оч гарч байгаа эсэхийг, дараа нь бензин карбюраторт ирж байгаа үгүйг үзэх хэрэгтэй.

Оч гарч байгаа эсэхийг шалгая гэж би Шмаков Петр хэлэв.

Би трамблерээс утсыг сугалж Петр манийлдахад утсыг төмөрт хүргэвэл хөх очнууд маналзав.

— Асаагуур нь зүгээр байна.

Би утсыг буцааж шургуулаад сайн хүргэхийн тулд юу ч атугай чүдэнзний мод хавчуулав. Гараашинд бид дандаа тэгдэг юм.

— Одоо тэжээлийг шалгая. Игорь, түлхүүр аваад аль!

Гэтэл Игорийг юу надад өгсөн гээ? Асаадаг түлхүүр шүү!

— Юугаа өгч байгаа юм бэ? Юугаа өгч байгаа юм гэж асууж байна шүү? Эрэг авдаг түлхүүр аль! гэж би зандрав.

Би ч уурласан юм байхгүй л дээ. Зүгээр л тийм дүр үзүүлсэн юм. Игорийг жаал бажгадуулах гэсэн юм.

Игорь цүнх ухаж, ухаж эрэг авдаг түлхүүр авч надад өглөө. Би бензиний хоолойг эрэгдэж авав. Хоолойгоор бензин гүйхгүй байлаа. Бензиний хоолой тагжирсан нь илт. Үлээсэн чинь бензин гүйж эхлэв. Шмаков бид хоёр инээмсэглэн бие биеэ харлаа. Болохгүй болсон газрыг оллоо. Энэ ч тийм амар биш ээ. Хашир жолооч ч хүртэл эвдэрхийг нь олтлоо өдөржин ноцолдох нь бий. Гэтэл бид хоёр дор нь оллоо. Бас чиг аятайхан байлаа...

Вадим хүрч ирлээ. «Москвичтай» ноцолдож байж бид саатсан нь түүний аз болж, тэгээгүй бол түүнийг яасан ч хүлээхгүй байсан юм.

Игорь машиндаа сууж хаазалж гарлаа. Зүгээр гэдгийг үзэх гэжээ. Зам нийлбэл биднийг, дөхүүлээд өгөхөөс буцахгүй хүний дуугаар

— Та нар хаачих вэ? гэв.

— Метро руу очно.

— Сууцгаа.

Бид сууж хөдлөв. Игорь бүүр сэхээ орж өөрөөр хэлбэл ердийнхөөрөө ихэрхүү дүр оров. Үүнийг харахад, сав саяхан Шмаков бид хоёрын урд хулгана шиг бүлтэлзэж байсан гэж итгэхийн арга алга. тэр бээр налайн сууж, өрөөсөн гараараа зална.

— Аль гээч орно гэнээ гэж тэр бээр биднээс ивээнгүй асуув.

— Химки руу, голын хөвөө орно.

— Явах газраа мөн олов оо гэж Игорь инээд алдаад

— Хөл гишгэх газаргүй байгаа. Би бол Мөнгөт шугуй руу явж байна. Элсэн эрэг ч ганц болдог газар даа! Би тэнд нөхөдтэйгөө уулзах юм!

Вадим шүүрс алдаж:

— Чи ч машинтай сайхан юм аа.

Вадимын дууны өнгөнөөс биднийг хамт аваад яваач гэсэн гуйлт дуулдаж байлаа. Игорь ойлгоогүй дүр үзүүлэв.

— Вадимын бараагүй юмыг Шмаков дөнгөх нь тэр.

Хар ухаан гэгч энэ дээ! Шмаков намайг заримдаа мэл гайхуулдаг юм.

— Хүрч чадахгүй ээ гэж Шмаков тоомсоргүй хэлэв.

— Яагаад!

— Бензиний хоолой бөглөрчихнө.

— Тэгэх болов уу? гэж Игорь мэгдэн асуугаад хурдаа саав.

Би Шмаков Петрийн аргыг дороо ойлгон шүүрч аваад

— Тэгэлгүй яах вэ. Бензиний саванд хог орчхож. Дахиад бөглөрөхгүй гэх газаргүй дээ, тийм ээ? гэлээ.

Игорь хариу дуугарсангүй. Метро хүртэл дуугүй явав. Нэгд биднийг авч явахыг хүсэхгүй байлаа. Нөгөөтээгүүр ганцаараа явахаас зүрх алдаж байв. Замд гэнэт суучихвал яана? Бидэнгүй бол тэр яах вэ? Сууж сурчихсан хүмүүсийн адил замын машин зогсоож, жолоочийг нь туслаад өгөөч гэж гуйх болно.

Бид метро хүрч ирэв. Игорь тээнэгэлзэн:

— Ингэхэд зам бас жаахан нийлэх юм байна. Тануус төвөөс метронд сууж болно шүү дээ.

— Мөн гайхуулав аа! гэж дургүйцээд, машинаас гарахаар завдан хаалгыг түлхэж, метрогоор арван минут яваад л Сокол хүрчихнэ. Чиний ямбийгаар явж байдаг мөн дураа! гэлээ.

— Химки яваад юугаа хийх юм бэ? гэж Игорь арга нь барагдан хэлээд Мөнгөт шугуй руу явъя л даа.

Харин ээ гэж би хайхрамжгүй дуугаар сунжруулан хэлснээ, яах вэ хүүхдүүд ээ гэлээ.

— Болох л юм даа. Яах вэ Вадим аа? гэж Шмаков хэлэв.

— Яах вэ явъя л даа гэж Вадим зөвшөөрлөө.

Мөнгөт шугуй руу явав. Бид мөн догь аргалсан даа!

Мөнгөт шугуйн хаялга мөн гойд оо! Хүн ихтэй машин олонтой боловч Химкитэй зүйрлэх юм биш. Уужим тавиу! Үзэсгэлэнтэй!

Бид сэрвэн дээгүүр аяархан явав. Голын хөвөөнд хүн пиг дүүрэн. Игорь машинуудыг анхааралтай харж явснаа дор «победа» машин байхыг үзээд тоормослов. Тэр машины дэргэд цагаан шуудагтай, хар халимагтай хүн түрүүлгээ харан хэвтэж байлаа.

— Николай гэж Игорь дуудав.

Нөгөө хүн буржгар толгойгоо өндийлгөн, Игорийг гараар залхуутай далласнаа ахин элс рүү шургав.

— Доош буулгүй машинаа дээр тавихыг Игорьт зөвлөв. Машин дороос сайн харагдана. Гэвч Игорь үгэнд нь орсонгүй. Бид цаашилж, урууддаг газрыг олж буув.

Игорь машинаа зогсоолоо.

— Байр олж ав, би одоо эргэж ирнэ. Танилуудтайгаа уулзчихаад ирнэ.

Игорь биднийг энд яагаад орхиж байгааг бид сайн ойлгож байлаа. Найз нартайгаа биднийг танилцуулах дургүй байгаа юм. Өөрөөр хэлбэл бидэнтэй тэднийг танилцуулахыг хүсэхгүй байгаа юм. Энэ нь бидэнд ямар ч падгүй. Бид Игориор ер дутахгүй. Тэгэхдээ юугаар буцдаг хэрэг вэ?

— Бид юугаар буцах вэ? гэж асуухад маань

— Жигтэйхэн амьтад бэ. Би одоо эргээд ирнэ гэм! гэж Игорь инээлээ.

— Эргэж ирэхгүй л дээ! гэж Вадим хэлэв. Вадим Игорийг мэдэлгүй яах вэ, хэчнээн жил туслах нь байв даа.

— Нээрээ гэм! гэж Игорь андгай тавив.

— Алга болчихвол чинь мартаггүй болтол чинь тавина гэж мэдээрэй! гэж би хэлэв.

— Бүү сүрдүүл. Ямар муухай юм бэ? Сүр бадруулаад байвал чинь одоо явчихна шүү.

— Тэгээд үзээрэй! гэж Шмаков Петр хэлэв.

— Хаана усанд орох нь та нарт ямар ялгаа байгаа юм? гэж Игорь бухимдаж асуув.

— Ихээ ялгаа байна! Бид машинд хувцсаа тайчиж болно, тэгээд муусайн хувцсандаа санаа зовохгүй байж болно. Энд дэлсчхэж мэднэ

гэж Вадим хэлбэл:

— Чиний наад муусайнаар яах юм? гэж Игорь татгалзав.

Тэрүүнтэй мэтгэлцэхээ би төвөгшөөв.

— За явж л байхгүй, харин алга болбол уу, сайхан мэдээрэй!

Бид аятайхан газар эрэв. Игорийн биднийг буулгасан газар тааруухан ажээ. Хажууд уруудах газар байсан тул машин сүлжилдэж, тэрүүхэнд худалдааны майхан байсан учир хүмүүс хөлхөж, махны лааз хөглөрнө. Тавгүй газар юм!

Бид Игорийн явсан зүг явав. Өөр тийшээ явчхалтай биш. Игорь бид наргүй явахаас хулчийж байгаа, гэхдээ түүнийг нүднээс алдахын хэрэг бас үгүй.

«Победоос» тавиад метрийн зайтай аятайхан газар олов.

«Победын» дэргэд Игорийн «москвич» зогсож байлаа. Игорь өөрөө явган суучихсан, элсэн дээр хэвтэж байгаа Николайтай ярилцаж байна. Дараа нь хувцсаа тайчиж, машиндаа тавиад «номхон» зогссоноо суниан гүнзгий амьсгаа хэдэнтээ авч, хэдэнтээ гаргав.

Тэгснээ Николайд нэг юм хэлснээ бидэн рүү ирэв. Биднийг хараад дөнгөж тааралдаж байгаа юм шиг баярласан царай гаргалаа.

— Тавлаж авав уу? Сайн байна! гээд хажууд сууж

— Биеэ шарах уу? гэв.

— Явж усанд оръё гэж Вадим санал гаргав.

— Би жаал хэвтэнэ ээ гээд Игорь өөдөө харан хэвтэв.

Бид ус руу үсрэн орлоо. Гол энд өргөн боловч гүехэн, бараг өвдөгцөөр ажээ. Дундаа арай гүнзгийрснээ цаад эрэг хүртэл гүехэн байлаа.

Энэ жил голд орж байгаа минь л энэ. Усанд орох болгондоо л өдөр бүр усанд сэлж байхаар шийддэг юм. Энэ нь тийм хэцүү гэж үү? Зарим нь тэнгэр ямар ч байсан, тэр ч байтугай өвөл голд орж байдаг юм. Гэтэл би түүнийгээ биелүүлдэггүй юм. Яагаад гэдгийг өөрөө ч үл мэднэм, Нэг бол залхуу хүрнэ, нэг бол зав эс гарна. Одоо бол ингэж бүрэн болно. Ингээд би ажил тараад гол руу юм уу, усан сан руу очиж байхаар одоо хатуу шийдэв.

— Чи сэлбүүрээ яагаад хийсэнгүй вэ? гэж Вадим асуув.

— Би мартаж орхиж. Машинаас ч авсангүй. Тэнд л хэвтэж байлаа.

— Машинд мартчихаж, чи өөрийнхийгөө яасан бэ?

Вадим инээд алдаж:

— Мөн санав аа! Аль, язгуурт сольчихсон.

— Юугаар

— Нэг юмаар гэж Вадим нуув.

Тэр бээр наймааныхаа тухай ярих дургүй, биднийг тохуу хийнэ гэж айдаг юм.

Бид хэд усанд жаал тонгочиж, эрэг дээр гарав. Игорь нөхөд рүүгээ арилж өгчээ. Тэнд шуудагтай залуу, улаан резин малгайтай бүсгүй нар сууж байлаа. Би тэднийг дор нь танилаа. Тэд энэ «победоороо» Игорь дээр дагтан ирдэг юм. Одоо тэд ярилцан сууж байна. Ганц Николай л түрүүлгээ харан хэвтсэн чигээрээ ажээ.

Игорь нэг л найзгүй аашилж байлаа. тэр бээр бахь байдгаараа биднээс холдохын мөн болно.

— Сэлбүүрээ аваад ир, үзье гэж Вадим хэлэв.

— Би тийш очихгүй, тэндээ байж л байг!

— Сэлбүүр чинийх шүү дээ гэж Шмаков Петр хэлэв.

— Чи аваад ир л дээ.

— Өөрөө айгаа юу?

— Айгаагүй ээ, гэвч очихгүй. Дагаад байна гэж санана.

— Нэрээ хичээж байгаа нь энэ гээд тоглож наргихаа болих гэж үү? Бүгдээрээ очье гэж Вадим хэлэв.

Бид хэд хүрч очлоо. Игорь биднийг тавгүйнхэн ширтэв. Залуу, хүүхэн хоёр ч яах нь вэ гэсэн шиг харав. Николай л ганцаараа түрүүлгээ харан хэвтсээр байлаа. Ийм үсэрхэг хүнийг энэ насандаа үзээгүй. Далан дээр нь хүртэл мушгирсан хар үс халиурч байлаа.

— Сэлбүүр авъя гэж би Игорьт хэлэв.

— Ав, ав! гэж Игорь зөвхөн сэлбүүр, авах гэж бидний очсонд баярлан хэлэв. Тэгээд танилууд руугаа эргэж хүлцэнгүй дуугаар

— Манай байшингийн хүүхдүүд, би авч ирсэн юм. Бурхны орон үзүүлж яваа юм.

— Игорь хүүхдүүдтэй үерхдэг байх нь ээ! гэж хонгор үстэй, унжуу хамартай, шөвөгдсөн ширүүн харцтай залуу даажигнан өгүүлэв.

Энэ өгүүлбэр ацан утгатай боловч Игорийг шоолсноос биш, биднийг шоолоогүй болохыг би ухаарав.

Би машины хаалгыг нээж сэлбүүр, баг хоёроо авлаа. Бүсгүй гараа сарвайж:

— Үзүүлээч гэв.

Николай толгойгоо дөнгөж эргүүлэн, биднийг нүднийхээ булангаар харснаа зөрүүлсэн гараа ахин дэрлэв. Түүний хар нүд, хар сахлыг ажиж амжив. Бүсгүй сэлбүүрийг эргүүлж тойруулснаа

— Үүнийг чинь хийгээд сэлж үзэх үү? гэж гуйсанд

— Тэгээ тэг гэж би хэллээ.

Бүгдээрээ ус руу оров. Николайгаас бусад нь. Николай хөдөлсөн ч үгүй.

Бид гүн газар оров. Елка гэж хачин нэртэй бүсгүй, Игорь, хонгор үст залуу хоёроор туслуулан сэлбүүрийг хөлдөө углав. Залуу бүүр жигтэйхэн Люся гэдэг нэртэй ажээ. Эрэгтэй хүн байж Люся болчихдог нь юу ч вэ.

Елка баг өмсөж, толгойгоо хөдөлгөснөө бидэн рүү хэлээ гаргаад шумбав. Сэлбүүр хийж урт болсон хөл нь хийд гялалзав. Биднээс арваад метрийн зайтай шовсхийн гарч ирэн багаа авч

— Юу ч харагдахгүй байна гэв.

— Нүдээ бүү ань, нүдээ аних хэрэггүй. Аль вэ нааш нь гэж Люся хэлэв.

Люсягийн дараа би, тэгээд Игорь, Игорийн дараа Вадим шумбав. Хамгийн сүүлд Шмаков Петр шумбалаа. Гэвч яагаад ч юм, багаа гартаа барьчихсан гарч ирлээ.

Сэлбүүр, багийн ашиг гэж бага ажээ. Голын ёроол, хүний хөл л түр зуур үзэх юм. Тэнгист сайхан байдаг байж магадгүй, гэвч Москва голд ч дээ...

Елка, Люся хоёр ч сайн залуучууд ажээ. Бүүр энгийн хүүхдүүд байлаа. Даан ялангуяа Игорийг хүндэтгэж тоосон янзгүй байгаа нь бидэнд зүгээр санагдаж байв. Игорийг ямар нэг юм хэлэхэд Люся заавал:

— Тийм гэж үү? гэж эргэлзсэн аялгуугаар хариулна.

Хумсын чинээ ч итгэхийн аргагүй хүнтэй л ингэж ярьдаг даа.

Гэтэл Игорь нь үнэмшүүлэх гэж дэндүү оролдоно. Өөрт нь хумсхан ч итгэхгүй байхад дасчихсан хүн л ингэдэг юм.

Бид эрэг дээр гарав. Тэд машин руугаа, бид хувцсаа өмсөхөөр явав.

Маш сайхан байлаа. Нар хамаг илчээрээ төөнөнө. Бид түлэгдчих вий гэж айсангүй. Түлэгдэхээс хамгаалах тусгай түрхлэг Вадимд байсан юм. Шмаков бид хоёр бүх тосыг биедээ нялав. Шмаков өсгийдөө хүртэл түрхлээ.

Дараа Игорь биднийг даллав. Николай, Люся хоёр хувцсаа өмсөж байлаа. Елка харагдахгүй байгааг бодоход машин дотор хувцаслаж байгаа байх. Игорь өмдөө татаж харагдана. Тэд явах нь ээ...

Бид хувцаслаад тэдэн рүү очив. Николай, Люся хоёр машиндаа оров. Елка хэдийнээ жолооны ард суусан байв аа.

Игорь гуйсан дуугаар

— Хүүхдүүдийг метронд хүргэж өгчхөөд л очно гэв.

— За гэж Люся дуугарлаа.

— Намайг орхиод бүү явчхаарай.

— За за гэж Люся хайхрамжгүй хэлээд Нико явъя гэлээ.

Тэднүүс машиндаа оров. Хаалга тас хийв.. Мотор хүрчигнэлээ. Машин байраас хөдөлж, огцом эргэн эрэг дээгүүр явав.

Би холдож байгаа машины араас хардагчлан хойноос нь санаандгүй ширтэж байв. Тэгээд! нүд минь элсэн дээр туслаа. Мэл гайхаж хоцров.

«Победа» яваагүй, ГАЗ-69 яваад өнгөрсөн юм шиг гүнзгий, огцом шигдсэн, өргөн мөр элсэн дээр тодхон дурайж байлаа. Яг ийм мөр элс авдаг газар руу явдаг зам дээр байсан...

Би энэ мөрийг дагуулан харвал машин огцом эргэсэн тэр газар ГАЗ-69-ийн мөртэй зэрэгцэн «победын» мөр гарсан байв. Машин чигээрээ явсан газар «победын» мөр арилаад, зөвхөн ГАЗ-69-ийн л мөр гарчээ.

— Крош явъя, би хожимдох нь гэж Игорь дарга хүний буурьтай яаруулав.

Би Игорийг харахаас ичиж байлаа. Эргэж ч харалгүй би

— Энэ машин ямар хачин дугуйтай юм бэ?

— Хачин юм юу байгаа юм! Бартаа туулахад сайн гэж ГАЗ-69-ийн дугуй хийсэн юм.

Зүрх палхийн

— Дөрвөн дугуй нь уу? гэлээ.

— Үгүй ээ? гэж Игорь шалавхан хэлээд:

— Зөвхөн арын хоёр дугуй нь. Урд талынх нь ердийн дугуй. За болоо явъя! гэв.

Хурлын дараа манай машиныг сэлбэх ажил удаашрах байх гэж бид бодож байлаа. Урьд нь бид өдөржин хийж байсан, гэтэл одоо ажлын дараа хоёрхон цаг хийнэ. Гэтэл ажил харин маш түргэсэв. Ажилчид сайн тусалж байв. Зарим нь бүүр ажилдаа махраад, манайхаар хийлгэхгүй өөрсдөө хамаг юмыг хийж байлаа. Үүнд бид зүй ёсоор дургүйцэж байв. Машиныг бид босгож байгаа шүү дээ!

— Харж байна уу, номын хэнээ минь, түрүүнд байдал тодорхойгүй байсан. Ямар нөхцөлд машиныг босгож байгааг бригад мэдэхгүй байлаа л даа. Одоо бол сайн дураараа гэдгийг мэдэж байна. Хүн бүр нийтийн хэрэгт тус дөхөм болохыг хүсэж байна гэж бригадын дарга Дмитрий Александрович хэлэв.

«Номын хэнээ» гэдэг үгийг л хайхрахгүй юм бол Дмитрий Александровичийн санаа маш ухаалаг, маш цаагуур санаа шиг надад бодогдов. Бүх юм тов тодорхой байх ёстой.

Тэгж тэгж бид арлыг хашаанд тавин угсарч эхэллээ. Угсарч эхэлнэ гэдэг маань ажил шувтарч байгаа хэрэг. Ажил дуусах шахна гэдэг цөм түргэн ажиллана гэсэн үг. Нүцгэн арал хэрхэн машин болж байгааг харахад сайхан байлгүй яах вэ.

Манай машин дээр хүмүүс овоорно. Өөр машины дэргэд бол хэн ч хавьтахгүй, харин манай машины дэргэдээс бол салахгүй. Дарга хүртэл ирнэ. Нээрээ шүү! Ажил саатаж ямар нэг юм дутвал тэр бээр «Агуулах руу очоод аваад ир! Намайг ав гэж байна гэж хэл» гэнэ. Хүнд суртал гаргаж, бичиг сачиг гэж чирэгдэл учруулахгүйгээр ажил урагш ахиж байлаа.

Даргын хувьд хашаанд наранд ээж суух нь тамхины утаа суунагласан тасалгаанд суухаас аятайхан байснаас энд ирдэг байсан болов уу гэж би боддог. Гэхдээ хашаанд зүгээр суугаад байх эвгүй. Манай машиныг нийтийн хүчээр засаж байгаа болохоор дэргэд нь суухад дажгүй ээ.

Ажилчдад шүүмжлэн хэлэлцэж байх нь аятайхан. Тэд өөр машин засаж байхад нормоо биелүүлэх хэрэгтэй учир ярилцах зав хаа байх вэ. Манай машиныг нийтийн хүчээр засаж байгаа болохлоор ярилцаж ч болно. Даргатай цэц булаалдаж байх нь ажилчдад бас аятайхан. Цехэд бол маргах юмгүй, тушаасныг хийх хэрэгтэй. Тэгвэл манай машиныг нийтийн хүчээр засаж байгаа учраас маргаж болно. Тэр тусмаа бид түүнийг сургуулилах машин болгон тоноглож, байцаагчид зориулан

нэмж залуур тавьж байгаа юм. Байцаагч сурагчийн гаргасан алдааг засаж, ослоос урьдчилан хамгаалах юм.

Үдийн завсарлагаагаар ажилчид сүү, тал талхаа барин манай машиныг тойрон сууж тэг, ингэ гэж зөвлөн, элдэв санал гаргана. Ээлжид гараагүй жолооч нар дэргэд зогсож, сургуулийн машинаар яаж сургуулиж байснаа дурсаж, манайхыг яаж сайн болгох вэ гэж ярилцана. Даргатай хүртэл булаацалдана. Дарга өөрийнхөө санааг нотлох гэхдээ даргаар ажиллаж байгаагаараа биш, харин урьд бас жолооч байсныхаа хувьд ингэдэг юм гэнэ. Ер нь манай машины дэргэд чөлөөтэй, сайхан байдал тогтов. Ийм байдалд ажиллах нь бид бүгдэд зүгээр санагдана.

Албан хаагчид хүртэл гадаалахдаа бидний хэрхэн ажиллаж байгааг харж, ажилчдын шүүмжлэн хэлэлцэх, маргалдахыг чагнан, сурагчид ёстой машин босгож байгааг гайхна.

Ерөнхий нягтлан бодох гэж нэлээдгүй дүнсгэр хүн
— Харахад нүдэнд дулаан байна гэв.

Машиныг үнэ төлбөргүй босгож байгааг харахад аятайхан байна гэдэг утгаар үүнийг хэлсэн бололтой. Өөр утгаар ч хэлсэн байж болно л доо. Би түүнийг нь лавласангүй.

Хүүхдүүд хоёр цагтаа шударга ажиллаж байлаа. Зарим нь түүнээс ч удах удаа байв. Жишээлбэл Полекутин, Гринько зэрэг техникт сонирхолтой хүүхдүүд Зуевын баруун гарын туслахууд байсан болохлоор Шмаков бид хоёр ч гэсэн үлдэнэ. Игорь машины хавьд эргэлдэнэ.. Бусдаас чанга чанга дуугарна. Ажил зүгширч байгааг үзжээ. Гэвч хавтаснаасаа өөр юм барина гэж хол.

Зөөллүүрийн хэрэг надад одоо тов тодорхой боллоо. Яагаад тэр дороо санаанд орсонгүй вэ? Тэнд хойд хоёр дугуй нь ГАЗ-69-ийн дугуйтай «победа» иржээ. Ар талын дугуй нь урьдахынхаа царигаар өнхрөхдөө мөрийг нь даржээ. Эргэлт дээр цариг нь давхцаагүй газар хоёр мөр хоёулаа харагдаж байсан. Энэ бол Игорийн найзын машин байлаа.

Игорийг харахад энэ ийм хэрэгт оролцлоо гэж үү дээ?! гэж бодогдоно. Одоо ч гэсэн би нэг л итгэж өгөхгүй байлаа. Гэмт хэрэг үйлдэж тэр яаж зүрхлэв?.. Люся, Елка, Николай гурав гэмт хэрэгтэн гэж үү дээ? Тэд бидэнтэй инээж, усанд сэлж байсан биш үү?

Үүнийг би толгойгоо дүйртэл бодно. Гэмт хэрэгтэн бусдаас гажууд хүн байх ёстой. Хүн ч биш, бүгдээс этгээд амьтан байх мэт би

төсөөлдөг юм. Гэмт хэрэгтнүүд бүх хүмүүс шиг хувцаслаж, зарим нь бүр дэгжин гэгч хувцасладаг нь надад ямагт жигтэйхэн санагддаг бөгөөд тэр бол хүний сэтгэлийн илрэл, гэтэл тэдэнд хүний сэтгэл гэж байхгүй, түүнийг ойлгодоггүй, дайсагнадаг. Гэмт хэрэгтнүүд яагаад кино үздэгийг би ойлгодоггүй юм, гэтэл тэнд ердийн хүмүүс хүний ердийн сэтгэлийг үзүүлдэг юм. Тэд яагаад хөгжим сонсож, дуу дуулж, тэр ч байтугай ном уншдагийг нь ойлгодоггүй юм, ном бол сайныг сургаж, мууг буруушаадаг шүү дээ. Гэмт хэрэгтэн бол хүнээс ангид хүн, түүний үйлдэж буй хүнийрхүү явдал нь ёсон бус юм шиг надад санагддаг юм.

Сайн тэр ч атугай алдар гавьяатай хүний хүүхдүүд гэмт хэрэг үйлдсэн тухай би уншиж, сонсохоороо л нэг болсон. Гэвч энэ бүхэн нь алсын, хийсвэр юм шиг байсаан... Тэд ерийн хүмүүстэй адилхан гэж сэтгэлд нэг л буухгүй байв. Өчнөөн жил миний мэддэг Игорь, миний найз Игорь гэмт хэрэгтэн байдаг. Люся, Елка гэдэг сайн хүүхдүүд, номой төвшин Николай гэмт хэрэгтнүүд байдаг...

Элсэн дээрх мөрийг Вадим, Шмаков хоёр анзаараагүй, би л ганцаараа ажигласан гэж би голын хөвөөн дээр байхдаа бодсон юм. Гэвч метронд ордог үүдний өрөөнд Шмаков Вадимаас нууцгайхан:

- Нөгөө машин байна гэж надад хэлсэн билээ.
- Бас урсдаг шатаар уруудаж явтал Вадим над руу бөхийж
- Өнөө машин чинь! гэж шивнэлээ.

Бүх замын турш Вадим Шмаков хоёр ээлжлэн энэ машины тухай ярих. Вадим нь Шмаков дуулахааргүй байгааг самбаачилж, Шмаков нь Вадим дуулахааргүй байгааг самбаачилж ярина. Ингэж хоёрын хооронд байхаа болихоор шийдэж би Вадимд

- Шмаков Петрт бүгдийг ярих хэрэгтэй юм гэв.
- Яах юм?
- Гүндүүгүй залуу!

Ийнхүү Шмаковт алийн дээр бүх явдлыг ярьчихсаныг Вадим мэдээгүй өнгөрч билээ.

Оройжин бид гудамжаар явахдаа алхаагаа ч хэмжсэнгүй.

Бид бүх газрыг алхмаараа яг хэмжсэн байдаг юм. Хэнийг ч гомдоохгүйн тул бид бие биеэ гаргаж өгдөг билээ. Вадим бид хоёр хичээл тараад манай гэрийн хажуугаар өнгөрвөл би түүнийг бас дөчин алхам дөхүүлж өгөх үүрэгтэй. Бид түүний байшингийн дэргэдүүр гарвал тэр намайг жаран алхам гаргаж өгөх ёстой.

Тэр ням гарагийн үдэш алхам хэмжихтэй манатай байв.

— Юу л гэж бодно вэ, би л Игорийг хулгайч гэж итгэхгүй. Тэр энэ хэрэгт зүгээр л татагдаад орчихсон байж болох доо? Бид түүнтэй ярилцах хэрэгтэй гэхэд минь

Вадим татгалзаж:

— Ярих явдалгүй! Энэ асуудлыг ангийн хурал дээр тавья гэхэд би

— Вадим, та хоёр нэг үе найзалж байснаа санаарай!

— Тэр надад найз шиг ханддаг байсан гэж үү? Бүх юмыг над руу бухах гэсэн биз дээ! гэж Вадим дуу өндөрлөв.

Вадим сайн залуу. Гэвч одоо сэлбэг хэрэгслийн хэрэгт орооцолдоход нь Игорь ямар хуншгүй аашилсныг санахдаа тэр бээр уур нь бадарч байв. Вадим ангидаа хүний өмнөөс хохирох нь олонтоо. Тэгж элэг бариулж байснаа одоо санан санан, эгдүү нь хөдөлж байлаа.

— Арай дээгүүр байх хэрэгтэй гэж сануулав.

— Юунаас?

— Өөрийн гомдлоос дээгүүр!

— Игорьт хэлчихвэл тэд мөрөө баллачихна. Аль ч үгүй хоцорно гэсэн үг. Зохих газар нь мэдэгдэх хэрэгтэй гэж Шмаков Петр үглэв.

— Далдуур уу? Яасан ч үгүй гэж би эрс хэлэв. Тэгэхэд бид юу ч товлож чадсангүй. Өөрөөр хэлбэл гүйцэд тохиролцтолоо юу ч хийхгүй, нууцаа хадгалах болно гэж хэлэлцэж тохиров.

Би нууц мууцад дургүй. Бусад хүүхэд дуртай байдаг бол би дургүй ээ. Битүүлэг сэдэвтэй номд хүртэл дургүй, тэртэй тэргүй төгсгөлд нь цөм тайлагддаг шүү дээ. Сүүлийн хуудсыг нь л голдуу шууд харчихдаг юм. Үүний дараа унших сонирхолгүй болчихдог билээ.

Ном ч бас цаанатай наанатай. Өөртөө элдэв юм нууж явахыг би хүлцэж чаддаггүй юм. Энэ нь хүнийг хуурамч, нууж хаадаг зантай болгодог. Жишээлбэл Майкатай гудамжаар явахдаа, юм бүхний тухай илэн далангүй ярилцан яваа мөртөө түүнээс бас нэг юм нууж байна. Эвгүй ч юм, тусгүй ч юм. Тэр тусмаа Майка эвлэлийн үүрийн дарга. Түүнээс ийм хэргийг нууна гэдэг ер нь буруу.

Майкатай хамт гудамжаар явахад гудамж ердийнхөөсөө шал ондоо бодчихдог юм. Майка бид хоёр тэнгэр сайхан байхад л гудамжаар хамт явдаг, муухай байхад гэрээс гардаггүйгээс ч тийм байдаг байж мэдэх юм. Бүгдээрээ хэчнээн хөөрхөн охин бэ? гэж Майкаг шохоорхохын далимд намайг харж байгаагаас ч тэр байж мэдэх юм. Бид хоёр амьтны нүдийг хужирлаж, би ч онцгой хариуцлага хүлээж байгаагаар ухамсарладаг юм. Юу гэвэл хүнийг түлхчхээд уучлал ч гуйхгүй байхаа юман чинээ үл бодох цадиггүй, танхай этгээдүүд гудамжинд мундахгүй бий... Мэдэхгүй юм. Үнэн юм үнэнээрээ. Майкатай хамт явахад гудамж улам нарлаг, хүмүүс улам ялдамхан, бүх юм нэг л баясгалантай, инээдтэй болчих юм. Тэр тусмаа бид хоёр гудамжинд нэг л наадмаар наадаж, элдэв буруу зөрүү хаягийг шүүмжилнэ. Жишээлбэл «боловсон бараа» гэсэн дэлгүүр байна. Энэ чинь юу гэсэн үг вэ? «Соёлын бараа» гэсэн үг. Тэгэхлээр бусад дэлгүүрийн бараа боловсон биш болж таарах нь уу? Ер нь бараа өөрөө боловсон бус байж чадах уу даа? Эсвэл бас «Индподшив» гэж бий. «Ин» гэдэг угтвар «инвалид» (тахир дутуу хүн) гэсэн үгийнх гэж бид дан боддог байсан тахир дутуучуудын артель даашинз оёдог болох нь уу. Гэтэл тийм биш юм санж. «Ин» гэсэн угтвар маань «индивидуальный» буюу хувийн гэсэн үгсийнх юм байжээ. Мөн ч эвгүй юм.

Бид хоёр Наталья Павловнагийнх руу явж байсан юм. Биднийг ерөнхий инженер ийш нь явуулсан билээ. Дадлагын хугацаа дуусаж инженер түүнийг «асуудал хэлэлцэхээр» бааз дээр ирэхийг гуйсан юм.

Ямар асуудал гэдгийг хэлээгүй. Майкаг Наталья Павловнад хэл хүргэ гэжээ. Би Майкаг хүргэж өгье гэсэн юм.

Наталья Павловна манай гудамжны үзүүрт суудаг, манай гудамж Москвагийн хамгийн урт гудамжны нэг, Ганцаараа хамгийн урт нь ч байж мэднэ. Нэг үзүүрээс нөгөөг нь хүртэл, метроны өртөөнөөс шинэ зогсоол хүртэл тусгай автобус явдаг юм.

Наталья Павловнагийнх манайхан шиг шинэ байшинд байдаг. Харин бид Москвагийн янз бүрийн районоос нүүж ирсэн, харин Наталья Павловна хуучин энд байсан тосгонд сууж байсан юм. Манай сургуулийг барьсан газар урьд байсан сургуульд багшилж байжээ.

Майкад энэ нь маш чухал юм шиг санагдана. Өөрөөр хэлбэл Наталья Павловнагийн сууж байсан тосгон алга болсон, түүний гэр нь ч, сургууль нь ч байхгүй болсон байхад Наталья Павловна амьд мэнд, энд сууж урьдын хэвээр багшилж байдаг. Харин шинэ байшинд сууж, шинэ сургуульд багшилж байдаг шүү.

— Юм ор мөргүй болсон байхад, хүн үлджээ. Энд нэг учир байна, тийм биз гэж Майка өгүүлнэ.

Үнэнийг хэлэхэд үүнд ямар ч гойд юм байхгүй гэж би бодож байв. Хуучин байшин, хуучин сургуулийг төлөвлөгөө ёсоор буулгаж, буурин дээр нь шинийг барьж, хүмүүс нь үлдэх нь мэдээж. Тэд хаачих юм билээ дээ? Гэвч Майка хамгийн өчүүхэн гэж санагдах зүйлд ч гүнзгий учир утга байна гэдэг юм. Гэтэл би номчирхох дургүй, толгой өвддөг юм. Майка номчирхож л байг, би саад болоод юу хийнэ. Хариуд нь сайшаасан байртай амандаа гүвтнэв...

— Бодоод үз, олоон жилийн хойно эд байхгүй болно гээд Майка гудамж тойруулан зааж, оронд нь өөр ямар нэг юм бий болно. Шинэ хүмүүс ирнэ. Бид л алс тэртээ үеэс үлдэж хоцорно гэв.

— Өөр юу байх гэж? гэж гайхахад минь:

— Би жишээ болгож ярьж байна. Шинэ байшин гэж бодъё л доо гэлээ.

— Энэ байшин маш удна гэж би зөрөв.

— Би ойлгож байна... Гэвч Наталья Павловнагийн амьдрал үүгээрээ сонин байна, түүний харсаар байтал нь ийм хачирхам өөрчлөлт гарсан байна.

— Энд модон байшин байсан, байшин ч гэж дээ, өөвгөр байшинархуу юм байсан юм. Тийм юмыг буулгахад юухан ч биш. Харин ийм лужир чулуун байшинг нураана гэж үү?

Майка хэлсэн нь:

— Асуудлын гүн ухааны талыг би сонирхсон юм.

Гүн ухааны талаас бол энэ нь зөв гэдгийг би зөвшөөрөв. Гэвч цааш номчирхох хүсэлгүй болж, үүнээс болж толгой өвдөж эхэлсэн тул би

— Метрог Бурцево хүртэл сунгах гэнэ лээ гэв.

Бурцево урьд Москвагийн ойролцоох суурин байсан бол одоо аж үйлдвэрийн том хот болсон билээ. Метрог эхлээд манай гудамж хүртэл, дараа нь Бурцево хүртэл тавих юм. Ингээд Бурцево Москва хоёрыг холбоно гэж би сониноос уншсан юм.

— Ямар сайхан бэ? гэж Майка хэллээ.

Майка шинэ юм бүхнийг өлгөж авна. Бусад охид бол тэгдэггүй. Майка л тосож авдаг юм. Би ч бас тосож авдаг юм. Ямар нэг юм барьж бүтээж байгаа нь надад сайхан байдаг. Яагаад тэгдгийг мэдэхгүй боловч сайхан л байдаг юм. Шинэ байшин, шинэ машин, шинэ зам, мод, метроны шинэ өртөө, автобусны шинэ шугам. Тэр шинэ байшинд би суухгүй. Энэ шинэ дэлгүүрээс би юу ч худалдаж авахгүй байж болно. Гэвч эдгээр нь урьд байхгүй байсан бол одоо шинээр бий болж байгаа нь сэтгэлд таатай байдаг юм. Майкад ч бас адилхан. Түүний жаахан номчирхдог нь ч угтаа бол саад болох юмгүй.

... Наталья Павловна дэвтэр засан сууж байв. Наталья Павловна ажилчин залуучуудын оройн сургуульд утга зохиолын хичээл заадаг юм.

Майка, Наталья Павловнагийнд урьд ирж байжээ. Би ирж үзээгүй. Яагаад ч юм учир таараагүй юм л даа. Гэвч би бусад багшийнхаар орж үзсэн. Одоо ч гэсэн тэдний гэрт байхад төрсөн шиг сэтгэгдэл Наталья Павловнагийнд төрөв. Багш нар гэртээ шал өөр, багштай төсгүй, хамгийн жирийн хүнтэй л адил байдаг юм. Багшийг гэрийнх нөхцөлд хорго, шургуулга, тасалгааны голд тавьсан том ширээ, малтмал сандал, хуучин зөөлөвчит вандан... зэрэг ийм эгэл эд хогшлын дунд харахад нэг л хачин... Хачин уйтгартай ч юм шиг байдаг. Наталья Павловна нас ахисан шиг энэ юмс элэгдсэнээс ч тийм байж магадгүй. Манай байшинд суугчид байранд орохдоо шинэ тавилга авчрахыг хичээдэг. Гэтэл Наталья Павловнагийн юм нь хуучин, хэв янз нь хуучирсныг харахад лав энд тосгон байх үед л тавьж байсан эдлэл нь байхаа даа.

Машинаа босгоход бүгдээрээ шамдан оролцож байгаа тухай Наталья Павловнад бид хоёр ярив. Наталья Павловна үүнд учиргүй баярлаж, биднийг цайгаар зочлов. Шоколадтай бусад бүх чихрийн дотроос хамгийн их дуртай «цөцгийт» гэдэг чихэртэй цай ууж суухад эндэх юм эхний үед бодогдож байснаас хавьгүй тухлаг юм шиг санагдав. Наталья Павловнагийн бүх юм гарын нь дор учир хаашаа ч босох хэрэггүй ажээ. Бид хоёр юм идмээр болж бүтэн хайрцаг жигнэмгийг бараг бүгдийг нь идэв. Үүнд би бас их дуртай аж.

— Серёжа чи юун өргөдөл даргад өгсөн юм бэ? гэж Наталья Павловна асуув.

Би ярилаа. Майка намайг гайхан харав. Майка энэ тухай юу ч мэдээгүй байсан билээ.

Үнэн зөвийг ялгах гэсэн минь багшид таашаагджээ.

— Тийм ээ, Зуев. Миний шавь байсан юм шүү дээ гэж Наталья Павловна санаа алдав.

Зуев урьд сурагч байсныг бид мэдэж байсан боловч энэ нь нэг л сэтгэлд буудаггүй юм.

Тийм харимал, сахалтай хүн манай багш Наталья Павловнагийн сурагч байсан гэнэ...

— Гэр бүлийнхэн нь дайны дараа амь сүйдсэн юм. Хоёр хүү нь германы булсан минад дайрагдсан. Эхнэр нь хүндээр өвчлөөд, одоо хүртэл эмнэлэгт байгаа...

Наталья Павловнагийн хэлснээс үзэхэд Зуевын гэргий сэтгэл мэдрэлийн эмнэлэгт байгаа юм байна гэж бид хоёр ойлгов. Хүмүүс энэ тухай шууд ярихаас яагаад цээрлэдгийг би гайхдаг юм. Үүнд муухай юм юу ч байхгүй ээ.

— Маш сайн дархан юм гэж би хэлэв.

— Тиймээ гэж Наталья Павловна батлаад:

— Сергей Сергеевич тэтгэвэрт гарч байгаа, түүний оронд Зуевыг ажиллуулах байхаа даа гэлээ.

— Сергей Сергеевич сургуулийн засварын газрын эрхлэгч билээ. Зуев манайд ажиллана гэдэгт би тун их олзуурхав. Хамгийн гол нь хүүхдийн эвийг олдог хүн.

— Автобазын дарга түүнийг өгье гэж байгаа юм гэж Наталья Павловна хэлэв.

Зуевын тухай Наталья Павловнагийн ярьсны дараа түүний төлөөнөө улам гомдолтой болж

— Донгодсон байж, дараа нь нэрийг нь дэвшүүлдэг нь гэж би хэллээ.

Наталья Павловна хэлсэн нь:

— Ганц сэтгэл зовоож байгаа хүн Игорь л байна даа! гэв.

Би ам ангайж хоцров. Наталья Павловна тэр бүхнийг мэдлээ гэж үү? Яаж мэдэв?!

— Дадлага түүнд ямар ч нэмэр болсонгүй гэж Наталья Павловна гунигтайхан үргэлжлүүлж,

— Цехэд очих байсан юм. Автобазын хамаг ажлын дотроос түүнд ноогдох ёсгүй байсан тэр ажил л түүнд таарчих юм. Би эндүүрчээ. Ангийнхан ч буруутай. Хамт олон Игорьтой ажиллахгүй байна. Хүмүүжүүлэхгүй байна гэв.

Энэ ч харин лут аа! Бид ч бас буруутан болох нь дээ! Муу хүмүүжүүлсэн гэнэ... Түүнийг хүмүүжүүлэх гээд үз!

— Хамт олон хамт олон л юм, гэхдээ хүн өөрийгөө хариуцах ёстой гэж Майка хэлэв.

Тэд хамт олны хүмүүжүүлэх хүч чадлын тухай яриа дэлгэв. Наталья Павловна элдэв жишээ дурдана. Гаргаж байгаа жишээ нь аргагүй үнэмшмээр. Гэвч би дотроо тэдгээрийг Игорьт таарах нь уу гэж бодож үзэхэд огт таарахгүй болж байв... Гэвч би дуугарсангүй. Би Игорийн тухай маргалдвал үг санаандгүй алдаад нууцыг задалчхаж болзошгүй. Би нууцыг хадгална гэж ам алдсан шүү дээ.

Би нууж хаах дургүй боловч энэ нууцыг хадгалах нь хадгалах л байсан юм. Гэвч Наталья Павловнагийнхаас буцаж яваад Майка өөрөө энэ яриа руу намайг оруулчхав. Автобаз дээр бие биеэ сургууль дээр байдгаас илүү таньж мэдлээ. Энэ нь хүний зан чанар жинхэнэ амьдрал дунд ёстой илэрдэг гэдгийг нотолж байна гэж Майка ярилаа.

Энэ зөв санаа юм, гэвч ерөнхий байлаа. Сургууль дээр ч гэсэн бид бие биеэ сайн мэддэг байсан. Харин үйлдвэрлэл дээр хүн бүрийн зан чанар арай тодорхой илэрдэг юм байна.

— Игорийг аваад үзье л дээ. Түүнийг ямар гэдгийг бид мэдэхгүй байсан гэж үү? хэмээн би хэллээ.

— Машин босгоход зэсээ цухуйлгалаа даа! гэж Майка хэлэв. Нууцаа задлахгүйг хүсэн би биеэ барьж

— Үүгээр ч зогсохгүй ээ! гэлээ.

— Тиймээ, Вадимыг нөгөө сэлбэгийн хэрэгт ороолцолдоход ч тэр гэв.

— Ганц энэ ч биш ээ гэж би биеэ чадахынхаа хэрээр барин хэлэв.

— Ер нь автобаз дээр байсан бүх араншингаараа гэж Майка өгүүлэв.

Би дуугарсангүй.

Гэвч миний дуугаа хураасан нь учиртай юу, үгүй гэдгийг Майка ямагт мэдчихдэг юм. Тэгээд ч асуусан байртай намайг харав. Хаашаа ч зайлах газар байсангүй. Зөөллүүрийн тухай паянг би Майкад үүрийн даргын нь хувьд ярьж өглөө.

Гайхалтай нь, миний яриа түүнд миний бодож байсны дайтай сэтгэгдэл төрүүлсэнгүй. тэр бээр миний ярихыг итгэхгүй янзтай, түүгээр үл барам егөөдсөн байртай чагнав. Хөвүүд л элдэв нууц мууцад дуртай байдаг гэж итгэдэг охид иймэрхүү зүйлийг ингэж чагнадаг юм.

Угтаа бол охид л нууц мууцад хавьгүй илүү дуртай. Гэвч тэдний нууц нь тулга тойрсон юм байдаг. Хэн нэг нь хэнд ч юм дурлачихсан гэнэ... Хэн нэг нь хэнд ч юм юу ч юм бичиж өгч гэнэ... Хэн нэг нь хэнтэй ч юм хаашаа ч юм явж гэнэ гэх жишээтэй. Тэгсэн мөртөө тэд нарийн ухаан шаардагдах адармаатай үзэгдлийн учрыг олж чадахгүй. Ийм үзэгдэлд тэдний ухаан хүрэхгүй ээ. Баримт шалихгүй байх тусам

тэд энд нь төдий чинээ лут юм шиг байна. Гэтэл хэрэв баримт өөрөө чухал бол тэдний ухаанд багтахгүй. Гэвч Майка

— Юун түрүүнд Игорьтой ярих хэрэгтэй.

— Би ч бас тэгж бодож айна! гэж би дуу алдав.

— Өнөө орой манайд цуглаад Игорийг дуудъя гэв.

Орой нь бид Майкагийнд цугларлаа.

Игорьтой биднийг ярих гэлээ гэж Шмаков дургүй байв.

Тэр чинь хулгайч нартаа хэл залгуулчихна гэж тэр хэллээ.

— Хүн бүрийг хулгайч гэж хардаж сэрдэж болохгүй гэж Майка өгүүлэв.

— Үнэхээр тийм гэж би тосож аван:

— «Сүм, шоронг газрын хөрснөөс арчина» гэж яриад байдаг, тэгсэн мөртөө хүн бүрийг гэмт хэрэгтэн гэж үзэж байдаг... гэлээ.

Игорь тохуурхсан янзтай, хөгжилтэй гэгч нь хүрч ирэв. Тэгээд:

— Сод мэргэд, өтгөс настнуудын ямар гээч зөвлөл вэ энэ чинь? гэж инээмсэглэн хэллээ.

Би түүнд зөөллүүрийн тухай ярьж өгөв. тэр бээр инээмсэглэж:

— Яагаад аваагүй юм бэ?.. Өө мэдлээ!.. Хулгайчийг мөшгөх гээд нойрноос морио гэгчээр болчихоо юу? Лут ч эрүүлчид бол доо... гэв.

— Инээд бишээ гэж би тайван хэлээд:

— Зам дээр мөр нь үлдсэн гэлээ.

— Нохойн битүү туурайных уу?

— Үгүй ээ, машиных. Тэгэхдээ бүүр «победных»... Түүний дугуй их сонин, урд талынх нь «победынх» хойд талынх нь ГАЗ-69-ийнх.

Бид Игорийг ширтэв. Бидний ширүүн харцанд барьц алдаж

— Үүнийг чи ямар учиртай хэлэв? гэж мэгдэн асуулаа.

Би чиний тэр найз Елка, Люска, Николай нарын чинь машин яг ийм дугуйтай гэж би хэлэх гэсэн юм даа. Үүнийг л хэлэх гэсэн юм.

Майка хүртэл байдал эгзэгтэй болсныг ойлгов. Энэ бол санаанаас авсан зүйл биш, ноцтой, хариуцлагатай хэрэг болохыг ухаарав. Лут утга учиртай асуулт тавьсныг минь лав дотроо хачирхсан байх аа.

— Зөөллүүрийг яасан бэ?! хэл гэж Шмаков хар муйхраар шаардав.

— Та минь яаж байна, солиоров уу? гэж хашгаараа Игорь суудлаас үсрэн босож:

— Надтай ингэж ярьж яаж зүрхэлнэ вэ? гэлээ. тэр бээр ийнхүү үнэн сэтгэлээсээ эгдүүцэж байсан тул бид зовчхов. Вадим эгээ л

уйлчихсангүй. Игорь тэр хоёр нэг үе үерхэж байсан, одоо ч Вадим түүнийг өрөвдөхдөө нулимс гаргаж байв. Ганц Шмаков л тоосонгүй. Жигшсэн байртай:

— Бүү цовхч, сандал хэмхэлчихнэ! гэж бувтнав.

— Хатуу тоглоом хийхгүй байж болохгүй байна уу гэж би

Шмаковт сануулав.

— Игорь оо, хэн ч чамайг доромжлох гээгүй, гэвч тодруулах хэрэгтэй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ гэж Майкаг өгүүлсэнд,

— Игорь, тийм шүү, хэн ч чамайг авлаа гэж сэжиглээгүй шүү гэж Вадим өрөвдөм дуугаар хэллээ.

Игорь жаал уужирч, дахин суугаад хөлөө ачсанаа

— Би ч, миний найз нар ч зөөллүүрийг аваагүй. Энэ тухай ярихад хөх инээд хүрч байна. Чухам энэ машины мөр гэж байгаа чинь ямар учиртай юм? Солжир дугуйтай машин Москвад цөөн гэж бодоо юу? гэж уруухан хэлэв.

— Ямар ч гэсэн ингэж тохирно гэдэг хачин л юм гэж Майка хэлэв.

— Огт санаанд оромгүй тохирол амьдралд гарахыг алийг гэх вэ гэж Игорь айлдахдаа дууны нь өнгө дахин итгэлтэй, доогтой болж ирэв.

— Найз нараа яах гэж Автобаз руу аваачсан юм бэ? гэж Шмаков Петр цохиж асуув.

Игорь нүдээ анивчиж:

— Хэзээ би аваачсан юм?.. Аа тийм, тэгсэн юм байна... Би тэдэнд машинаа засахад нь туслах гэж ерөнхий инженертэй танилцуулсан юм.

— Тэгээд?

— Ерөнхий инженер зөвшөөрөөгүй.

— Энэ хэргийг бүрэн дуусгавар болгохын тулд чиний найзуудтай ярих болж дээ гэж би хэллээ.

— Тэг, Тэг! Очиж ярилцах л үгүй юу.

— Аа тийм бий. Чи өөрөө очихгүй юу? гэж Майка өгүүлэв.

— Үгүй ээ

— Яагаад?

— Энэ яриа нэрийг минь хугалчихна. Би кино зураг авхуулж байгаа, ийм балай юм тэнд хүрээсэй гэж би хүсэхгүй байна.

— Асуудлыг товчоонд тавья гэж Майка хэлэв.

Игорь дуугарсангүй.

— Бид зөвхөн машины талаар л асууна, чиний тухай ганц үг цухуйлгахгүй гэж Вадим хэлэв.

Игорь царайгаа барайлган

— За яах вэ, би өнөөдөр утасдамз гэв. Хүн хэрэв гэм хийгээгүй бол юундаа гэлбэлзэх билээ. Игорь биднийг нөхөдтэйгөө уулзуулахдаа ингэтлээ юунд дургүй байна вэ? Юунаас айв? Ямар ч гэм зэмгүй гэж бидэнд батлаад байсан биш билүү... Түүний гэмгүй гэдэгт нь Шмаков Петрээс бусад хүүхдүүд үүнээс өмнө ч эргэлзэхгүй байсан юм.

Сургуулийн талбай дээр Игорь болон түүний найз нарыг хүлээж суухдаа бид ингэж бодож байлаа. Бид бодсоноо ил гаргаж хэлсэнгүй, гэвч Игорь юунаас айв гэж бид цөм дор бүрнээ өөр өөрөөсөө түгшин асууж байлаа. Бидний нөхөр Игорь ийм гутамшигт хэрэгт орооцолдсон гэж бодохоос ч аймаар байлаа.

Сургуулийн талбай эзгүй байв. Захад нь урагдсан тортой самбар, гар бөмбөгний торны хэлтийсэн шон, газарт зоосон хөлтэй элс урт хар сандал, талбай дээр торойж, харайлтын газрын элс шаргалтан дээр нь саяхан хүн харайсан юм шиг хөлийн мөр харагдаж байлаа.

Бидний мэдэх «победа» сургууль руу хүрч ирэхэд долоон цаг болж байв. Түүнээс Игорь, Люся, Николай гурав гарч ирэв. Елка байхгүй байлаа. Тэд бидэн дээр хүрч ирлээ.

— За, энэ хүүхдүүд Автобазынх: Би танууст ярьсан. Зөөллүүрийн талаар ч ярьсан гэж Игорь инээмсэглэн хэлэв.

Игорь тэдэнд цөмийг нь ярьчихсан нь бидэнд таашаагдсангүй. Хэн түүнийг гуйсан юм бэ?

Люся инээд алдаж:

— Автобазынхан цөм ийм өөдөс шиг юм уу? Николай хараач, ямар өөдөснүүд вэ! гэлээ.

Энэ доогтой аялга ч бидэнд таашаагдсангүй.

— Тэгэхлээр тануус ямар нэг зөөллүүр хулгайлсан гэж сэрдэж байгаа юм биз дээ? хэмээн Люся үргэлжлүүлэн хэлэв.

— Үгүй ээ, хэн ч та нарыг сэжиглэсэн юмгүй. Гэвч зөөллүүрийг машинаар авч гарсан. Энэ машины дугуй нь яг та нарын машиныг шиг юм.

Люся тачигнатал хөхөрч:

— Өө тийм бий?! Николай дуулж байна уу?! «Победа» машин цөм адилхан дугуйтай шүү дээ.

— Та инээх чинь арай эртдэж байна гэж би хэлээд

— Та нарын машины ар талын дугуй нь ГАЗ— 69 машиных. Тэр бас тийм байсан гэв.

— Николай сонсож байна уу? Тэр машин бас ийм дугуйтай гэнэ гэж Люся хашхирлаа.

— Ингээд та нар чухам яагаад мөрдлөг хийж байдаг билээ? гэж Николай гэнэт асуув.

— Яагаад гэвэл дадлага хийж байгаа биднийг үүнд сэжиглэсэн юм.

— Тануус дадлага хийж байгаа гэнэ ээ? Хаанаас ирж хийж байгаа юм, техникумаас уу?

— Үгүй ээ сургуулиас

Игорь чавга шиг улайж үгийг минь таслан

— Энэ ч хамаагүй ээ гэв.

— Байз, байз гэж Люся түүнийг зогсоож:

— Тэгэхлээр та нар дадлага хийж байгаа сурагчид байх нь ээ.

Николай сонсож байгаа биз!? гээд

— Энэ?! гэж Игорь руу дохив.

— Энэ ч бас...

Люся унаж тусан хөхөрч

— Николай! Энэ ямар байна? Сурагч! Мөн элэг авчихмаар юм!

Игорь мөн ч мундаг эр ээ! Николай чамд ямар санагдаж байна гэв. Гэвч Николай өөрт нь ямар санагдаж байгааг юугаар ч харуулсангүй.

Игорь царайгаа барайлган газар шагайж, элсэн дээр өсгийгөөрөө ямар нэг дүрс гаргана.

— Ээ жаалууд минь, жаалууд минь мөн ч айхавтар насаа даа гэж Люся даажигнан өгүүлээд сурагчид юм шив дээ? Игорь ч гэсэн тэр... гэснээ хөмсөг атируулж:

— Би та нарыг яадаг юм билээ? Николай эднийг яах вэ? Турсагыг нь хуул юу? гэхэд нас бага юм... Чихийг нь мушиг юу? гэхэд арай том юм...

— Бид ч гэсэн турсага хуулж чадна аа гэж Шмаков өгүүллээ.

— Тэгвэл л зохих юм гэж Люся Шмаковын хэлснийг хайхралгүй хэлэв.

— Яалаа гэж? хэмээн доогтой асуув.

Николай Игорийг харж

— «Техникийн хэлтсийн орлогч дарга гэж жигшингүй хэллээ.

Бид учрыг ойлголоо... Тэгээд инээдээ барьж чадсангүй. Игорь найз нараасаа сурагч гэдгээ нуусан юмсанжээ. Техникийн хэлтсийн орлогч дарга гэж биеэ танилцуулж. Бааз дээр тийм тушаал ч байхгүй. Игорь мөн хүнээ! Ингэж уулзахаас яагаад тэгж их айж байсан нь одоо ойлгомжтой.

Люся тохуутай гэгч нь онийж

— Том хүн болж наадацгааж байгаа юм биз дээ.

Игорь орлогч дарга болж, та нар мөрдөн байцаагчид болж? Игорь эхлээд биднийг маллаж байж, одоо тануус... гэв.

Майка хэлсэн нь,

— Игорь биеэ том зүтгэлтэн гэж та нарт хэлж. Маанаг юм!

Наадах чинь байгаагаасаа дээгүүр санаатай хүн. Энэ нь түүний дутагдал. Гэвч та бүхэнтэй бидний ярьж байгаа энэ зүйл маш ноцтой. Үүнд ингэж егөөдөж хандаж байгаа нь тоогүй дээ гэв.

Майка ёстой догь хэлсэн! Люся Николай хоёр дуугай болов. Би үүнийг даруй ашиглаж:

— Та нарын машин цулгайд очсон уу, үгүй юу гэдэг ганц л асуулт бидэнд байна гэв.

— Юун цулгуй

— Автобазын ар дахь

— Үгүй чиш. Танай бааз дээр бид өдөр очсон. Игорь машиныг минь засуулж өгнө гэж амласан. Энэ чинь «техникийн хэлтсийн орлогч» шүү дээ. Тэгээд энэ нь ямар юмаа бүтэх вэ дээ гэж Люся хэлсэнд:

— Та нар тэгээд засуулж чадаагүй юу? гэж Вадим асуув.

— Хувиараа засуулсан гэж Люся хариулаад:

— Гэхдээ зөөллүүрийг сольж тавиагүй. Гүйцээ юу? Бид явах шив гэв.

Тэр бээр тохуурхсан аялгатай ярьж байснаа болиод гэнэт дуугаа төв болгож тэгснээ дахин даажин хийнэ. Бас тэгээд «Николай, чи дуулж байна уу? гэж ахин дахин хэлэх дуртай юм. Гэтэл Николай цөмийг сайн сонсож байсан. Тэр ямар дүлий хүн биш.

Игорь толгойгоо өндийлгөж залхуутай дуугаар

— За яах вэ! Би техникийн хэлтсийн талаар үнэхээр залчихсан юм. Яах гэж тэр вэ? Зүгээр л наадам болгож тэгсэн юм. Тэгмээр санагдаад бурчихсан юм. Энэ нь хүнд нэг их хор болоогүй болов уу? гэж бодож байна.

— Будилааны учир олдов! Николай явья гээд Люся босов.
Шмаков Петр гэнэт
— Машиныг чинь ямар ажилчин зассан бэ? гэж асуув.
Люся мөрөө хавчисхийлгэж
— Танай ажилчид биш болов уу? гэж бодож байна гэв.
Тэгэхэд нь би
— Та нар тэдэнд машинаа орхиж байсан уу, эсвэл тэд тануус дээр ирж байсан уу? гэж асуув.
Люся намайг харлаа. Николай ч намайг харав. Энэ харцнаас үзэхэд машинаа цаадуулдаа өгч байсан нь надад илэрхий боллоо.
— Үгүй ээ бид тэдэнд машинаа орхиж байгаагүй. Тэд манай гараашинд материалтайгаа ирж цөмийг хийсэн.
Тэр бээр бодосхийснээ
— Гэхдээ дараа нь тэд хоёр цаг хэртэй хотоор явж үзсэн гэж нэмж хэлэв.
— Энэ чинь гурав дахь өдрийн орой юу?
— Тийм байхаа...
— Баяр хүргэе, та нарын машинаар хулгай хийсэн байна.
Баярлаж болно гэж би хэлэв.
Хэсэг зуур цөм таг чиг болов.
Люся жаахан хулчийсан нь илт байлаа. Хамгийн сонирхолтой нь гэвэл Игорь ч бас айчихжээ. Игорь яагаад тэр билээ?! Тэгтэл Люся
— Тэд цагариг, жийргийг «сольж, мотор угсарч, машинаар явж шалгаж ирээд л мөнгөө аваад явсан. Нэгийг нь Василий Иванович гэж байсан шиг санагдаж байна.
— Тохиолдлын хүмүүст машинаа итгэж өгнө гэдэг болгоомжгүй хэрэг гэж Майка хэлэв.
— Би Игорьт найдсан юм. Игорь нэг ажилчныг бидэн рүү явуулж, тэр нь биднийг энэ механикуудтай танилцуулсан юм. Баазын дааманы л дэргэд дээ гэв.
— Энэ ажилчин Лагутин уу? гэж би Игорийг харан асуув.
Игорь дуугарсангүй.
— Чи яагаад дуугарахгүй байна вэ? гэж Майка хэлэв.
Игорь бөглүү дуугаар
— Би ерөнхий инженерийн өрөөнөөс гараад явж байтал Лагутин ирж явж тааралдсан юм. Хувиараа мотор засчихаар хүн олдохгүй биз гэж би түүнээс асуусан. Хэдэн механик танина. Итгэлтэй, олны ам

сайтай улс гэж Лагутин хэлсэн. Тэгээд Люсяд энэ механикуудыг тэр зааж өгсөн. Тэд тохиролцсон. Ингээд л гүйцээ... гэв.

— Чи энэ бантанг хутгаж дээ гэж Шмаков Петр хэлэв.

— Би юу хийчихээ вэ? Хэн нэг нь зөөллүүр сольчихож. Үүнд чинь Люся, Николай бид гурав ямар хамаатай юм бэ?! Сольсон хүн үүнийгээ хариуцаг. Гэтэл хэн сольсон нь мэдэгдэхгүй байна.

— Мэдэж байна аа, Лагутин гэж би хэллээ.

— Нотолгоо хаана байна вэ?

— Би итгэж байна.

Игорь гараа сэгсэрч

— Чиний итгэж байгаа бол нотолгоо биш ээ. Баримт хэрэгтэй.

Гэтэл баримт алга!

— Игорь зөв хэллээ. Зөөллүүрийг миний машинаар авч гарсаан. Энэ бол санамсаргүй тохиол. Өөр ямар ч машинаар, таксигаар ч гэсэн ингээд л аваад гарчихад ядах цөхөх юмгүй шүү дээ. Зорчигчид юу авч явааг жолооч мэдэж байх албагүй гэв.

— Та нар ямар ч гэм зэмгүй хэрэг үү? гэж Майкаг ёжтой асуусанд

— Тийм гэж Люся хариулав.

— Тийм ч үгүй дээ? гэж би татгалзаад:

— Лагутин шударга биш хүн гэдгийг Игорь мэдэж байсан, иймд түүнээс гуйх ёсгүй байсан. Гэтэл Игорь гуйсан байна. Ямар нөлөөтэй хүн гэдгээ харуулах гэж. Гэтэл та нар насаар ахмад хүмүүс бодох ёстой байсан.

— Тунгаах хэрэгтэй! гэж Шмаков Петр нэмэрлэв.

— Нэгэнт хийчихсэн хойно өнгөрч. Игорь шиг ийм жулдрайнуудтай дахиж ойртож болохгүй гэж бидэнд хойшид сургамж болно.

— Үүнийг алсан ч багадна гэж Николай хүрлийн хэлэв.

— Хэн ч та нараар алуулахгүй, гэвч зөөллүүрийг буцааж өгөх хэрэгтэй гэж Майка өгүүллээ.

Люсягаар барахгүй бид ч гэсэн ийм гэнэтийн саналд гайхчхав.

— Юунд нь их гайхав? Гайхах юм алга! Улс та нарын хөнгөмсөг, Игорийн биеэ тоосон занг хариуцахгүй гэж Майка хэллээ.

— Бид аваачиж өгвөл бид авсан болно шүү дээ гэж

Люся татгалзав.

— Авсан хүмүүсээр нь, нөгөөх механикуудаараа өөрсдөөр нь өгүүл гэж би хэлэв.

— Бид тэднийг хаанаас олох юм гэж Люся адарч хэлэв.

— Дажгүй ээ! Хаанаас олохыг Лагутин та нарт заагаад өгнө гэж Шмаков дүнсийн өгүүлэв.

— Лагутин гэж нэг юмтай бид яагаад орооцолдох болж байгаа юм?

— Уухай? Хэрэгтэй болохлоороо та нар тохиролцоогүй юу? Нийтийн хэрэг болохлоор чадахгүй нь үү? Тэгвэл худалдаж авахгүй юу.

— Ээ хэ! Дөрвөн зөөллүүр тавин рубль байдаг юм гэж Николай хэлэв.

— Алдааныхаа төлөөсийг өгөх болж дээ гээд Майка инээмсэглэв.

Мотор тавина! Энэ нь машин угсрах ажлын хамгийн хариуцлагатай зүйл. Мотор бол машины зүрх нь, түүнийг амьдруулж, хөдөлгөдөг эд билээ. Моторгүй машин амьгүй.

Моторыг өргүүлд машинаар өргөж авчрав. Гинжээр багласан мотор агаарт данхагнаж явах нь өд аятай. Гэтэл энэ нь зуун килограммын жинтэй байж мэднэ. Түүнийг тавина гэдэг тийм амар биш, бүх юмыг яв цав тохируулах хэрэгтэй. Бэхэлгээ нь яг хоногтоо суусан байхаар тооцох хэрэгтэй.

Мотороо бэхлээд, цахилгаан тоноглол усны сав, карбюратор тавьж эхлэв... Тэгж тэгж ус, бензин тос юүллээ.

Машин бэлэн болох нь энэ.

Будгаас бусад нь гүйцлээ. Өнөө үдэш будчихна, шөнө хатаад хононо. Маргааш хотоор давхиж болно, гэхдээ хашлага дээр нь «туршилтынх» гэж бичнэ л дээ.

Өнөөдөр хашаа дотроо явж үзнэ.

Машиныг асаахад хүүхдүүд цөм цехээс гүйлдэн гарч ирэв. Игорь ч бидэнтэй хамт байлаа. Зүгээр зогсохгүйг мэрийж байсан гээч. Энэ сард юу ч сураагүй дээ хар буусан биз ээ.

Ангийнхан цөм зөөллүүрийн тухай яагаад ч юм мэдчихжээ. Хэн ярьчихсан юм бол? Ямар ч гэсэн би биш юм даг. Би зөвхөн Шмаков, Майка, бас Полекутин, мөн Гринькод шиг билээ дээ... хэлсэн юм... Гэтэл бусад нь? Бусдад нь хэн ярьсан нь сонин байна.

Манай ажлыг удирдсаны хувьд Зуев эхэлж жолоодож үзэв. Машин хашаа дотуур, нэг романд их догь бичсэнчлэн, «хүмүүсийн баярлан хөөрсөн шуугиан дундуур» явлаа.

Дараа нь Зуев шалгагчийн суудалд суув. Бид бүгдээрээ ээлжлэн машинаар хашаа дотуур тойров. Гэхдээ залуу жолоочийн үнэмлэхтэй нь л дээ. Машин маань сайхан болж, бүх агрегат нь сайн ажиллаж байлаа.

Дарга ирж: «Юу бүтээснийг чинь үзье» гээд мөн тойров. Кабинаас гарч ирээд

— Овоо болж гэж магтлаа.

Дараа нь бид машиныг будгийн цехэд оруулж Гаркуш, Рождественский ажлаа эхлэв.

Урьдын адил манай машиныг хүмүүс бүчсэн байлаа. Лагутин хүртэл хэд хэд ирэв. Гэвч тэр машиныг харсангүй, намайг харжээ. Шмаков Петр үүнийг ажигласан байна.

— Юунд чамайг бүлтэртлээ харна вэ? гэж Шмаков хэлэв.

Лагутин надыг ширтээд байгааг би мэдсэнгүй. Би үүнтэй манатай байлаа. Өнөөдөр би нэг нээлт хийлээ. Ямар ч гэсэн техникт бага зэрэг сонирхол байх шиг надад санагдав. Энэ бол сүрхий нээлт. Энэ нь миний амьдралын төлөвлөгөөг өөрчилж ч болзошгүй.

Лагутины нүд салгалгүй ширтэх нь надад нэлээд эвгүй болов. Нээрээ яагаад намайг гөлийгөөд байна вэ?

Хонх жингэнэв. Ажил тарлаа. Ажилчид шүршүүрт орж, шүүгээний дэргэд хувцсаа солин, ажлын хувцсаа тайлж костюмаа өмсөв. Бид ч бас тарлаа. Өнөөдөр лут ажиллаа.

Тэгээд Шмаков бид хоёр манайхыг бараг хүрч явтал хэн нэгэн хүн мөрөн дээр минь бахим гараа тавив. Би эргэлээ. Ард Лагутин зогсож байна. Түүний хөлийн чимээ дуулдаагүй нь гайхалтай юм.

Би мөрөө мулт татан зайлуулав.

— Чангаахгүй байж болох болов уу?

Лагутин Шмаков Петрийг харав.

— Холд, ярих хэрэг бидэнд байна.

Гэтэл Шмаков байраасаа хөдлөх янз байсангүй.

— Хаачих юм?

— Холд гэж байна шүү! гэж Лагутин дуу өндөрлөв. Түүнтэй улаан нүүрээрээ ярилцахад айх юм надад огт алга. Гэвч нэгд, дээрэлхээд байх юу юм? Хоёрт, Шмаков Петрээс нуух юм надад байдаггүй. Тэгээд би:

— Дээрэлхэхгүй байж болмоор?! гэлээ.

Лагутин намуухан боловч занасан дуугаар:

— Муу ахаараа юунд даажин хийгээд байна вэ? гэж хэлэхэд нь:

— Юун тухай ярьж байна? гэж би асуув.

— Мартчихав уу? Сануулаад өгөмз, гайгүй...

— Ха ха! Ямар аймаар вэ! гэж намайг хэлэхэд Шмаков

— Чичрүүдэс хүрч байна гэж нэмэрлэв.

— Чи зөөллүүр авч байхыг минь харсан уу? гэж ууртаа багтран:

— Харсан уу? гэж шивнэв.

— Үгүй ээ? Хараагүй Гэвч таны танил механикууд цулгуйгаас авч гарсан. Машиныг нь хүртэл мэдэж байна.

— Үүнийгээ батлах хэрэгтэй гэж дээрэнгүй хэлэв.

— Бид юуг ч нотлох гээгүй байгаа юм! Харин зөөллүүр олдохгүй бол нотлох л болно доо гэж би хариулав.

— Түрүүнд Зуевыг гүтгэсэн, одоо намайг гөрдөх нь үү?

— Зуевыг гүжирдсэн хүн байхгүй, та л бүхнийг санаанаасаа зохиосон гэж би татгалзан:

— Гэвч таны санаанаасаа юу зохиох нь надад сонин биш! Бид зөөллүүр олох ёстой, олно чиг. Зөөллүүр өөрөө олдвол сайн л биз. Гүйцээ! Өөр ярих юм алга. Петро явъя гэв.

Би тайван эргэж гэр өөдөө явлаа. Лагутин хаашаа явсныг би мэдээгүй. Бид нэг ч эргэж хараагүй юм.

Үдэш би зөөлөвчит вандан дээр хэвтчихээд Гоголийн «Амьгүй албатыг» уншиж байлаа. Энэ ном надад маш аятайхан санагддаг, хүмүүсийн дүрийг зурагласан нь сэтгэлд таардаг юм. Маш нарийн, инээдтэй тодорхойлсон гээч! «Амьгүй албатыг» сөхөж, губернийн N хотод Чичиковын нумтай хөнгөн сүйх тэрэг хэрхэн орж ирж, хоёр тариачин эр энэ тэргийг Москва, Казани хүрч чадах уу, үгүй юу гэж эргэцүүлж байгааг уншиж эхэлмэгцээ л би тавьж чаддаггүй юм. Плюшкин, Собакевич, Ноздревыг яах гээ!

Тийнхүү «Амьгүй албатыг» уншаад вандан дээр хэвтэж байтал хонх дуугарав. Үүдний өрөөнд ээж байсан тул хаалга онгойлгож өглөө. Тэгээд өрөө рүү минь шагайж

— Серёжа, чамтай хүн уулзья гэнэ гэж хэлэв.

Ахмад Копейкины тухай уншиж байсан тул харууссаар номоо хойш тавиад коридор руу оров. Хаалга дутуу онгойжээ. Би нээлээ. Үүдний чөлөөнд бүртгэгч Зина зогсож байв.

— Та надтай уулзах нь уу? гэж гайхан асуулаа.

— Серёжа! Чамтай ярих хэрэг гараад! гэж Зина сандрангуй хэллээ.

— Ор ор.

— Чи түр гар л даа.

Би үүдний чөлөөнд гарч хаалгаа хаав. Зина гараас минь шүүрээд авлаа.

— Серёжа! Юу болоо вэ?

Түүний юу хэлж байгааг би дор нь тааварлав. Зинаг юу юугүй уйлчих гэж байгааг хараад би учиргүй айв. Бүсгүй хүн уйлахад дургүйг минь яана. Эмэгтэйчүүд, жаахан хүүхэд, муур уйлахад шүү.

Тэднийг уйлахлаар зүрх урагдах шиг болдог юм. Би Зинагийн сэтгэлийг засахуйц хариу хурдхан бодов. Гэвч амжсангүй.

— Чи түүнийг мэдэхгүй байна. Тэр маш сайн хүн. Найз нар нь л түүний замыг алдуулж байгаа юм гэж Зина ярив.

Нүдэн балай дурлах гэгч юунд хүргэдэг байна даа! Хэнд дурласан гээч? Өөрийг нь огт ойшоодоггүй хүнд шүү.

— Тиймээ нөхөд нь! Зөөллүүрийг буцааж өг гэж нөхдөөсөө гуйг гэж би хэлэв.

Зина амьсгаа нь дээр гарснаа уйлчхав. Енгинүүлж гарсныг хэлэх үү... Би яадаг билээ?

— Би түүнд тун хайртай гэж Зина уйлан хэлээд

— Түүнийг ямар нэг юм болчихвол би яахаа мэдэхгүй байна гэв.

Би эмэгтэй хүнтэй дурлалын тухай ер ярьж үзээгүй. Энэ асуудлаар санаж боддог зүйлээ хэлэх боломж гарсанд би баярлав бололтой.

— Дурлал гэдэг бол юуны өмнө бие биеэ хүндлэх явдал мөн гэж би хэлэв.

Энэ агшинд дэргэд минь Майка байсангүйд тун харамсав. тэр бээр байхгүй байсан боловч санаагаа лавшруулан:

— Нэг нь нөгөөгийнхөө сэтгэлд юм оруулахаар юм хийхгүй байх ёстой. Хэрэв нэгэнд нь эвгүй байвал элдэв базаахгүй хүмүүстэй бүжиглэх хэрэггүй юм.

Зина уйлагнасан дуугаар,

— Би хэнтэй ч ер бүжиглээгүй гэв.

— Бүжиглэж ч болох нь болно л доо. Тэгэхдээ үүний нь цаана тодорхой санаа далдлагдаж байвал бүжиглэхгүй байсан нь дээр гээд би хашлагыг тохойлдож

— Дараа нь шулуухан улаан нүүрээрээ учирч бие биеийнхээ алдаа дутагдлыг илэн далангүй ярих хэрэгтэй гэв.

Дурлалын талаар өөр ухаалаг юм хэлчих юм сан гэж жаал бодсон боловч сэтгэлд юу ч орж өгсөнгүй.

Намайг дуугүй байгааг ажиглаж Зина

— Түүнийг нь эргүүлээд өгчихвөл яах ч үгүй юү? гэж асуув.

— Яах ч үгүй ээ! гэж би хариуллаа.

— Би их айж байна! Гэнэт шоронд хорьчихвол яана! гээд Зина дахин уйлж эхлэв.

— Юуны чинь шорон морон бэ? «Сүм шорон хоёрыг газрын хөрснөөс арчина!». Асуудал ийм янзтай байна! Бүгдийг нь буцаагаад өгчихвөл, дахиад луйвар хийхээ боливол яалаа гэж шоронд хорих вэ?

— Тэр огт ийм хүн байгаагүй юм. Тэдэнтэй нийлснээс хойш л хамаг хэрэг ундарсан гэж Зина шивнэв.

— Тэр тусмаа л түүнд нөлөөлөх хэрэгтэй. Хожим нь алдааныхаа төлөө хариуцлага хүлээж байснаас одоо буруугаа хүлээсэн нь дээр дээ гэж би хэллээ.

Зина явав. Би ч номоо барьж авлаа. Гэвч уншиж болохгүй байв. Зинаг өрөвдмөөр байлаа. Хэчнээн өрөвдмөөр харагдаж байв.

Лагутинаас болж энэ шүү дээ. Лагутин шударга бус хэрэг хийж байгаа нь багадаад бусдын элгийг хатааж байх юм.

Зинад хэлбэл зохих юмыг огт хэлсэнгүй дээ. «Лагутинд сэтгэлтэй бол түүнийг дахин хүмүүжүүлэхэд нь тусал» гэж хэлдэг байж. Үүнийг л хэлэх хэрэгтэй байсан юм. Гэтэл би дурлалын тухай бурж бурчихсан.

Яая гэх вэ! Зөв санаа, хэрэгтэй үг ярилцаад бүр өнгөрсөн хойно толгойд минь ордог юм.

Дадлагын ажил өнөөдөр дуусна! Би ажилдаа эрт ирэв. Машиныуд замдаа дөнгөж гарч байв.

Ачааны лужир лужир машин, ачаагаа өөрөө буулгадаг машин хойно хойноосоо цувран гарч цардмал замаар давхин Москвагийн гудамжаар тарна. Кабинд жолооч нарын ширүүн царай зурсхийн өнгөрнө.

Хашаанд өглөө эрт нөгөө л хөл хөдөлгөөн ихтэй байдгаараа байлаа. Радиоогоор бүртгэгчийн чанга дуу сонстож, ашиглалтын дарга утсаар ярьж, ерөнхий инженерийн зовонгуй царай үзэгдэнэ. Дарга нь байдаг газраа дуугүй сүртэй гэгч нь зогсож, явж байгаа машиныг нүдээрээ үднэ.

— «Ямар сонин бэ? Маргааш бид шувуу шиг эрх дураараа болно. Ханатлаа унтаж болно. Дуртай юмаа хийж болно. Долоо хоноод ээжтэй Касимов орж, Окад сэлж, сэлбүүрээ бүхэнд гайхуулна... » гэж би бодов.

Гэтэл сэтгэл нэг л гунигтай...

Өглөө эртэлж энд ахиад ирж байхгүй, бүх ажилчдын адил шүүгээнийхээ дэргэд хувцсаа дахиж солихгүй, тэдний тоглоом тохуу яриа хөөрөөг ахин сонсохгүй, бригадын дарга Дмитрий Александровичид «дууслаа, шалгагтун» гэж дахиад хэлэхгүй гэж бодохоос уйтгар төрнө. Дмитрий Александрович ч за яах вэ номын хэнээт минь болж... гэж ахин надад хэлэхгүй ээ.

Гагнуурын үлээгүүрийн шуугих, гагнуурын шарчигнах, хөрөөний хяхтнах, харуулын шурд шурдхийхийг дахин сонсохгүй, бензин, нүүрс төст, ацетоны дасал болсон үнэрийг мөдхөн авч чадахаа байчих байх даа. Агуулахаа цаг болоогүй байхад хаалаа гэж няравтай дахиж ам мурийхгүй нь. Өөрийн гараар хийж олсон мөнгөө хоёр долоо хоноод л авч байхаа болино.

Бид дадлага хийгчид байхаа болино л доо. Гэвч бид энд өөрсдийгөө ажилчид гэж санаж байв. Бүхний хийдэг ажлыг л бид хийж байсаан.

Гараашны харалдаах урт сандал дээр сууж халаа авалцахыг хүлээж байхад надад ийм гунигтайхан бодол төрж билээ.

Дараа нь хонх дуугарч бид цех цех рүүгээ оров.

Үнэнийг хэлэхэд бидний хэн нь ч өнөөдөр ажил хийсэнгүй. Игорь ирээд бидний тухай тушаалыг самбарт өлгөсөн байна гэж хэлэв. Бид уншихаар гүйлдэв.

Сайн ажилласан учир бүх хүүхдэд талархал илэрхийлжээ. Ерөнхийд нь сайн удирдсан учир ерөнхий инженерт талархал дэвшүүлжээ. Цехийн дарга нарт тодорхой сайн удирдсаны учир нийт ажилчдад, бидэнд сайн хандаж байсны учир талархал илэрхийлсэн байна.

— Догь бичсэн байгаа биз! гэж Игорь хэлээд далд учрыг нь мэднэ гэдгээ ойлгуулах гэсэн хүний дүр гаргалаа.

Гэтэл би түүнтэй санал нийлэхгүй байв. Одоо дадлага шувтрахад муу нь мартагдаж, сайн нь л сэтгэлд үлджээ. Эхлээд бид бараг юу ч хийж чадахгүй байсан болохлоор ам мурийх удаа гарах нь дамжиггүй байлаа.

Манай машиныг босгоход сайн тусалсны учир Зуевт ч бас талархал илэрхийлжээ. Липкад гарсан ослоос болж ноогдуулсан шийтгэлийг цагаатгажээ.

Тэгтэл бидэнд одоо цалин өгөх нь гэдэг сураг гарав. Бид санхүү рүү ухасхийлээ. Яг л анхны цалин шиг арван зургаан рубль хорин мөнгө бидэнд тавьж өгөв. Сарын эцсийн мөнгө урьдчилгаанаас ямар ялгаатайг бид ойлгосонгүй.

Цалин авсны дараа цех цехдээ очиж хариуцаж авсан зүйлээ тушаахыг ерөнхий инженер даалгав. Тэгээд:

— Ажилчидтай салах ёс хийхэд зүгээр байх шүү гэв.

Бид үүнийг ерөнхий инженертэй инженергүй ойлгож байлаа. Ямар ч гэсэн түүний үгэнд би зэгсэн гайхав. Энэ үгнээс үзэхэд элэг нимгэн хүн юм. Гэтэл бид ерөнхий инженерийг цэвдэг хатуу сэтгэлтэй гэж бодож байжээ.

Шмаков бид хоёр гарашинд очиж, багаж хэрэглэл, ажлын хувцсаа тушаагаад ажилчидтай салах ёс гүйцэтгэж эхлэв. Цөмөөрөө алчуурынхаа сэжүүрээр гараа арчиж, бидний гарыг атгав. Ажиглах нүхэнд байгчид ч бас бидний гарыг барилаа.

Биднийг явж байгаад бүгдээрээ харамсаж байгаагүй байж болно. Гэвч бүтэн сар цуг ажиллаж, муу сайнаа хуваалцаж байсан учир бидэнд хааш яаш хандаж яаж чадах вэ.

Шмаков бид хоёр гараашны дааман хүрээд эргэж харав. Цөмөөрөө юу ч болоогүй юм шиг ажлаа дахин хийж байлаа. Дадлага

дуусаж байгаа нь бидэндээ л үйл явдал юм. Гэвч сэтгэл нэг л эвгүй болов. Гараашныхны хувьд бид гаднын хүмүүс гэж үү? Хэд хоноод биднийг мартчих байхаа даа...

Хашаанд Игорь бидэнтэй уулзаад дүнгийн тухай яриа одоо болно гэв.

Тэгээд намайг нэг л учиртай харж эгдүүтэй жуумганан:

— Бэлдэж бай, Крош... гэв.

Түүний дууны өнгөнөөс эвгүй явдал болох гэж байгааг би мэдэв. Чухам ямрыг надад хэлсэнгүй. Гүйцэд хэлдэггүй тийм зантай хүн. Үүгээрээ юм их мэддэг гэдгээ гайхуулж байгаа юм.

Үүнд нь уур минь хүрэхийг яана. Бүрхэг юманд би дургүй. Ямар ч гэсэн би дор нь мэдэж авахыг эрхэмлэдэг юм. «Серёжа, чамтай ярилцмаар байна» гэж хэлэхийг хүлцэж чаддаггүй билээ. Дашрамд хэлэхэд аав ч тийм зуршилтай. Шууд эхэлнэ гэж ер байхгүй, царайгаа барайлгаж «Серёжа, чамтай ярих хэрэг байна» гэж хэлнэ. Тэгээд хоёр ч өнжинө. Энэ хоёр өдөр би яах гэж байгаа бол гэж үйлээ эдэлнэ. Айгаад байхаар юм юу ч хэлэхгүй гэдгийг би мэднэ. Гэвч ярилцах тухай сануулснаас яг ярилцах хүртэлх завсар яах гэж байгаа нь мэдэгдэхгүй байхад л би дургүй. Аав дургүй нь хүрснээ шууд хэлчихгүй, энэ дургүйцлээ дотроо хадгалж, онцгой үеийг хүлээдэг нь надад эвгүй байдаг.

Одоо ч би иймэрхүү л байдалтай байв. Дүнгийн яриан дээр ямар эвгүй юм болох гэж байгааг би мэдэхгүй байв. Мэдэж байсан бол сэтгэл төвшин байх сан. Игорь ёстой найз сан бол ингэж тамыг минь үзэхгүй байх сан.

Бид цулгуйд ердийнхөөрөө өнөөдөр эцсийн удаа цугларав.

Тэнд манай машин дөнгөж сая заводуос гарсан юм шиг цоо шинэ будагтай гялалзан зогсож байлаа. Түүнийг сургуульд албан ёсоор шилжүүлж өгч байгаа юм.

Бидний зэвүүг хүргэх гэсэн шиг машиныг сургуулийн аж ахуйн дарга Иван Семенович хүлээж авав.

— тэр бээр машиныг тойрон явж, гараа баясан үрчих нь хэдий хэр нүүрс үүгээр татдаг бол гэж бодож байгаа бололтой.

Энэ машины төлөө гайгүй сайн үзэлцэх хэрэгтэй болохыг бид ойлгов.

Дарга авто үзгээ гаргаж, хөмсөг зангидан шилжүүлэх баримтад гарын үсэг зурав. Энэ минутаас хойш машин сургуулийнх болно.

Аж ахуйн эрхлэгч Иван Семенович ганцхан ухасхийгээд кабин руу орж, Зуев жолоо барин сургуулийн гарааш руу явав.

Манай ангийн багш Наталья Павловна өгүүлсэн нь:

— Дадлага дууслаа! Практик бидний бодож байснаас дор болсон уу, дээр болсон уу гэдэг гол биш. Энэ бол та нарын бие даасан амьдрал, хөдөлмөрлөж үзсэн амьдралын анхны сар гэдэг гол нь байгаа юм. Энэ сар та нарын санаанаас ер гарахгүй гэв.

Үүнийг ч харин тэр бээр зэгсэн онож хэллээ шүү.

Бидэнд бүгдэд нь гуравдугаар зэрэг, Полекутинд дөрөвдүгээр зэрэг олгож байгааг ерөнхий инженер зарлав. Зарим хүүхэд үүнд гомдов. Гэтэл миний бодоход ерөнхий инженерийн зөв юм. Полекутин бол ямар ч маргаангүй авах хүн. Дөрөвдүгээр зэргийг надад юм уу, Шмаков Петрг өгвөл энэ нь харин эргэлзээтэй. Ингэсэн бол дургүйцэх үндэс ч аргагүй их байх сан. Тэгэхлээр ерөнхий инженерийн зөв. Полекутин биднээс илүү техник мэддэгийг тэр харин яаж мэдэв ээ.

Дараа нь дарга:

— Та нар цаг дэмий үрсэнгүй гэж бодож байна. Бага ч болтугай юм сурлаа. Ертөнц дээрх бүх юмыг яаж хийдгийг харлаа. Тэгвэл ертөнцийн бүх юм ажилчин хүний гараар бүтдэг юм.

Энэ үед бригадын дарга Дмитрий Александрович түүн рүү очиж, чихэнд нь нэг юм шивнэв. Дарга гайхаж:

— Хаана гэнэ ээ? гэж магадалж асуув.

— Пинд

— Оньсого байна даа! гэж дарга бувтнаад

— За одоохон очъё гэснээ бидэн рүү дахин эргэж

— Зөөллүүр олдож, ямар сайн хэрэг вэ! гэлээ

Яаж олдсоныг бол бид мэдэж байв. Гэвч гэмгүй царайлав. Таавар хэвээрээ л үлдэг.

— Учрыг олно оо! гээд дарга

— Би юу гэж ярьж байлаа гэснээ дээш харан

— Мартчихаж, за тэгээд өөр юу ч хэлэх вэ дээ? Сайн хүүхдүүд.

Сайн ажилласан. Игорь ч сайн тусалсан...

Цөм Игорийг харав. Даргын магтаалд маш ичингүйрсэн дүр үзүүлсэн боловч үнэн чанартаа маш додигор байв.

— Игорь тусалж байсан, ерөнхий инженер түүнд сайн тодорхойлолт өгсөн. Бүртгэл, бичиг баримтыг хөтөлж сурч. Би залуудаа алх, сүх барих гэж голдуу улайрдаг байсан л даа. Яах вэ одоо

даргалж л байна. Гэхдээ бүртгэл, баримт сэлт ч хэрэгтэй л дээ... Ер нь бүх хүүхэд сайн ажиллалаа. Сахилга бат ноцтой зөрчсөн удаа байхгүй. Дашрамд хэлэхэд сахилга батын талаар нэг хүүхэд доголдсон удаа бий.

Тэр биднийг тойруулж харав. Харц нь над дээр тогтов. Бие хүйт оргив оо.

Игорийн хэлээд байсан нь энэ байж! Одоо дарга намайг номнож гарна. Тасалгаандаа болсон тэр яриаг сөхөж ирнэ.

— Тийм ээ, энэ байна. Крашенинников гэдэг байх аа!

— Тиймээ гэж би бувтнав.

— Доголдсон тал бий юу?

Би дуугарсангүй.

— Бий гэж дарга өөрөө хариулаад осол гаргахад хуруу дүрсэн биз?

— Тэгсэн гэж би хүлээв.

— За тэр! Дараа нь албан тасалгаанд хүрч ирээд, дэглэм журмыг өөрийнхөөрөө тогтоож гарсан. Тэгж болохгүй, нөхөд өө. Хүн болгон намайг сургаж гарвал юу болох билээ!

Би Игорийн доогтой харж байгааг ажив.

— Юмны учир ийм байна. Та нар нас бага, цус шингэн байна. Өөр их юм сурах хэрэгтэй. Бусдыг зааж сургах цаг ирнэ. Үүнийг санаж авах хэрэгтэй. Гэвч бултаараа сайн хүүхдүүд юм! Крашенинниковын тухайд гэвэл, сайн байна, Крош! Шударга залуу! Крош минь үзэлцээд бай! гэж би ерийн, ажилчин хүний ёсоор хэлэх байна.

Намайг зэмлэсэн атлаа сүүлд нь магтаж байх шив...

Үүнд авцалдаа байна гэж үү?

Уг номыг “Болор дуран” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

"БОЛОР ДУРАН" ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.



Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qpay

1971 ОНЫ ХЭВЛЭЛИЙН Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

А. РЫБАКОВ

КРОШИЙН ПАЯН

БНМАУ

АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР

1971

ПРИКЛЮЧЕНИЯ КРОША

Орчуулсан Г. Аким,

редактор П. Шагдар

Сургуулийн дунд насныханд

Хавтсыг А. Лүндэн,

зургийн редактор Ц. Энэбиш,

техник редактор Б. Дашлэгцэг,

хянагч Б. Цэдэндорж, Б. Зоригт

Хэв. газ. № 193/71

Зах № 140

Өрөлтөд 1971—V—10.

Хэвлэлтэд 1971—VII—3.

Цаасны хэмжээ 84X108/32.

Хэв. хуудас 5,625.

Хэвлэлийн нэгж хуудас 9,26.

тооцооны хуудас 7,52

Хэвлэсэн тоо 6000.

БНМАУ Ардын Боловсролын Яам.

Улаанбаатар, Октябрын 13

Д. Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинатад хэвлэв.

Улаанбаатар, Д. Сүхбаатарын талбай, 2.

Заметки

[←1]

Дүүргээс (ЦБ)